

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
03 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР /ДАВАА ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6 – 145

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан /үргэлжилнэ/	6 – 144
2. Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.	144 – 145

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
03 дугаар сарын 31-ний өдөр /Даваа гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 74 гишүүн хүрэлцэн ирж, 58.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Анар, Ж.Баярмаа, Ш.Бямбасүрэн, Ж.Галбадрах, Ц.Даваасүрэн, Б.Дэлгэрсайхан, С.Цэнгүүн;

Чөлөөтэй: Г.Дамдинням, Л.Оюун-Эрдэнэ, Н.Номтойбаяр, С.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, А.Ганбаатар, М.Ганхүлэг, Б.Найдалаа;

Тасалсан: Т.Аубакир, Х.Ганхуяг;

Хоцорсон: Н.Алтаншагай – 1 цаг 41 минут, Ц.Баатархүү – 04 минут, Б.Батбаатар – 27 минут, Д.Батбаяр – 04 минут, Р.Батболд – 02 минут, Э.Батшугар – 1 цаг 03 минут, Б.Бейсен – 02 минут, Г.Ганбаатар – 03 минут, С.Ганбаатар – 08 минут, Д.Ганбат – 1 цаг 15 минут, П.Ганзориг – 01 минут, Л.Гантөмөр – 02 минут, Т.Доржханд – 20 минут, С.Одонтуяа – 02 минут, Б.Пунсалмаа – 27 минут, П.Сайнзориг – 03 минут, Л.Соронзонболд – 01 минут, Г.Тэмүүлэн – 07 минут, Н.Учрал – 21 минут, Г.Уянгахишиг – 04 минут, Да.Цогтбаатар – 07 минут, Б.Жаргалан – 08 минут, Ц.Мөнхбат – 15 минут, Ц.Мөнхтуяа – 19 минут, З.Мэндсайхан – 06 минут, М.Нарантуяа-Нара 02 минут, Ч.Номин – 06 минут, Б.Чойжилсүрэн – 10 минут, Ж.Энхбаяр – 02 минут, Р.Эрдэнэбүрэн 1 цаг 19 минут.

Нэг.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан /үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд “20 минутын хот” Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын

өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Мөнхзул, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, мөн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын дарга Ж.Өнөржаргал, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудитын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Б.Сандуйжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан, Ж.Чинбүрэн, Ө.Шижир, С.Замира, П.Сайнзориг, Б.Заяабал, Г.Очирбат, Б.Уянга, Ц.Сандаг-Очир, Ж.Алдаржавхлан, Л.Соронзонболд, О.Саранчулуун, Б.Түвшин, Д.Батлут, О.Номинчимэг, Б.Бейсен, П.Ганзориг, Ж.Баясгалан, М.Нарантуяа-Нара, З.Мэндсайхан, Д.Ганмаа, Х.Булгантуяа, Х.Тэмүүжин, Б.Жаргалан, Б.Пунсалмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд Л.Гантөмөр, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний

Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Боловсролын сайд П.Наранбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Мөнхзул, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Ү.Амарбат нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж дууслаа.

Уг асуудлыг 15 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:24/

2.Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:24/

3.Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:24/

Уг асуудлыг 15 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 25 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 109 гишүүн ирж, 86.5 хувийн ирцтэйгээр 15 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр, Даваа гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 00 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтгая.

74 гишүүн бүртгэгдэж, ирц 58.7 хувьтай болсон байна.

2025 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар хоёр асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,
Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны
хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон
Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан
/үргэлжилнэ/**

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд үргэлжлүүлэн асуулт асууж үг хэлэхээр байгаа.

Нийт 30 гишүүн үг хэлэхээр үлдсэн. Нэрс бүрэн орсон юм уу? Үг хэлэхээр бүртгүүлсэн гишүүдийн нэрсийг бүрэн оруулъя.

Ингээд дарааллын дагуу Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Жаргалсайхан: Бүх гишүүддээ өглөөний мэнд хүргэе.

Өнөөдөр бид бүхэн таван жилийн хугацаанд, мөн дээрээс нь 2024 оны Засгийн газрын хийсэн ажил, бидний бас баталж өгсөн ажлын тайлан буюу гүйцэтгэлийн талаар ингээд ярьж байна.

Хэмжих тал дээр буюу шалгуур үзүүлэлт дээр нэлээн асуудлууд байна.

Тэгээд өнөөдөр бидний хувьд бас ийм асуудал ярина гэдэг бол байж болохгүй. Энэ дээр хариуцлагын асуудал яригдах ёстой. 45 хувьтай гээд Улсын Их Хурлын Тамгын газраас дүгнэчихсэн байна.

Ингээд бусад газруудаас 50, 51, 52-той гээд дүгнэсэн байгаа.

Тэгэхээр шалгалтдаа буюу ажилдаа муу хандсан байна. Ер нь муу үнэлгээг авчихсан байна шүү дээ.

Тэгэхээр бидний хувьд ч гэсэн өнөөдөр бас энэ Засгийн газар энэ ажиллаж байгаа хүмүүстэй хариуцлагын асуудал ярих ёстой. Ийм байдлаар өнөөдөр асуудлыг ингэж хэлэлцсэн төдий өнгөрөөж болохгүй.

Үүний цаана юу харагдаж байгаа вэ гэхээр миний хувьд.../микрофон тасрав/

Тасарчих юм. Байхгүй. Үүний цаана юу харагдаж байгаа вэ гэхээр ихэнх аймгаар ороод ирлээ. Ард иргэд ч хэлж байна. Энэ судалгааны, мөн дээрээс нь бидний үнэлсэн үнэлгээгээр ч гэсэн харагдаж байна. Маш муу байна. 2023 оны нэг хүний нэг сарын амьжиргааны зардал 2024 оныхоос 45 хувиар нэмэгдчихсэн байна.

Тэгэхээр бидний гаргаж байгаа бодлого, үйл ажиллагаа ард иргэд дээр маш хатуу, амьдрал ахуйд нь хүндрэлтэй, амьдрал ахуй нь сайжирсан биш, бидний өнөөдөр 45 хувьтай гэж үнэлж байгаа шиг маш муугаар үнэлэгдээд явж байна.

Тэгэхээр энэ зүйлүүд дээр бид өнөөдөр болж байгаа мэтээр, тэр тусмаа 5 дахь өдөр хэлэлцэж байхад сайдууд байхгүй. Ажлаа танилцуулж байгаа, ажлынхаа үнэлгээг авах гэж байгаа хүмүүс маань байхгүй байж байгаа нь л ажилдаа хандаж байгаа хандлага нь гэхэд л ийм байна.

Тэгэхэд бидний хувьд өнөөдөр ард иргэдийн амьдрал ямар байна вэ гэдэг дээр л гол үнэлгээгээ өгөх ёстой. Ард иргэдийн маань амьдрал ийм болчихсон байна шүү дээ. Тэгэхэд өнөөдөр нэг шалгуур үзүүлэлт бид яриад л сууж байгаа. Шалгуур үзүүлэлт гэдэг чинь ажлаа хийж чадахгүй төрийн албан хаагч нарын асуудал л ярьж байгаа шүү дээ. Түүнээс амьдрал ахуй сайжирчихсан байгаа бол бид өөр асуудал ярих ёстой.

Тэгэхээр аль аль талдаа бид хариуцлагын асуудлыг сайжруулахгүй бол болохгүй байна.

Ингээд Монголбанкнаас инфляцын талаар танилцуулга хийгдсэн. Инфляц 9.6. Хоёр оронтой тоонд орно оо гээд тодорхой төсөөлөл танилцуулчихлаа. Мөн дээрээс нь бодлогын хүүг 12 буюу 10 байсныг 12 болгочхож байгаа юм. Дахиад л нөгөө ард иргэд дээр ачаалал нэмэгдэнэ. Дарамт нь ирнэ.

Тэгэхээр ард иргэдийн маань амьдрал ахуй дахиад л хүндрэх нь. Төсвийн орлого бас тасрах нь тодорхой боллоо. /микрофон тасрав/

Д.Амарбаясгалан: Энэ микрофон яагаад тасраад байна. 4 минутаараа юу. Минут нь дууссан байна. 1 минут нэмчихье. Д.Жаргалсайхан гишүүнд.

Д.Жаргалсайхан: Гялс л гэж байна шүү. Манайхан.

Ингэхээр бидний хувьд үндсэндээ өнөөдөр нөхцөл байдлыг харахад тодорхойгүй шийдвэрүүд ард иргэдийн амьдрал дээр эргэлзээг, мөн дээрээс нь амьдралд нь хүнд дарамт болж очиж байна.

Эндээс ер нь болж байгаа зүйл нь хэдхэн байна. Болж байгаа зүйл яг энэ тайлан мэдээ, судалгаан дээр юу харагдаж байна гэхээр банк бус санхүүгийн байгууллагууд л орлого нь сайжирч байна. Өмнөх оны ашиг нь 85 хувиар өссөн байна гээд тайлан мэдээ явж байна. Үндсэндээ ард иргэдийг шулан мөлжиж байна.

Эсрэгээрээ ард иргэдийн амьдрал 45 хувиар дордчихсон.

Монгол Улс ажил амьдрал, ажлын байр олгох, ард иргэдийнхээ орлогыг сайжруулах томоохон ажлуудыг хийх гэж байна. Тэгээд хийж байгаа ажлууд нь яг ард иргэддээ биш. Тийм ээ. Гаднынханд зориулагдсан ажил байгаад байна. Жишээ нь, Монголчууд л барилгаа барьж чаддаг болчихсон шүү дээ.

Д.Амарбаясгалан: Д.Жаргалсайхан гишүүн үг хэллээ. Тодруулах 1 минут өгчихье. Сая бас техник тасалдаад минут тасарчихлаа. 1 минут нэмж өгье.

Д.Жаргалсайхан: Ингээд ерөөсөө асуулт, энэ юмнууд чинь ерөөсөө замбараагаа алдлаа л даа. Энэ минут дээр яваад.

Ингээд машины номер олгохгүй байх шийдвэр гарч байгаа юм. Тэгэнгүүт зөндөө л асуудал гарлаа. Үүнийг өөрөөр шийдэх боломжууд байсан. Жишээ нь, хуучин машин дээр импортын татварыг нэмэгдүүлэх асуудал байсан.

Мөн дээрээс нь энэ 2023 онд ноолуурыг 100 хувь самнана гэдэг Засгийн газрын шийдвэр гарсан. Гэсэн хэдий ч бэлтгэл ажлууд нь хангалттай биш байсаар байгаад өнөөдрийг хүрсэн. Өнөөдөр ноолуур авах хүнгүй болсон. Монголын ард түмэн яг энэ хаврын цагаар ноолуураа самнаж өрнөөс гардаг бол өнөөдөр ноолуур авах хүнгүй болсон. Үнэ нь унасан.

Иймэрхүү байдалтай бидний шийдвэрүүд яваад байгаа нь үнэхээр оновчгүй. Түрүүн хэлсэн. Тэр барилгын салбарт гэхэд л одоо өнөөдөр нийслэл дээр 10 мянган айлын орон сууц барих гэж байна. Метр квадрат нь 7 саяын өртөгтэй байна. Монголчууд өөрсдөө барилгаа барьдаг болчихсон. Тэгэхэд монгол аж ахуйн нэгжүүд орох боломжгүй. Яг ийм төслийг буюу ийм тендер гээд зарлачихсан байж байгаа. Дахиад л гаднын компаниуд орж ирнэ.

Д.Амарбаясгалан: Д.Жаргалсайхан гишүүн үг хэллээ. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Чинбүрэн: Эрхэм гишүүддээ бүгдэд нь энэ шинэ долоо хоногийн мэнд хүргэе. Эхний асуулт ийм байна.

Бид өнөөдөр урт хугацааны буюу “Алсын хараа-2050”, дунд хугацааны буюу 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, богино хугацааны буюу 2024 оны жилийн төлөвлөгөө гэсэн гурван баримт бичиг хоорондоо тайланг сонсож байна.

Эдгээр нь хоорондоо хэр уялдаатай байгаа юм бэ гэдэг асуулт тавих гэж байна.

Дунд, урт хугацааны төлөвлөгөөнд туссан зүйлс жилийн төлөвлөгөөнд тусдаг эсэх нэлээн эргэлзээтэй байна. Энэ талаар Аудитын газар хариулт өгнө үү. Тэр дундаа эрүүл мэндийн бодлогын хувьд харьцуулсан дүгнэлт, урт хугацааны, дунд хугацааны, мөн нэг жилийн богино хугацааны гүйцэтгэлийн тоо баримтууд нь хэр хоорондоо уялдаж байгаа юм бэ?

Мэдээж Эрүүл мэндийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд төлөвлөгөө өгдөг байх. Тэгвэл би бас Эрүүл мэндийн яамныхнаас асуумаар байна. 2024 оны ажлын төлөвлөгөөнд оруулсан хэчнээн үзүүлэлтүүд Эдийн засаг, хөгжлийн яамнаас хасагдсан юм бэ? Үүнийг Эрүүл мэндийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам хоёр тус тусдаа хариулж өгнө үү.

Тухайлах юм бол бид 2050 алсын хараандаа Монгол хүний дундаж насыг 82 болгоно гэж байгаа шүү дээ. 82 болгоё. Хүн амын өсөлтөө 5 сая болгочхож байгаа юм. Тэгтэл өнөөдөр зөвхөн 2024 оны тайланг аваад үзэхэд 6700 гаруй төрөлтөөр буурчихсан байх жишээтэй.

Тэгэхээр бид нэгд наслалтаа уртасгаж чадах юм уу? Нярайн эндэгдлийн асуудлыг яагаад богино хугацааны бодлогодоо тусгахгүй, энэ үзүүлэлтүүд яригдахаа больчихов оо? Энэ тал дээр хариулт өгөөрэй.

Хоёр дахь асуулт. Улсын Их Хурал хоёр дахь удаагаа сонгогдлоо. Түр хороог ахалж ажиллаж үзлээ. Нийтийн хяналтын сонсголыг ахалж ажиллалаа. Энэ бүгдээс харахад аудитын дүгнэлт нэлээн сүрхий гарч байгаа. Олон чухал чухал зөвлөмжүүдийг өгч байгаа. Мөн түр хороо ахлаад ажиллахлаар экспертүүд буюу шинжээч нараа бид голдуу л Аудитын ерөнхий газраас авдаг. Тэндээс мэдээллүүдээ буцаагаад авдаг.

Тэгтэл гурван янзын тайлан бид одоо яг сонсоод сууж байна. Тийм ээ. Аудитын газрын, Засгийн газрын, Их Хурлын Хяналт шинжилгээний газрын гэсэн гурван газрын тайлан. Гурвуулаа дотроо өөр өөр дүгнэлттэй. Аль тоонд нь итгэх юм бэ?

Гурван хяналтын байгууллага гурвуулаа энэ тооны ард байгаа баримтуудынхаа талаар хэлээрэй. Тухайлбал, би зүгээр ганцхан жишээ хэлмээр байгаа байхгүй юу.

Улсын Их Хурлын Тамгын газрын дүгнэлтэд 3.3 дээр 12 төсөл арга хэмжээнээс үр дүнтэй буюу 100 хувь үнэлэгдсэн нэг ч төсөл, хөтөлбөр байхгүй гээд өвчлөл, нас баралтыг бууруулна гэсэн ажлын 12 төслийг дүгнэсэн байх жишээтэй.

Тэгтэл аудитын газрын дүгнэлт нь 12-т 3.3 өвчлөл, нас баралтыг бууруулна гэсэн дотор 10 мянган хүн амд ногдох халдварт өвчний тоо. Энэ дээр 100 хувь биелэлттэй гэх.

Тэгэхээр эдгээр хяналтын байгууллагын тоо баримтууд хоорондоо яагаад уялдаж өгөхгүй байна аа? Тэгэхээр эх сурвалжууд нь юу байдаг юм бэ? Үүнийг тодруулж өгөөч.

Гурав дахь нь, дотоодод худалдаж байгаа эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ гэсэн төлөвлөгөөг 100 хувь гэж аудитаас дүгнэсэн байна. Ямар баримтыг үндэслэн энэхүү дүгнэлтийг гаргасан бэ? 100 хувь. Нэг ёсондоо Монгол Улсад чанартай эмийг 100 хувь болчихсон гэж үзэж байна шүү дээ. Тэгтэл би өнгөрсөн долоо хоногт Эмийн хяналт, үнэлгээний газар очиход бүхэл бүтэн Монгол Улсад ганцхан хийгддэг аппарат нь 2024 оны 10 сард тендерээ авсан нэртэй хүртэл ажиллагаанд ороогүй байж байх жишээтэй. Энэ дээр Эрүүл мэндийн яам хариулт өгнө үү?

Төгсгөлд нь. Нэмэлт минут яахаар үргэлжлүүлээд асууя.

Д.Амарбаясгалан: Аудит. Д.Загджав дарга хаачсан. Хэн хариулт өгөх гэж байна? Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон. Энэ Д.Загджав дарга хаана байна? Үндэсний аудитын газар Гүйцэтгэлийн аудитын газрын дарга Д.Энхболд. Ж.Чинбүрэн гишүүний асуултад хариулъя.

Аудитын үнэлгээ болон хяналт хийж байгаа байгууллагуудын үнэлгээнүүдийн хоорондын зөрүүтэй холбоотой асуултыг асуусан.

Тэгэхээр Үндэсний аудитын газар...

Д.Амарбаясгалан: Хариул. Энэ Д.Загджав даргыг дуудаарай. Одоо энэ асуултад хариул.

Д.Энхболд: Үндэсний аудитын газар бол 02 сарын 15-нд Засгийн газраас...

Д.Амарбаясгалан: За хариул.

Д.Энхболд: Үндэсний аудитын газраас 02 сарын 15-нд Засгийн газраас мэдээллийг аваад Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний системд нь цугларсан мэдээллийг нотлох баримттай нь тулгаж, хэрэгжилтийг гаргадаг.

Тэгэхээр нийтдээ төлөвлөлтийн хэд хэдэн алдаа байна гэдгийг Үндэсний аудитын газраас дүгнэсэн. 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд хөгжлийн бодлого, төлөвлөлт болон таван жилийн үндсэн чиглэл, 2024 оны төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг тулгахад нийт 234 арга хэмжээнээс үндсэн чиглэлд тусгагдсан 200 арга хэмжээ 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байсан.

Мөн Үндсэн чиглэлд 243 арга хэмжээнээс 108 нь хүрэх түвшин тодорхойгүй, хэрхэн хэмжих нь тодорхойгүй асуудлууд байсан учраас төлөвлөлтийн алдаатай асуудлууд дээр хариуцлага тооцох шаардлагатай. Үүний эрх зүйн орчныг нь нарийвчилж өгөх зөвлөмжийг Улсын Их Хуралд толилуулсан.

Ер нь цаашдаа хяналтын тогтолцоонуудын нэг анхаарах асуудал бол төсвийн ерөнхийлөн захирагчаас авхуулаад Үндэсний аудитын газар болон Улсын Их Хурал хяналт шалгалтын гээд 5, 6 хяналтын үе шат байна. Эд нарын зохистой хяналтыг хэрэгжүүлэхийн тулд төлөвлөлтийн өмнөх хяналтыг илүү их анхаармаар байна. Тэгэхгүй бол саяын 5 үнэлгээ гаргасан байгууллагууд тавуулаа үйл ажиллагаа, арга хэмжээ хэрэгжсэний дараа буюу үйл явц өнгөрсний дараа үнэлгээ, дүгнэлтээ өгч байна.

Тэгэхээр төлөвлөлтийн алдаатай бодлогыг төлөвлөлтийн үед нь батлагдахаас нь өмнө тэрийг нь зогсоодог ийм эрх зүйн орчин, хэрэгжилтийг дууссаны дараа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофоныг нэмж өгье. Жоохон тодорхой ярья.

Д.Энхболд: Тэгэхээр эрх зүйн энэ нарийвчилсан зохицуулалтуудыг нь тодорхой болгож өгөөч ээ гэдэг ийм асуудлыг ярих гэж байгаа юм.

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаа тохиолдолд Төрийн аудитын тухай хууль дээр илүү сахилгын шийтгэлүүдийг болон ямар арга хэмжээг хэрэгжүүлээгүй, ямар кэйс дээр ямар арга хэмжээ авах юм бэ гэдгийг нь эрх зүйн зохицуулалтыг нь нарийн тодорхой болгож өгөх шаардлага байна гэдэг ийм дүгнэлтүүдийг аудитын байгууллагаас хийсэн байгаа.

Тэр Ж.Чинбүрэн гишүүний түрүүний асуусан эмийн хангамж, чанар хангалттай түвшинд хүрчихсэн болоод 100 гэж үнэлсэн үү гэдэг дээр тухайн онд 2024 оны жилийн төлөвлөгөөн дээр “эмийн чанарын хяналтыг хэрэгжүүлэх системийг бий болгоно” гэдэг дотор нь дэд арга хэмжээ байсан. Тэр системийг бий болгочихсон байсан учраас тухайн арга хэмжээг нь хэрэгжсэн гэж Үндэсний аудитын газраас үзсэн. Түүнээс бүхэлд нь тэр зорилтыг бол 100 хувь хэрэгжсэн гэж үнэлээгүй байгаа шүү гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Байз. Энэ Ч.Өнөрбаяр дарга энэ асуудал дээр ер нь Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас төлөвлөлт, тайлагналт, гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг нэг болгох тал дээр ямар арга хэмжээ авах вэ? Цаашид.

Өнгөрсөн жил ч гэсэн яг энэ асуудал ингээд л төлөвлөж байгаа нь бас учир дутагдалтай байна. Гүйцэтгэл хийгээд, үр дүн гараад тайлагнаж байгаа нь бас учир дутагдалтай. Төлөвлөгөө гүйцэтгэл хоёрыг харьцуулаад үзэхэд ер нь 30 гаруй хувийн гүйцэтгэлтэй явж байна.

Тэгэхээр төлөвлөлтөө их буруу хийж байна гэдэг асуудал байнга л хөндөгдөөд байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ дээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар энэ удаагийн үндсэн чиглэл хэлэлцэх, тайлан хэлэлцэж байгаа үе дээр ямар чиглэл өгөх юм. Цаашдаа дараа жил ахиад ийм нөхцөл давтагдахгүй байх тал дээр яаж анхаарах юм. Энэ дээр танай газрын зүгээс ямар байр суурьтай байна? Нэг мэдээлэл өгөөдөхье. Тийм ээ. Ажлын хэсгийн 11 дүгээр микрофон.

Ч.Өнөрбаяр: Улсын Их Хурлын даргын асуултад хариулъя.

Ер нь манай газар үнэлэхдээ 2020 оны Засгийн газрын 206 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу үнэлдэг. Ингэж үнэлэхийн тулд салбарын яамд өөрсдийнхөө жилийн тайланг нотлох баримтын хамт цахимаар ирүүлээд энэ дээр нь энэ аргачлалын дагуу үнэлдэг.

Гэхдээ яг Д.Амарбаясгалан даргын хэлж байгаа шиг энэ үнэлж байгаа аргачлал, шалгуур нь болохгүй байгаад байгаа юм. Хоорондоо зөрүүтэй байдаг. Эдийн засаг, хөгжлийн яам яаж төлөвлөж байгааг Сангийн яам, бусад яам харах боломжгүй. Сангийн яамны хэрхэн төсөвлөж байгаа бодлогыг нь бусад нь мэдэх боломжгүй уялдаагүй явж ирсэн.

Тийм учраас Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас 3 цогц журмын төслийг боловсруулаад Засгийн газрын хуралдаанд батлуулсан. Тэгээд одоо энэ журмууд хараахан албажиж амжаагүй байна. Удахгүй албажаад энэ оны 5 дугаар сарын 01-нээс эхлээд хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Энэ журам батлагдсантай холбоотой бид бүх яамд, тайлан гаргадаг, үнэлгээ хийлгэдэг төрийн захиргааны байгууллагуудад нэгдсэн ардчилалтай холбоотой мэдээлэл өгнө.

Ер нь журам батлагдахаас өмнө бид бүх шатын яаманд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт журмын дагуу сургалтууд хийсэн байгаа. Тэгээд энэ 3 журам гарсны дараа таны хэлээд байгаа үр дүнтэй төсөвлөдөг, төлөвлөдөг, үүний гүйцэтгэлийг нь хянадаг энэ юм руу Монгол Улс ахиц дэвшил гарна гэж харж байгаа.

Бас нэг юм бол хуулийн нэг доголдол байгаа. Улсын төлөвлөлтийн тухай хууль дээр таван жилээр гээд урт хугацааны бодлогын баримт бичгийг үнэлнэ гэчихсэн хэрнээ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар 10 жил ч гэдэг юм уу ингээд хуулиудын бас зарим нэг тайлан сонсохтой, хэлэлцэхтэй холбоотой цаглаврын зөрүү байгаа. Энэ дээр шаардлагатай хууль тогтоомжийг боловсруулаад Улсын Их Хурлаар нэн даруй батлуулах шаардлагатай байгаа гэж харж байгаа.

Тэгээд энэ 3 журам ямар ч байсан хэрэгжээд ирэх юм бол таны яриад байгаа асуудлууд ирэх жил хүндрэл үүсэхгүй байх нөхцөл рүү явна.

Нөгөө DM_[Design, Monitoring] гэж яриад байгаа. Үр дүнтэй “төсөвлөдөг”, “төлөвлөдөг”, “тайлагнадаг” тогтолцоог Засгийн газар хийх бололцоотой гэж харж байгаа.

Одоогийн байгаа 206 дугаар журам буюу үнэлж байгаа журмаар үүнийг хийх ямар ч бололцоо байхгүй.

Мөн Үндэсний аудитын газар энэ журмын үнэлдэг. Энэ журам албажсаны дараа ирэх жил Үндэсний аудитын газар энэ шинэ 3 журмын дагуу нотлох баримт дээр нь суурилаад үнэлдэг байдлаар тайланг оруулж ирнэ л гэж ойлгож байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энэ аудитын байгууллагаас гаргасан дүгнэлттэй холбогдуулж хариуцлагын асуудлыг ер нь Засгийн газрын түвшинд яаж авч

хэрэгжүүлэх юм бэ? Сая аудитын байгууллага бид хуулиар олгогдсон чиг үүргийнхээ хүрээнд үнэлэлт, дүгнэлтийг өгч байна.

Тэгэхээр захиргааны хариуцлагын асуудлуудыг ярих шаардлага байна гэдэг асуудлыг хөндөж байгаа шүү дээ. Энэ бас л жил болгон л хөндөгдөөд байгаа асуудал. Энэ дээр Н.Учрал сайд хариулах уу? Хэрэг эрхлэх газрын дарга. Н.Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Засгийн газар дээр хяналт хэрэгжүүлэх чиглэлээр үнэлгээний аргачлалаа баталсан байгаа. Тэр үнэлгээний аргачлалын дагуу төрийн байгууллагууд өөр өөрсдөө яг тэр аргачлалынхаа дагуу үнэлгээгээ хийж байгаа.

Тэгээд үнэлгээгээрээ хяналт хэрэгжүүлэх газрын зүгээс тухайн өөрийгөө үнэлсэн тэр тухайн төрийн байгууллагын үнэлгээ нь тэр аргачлалын дагуу зөв байна уу гэдэг дээр дахиад үнэлгээ өгдөг. Үүн дээр нь Үндэсний аудитын байгууллага төрийн хяналт шалгалтын хуулийнхаа дагуу аудитын байгууллага хөндлөнгийн үнэлгээг өгч байгаа.

Тэгэхээр эдгээр үнэлгээнүүдэд үндэслээд хариуцлага тооцох асуудлыг жил болгон ярьдаг. Үүний дагуу бид нэгдсэн үнэлгээнүүдийг Засгийн газарт орж танилцуулаад холбогдох арга хэмжээнүүдийг авна, хариуцлага тооцно доо л гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Эдийн засаг, хөгжлийн яам. Л.Гантөмөр сайд хариулах уу? Төлөвлөлттэй холбоотой асуудал дээр. Сая тэр Ж.Чинбүрэн гишүүний асуусан эрүүл мэндийн салбартай холбоотой асуудал дээр.

Л.Гантөмөр: Тийм.

Тэгэхээр Ж.Чинбүрэн гишүүний хэлж байгаа тэр 3 төрлийн бичиг баримт дээр бид дүн шинжилгээ хийгээд, хэлэлцүүлгээ хийж байгаа гэдгээ бид мартаж болохгүй. Таван жилийн өмнөх үндсэн чиглэлийн төлөвлөлтийг тухайн үеийн агентлаг хийсэн гэж би ойлгож байгаа. Баталсан нь тухайн үеийн Их Хурал баталсан гэж ойлгож байгаа. Энэ үед Эдийн засаг, хөгжлийн яам байгаагүй гэдгийг одоо энд байгаа бүх гишүүд мэдэж байгаа байх.

Тийм учраас аудит тухайн үеийн төлөвлөлт дээр тухайн яам алдаа гаргасан энэ тэр гэж ингэж худлаа ярихаа болих хэрэгтэй.

Мэдээж таван жилийн төлөвлөлтөд орсон арга хэмжээ, үндсэн чиглэлд тусгачихсан ажлуудыг тодорхой хугацааны дараа хаяж орхигдуулдаг юм байна.

61 ажлыг явцын дунд гээсэн, орхисон. Арван хэдэн ажлыг бүр хийгээгүй. Би зүгээр Их Хурлын гишүүд хариуцлага нэхэхдээ энэ арван хэдэн ажлыг санаатайгаар хэн хийгээгүй вэ гэдэг эзнийг ол гэдэг даалгаврыг өгөөд байна л гэж харж байгаа.

- ▶ Жишээлбэл, Тавантолгойн цахилгаан станц. Яагаад барьдаггүй юм.
- ▶ Жишээлбэл, Багануурын цахилгаан станц.
- ▶ Жишээлбэл, Дарханы арьс ширний цогцолбор.

Үгүй ээ, одоо яах юм тэгээд.

Тэгэхээр хууль дээр үүнийг хийгээгүй тохиолдолд хэнд хариуцлага хүлээлгэх вэ гэдгийг тодорхой хэлчихсэн. Хэдэн хувьтай байвал хэрхэн хариуцлага хүлээлгэх вэ гэдэг нарийн журам нь алга байна.

Би яамныхнаасаа асуугаад байгаа юм.

▶ Үүнийг хийгээгүй яамны Төрийн нарийнд ямар хариуцлага хүлээлгэдэг юм. Бүү мэд.

▶ Төрийг хийгээгүй газрын даргад ямар хариуцлага хүлээлгэдэг юм. Бүү мэд.

Үүний дундуур жинхэнэ алга болж байгаа хүмүүс бол агентлагийн дарга нар. Бүр журамдаа хэрхэн хариуцлага хүлээх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тийм. Одоо тэгээд энэ төлөвлөж байгаа арга хэлбэр дээрээ их анхаарахгүй бол яг дараа жил хэдүүлээ бас яг адилхан ийм хэрүүл хийгээд сууж байх болчихоод байна л даа.

Одоо жишээлбэл сая Л.Гантөмөр даргын хэлж байгаа агентлагийн даргатай холбоотой буюу Засгийн газрын дотоод бүтэцтэй холбоотой асуудал дээр хяналт тавих чиг үүрэг чинь өөрөө Засгийн газрын тухай хуулиараа Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт шууд оноогдож байгаа шүү дээ.

Тэр битгий хэл Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын тайланг бид Улсын Их Хурал дээр хэлэлцээд сууж байх шаардлагагүй байгаа юм. Ер нь бол. Тэр дотооддоо өөрсдийн үйл ажиллагаа, үр дүн, хариуцлагыг ярилцаж байх ёстой субъектийн хувьд тэнд.

Харин энэ аудитын байгууллагын дүгнэлтийг бид Улсын Их Хурлын яг хяналт гэдэг агуулга дотор авч энэ хяналтаа Улсын Их Хуралд тавьж байгаа чиг үүргээ гүйцэтгэх хүрээндээ авч үздэг болох хэрэгтэй.

Тэгэхээр бид энэ төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, тайлантай холбоотой арга барилууд дээр одоо харин өнөөдөр сайн ярилцаад ямар хэлбэрээр явах вэ гэдгээ нэгдсэн нэг ойлголтод хүрээд.

Түрүүн Ч.Өнөрбаяр даргын хэлж байгаачлан шаардлагатай хуулиудад өөрчлөлт оруулаад, ирэх жил бүх зүйл ойлгомжтой л болмоор байгаа юм.

Баахан арга хэмжээ төлөвлөчихдөг. Нөгөөдхийгөө хийж гүйцэтгэдэггүй. Ахиад Засгийн газраас төлөвлөгөө оруулаад ирэнгүүт Улсын Их Хурал дээр гишүүдийн гаргасан маш олон санал төлөвлөгөөнд нэмж тусгагддаг. Эргээд гүйцэтгэл үр дүнгүй болоод ирэхээр гишүүдийн гаргасан санал шүү дээ гэдэг хариултыг өгчихдөг.

Тэгэхээр энэ байдлыг л бүгдийг нь нэг цэгцэд оруулахын тулд Эдийн засаг, хөгжлийн яам илүү санаачилгатай ажиллах шаардлагатай гэж үзээд байгаа юм.

Т.Мөнхсайхан сайд нэмж хариулт өгье.

Т.Мөнхсайхан: Ж.Чинбүрэн гишүүн ер нь дундаж наслалтын асуудлыг хөндөж ярьж байна.

Тэгээд улс эх орны хувьд дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд амаргүй. Энд төрөлтийн тоо нөлөөлж байгаа. Гэхдээ манай улсын хувьд төрөлт сүүлийн жилүүдэд жил ирэх тусам нэмэгдэж байгаа. Сүүлийн 5 жилийн хугацаанд 20 орчим хувиар төрөлт буурсан ийм зүйл байгаа. Энэ бол ер нь 1990 оноос 2005 оныг хүртэлх төрөх нас насны эмэгтэйчүүдийн тоо буурсан нь нэг номерын шалтгаан нь болж байгаа.

Бид таны ярьж байгаа нярайн эндэгдэл дээр ямар нэгэн ач холбогдол өгөхгүй байгаа зүйл огтоосоо байхгүй. Бид төрөлт буурч байгаа энэ цаг үед нярайн эндэгдлийг бууруулах, төрж байгаа нярайг илүү их чанартай амьдрах баталгааг бий болгох тал дээр бодлого.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ж.Чинбүрэн гишүүн тодруулж асууя.

Ж.Чинбүрэн: Хариултыг ингэж өгмөөргүй байна.

Эдийн засгийн яам жишээлбэл Эрүүл мэндийн яам ийм ийм бодлогын асуудал оруулж ирээд тэдийг нь би хассан юм гэдгээ л хэлчихмээр байна шүү дээ.

Эрүүл мэндийн яам нь би ийм ийм бодлого оруулсан чинь ингээд Эдийн засгийн яаман дээр хасагдсан юм.

Одоо бид 2026-2030 оны дунд хугацааны төлөвлөгөө хийх гээд байж байна шүү дээ. Энэ дотор чинь эрүүл мэндийн чухал чухал үзүүлэлтүүд буюу

► их нярайн эндэгдэл,

- дундаж наслалт,
- хүн амын тоо,
- дээрээс нь халдварт өвчин.

Дэлхий даяараа 2030 он гэхэд “умайн хүзүүн хавдаргүй” болох гээд байна, “сүрьеэгүй” болох гээд байна. Тэгтэл бид ямар байдалтай байгаа юм.

Яагаад энэ тоонуудаа тодорхой үзүүлэлтээр оруулж өгөхгүй байгаа юм бэ? Энэ асуудлыг л яриад байна шүү дээ.

Тийм учраас төлөвлөлтдөө энэ ажлаа үнэлүүлэх юмандаа бодитой тоо оруулж өгдөг баймаар байна.

Д.Амарбаясгалан даргатай би бас яг санал нэг байна. Ер нь бид энэ төрийн аудитын байгууллагаа хүчжүүлэхгүй бол олон баахан хяналтын байгууллагууд байгаад байна.

Одоо би нэг асуулттай дутуу авчихлаа. Их Хурлын Тамгын газраас тэр нас баралтын үйл ажиллагаа, нас баралт бууруулах чиглэлд “0” үнэлгээтэй ажилласан гэж байна. Үүний тайлбарыг би авчихмаар байна.

Ж.Бат-Эрдэнэ: Их Хурлын Тамгын газраас Тамгын газрын Дэд дарга Ү.Амарбат. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Ү.Амарбат: Гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Ж.Чинбүрэн гишүүний асуултад хариулъя.

2024 оны хөгжлийн төлөвлөлтийн 3.3-д өвчлөл, нас баралтыг бууруулна гэдэг энэ зорилтыг Засгийн газрын өөрийн хийж оруулж ирсэн үнэлгээг “тэг” болгож бууруулсан шалтгаан нь зорилт маань өөрөө зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин 10 мянган хүн тутамд 32 байгааг зорилтот түвшнээр 26 болж бууруулна гэдэг ийм зорилтыг тавьсан. Жилийн эцсийн дүнгээр энэ нь зорилтот түвшиндээ хүрэх биш 38.4 болж өссөн ийм үзүүлэлттэй байгаа. Өөрөөр хэлбэл үнэлгээгээр зорилтот түвшин нь буурах ёстой байтал өссөн байгаа.

Тэгэхээр үр дүнгийн үнэлгээгээр харахад энэ бол өөрөө “тэг” хувьтай байна гэдэг энэ дүн шинжилгээг Улсын Их Хурлын Тамгын газраас хийж оруулсан байгаа.

Их Хурлын Тамгын газрын хийж байгаа дүн шинжилгээ нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье.

Ү.Амарбат: Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заагдсанаар Улсын Их Хурлын Тамгын газраас хийж байгаа дүн шинжилгээ нь өөрөө үйл ажиллагааг биш илүү үр дүнг үнэлнэ гэдэг ийм зохицуулалттай учраас үр дүнгээрээ зорилтот түвшиндээ хүрээгүй байна гэдэг ийм агуулгаар “тэг” үнэлгээ өгсөн байгаа.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя. Үг хэлье.

Ө.Шижир: Бид нэг асуусан болоод ажлын хэсэг нэг хариулсан болоод. Энэ маш чухал гурван хөтөлбөрт дүгнэлт хэлэлцээд дуусах нь л дээ. Харамсалтай байна.

Ер нь төрийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын хамаарал, ажлын уялдаа холбоо нь ямар байгаа юм эндээс харж байгаа.

▷ Төрийн байгууллагууд хоорондоо “харилцан ажиллах санамж гэрээ” зурдаг болсон. Ямар ч утгатай юм.

▷ Төрийн байгууллагууд хоорондоо бие биеийнхээ “үйл ажиллагааг дэмжих хамтын ажиллагааны гэрээ” зурдаг болсон. Энэ бас ямар ч учиртай юм.

Одоо ингээд аудитын байгууллагын өгч байгаа хариулт, гишүүдийн асууж байгаа асуулт газар тэнгэр шиг хоёр өөр юм явж байна шүү дээ. Тэгээд энэ дээр бид ямар нэгэн асуудал ярих ёстой юм биш үү.

Ер нь Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар гээд яам байгаа. Их Хурлын Тамгын газар гээд Тамгын газраас яг хоёулаа адилхан Монгол Улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолоор яг адилхан дүгнэлт хийдэг мөртлөө хоёр өөр газар тэнгэр шиг дүгнэлтүүд хийчихсэн байна.

Сая заримыг нь Ж.Чинбүрэн гишүүн ярьж байна. Би заримыг нь уншиж өгье.

▷ “Амьдралын чанар ба дундаж давхарга” гэдэг хэсэг дээр “Нийгмийн халамж зорилтот бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээ ил тод, нээлттэй, чирэгдэлгүй болно.” гэдгийг нь:

▶ Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас **90 хувь** гээд дүгнэчихсэн.

▶ Улсын Их Хурлын Тамгын газраас **30 хувь** гээд дүгнэчихсэн.

▷ “Залуучууд бизнес эрхлэх зорилгоор хүргэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.”

▶ Засгийн газраас **90 хувь**,

► Их Хурлаас **30 хувь**.

▷ “Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй нэг хэсэг болгоно.”

► Засгийн газар **100 хувь**,

► Их Хурал **90 хувь**.

Ингээд дүгнэчихсэн.

Дахиад энэ дээр одоо жишээ нь “Төрийн бүтээмжийг дээшлүүлнэ” гээд. Үүнийгээ **100 хувь** гээд дүгнэчихсэн. Гэтэл өнөөдөр төрийн бүтээмжтэй ажиллаж чадаж байна уу гэдэг асуудал байна.

Төрийн өмчит компаниудын 5-хан хувь нь ашигтай ажилласан.

Эрчим хүч дээр “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг үр ашигтай ажиллуулна” гээд заачихсан. Бас 100 хувь гээд дүгнэчихсэн.

Тэгээд эд нар үнэхээр 100 хувь ажиллаад, 100 хувь гээд дүгнээд байгаа юм уу? Тийм бол “тийм” гэж хэлээд, үгүй бол “үгүй” гэж нэг хэлээдхээч. Засгийн газраас болон Их Хурлаас.

Мөн “Төрийн байгууллагуудын чиг үүргийг оновчтой болгоно” гээд заачихсан. Одоо жишээ нь өнөөдөр зөвхөн эрчим хүчтэй холбоотой гэхэд 3 бүтэц ажиллаж байна. Төрийн бүтэц.

► Эрчим хүчний яам;

► Эрчим хүчний зохицуулах хороо;

► Эрчим хүчний Үндэсний хороо гээд бүгдээрээ чиг үүрэг нь давхацчихсан.

Яаман дээрээ бүгдийг нь бөөгнүүлээд хэлэлцээд явчхаж болохгүй байгаа юм уу?

Тэгэхээр энэ дээр Улсын Их Хурлаас, Засгийн газраас яагаад яг адилхан дүгнэлтээр дүгнэж байж ийм газар тэнгэр шиг хоёр өөр дүгнэлтүүд хийгээд байгаа юм бэ гэдгийг би Улсын Их Хурлаас болон Засгийн газраас асуумаар байгаа юм.

Яг үнэхээр 100 хувь байгаа бол 100 хувь гэдгийг чинь хүлээн зөвшөөрье. Ийм ийм гээд хэлээдэх. Хоёр өөр байгаагаа хоёр өөрөөр тайлбарлаадхаач. Нэг бол хуулиа хоёр өөрөөр ойлгоод байдаг юм уу? Дүгнэхдээ хоёр өөрөөр дүгнээд байдаг юм уу?

Тэгэхээр энэ дээр Засгийн газраас болон Улсын Их Хурлын Тамгын газраас хариулт өгөөч. Яагаад яг адилхан 206 дугаар тогтоолоор дүгнэж байж дүгнэлтүүд чинь хоорондоо газар тэнгэр шиг зөрөөтэй байгаа юм бэ?

Д.Амарбаясгалан: Л.Гантөмөр дарга хариулт өгье.

Л.Гантөмөр: Яах вэ, ер нь манай хуулиудын уялдаа холбооны алдаа дутагдал энэ дээр гараад байгаа юм л даа. Жишээлбэл, бид өнөөдөр хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүнийхээ хэрэгжилтийг ярьж байгаа бол яг энэ бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиа л баримаар байхгүй юу. Яг энэ хуулиа баримаар байгаа юм. Их Хурлын дарга аа.

Тэгээд энэ хуулийг барихаар энэ хууль дээр жишээлбэл “Тамгын газар дүн шинжилгээ хийнэ” гэдэг зүйл энд байхгүй.

Тэгээд Тамгын газар яаж дүн шинжилгээ хийсэн юм бэ гээд сая асуухаар Тамгын газрын дарга бол тэнд юу гэж хариулж байгаа вэ гэхээр Засгийн газраас баталсан 206 дугаар тогтоолоор батлагдсан энэ журмыг чинь бид ашиглаагүй гэж байгаа юм.

Бид хүрсэн үр дүнг шууд утгаар нь үнэлгээндээ авсан гэж байгаа юм.

Нэг үгээр хэлбэл нэг журам барихгүйгээр өөр өөр байдлаар үнэлэх юм бол өөр өөр үнэлгээ гарна. Тэр бол ойлгомжтой.

Тийм учраас хөгжлийн бодлого, төлөвлөлт дунд байна уу, урт байна уу аль ч тохиолдолд гүйцэтгэл болоод төлөвлөлт ярихдаа энэ хуулиа л хэдүүлээ барья. Тэгэхгүй бол Тамгын газрын хууль, Их Хурлын хууль, өөр ямар ч байдаг юм Хяналтын хууль гээд өөр юм бариад явчихаар дүгнэлтүүд нь өөр өөр гараад байна. Үүнийг тал талдаа ойлгоод, тэгээд энэ журам нь алдаа байна гэж Ч.Өнөрбаяр сая хэлж байна шүү дээ.

Тийм учраас бид энэ журмаа өөрчилсөн гэж байна. Журам хаана алдаа байна вэ гэхээр тодорхой хувь дээр хувь хүний оролцоо ороод байна.

- Зүүний үзэлтэй хүн нэг өөр дүгнэлт хийхээр байна.
- Барууны үзэлтэй хүн бас өөр дүгнэлт хийхээр байна.
- Мэргэжлээсээ хамаараад бүр өөр дүгнэлт хийгээд байна.

Жишээлбэл,

Хууль талын мэргэжлийн хүн дүгнэх юм бол өөр дүгнэнэ. Эрүүл мэндийн салбарыг.

Ж.Чинбүрэн гишүүн дүгнэх юм бол шал өөр дүгнэхээр байгаа байхгүй юу. Нэг үгээр хэлбэл Ж.Чинбүрэн гишүүний хэлж байгаа бүх санаа бол зөв байхгүй

юу даа. Гэтэл хууль, журам хоёр нь хуульчид, эдийн засагчид асуудлыг дүгнэхээр арай өөр тоо гараад байна.

Тийм учраас Та бүхэн гурван өөр дүн дээр битгий төөрөөчээ гэж хүсмээр байна.

Ерөнхийдөө нөхцөл байдал ямар он жилүүдийг давж гараад өнөөдөр бид энэ тоог ярьж байгаа вэ. Яагаад бид хамтарсан Засгийн газар байгуулсан бэ. Тэгээд өнөөдөр бид амьдрал муу байна, хэцүү байна гээд. Үүнийг чинь мэдэж байгаа учраас хэдүүлээ үүнийгээ засъя гээд урагшаа алхаж байгаа.

Тийм учраас хяналт шинжилгээ, үнэлгээ дээр би гишүүдийн ярьж байгааг зөв гэж бодож байгаа. Хамгийн гол нь нэгдсэн платформ хэрэгтэй. Нэгдсэн платформыг одоо бид угсрах гэж байна. Угсрах гэж байна. Олон улсын аргачлал хэрэгтэй. Олон улсын аргачлал руугаа одоо шилжих гэж байна. Тэгэхдээ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Их Хурлын Тамгын газар. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон хариулт өгье.

Ү.Амарбат: Ө.Шижир гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Засгийн газраас 2020 оны 206 дугаар тогтоолд ямар зорилтыг яаж үнэлэх тухай маш тодорхой заасан байгаа. Тухайлбал,

- ▶ шалгуур үзүүлэлт тодорхой,
- ▶ суурь түвшин тодорхой,
- ▶ хүрсэн түвшин тодорхой байвал үүнийг үнэлэхдээ томъёогоороо бодно.

206 дугаар тогтоолынхоо хавсралтад заасан журамдаа байгаа.

Гэтэл Ө.Шижир гишүүний асуудаг “нийгмийн халамж зорилтот бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээ ил тод, нээлттэй, чирэгдэлгүй болно” гэдэг маань өөрөө шалгуур үзүүлэлттэй, суурь түвшинтэй, хүрэх түвшинтэй байгаа юм.

Тэгэхээр үүнийг томъёоллоороо бодох ёстой.

Гэтэл Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас үнэлгээ хийхдээ чанарын үнэлгээ хийгээд 90 хувьтай гэж оруулж ирсэн. Үүнийг нь яг журамд нь заасны дагуу томъёоллоор нь бодохоор 30 хувьтай болж гарч ирж байгаа. Ингээд энэ нь томъёоныхоо дагуу 30 хувь байна гэдгийг илэрхийлж, 90 байгааг 30 болгож оруулсан байгаа.

Өөрөөр хэлбэл 206 дугаар.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ө.Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Яах вэ, үүнийг л хэлээд байгаа юм л даа. Төрийн байгууллагууд бие биедээ 100 дүгнэдэг, бие биеэ шалгасан болдог, онц тавьдаг.

Тэгээд яг бодит амьдрал дээрээ тэр нь хэзээ ч нийцдэггүй. Бие биедээ онц дүн тавиад хэдэн биеэ магтаад яваад байдаг байж болохгүй л дээ. Ийм байдалтай бид маш олон жил явсан учраас өнөөдөр яг ийм гурван өөр дүгнэлт яриад, гурван өөр хэрүүл хийгээд сууж байгаа байхгүй юу.

Асуусан асуултад нь маш бөөрөнхийгөөр тойруулж хариулдаг. Би маш тодорхой асуусан шүү дээ. Нийгмийн халамж тэгээд зорилт бүлэгтээ хүрээд ил тод ялгалгүй болчихсон юм уу? Тийм бол “тийм”, үгүй бол “үгүй”. Тийм болсон юм бол “тийм” гээд хэлчих. Үгүй болсон бол “үгүй” гээд хэлчих.

Тэгээд бид шал буруу дүгнэлт гаргаж ирчхээд юуг юугаар хэмжих гээд байгаа нь ойлгомжгүй очоод ингээд бөөн хэрүүл хийгээд сууж байгаа байхгүй юу.

Тэгэхээр дахиад тэр “цахилгааны найдвартай эх үүсвэр хангана.” 100 хувь гээд биччихсэн. Одоо бид цахилгааны хязгаарлалтгүй байгаа юм уу? Засгийн газраас асууя. 100 хувь байгаа юм уу? Тийм бол энэ 100 хувь гэдгээ нотлох хэрэгтэй шүү дээ. Тэгээд тэрийг нь бас дахиад Их Хурал нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Л.Гантөмөр дарга нэмж хариулъя.

Л.Гантөмөр: Манай гишүүдэд бас нэг буруу ойлголт байна.

Засгийн газар өөрөө өөрийнхөө ажлыг сайд нар дүгнээд байгаа юм байхгүй шүү дээ. Тэнд сууж байгаа залуу шиг манай яамны мэргэжилтнүүд дүгнэж байгаа шүү дээ. Хэрвээ ингээд нэг талд нь мэргэжлийн хүмүүс авчраад, нөгөө талд нь сайд нараас юм нэхээд байх юм бол энэ явахгүй шүү дээ.

Яаж байна вэ гэхээр аргачлалын хувьд жишээлбэл эрчим хүчний хангамжийг 100 хувь болгохын төлөө юу хийх вэ гээд төлөвлөсөн юм байна даа. Энэ хуулийн дагуу. Төлөвлөсөн юмныхаа бид ийм ийм ажил хийчихлээ гээд тайлан өгч байна шүү дээ. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Тэгэхээр Эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга яг энэ журмынхаа дагуу энэ хүн төлөвлөсөн ажлынхаа хэдэн хувийг хийсэн бэ гэдэг дүгнэлт гаргасан байна шүү дээ. Ө.Шижир гишүүн ээ. Үр дүн ярих юм бол маш хүнд байдалтай байгаа гэдгийг бид бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгэхээр энэ ялгаа байхгүй тэр Тамгын газар ажиллаж байгаа залуучууд, энэ аудитад ажиллаж байгаа залуучууд, тэр яаман дээр ажиллаж байгаа

залуучуудыг одоо бид дуудаж авчраад хооронд нь мэтгэлцүүлэх гээд байх шаардлага байна уу гэдгийг л гишүүд маань бодоочээ гэж байхгүй юу.

Зүгээр Их Хурал бол энэ хууль чинь зөв байна уу, Их Хурал өөрөө энэ журмаа гаргах уу, нэгдсэн бодлого руу явах уу гэдгээ хэдүүлээ энэ дээр Их Хурлын даргын хэлж байгаагаар яг энэ дүгнэлт дээр үндэслэж дараагийн төлөвлөлт гарах ёстой гэдэг хуультай.

Тийм учраас энэ дүгнэлтээ их зөв гаргаад, дүгнэлт дээрээ суурилсан таван жилийн хөгжлийн үндсэн чиглэлээ хэдүүлээ гаргах л ийм л юм руу алхах нь зөв байх гэж бодож байгаа юм.

Түүнээс хөөрхий тэр Эдийн засгийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга, эсвэл Тамгын газрын нэг нөхөр, эсвэл тэр аудитын нэг дарга эд нарыг хооронд нь мэтгэлцүүлээд байх юм бол хэдүүлээ урагшаа алхахгүй байх аа.

Д.Амарбаясгалан: Тийм. Байнгын хороо, энэ дээр хоёр Байнгын хороо хамтарч хуралдаж асуудал ярьсан байж байгаа.

Тэгээд Л.Гантөмөр даргын яг ярьж байгаа энэ асуудлыг Байнгын хорооны түвшинд нэлээн нарийвчилж ярьж чадсан бол өнөөдөр бас Улсын Их Хурлаас тогтоол гаргаад баталж байх боломжтой л доо. Тодорхой хугацаатай үүрэг даалгаврыг өгөөд, эмхэлж цэгцлэхтэй холбоотой асуудлыг.

Харин одоо бид өнөөдөр ингээд Улсын Их Хурал дээр нээлттэй ярилцаад, асуулт хариултад асууж хариулаад өнгөрчихдөг. Эргээд тодорхой үүрэг чиглэл өгсөн тогтоол батлагдахгүй болохоор энэ бас л тийм учир дутагдалтай байдалтай л болох гээд байна. Зүгээр энэ дээр гишүүд өөрсдөө бас тодорхой саналуудаа бодитой хэлээд, шаардлагатай бол магадгүй өнөөдөр чуулганы дундуур Байнгын хороо эргэж хуралдаж, холбогдох тогтоолын төслийг санаачилж, эргэж Улсын Их Хурал дээр оруулж ирж батлуулж, үүрэг чиглэл өгөх бас боломжтой.

Тэгэхээр гишүүд энэ дээрээ бодож ажиллаарай гэдгийг хэлье.

Сонгобайн Замира гишүүн асуулт асууж үг хэлье.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Ингээд бидний хэдэн жил гарсан гээд баталсан төслүүд эхнээс нь сайн явж өгөхгүй, болохгүй байгаад байна л даа. Энэ ямар учиртай вэ гэдэг дээр бид нэг дүгнэлт хийх ёстой юм шиг байна.

Бид “Алсын хараа-2050” гээд 14 мега төсөл, 36 том төсөл гээд энэ бүхнийг хэрэгжүүлэхийн төлөө бид яах ёстой юм.

Монгол Улс одоогийн тогтолцоогоо эргэж харах нь зүйтэй. Энэ тогтолцоогоор цаашаа явахгүй юм шиг байна шүү дээ. Яам, Тамгын газрууд болгонд байдаг аудитын газар гээд. Тэд нар яг бодитойгоор яг өөрөө өөрсдийгөө шалгаж байна уу?

Ер нь өөрөө өөрсдийгөө яг бодитой шалгана гэж би бодохгүй байгаад байна. Энэ байгууллага бүрд байдаг аудитын газруудыг уг нь татан буулгах хэрэгтэй байх.

Тэгээд төр, засгаас хэчнээн сайн төсөл гарсан ч тэгээд дунд, доод шатад очоод энэ чинь хэрэгжүүлэх шатад очиж замхардаг. Энэ нь ямар учиртай гэхээр нь өнгөрсөн 30 жилд нам дагасан боловсон гишүүн бэлтгэгдсэнтэй шууд холбоотой юм болов уу.

Одоогоор яг яам, Тамгын газар, төрийн албан байгууллагуудыг шинэ боловсон гишүүнээр хангах, шинээр сургууль төгсөж ирсэн залуучуудыг дэмжин ажиллуулах ямар ч боломж байхгүй. Яагаад гэвэл хууль нь тийм батлагдсан. Хууль нь ямар учиртай хууль вэ гэхээр нь төрд ажиллах юм бол хоёр, гурван жилийн туршлагатай ажилласан тийм туршлагатай байна гэсэн нэг ганц юм энэ бүгдийг нь гацаагаад байгаад байдаг.

Тийм учраас энэ хуулийг бас нэг эргэж харах нь зүйтэй болов уу.

Одоо ингээд цахилгааны үнэ нэмээд бид үйлдвэр хөгжүүлнэ гээд сууж байна. Цахилгааны үнэ нэмэгдсэнээр манай Монгол Улсад үйлдвэр хөгжинө гэж бодохын ямар ч арга байхгүй. Яагаад гэвэл үйлдвэрээс гарсан бүх бүтээгдэхүүн нь маш үнэтэй гараад ирнэ гэсэн үг. Тэгээд урд, хойд хөршүүдээс орж ирсэн бараа тэрнээс хямд. Тэгээд бид өөрсдийгөө цахилгааны үнэ нэмснээр тэгээд бүх үйлдвэрийн замыг хааж байгаа гэж ойлгож болно.

Бас тэгээд энэ хувийн хэвслүүд ч үйл ажиллагаа явуулах боломжгүй. Ийм байдалтай байхад.

Бид улс орныг хөгжүүлэе гэвэл гадаадаас зээл авах биш, цахилгааны үнэ нэмэх биш, харин гадаадаас хөрөнгө оруулалт татах, дотоодын компаниудын үйл ажиллагааг сэргээх, ажилгүйдлийг арилгах тал дээр гол анхаарлаа хандуулах ёстой юм болов уу гэж би бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: С.Замира гишүүн үг хэллээ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлье.

П.Сайнзориг: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе.

Одоо уг нь нэлээн чухал асуудал хэлэлцээд байгаа юм. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг бид юун дээр алдаж, юун дээр онож байгаагаа

бас зөв дүгнэж чадвал ажлууд эрчимжинэ, урагшилна. Төсвийн гүйцэтгэлийг ч гэсэн бас яг энэ зарчмаар явах ёстой байгаа юм. Гэтэл ерөөсөө энэ гүйцэтгэлийг сонсох, тайланг сонсох дээр дандаа формалддаг иймэрхүү зүйлүүд байна. Төсвийн гүйцэтгэлийг л яг таг ярьж байж, нэлээн детальный ярьж байж ирэх жилийн төсвөө зөв боох байхгүй юу. Гэтэл бид энэ тайлагнах процессыг дандаа ингэж учир дутагдалтай ийм байдлаар хийж ирснээс болоод өнөөдөр чи би гэдэг зүйлүүд ингээд газар хавтгайрч байна.

Тэгэхээр үүнийг ерөнхийдөө бас нэг шинэ түвшинд гаргах, маш энгийн байлгамаар байна. Өөрөө өөрсдөө ойлгохгүй баахан ийм аргачлал гэдэг юм уу ийм зүйлүүдийг ярьдаг. Энгийнээр хүнд ойлгомжтой, иргэдэд ойлгомжтой тоон чанараа илэрхийлдэг баймаар.

Тэгээд монголчуудын хамгийн нэг ийм зүйл байгаа. Би монголчууд гээд ерөнхийд нь ярьчихлаа. Төр дээр очихоор тайлагнаж чаддаггүй юм. Ерөнхийдөө тайлагналтыг тоон болоод тодорхой үзүүлэлтээр гаргаж чадахгүй баахан хурал зөвлөгөөн хийлээ тэглээ, бүсийн чуулган хийлээ, ийм хурал, зөвлөгөөнийг 5 удаа хийлээ ч гэдэг юм уу. Ингээд энэ ажлуудыг ерөөсөө дүгнэх боломжгүйгээр ийм байдлаар тайлан ирдэг. Тайлан харахаар зузаан боловч түүн дээр ерөөсөө яг бодитой биш байна гэдэг зүйлийг манай явуулж байгаа тайлангуудыг олон улсын байгууллага дүгнэж байгаа шүү дээ. Бид хэд энэ юу гэдэг юм. FATF^[Financial Action Task Force] дээр ч гэсэн ийм алдаанууд гарч байсан. Ерөөсөө л энэ.

Тэгэхээр бид хэд энэ тайлагнах гэдэг асуудлыг формалддаг биш. Тэгээд энэ тал талын институцүүд хийдэг биш нэг зөв болгомоор байна.

Тэгээд өнөөдөр энэ тайлагналтын асуудлыг хуучин Хэрэг эрхлэх газрын даргаас бас чиглээд ерөнхийдөө асуудаг байсан. Одоо ингээд Хэрэг эрхлэх газрын дарга нь мэдэхгүй. Тэнд тусдаа сайдтай гэж байгаа юм. Тэгээд тэр байгууллага маань дөнгөж шинэ тутам бас нэг бэхжих гээд л үзээд байх шиг байна л даа. Тэгээд хаана хаанаа бас дутагдалтай юм байна.

Ийм зүйлүүд байгаа учраас үүнийгээ ер нь нэг цаашдаа бас нэг тодорхой болгоод, энэ сайд нарын чиг үүрэг энэ тэрийг ойлгомжтой болгоод, эсвэл тэр байгууллагаа бэхжүүлэх тал дээр нь дэмжээд ч юм уу ингээд нэг цэгцрэхгүй бол тэгээд ерөөсөө ингээд Л.Гантөмөр сайд болохоор аудитаа загнаад л. Та нар зүгээр буруу яриад байна шүү ч гэдэг юм уу ийм байдлаар иргэдэд энэ болж байгаа бүтэж байгаа юу гэдэг зүйлээр мэдээлэл өгөх бололцоогүй байгаа юм.

Тэгэхээр энэ дээрээ нэг анхаараач гэдэг зүйл байгаа.

Хоёрт, тодорхой хэдэн асуулт асууя. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт байгаа бүх зүйлийг бид. Энэ амчихгүй ээ.

Тэгэхээр энэ дундаас яг тодорхой салбар салбарын зүйлүүдийг идэвхжүүлэх, маш эрчимтэйгээр идэвхжүүл гэж ярья. Би. Ийм зүйлүүдийг бүр

онцгой салбарын сайдууд анхаараач. Жишээ нь, уул уурхайн эдийн засагтай, уул уурхайн бүтцийн орон шүү дээ. Уул уурхайн эдийн засагтай орон. Энэ чиглэлийн бодлогоо хаана яваад байгаа юм бэ? Баялгийн сан чинь амилах юм уу? Баялгийн сан гэхээр ганц нэг л компаниудын асуудлыг нэр заагаад л яриад байх юм. Бусад тэр стратегийн ордуудын асуудал чинь хэзээ яригдаж байгаа юм? Хэлэлцээр хийх гээд байгаа юм уу? Ер нь ямар байдалтай яваад байгаа юм. Би ерөөсөө энэ мэдээллийг ойлгохоо болилоо.

Тэгээд сайдаасаа даваад нэг нөхөр БЭТ гээд нэг чанга орилчхож байгаа юм. Жагсана ч гэх шиг. Тэгээд энэ орон зай дээр чинь ер нь Монгол Улсад хөрөнгө оруулах юм уу? Энэ ямар зүйл яваад байгаа юм бэ? Тэгэхээр аль сайд нь хариуцаад байгаа юм бэ? Тэгэхээр үүнийг нэг тодорхой бас хариулж өгөөч ээ.

Хоёрдугаарт, “ногоон эдийн засаг” гээд яриад байдаг боловч их зүгээр ийм моодны үг болгож л хэрэглээд байна.

Тэгэхээр үүнээсээ хэзээ гараад яг тодорхой бодитой зохицуулалттай төрийн бодлого гарч ирэх юм бэ? Манай яг бодлогын бичиг баримтуудаар тусгагдаад байгаа боловч яг үүнийг дэмжсэн үйл ажиллагаанууд хууль эрх зүйн талаасаа дутмаг байна.

Тэгэхээр цэвэр эрчим хүчний асуудлыг би бас яримаар байна. Газрын гүний дулааныг шийдэж чадвал энэ аймгийн төвүүд болон Улаанбаатар хотын бас энэ агаарын бохирдол, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж гараад байдаг. Гэтэл энэ хөрөнгө оруулалтыг татъя гэхээр газрын гүний дулааныг ашиглах хууль эрх зүйн орчин одоо хүртэл Монгол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Үндэсний баялгийн сангийн хуулийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг миний бие ахалж байгаа.

2007 онд Их Хурлын тогтоол гарсан. 15 стратегийн орд, нэмээд жилийн дараа 1 орд нэмсэн юм байна лээ.

Дахиад 39 стратегийн орд нь тэр дотоодын нийт бүтээгдэхүүний 5-аас дээш хувийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоотой орд мөн. Үүнийг Их Хуралд оруулж ир гээд Их Хурал шийдчихээд байхад 18 жил хав дарсан.

Энэ 18 жилийн хугацаанд тэр 39 стратегийн ордуудыг гадаадын иргэдэд зарсан, үрсэн, ашиг хонжоо олсон, оффшор луу аваачиж хийсэн.

18 жилийн хугацаанд тэр баялгийн сангийн тэр баялагтаа эзэн болох тэр боломж байсан. 18 жилийн хугацаанд одоо бараг бодоод үзвэл энэ чинь хүүхэд

сургуулиа төгсчихсөн, цэрэгт явж байгаа ийм нас шүү дээ. Гэтэл 18 жил өнгөрчихсөн.

Тэгэхээр энэ дээр хэлэлцээр хийж байгаа. Хэлэлцээр гэдэг бол хэрүүл биш. Тулган шаардалт бас биш шүү. Хэлэлцээр гэдэг бол ширээний ард суугаад санхүүгийн модель дээрээ түшиглээд Үндсэн хуулийн тэр газрын хэвлийн баялгийн 50 дээр нэмэх нь “ард түмэн эзэмшинэ” гэдэг заалтыг хангуулах тэр босгыг давахын төлөө хийж байгаа хэлэлцээр.

Тэгээд ингээд энэ 39 стратегийн ордыг эргээд харахад энэ стратегийн ордууд дээр хэлэлцээр хийхэд их төвөг учирна. Энд энэ танхимд сууж байгаа хүмүүсийн манлайлал би бас хэрэгтэй гэж бодоод байгаа юм.

Одоо хөдөө орон нутгаар үндэсний баялгийн сангаа иргэддээ авчиръя, 34-өөс 50 хувиа авъя гээд манай төрийн тэргүүн байсан Х.Баттулга Ерөнхийлөгч яриад явж байгаа. Үгээрээ биш үйлдлээрээ үзүүлэх хэрэгтэй. Тантай нэр холбогддог тэр Төгрөг нуурын ордыг одоо бид ярих цаг бас ирсэн. Тэгвэл адилхан ярина.

Тэгэхээр бүгдээрээ л яриад л явъя. 39 стратегийн ордыг ярихаар бүгдээрээ үүнийг ярьж байгаа шүү дээ. Тавантолгойн бүлэг ордын 50 хувь, 3 тэрбум тонны нөөцтэй, 15 их наяд төгрөг зөвхөн тусгай АМНАТ-ын 5 хувиар бодвол ард түмэнд ирэх ёстой байсан ийм орд шүү дээ. Улаанбаатараас нэгхэн цаг яваад очдог. Тэр орд 250 сая доллароор 4 гадаадын иргэнд зарагдсан. Хонконгийн сайт дээр байна. Оффшороор дамжуулаад. Үүнийг хэлэлцэх юм уу. Эсвэл ялгаж аваад хэлэлцээр хийх юм уу. Тэгвэл 39 стратегийн орд дээр адилхан хэлэлцээр хийе.

Тийм учраас би бүх ард түмнээс сонгогдсон Монгол төрийн тэргүүн байсан хүн үгээрээ биш үйлдлээрээ энэ ажлыг бас хийж харуулаасай гэж би бодож байгаа, итгэж найдаж байгаа, ард түмэн харж байгаа. И-монгол дээр байгаа 138 мянган төгрөг. Энэ мөнгийг яаж нэмэгдүүлэх вэ гэж энэ ажлын хэсэг үйлээ үзэж байгаа.

Одоо Ц.Туваан сайд энэ 39 стратегийн ордын Их Хурлын тогтоолыг оруулж ирнэ. Ингээд бүгдтэй нь ижил хэлэлцээрийг эхлүүлнэ. Ингэсэн цагт энэ 138 мянган төгрөг нэмэгдэнэ. Ингээд энэ бол ард түмний дэмжлэг доор Монголын ард түмэн байгалийн баялагтаа эзэн болох цаг ирсэн гэдгийг л хэлье.

Д.Амарбаясгалан: Ногоон хөгжлийн асуудлаар С.Одонтуяа сайд. Л.Гантөмөр сайд хариулах юм уу? С.Одонтуяа сайд хариулах юм уу? Цэвэр эрчим хүч, ногоон хөгжил. Шадар сайд Т.Доржханд хариулъя.

Т.Доржханд: Баярлалаа. Ногоон эдийн засгийн хувьд бид 2030 он гэхэд нийт эрчим хүчний эх үүсвэрийн 30 хувь нь ногоон байна гээд Их Хурлаараа баталчихсан. Үүнийхээ төлөө явж байгаа. Үүнийгээ хийнэ.

П.Сайнзориг гишүүнтэй тэр хөрсний гүний дулааныг ашиглах энэ асуудал дээр санал нэг байгаа.

Энэ дээр анхны зардал их өндөр юм билээ. Суурь судалгаа, өрөмдлөг их хийх юм билээ. Тэгээд нэг хийсэн тохиолдолд урт хугацаандаа маш их зардал багатай, үр ашгийн хувьд бол байгаа. Тэгэхээр нөгөө хөрөнгө оруулалтын л асуудал гарч ирнэ. Төсөв дээрээ бид орон нутаг дээр мөнгөө тавьж чадах уу, үгүй юу гэдэг.

Ер нь тэгээд бид 30 жилийн хугацаанд дэд бүтэц рүүгээ мөнгө хийж чадаагүй шүү дээ. Үйлдвэр барья гээд сайхан юм яриад байдаг. Дэд бүтэц байхгүй бол ямар юмны үйлдвэр байх юм бэ. Эрчим хүч байхгүй бол, зам, төмөр зам байхгүй бол тэнд ямар ч үйлдвэр бариад үр ашиггүй шүү дээ.

Тэгэхээр одоо бүгдээрээ эрчим хүч рүүгээ оруулъя гэх юм бол төсвийнхөө бодлогоосоо эхлэх хэрэгтэй, хөгжлийнхөө бодлогоос эхлэх хэрэгтэй. Гаднаас орж ирж байгаа эх үүсвэрээ дэд бүтэц рүүгээ оруулж ирж байж тэнд нөгөө хувийн сектор чинь бизнес хийх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: П.Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Би нэг зүйлийг хэлмээр байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр мэтийн ийм бодлогын бичиг баримтуудын гүйцэтгэлийг цахимаар тайлагнадаг, хүссэн үедээ гишүүдэд нь ч юм уу сонирхогч этгээдүүд ороод харж байдаг. Үүнийгээ тэр яг цаг хугацаандаа албан ёсоор дүгнээд бас нэг оруулж ирдэг процесс руу орохгүй бол та хэд маань тэндээ дүгнэж байгаад баахан хэрэлдэж байгаад энд орж ирээд Засгийн газрын дотоод сайд нарын үл ойлголцлоо энд ярьсаар байгаад дуусчхаад байна.

Тэгэхээр үүнийгээ гишүүдэд урьдчилаад харж байдаг бас ийм бололцоог нь бүрдүүлээд цахим руу оруулаа. Бүх үзүүлэлт, зорилтуудыг оруулчих. Ямар байдалтай явж байгаа гэж долоо хоног тутмаар UPDATE хийгээд оруулчих гэдэг зүйлийг хэлмээр байна.

Дараагийн нэг асуудал энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль хэрэгжээд явж байдаг, хэрэгжих гээд байдаг. Энэ дээр ерөөсөө дорвитой ажиллаж байгаа юм алга. Энэ чинь цаашдаа энэ суурин газар дээр үүсэж байгаа нөхцөл байдлыг урьдаас харах, тэнд байгаа өмчийн эрхийг хамгаалах, тэнд байгаа хүмүүсийн эрүүл мэндийн асуудлыг хамгаалах, тэнд байгаа хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хамгаалах асуудал байгаа байхгүй юу.

Түүнээс биш хэдэн байшин барилга, засаг захиргаа, нэгжийг өөрчлөх тухай асуудал биш.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд гараад явчихсан байна. Л.Гантөмөр сайд хариулах уу? Л.Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Тийм. Ер нь П.Сайнзориг гишүүнтэй санал нэг байна.

Тэгээд бид өнгөрсөн хугацааны буруутгалыг нэгэн рүүгээ чихээд л. Жишээлбэл, сая Н.Учрал бол алдаа гаргаж байна. Х.Баттулга Ерөнхийлөгч хөдөөгүүр яваад энэ баялгийн санг хэрхэн амилуулах тухай л хэлэлцүүлэг хийж байгаа шүү дээ. Гэтэл тэрийг улс төржүүлээд л, бүгдэд нь хамаатай энэ тэр гээд л ингээд Монголыг хуваадаг, дайсгнуулдаг энэ юмаа болих хэрэгтэй. Аль аль түвшиндээ.

Ер нь П.Сайнзориг гишүүний хэлж байгаа энэ тайлагнал, төлөвлөлтийн гүйцэтгэлийн юм чинь ингээд нэг платформ дээр гараад, тэр нь ингээд хүмүүс харж болдог тэр зүйлийг Та нар хийгээч гэдэгтэй бид санал нэг байгаа.

Сарын өмнө Засгийн газраар энэ тухай тогтоол батлагдсан. Одоо тэр программ хангамжийг бид худалдаж авах ажлаа хийж байна. Ингэх юм бол бид сар болгон яг аль бодлого хаана очоод ямар үр дүнтэй байгаа вэ гэдгээ бүр тоон утгаар нь байнга хараад явах ийм бололцоо бүрдэх юм.

Үүнийг 2025 онд багтаж бид хийж чадах юм.

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Л.Гантөмөр: Тийм. Үнэхээр яг үүнийгээ бүрэн хийж чадах юм бол бид энэ хяналт, гүйцэтгэлийг байнга хардаг ийм боломж бүрдэх юм. Тэгэхгүй бол ний нуугүй хэлэхэд 2 сарын 01-нд бүх яамны тайлан ирж байна.

Эдийн засгийн яамны хяналт шинжилгээ дээр байгаа 6 залуу яг 14 хоног ноцолдоод дүн тавиад гаргаж байна. Хуулиараа ийм. 2-хон долоо хоногт дүн тавьдаг, үнэлгээ хийдэг. Тийм. Тэгэхдээ ажлууд нь цөөхөн учраас асуудал алга л даа. Гол нь газар дээр нь очоод асуудлыг харах боломж тэр 2 сарын 01-нээс 2 сарын 15-ны хооронд тэр боломж нь байхгүй юм билээ.

Тэгэхээр аудитын хэлж байгаа нэг талаасаа та нар газар дээр нь юмаа харсангүй гэж байгаа. Зөв. Нөгөө талаасаа хууль журмаараа тийм боломж алга.

Тэгэхээр нэгдсэн цахим платформ. Бүх хүн датагаа өгч байдаг. Тэгээд харагдаж байдаг зүйл рүү явах нь зөв. Би таны саналыг дэмжиж бид ажил хэрэг болгож байгаа гэдгээ хэлье.

Д.Амарбаясгалан: П.Сайнзориг гишүүн ахиж тодруулж асууя.

П.Сайнзориг: Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийг нэг анхаараач ээ, Засгийн газар. Энэ уг нь Үндсэн хуулийн өөрчлөлтийг амилуулах томоохон

асуудал байгаа. Энэ хот гэдэг ганцхан Улаанбаатар хот л байдаг юм шиг сэтгэхүйгээс гарах, эдийн засгийн төвлөрлийг зах зээлийн зарчмаар нь зөв тараан байршуулж хуваарилах. Цаана нь эдийн засгийн асуудал байгаа, хүний эрхийн асуудал байгаа. Энэ асуудлыг анхаарч байгаа зүйлүүд харагдахгүй байна.

Тэгээд эцсийн дүндээ сүүлийн зүйлээ хэлмээр байна.

Энэ Засгийн газар бол Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын хамтарсан Засгийн газар шүү. Асуудлыг жоохон бодитой хийж байгаа зүйлүүдийг нааж ярихдаа бас сайхан байгаа боловч яг асуудал яриад ирэхээр танай манай ч гэх шиг, манай сайдаас илүү асуулаа. Танай сайд ер нь яагаад юм хариулдаггүй юм, орж ирдэггүй юм гээд нэг ийм явган юмаа хэдүүлээ больё.

Тэгээд үүнийг ч гэсэн Улсын Их Хурлын дарга бас хэлээд байсан шүү дээ. Сөрөг хүчний дүрээр Ардчилсан нам маань, ХҮН нам маань орж ирж Ерөнхий сайдын цаг дээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сая Улсын Их Хурлын гишүүд чуулганы завсарлагаанаар орон нутгаар явж олон газар иргэдтэй уулзалтуудыг хийсэн.

Ерөнхий дүн байдлаараа олон нийт, ард иргэдийн зүгээс мэдээж хамтарсан Засгийн газар байгуулагдаад бодитой, зоригтой алхмуудыг хийж, ажил урагшлуулах гэж зорьж байна гэдгийг бодитой дүгнэж байгаа зүйл харагдсан.

Нөгөө талаасаа бас 126 гишүүнтэй олон намын оролцоотой болчихсон парламент нь өөрөө дотоод ардчилалтай, олон ургалч үзэлтэй, асуудлыг олон талаас нь хэлэлцэж, үр дүнд хүргэх тал дээр нь илүү хичээж ажиллах шаардлагатай гэдэг талаас бас ярьж байсан.

Тэр дотор нэг зүйл ажиглагдсан нь эрх баригч сөрөг хүчин гэж хэрэлдэхээсээ илүүтэйгээр парламент нь парламент шигээ байж, Засгийн газартаа ерөнхий хяналтаа тавьж ажиллах зайлшгүй шаардлагатай байна гэдэг зүйл байнга давтагдаж байгаа юм.

Тэгэхээр мэдээж улс төрийн асуудал байлгүй л яах вэ. Яг үндсэн ажил бол парламентын зүгээс Засгийн газартаа хяналт тавьж, шаардлага тавьж ажиллах энэ чиг үүргээ гүйцэтгэх дээр парламентын гишүүд бас бүгдээрээ нэгдсэн нэг ойлголттой, дотоод эв нэгдлээ бас хангаж ажилладаг байх шаардлагатай. Нэгэнт л ард иргэдийн эрхийг хангаж, дуу хоолой нь болж төлөөлж ажиллахаар сонгогдсон нөхдүүд учраас энэ дээрээ төвлөрч ажиллах нь зүйтэй.

Тэр улс төрийн хэрүүлийг бас бусад түвшиндээ хийж байх зайлшгүй шаардлагатай гэж байгаа юм.

Эцсийн бүлэгтээ ард иргэд бараг хэн засаглаж байгаа, аль нам засаглаж байгаа гэхээс илүүтэйгээр энэ төр, засаг ажил хийж байна уу, ард иргэдийн амьдралыг өөрчлөх дорвитой бодлогыг хийж хэрэгжүүлж байна уу гэдэг дээр л үнэлэлт, дүгнэлт тавьж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээрээ нэгдсэн нэг ойлголттойгоор бүгдээрээ анхаарлынхаа төвд тавьж ажиллах нь зүйтэй. Ялангуяа өнөөдөр Засгийн газрын үйл ажиллагааны тайлан, үндсэн чиглэл, хэлэлцэж байгаа цаг үе дээр Засгийн газрын гишүүд ч тэр, парламентын гишүүд ч тэр бүх талаасаа анхаарал хандуулж идэвхтэй оролцох зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Ингээд Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Заяабал: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе.

Өнөөдөр бид Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлийг хэлэлцэж байна.

Үндсэн чиглэл нь өөрөө 9 зорилго, 47 зорилт, 243 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байгаа.

Энэ 9 зорилгыг аваад үзэх юм бол дандаа Монгол хүн рүүгээ чиглэсэн ийм зорилгыг тодорхойлж төрийн бодлогыг хэрэгжүүлж байгаа. Өнөөдөр бодит үнэлгээг нь аваад үзэхэд үнэлгээ нь хангалтгүй байна гэдэг зүйлүүд нэлээдгүй гишүүд яригдаж байна. Бодит амьдрал дээрээ энэ бас зарим үнэлгээнүүд нь өндөр тавигдсан байна, бодит амьдралтайгаа нийцэхгүй байна гэсэн ийм зүйлүүдийг бас гишүүд маань ярьж байна. Би үүнтэй санал нэг байгаа.

Тийм учраас төрийн бодлогын гол цөмд нь монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлэх, монгол өрхийн орлогыг нэмэгдүүлэх нь төрийн бодлогын хамгийн чухал зүйл.

Орлого нь өнөөдөр тогтвортой байж чадах юм бол өнөөдөр энд нийгэмд үүсээд байгаа хүнд асуудлууд бүгд шийдэгдэнэ. Боловсролын ялгаатай байдал, гэмт хэрэг гаргалтын түвшин гэх мэтчилэн гээд л нийгэмд үүсэж байгаа бүх л болохгүй зүйлүүд орлоготой шууд холбоотой. Утааны асуудал гэх мэтчилэн гээд бүх л болохгүй зүйлүүд энэ орлоготой холбоотой.

Тийм учраас төрийн бодлогын бүх л зорилго нь орлогыг нэмэгдүүлэхтэй холбоотой асуудал байх ёстой.

Өнгөрсөн дөрөв, таван жилийн хугацаанд Монгол Улсын ядуурлын түвшин нэлээдгүй өндөр байсан. Харьцангуй буугаад хорин хэдэн хувь руу ороод ирчихсэн байгаа.

Гэтэл эдийн засаг дээр өнөөдөр 2025 оны 2 дугаар сарын статистик мэдээг хараад үзэхэд эдийн засгийн нөхцөл байдал, тогтвортой байдал алдагдаж эхэлж байна. Инфляц өндөр болж эхэллээ. 2020 оны зэрэгцүүлэх үнээр 9.6-тай байсан бол одоо сая он гараад 2023 оны зэрэгцүүлэх үнээр 9.6 гэдэг бол үндсэндээ 2020 оны зэрэгцүүлэх үнээр тооцоод үзэх юм бол энэ хоёр оронтой тоо руу даваад явчихсан байж байгаа.

Монгол төгрөгийн ханш бууж байна. Төсвийн тэнцэл алдагдалтай байна. Төлбөрийн тэнцэл алдагдалтай байна. Хос алдагдлын ийм эдийн засгийн нөхцөл байдал руу ороод ирчихлээ.

Энэ нь эргээд дахиад иргэдийн чинь орлогыг бууруулах ийм хүнд асуудал руу орж ирж байна. Энэ дээрээс үүдээд би асуух гэж байгаа юм. Яг энэ эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор.

Яг өнөөдрийн байдлаар Монгол Улсын дундаж давхарга яг хэчнээн хувь байгаа юм бэ? Нийгмийн 970 мянган өрхийн чинь яг хэд нь энэ дундаж давхаргад байгаад байгаа юм бэ? Эдийн засгийн яг ийм хос алдагдлын мөчлөгтэй макро эдийн засгийн тогтворгүй байдал үүсэж эхэлж байгаа энэ цаг үед дундаж давхаргыгаа доошоо оруулахгүйн тулд ямар хамгаалалтын бодлогууд авч хэрэгжүүлэх вэ гэдэг нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт нь, бид олон жил ярьсан. Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэе, солонгоруулна, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжинэ, хувийн хэвшлийг дэмжинэ гээд олон жил ярьсан. Өнөөдрийн бодит байдал дээр ингээд аваад үзэхэд төрийн өмчит компаниуд, аж ахуйн нэгжүүдийн зах зээлийг нэмэх чиглэлээр илүүтэй ажиллаж байна л даа. “Эрдэнэс Тавантолгой” байна. Монатомын энэ Ораногийн хэлэлцээрүүд байна.

Гэтэл хувийн хэвшил рүүгээ, хувийн хэвшилдээ зах зээлийг үүсгэх чиглэлээр ер нь бодитой юм бид хийж чадаж байна уу гээд гэдэг дээр төр эргэж харах зайлшгүй шаардлагатай байна.

Үнэхээр хувийн хэвшлийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд Монголын төр хувийн хэвшилд зах зээлийг нэмэгдүүлэх чиглэлээр онцгой анхаарал хандуулж ажилламаар байна.

2015 онд Японтой байгуулсан эдийн засгийн хэлэлцээр байна. Ямар ч үр дүнгүй хэлэлцээр өнөөдрийг хүртэл хэрэгжиж байна. Тэрийг сайжруулахын тулд ямар алхам хийж хэрэгжүүлэх юм бэ?

Хоёрдугаарт нь, саяхан энэ Евразийн хэлэлцээр гээд хийгдлээ. Нэлээдгүй шүүмжлэл дагуулаад явж байх шиг байна.

Энэ дээр бас холбогдох салбарын сайд нь тодорхой мэдээллийг олон нийт, иргэд рүү чиглэсэн мэдээллийг өгвөл их зүгээр байна. Хэчнээн хувийн зах зээлийг бий болгох юм бэ гэдэгтэй холбоотой мэдээлэл өгвөл зүгээр байна.

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут.

Б.Заяабал: Дээрээс нь бид хөрш зэргэлдээ Хятад Улс руугаа бид зах зээлийгээ нээх чиглэлээр онцгой анхаармаар байна.

Өнөөдөр Хятадын философи өөрчлөгдчихөөд байна шүү дээ. Хятадууд бол “муур хар ч байсан цагаан ч байсан хулганыг барьдаг”.

Тийм учраас юу ч хамаагүй үйлдвэрлээд мөнгө олохын төлөө үйлдвэрлэлээ явуул гэдэг ийм философитой байсан бол одоо энэ философи нь өөрчлөгдчихсөн. Нарийн, өндөр технологи шингэсэн ийм бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэдэг. Үүнийгээ зорилтоо болгоод тунхаглачихсан. Гэтэл өнөөдөр бид дахиад л нөгөө нүүрсээ ярьсан хэвээрээ л байгаад байгаа.

Гэтэл үүнтэйгээ чиглэсэн ямар бодлогыг бид авч хэрэгжүүлэх юм бэ гэдэг энэ бодлого дээрээ бид онцгой анхаарах шаардлагатай байна.

Уул уурхайн салбарын нөгөө нэг хэсэг бол яах аргагүй хөдөө аж ахуйн салбар. Тэр дундаа мал аж ахуйн салбар. Гэтэл өнөөдөр бид Монгол мал эрүүл бус байна, арьс нь цооролттой, нүхжилттэй байна гэдэг ийм зүйлүүдийг бид ярьсаар ирсэн. Гэтэл өнөөдөр бид Монголд малчдыг өрхийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд үүнийг ямар бодлого явуулж, малыг нь эрүүл болгох.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Л.Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Ер нь Монголын эдийн засагт хамгийн том байр суурь эзэлж байгаа салбар бол уул уурхай. Тийм ээ. Тэрийг бүгдээрээ мэдэж байгаа.

Энэ дундаа нүүрс байгаа. Нүүрсний үнэ 30, 40 хувь уначихлаа. Энэ бол худалдан авагчийн тавьж байгаа үнэ, дэлхийн зах зээл. Үүнийг сөрөх бидэнд байгаа боломж бол хил, гаалийнхаа асуудлыг шийдээд, экспортоо нэмэгдүүлэх л ийм л ажлыг бид хийж байна.

Яагаад гэвэл бусад экспорт тогтвортой байна. Жишээлбэл, зэс өсөлттэй байна, төмөр түвшиндээ хадгалагдаж байна, жоншны экспорт нэмэгдэх төлөвтэй байна, алтны мэдээлэл өнөөдөр тодорхой бус байна. Тэгэхдээ үнэ өсөж байна. Нэг үгээр хэлбэл алтны олборлолт айхтар буурахгүй. Үнэ тогтвортой өснө гэсэн үг.

Юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр манай эдийн засгийг бүрдүүлж байгаа олон салбар дунд байгаа энэ нүүрсний салбар гэдэг их том орон зай эзэлж байгаа салбар дээрээ тоон утгаараа доошоо уналтууд анзаарагдаж байгаа.

Энэ эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг багасгахын тулд бид экспортынхоо хэмжээг нэмэгдүүлэх, төлөвлөлтийг Засгийн газраар оруулаад батлаад Сангийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг гараад ажиллаж байгаа гэдгийг Б.Заяабал гишүүнд хэлье.

Евразийн хэлэлцээр экспортыг ер нь 10 хувь нэмэгдүүлэх зорилготой юм. Дээд утгаа бол 18 хувь гэж харж байгаа юм. Энэ дотор эзэлж байгаа жин нь түрүүн ямар гишүүн хэлээд байлаа. Ноолуур чинь үнэгүйдэж байна гээд. Ноолуур байгаа, ноос байгаа. Тэгээд мах.

Ерөөсөө энэ махаа үнэд хүргэж зарах, дээр нь ноолуур, ноосоо үнэд хүргэж зарах боломжийг л бид Евразийн 200 сая хүнтэй зах зээлээс олж авахын төлөө явж байгаа юм. Тийм. 250 мянган малчин ард нь байгаа гэдгийг Б.Пүрэвдорж дарга хажуугаас хэлж байна.

Ер нь энэ утгаараа бид зах зээл. Одоо таны хэлж байгаа энэ зах зээл тэлэх гэдэг бодлогыг тууштай баримталж явна гэдгээ хэлье.

Нөгөө талдаа үнэхээр хувийн хэвшлийг дэмжих бодлого чинь их ойлгомжгүй байгаа шүү гэдэг бол үнэн шүү.

Тийм учраас бид энэ бизнесийн орчин гэдэг зүйлээ яг олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай болгохын төлөө ажиллаж байна. Бизнесийн орчин гэж яг юу хэлээд байгаа юм бэ гэхээр компани бүртгүүлэх, татварын дарамт, хяналт шалгалтын нөхцөл байдал, дээр нь зөвшөөрлүүд. Зөвшөөрлүүд дотор эрчим хүчний, барилгын, мөн байгаль орчны үнэлгээ гэх мэтчилэн 7-гоос 10 төрлийн шалгуур байна.

Энэ шалгуураараа бид үнэхээр энэ өрсөлдөх чадвараа сайжруулах чиглэлээр маш тодорхой төлөвлөгөө гаргаж ажил хэрэг болгохгүй бол компаниуд бизнес хийх, ажил хийхэд төрийн дарамт байна гэдэг ийм л зүйл өнөөдөр хүртэл яриад байгаа юм.

Тийм учраас олон улсынхаа үнэлгээгээр бид бизнесийн таатай орчинтой улс шүү гэдгээ ойрын.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Б.Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний зарим асуултад нэмж хариулъя.

Тэр хос алдагдал гэж яриад байгаа дээр Их Хурал Монгол Улсын төсөв алдагдалгүй байна гээд баталчихсан шүү дээ. Энэ жил, хойтон, ингээд 3 жил

дараалаад алдагдалтай байж болохгүй шүү гээд. Тэгэхээр үүндээ итгэлтэй байх хэрэгтэй.

Мэдээж манай гол түүхий эдүүдийн үнэ унаж байгаа маань манай төсвийн орлогод тийм сайнгүй нөлөөлнө. Гэхдээ бид нэгэнт алдагдалгүй гарах ёстой учраас гүйцэтгэл, зардал дээрээ хяналт тавиад л зардлаа татаад л гүйцэтгэлээ гаргана.

Тэгэхээр хос алдагдал гэдэг ойлголт энэ 3 жил байхгүй гэсэн үг. Мэдээж төлбөрийн тэнцэл дээр гадаад худалдааны энэ асуудлууд бидэнд сөрөг нөлөө ирнэ.

Сая Тэргүүн Шадар сайд маш тодорхой хариуллаа. Засгийн газар үүн дээр бид хариу арга хэмжээ аваад боломжит бүх нөөц боломжоо шавхаад л ажиллана. Энэ төлбөрийн тэнцлийн алдагдлыг нь бууруулах, эерэг гаргах тал дээр бүх боломжуудаа дайчилж ажиллаж байгаа.

Нүүрс нэлээн унасан. Нэлээн унасан. Манай гол бусад стратегийн түүхий эдүүдийн үнэ харин эсрэгээрээ их боломжийн байгаа.

Тийм учраас энэ боломжуудаа ашиглах хэрэгтэй. Ялангуяа Төв банкны нөөц гэж байхгүй. Монгол Улсын нөөц л гэж байдаг. Тийм учраас Төв банкны асуудал гээд орхихгүйгээр Засгийн газар дээр бид Монгол Улсын нөөцийг тогтмолжуулах, бууруулахгүй байх, цаашид тогтвортой нэмэгдүүлэх, хамгаалах, мөн Монгол Улсын валютын нөөцөөр дамжиж орж ирдэг сөрөг макро үзүүлэлтүүдээ тогтворжуулах талд бүхий л боломжуудаа дайчилж ажиллаж байна.

Эхний үр дүнгүүд гарч ирж байна. Мөн яаралтай эрх зүйн зохицуулалтууд хийх ёстой. Ялангуяа экспортыг богино хугацаанд нэмэгдүүлэх ийм асуудлуудаа Улсын Их Хуралд эхнээс нь өргөн бариад явж байна.

Өнгөрсөн долоо хоногт Биржийн тухай хууль өргөн барилаа. Мөн дотооддоо Засгийн газрын.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Б.Заяабал гишүүн тодруулж асууя.

Б.Заяабал: Тэгэхээр яг энэ цаг үед макро эдийн засгийн байдлынхаа тогтвортой байдлыг хангах нь хамгийн чухал байгаа шүү гэдгийг би бас дахиж хэлье. Дахиж хэлье.

Байгаа бүх боломжийгоо бид ашиглах ёстой гэж хэлээд, гаднаас своп хэлцлээрээ баахан доллар оруулж ирээд интервенц хийдэг. 2012-2016 онд гаргасан тэр алдааг дахиж бид давтаж болохгүй гэдгийг нэгдүгээрт би хэлмээр байна.

Хоёрдугаарт нь, дундаж давхаргатай холбоотой би асуусан. Үүнтэй холбоотой Л.Энх-Амгалан сайд яг энэ дундаж давхарга Монголын нийгмийн яг хэдэн хувьд нь байгаа юм бэ гэдгийг бас тодорхой тоо мэдээ өгөөч гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Мөн түүнчлэн тэр асуусан өмнөх асуултаа үргэлжлээд асуухад энэ Японтой байгуулсан эдийн засгийн хэлэлцээр гээд нэг ашиггүй хэлэлцээр өнөөдрийг хүртэл явж ирлээ. Энэ дээрээ ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт, ахиц гаргах юм байгаа юу? Энэ дээрээ Та бүхэн бас анхаараач.

Хоёрдугаарт нь, тэр Солонгостоо хийж байгаа эдийн засгийнхаа зах зээлийгээ тэлэх хэлэлцээрүүд дээрээ өмнөх хэлэлцээрийнхээ алдаа оноог ашиглаж, бас сайжруулж сайн хэлцэл хийх шаардлагатай байна. Хятадтайгаа бид яг тэр шинжлэх ухаан.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Б.Заяабал гишүүн их чухал асуудал хөндөж тавиад байгаа юм.

Монгол Улсад зарлаж байгаа ядуурлын түвшин, ядуурлын хэмжиж байгаа хэмжүүр, ажилгүйдлийн хэмжиж байгаа хэмжүүр, тэгээд ер нь дундаж давхаргынхаа судалгаануудыг ер нь байнга хийж, их зөв тоонуудыг зарлахгүй бол энэ ер нь нэг тийм цаг үеэсээ жаахан хоцорсон ийм үзүүлэлтүүд байгаа.

Тэгээд бид яах вэ, Статистикийн ерөнхий газартай хамтарч салбарын их өгөгдлийн платформуудыг боловсруулж байна.

Урьд нь Монгол Улсад ер нь дундаж давхаргыг яг тэд байна гэж зарлаж байсан тохиолдол байхгүй юм билээ. Б.Заяабал гишүүн ээ.

Ер нь яах вэ, Дэлхийн банкны нэг аргачлал байдаг. Энэ бол нэг өрхийн медиум орлогыг харьцуулахад 67 хувиас 200 хувь хүртэл харьцуулсан харьцуулалтын хооронд байгаа өрхүүдийг дундаж давхарга гэж үзнэ гэж хэлсэн нэг ийм тооцоолол байгаа. Энэ тооцооллоор үзэхэд арай жаахан өндөр тоо гарч байгаа. Тэгээд ер нь ойролцоогоор 2 өрхийн нэг нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя.

Л.Энх-Амгалан: Яах вэ, энэ өөрөө их том сэдэв. Тэгээд 1 минутад хариулт өгөхөд их хэцүү.

Ямар ч байсан Дэлхийн банкны тэр 2 аргачлалын нэг нь яг тэр өрхийн орлогын 67-оос өрхийн орлогыг 200 хувь хүртэл үржүүлж тооцсон энэ хооронд байгаа өрхүүдийн тоог дундаж давхаргад байна гэж харьцуулж байгаа юм.

Мөнгөн тоогоор 50 доллароос 200 доллар хүртэлх зарлага хийж байгаа энэ өрхүүд дэлхийн дундаж дээр дундаж орлоготой иргэд, өрх гэж тооцно гэж байгаа юм. Энэ манайд арай жаахан өндөрдөнө. Нийт үндсэндээ жилийн 50 мянган доллароос 120 мянган долларын орлоготой өрхүүдийг MIDDLE CLASS буюу дундаж орлогод оруулж тооцдог ийм аргачлал байгаа юм.

Тэгэхээр яах вэ, бусад орлого багатай байгаа, өрхийн орлого багатай байгаа улсуудад хийж байгаа дундаж өрхийн, дундаж иргэдийн тооцоолол нь түрүүний миний хэлдэг өрхийн дундаж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Г.Очирбат: Өглөөний мэнд хүргэе.

Бид чинь бүгдээрээ ингээд сайхан онигоонд ороод сууж байна даа. Гурван газраас үнэлчихсэн. Үнэлгээ нь гурвуулаа өөр. Тэр дундаа Их Хурлын Тамгын газар нь эрхийг нь, асар их хэмжээний эрх өгчихсөн. Тэгээд Тамгын газар нь үнэлгээ бас гаргачихсан ингээд сууж байдаг.

Тэгэхээр хурлын даргаас бас нэг юм асуух гэсэн юм. Энэ гурван бодлогын том бичиг баримтыг хэлэлцэж байна. Хэтэрхий хялбаршуулсан маягаар хоёр Байнгын хороо хуралдаад ингээд Их Хурал руу оруулаад ирдэг. Ер нь бусад 9 Байнгын хорооноос танд санал ирсэн үү? Яг салбар салбарт нь бид энэ 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл, мөн дээрээс нь 2024-2028 он, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг авч хэлэлцье гэсэн. Эхний асуулт нь ийм байна.

Хоёрт гэх юм бол энэ хууль тогтоомжуудынхаа давхцалыг арилгахгүй бол ерөөсөө болохгүй байна. Их Хурлын гишүүд ч хэлж байна, сайд нар ч хэлж байна.

Дэгийн тухай хууль, Хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын тухай хуулиуд чинь бүгдээрээ Их Хурлын Тамгын газартаа баахан эрх мэдэл өгчихсөн. Тэгээд Их Хурлын Тамгын газар чинь өөрөө үндсэн чиг үүрэг нь Улсын Их Хурлын гишүүдийн сургалт, семинар, хэлэлцээр, үйлчилгээг хийж байх ёстой. Тамгын газар маань. Өөрсдөө үнэлж оруулж ирээд ингээд Засгийн газрын ажлыг Их Хурал, Үндэсний аудитын үнэлгээ хоёрыг хооронд нь хэрүүл уруул тэмцэл болгоод тавьчихсан.

Тэгэхээр хууль тогтоомжуудынхаа гажгийг юм арилгахгүй бол болохгүй байна. Сүүлийн 4 жилд ер нь юу хийсэн юм бэ гэдгийг Үндэсний аудитын газрын тоо баримт бол харуулаад байгаа юм. Бүгдэд нь тараагдчихсан байгаа шүү дээ.

2021-2025 онд 67.7 хувьтай. Тийм ээ. Ингээд 2024 онд 52.1. Дундажлахаар 59 хувьтай л ажилласан байна.

Тэгээд л зарим манай Монгол Ардын намын гишүүд өөрөө өөрсдөөсөө асуулт асуугаад, өөртөө хариулаад байх юм. Энэ чинь сүүлийн 4 жилийн ажлын чинь л үр дүнг өнөөдөр ярьж байна шүү дээ. Тэгээд 50 хувьтай ажил хийсэн. Тэгээд одоо ярьж байгаа асуултууд нь бүгдээрээ Ардчилсан намын сайд нараас асуугаад байдаг. Ардчилсан намын сайд нар хамтарсан засагт ороод үнэхээр ажил хийж байна шүү дээ. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, энэ Гашуунсухайт-Ганцмод боомт, олон ажлуудыг эхлэлийг нь тавиад аваад явж байна шүү дээ.

Тэгэхээр үүнийгээ бас нэг хаана хаанаа ярилцмаар байна.

Тэгээд тодорхой хоёр, гуравхан асуулт байна. Б.Жавхлан сайдаас эхлээд асууя. Монголбанк түрүүн бодлогын хүүгээ 2 хувиар нэмчихлээ. 2 хувиар нэмээд энэ яг хамгийн хүнд хэцүүг нь ард иргэд л үүрч байна шүү дээ.

Одоо ингээд арилжааны банкнууд, банк бус байгууллагууд, тэр аппликэйшны зээл эд нар чинь бүгд хүүгээ нэмээд эхэлчихсэн. Зээлийн хүүгээ. Тэгээд үүнийгээ яаж харж байгаа юм? Сүүлийн 4 жил та сайд хийсэн. Яг энэ Сангийн яаманд мэргэжлийн боловсон хүчин гээд Монгол Улсын бүх сан хөмрөгийг хариуцаад ажилласан. Таны хийсэн хөтөлбөрүүд ч гэсэн ерөөсөө тэр лүү чиглэсэн.

“Хүнсний хувьсгал” 2 их наяд төгрөг гаргачихсан. “Цагаан алт” хөтөлбөр 700 тэрбумыг гаргачихсан. “Шинэ хоршоо” бараг 700 тэрбум болж байна.

Ингээд 3.5 их наяд чинь инфляцыг онилсон. Инфляцад хамгийн өндөр өртөж байгаа эхний 20 нэр төрлийн барааг онилсон. Тэгээд үр дүн нь хаана байгаа юм? Бодлогын хүүгээ нэмчихсэн. Ард иргэд дээр ачаалал үүсгэчихсэн л явж байна шүү дээ. Энэ дээрээ тодорхой хариулт авчихмаар байна.

Хоёрдугаарт нь, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Ж.Энхбаяр сайд бас сууж байна.

Яг түрүүний хэлсэн гурван хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг нь нэг хэлээд өгөөч. Ийм их хэмжээний. Одоо манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бол зүгээр ийм халамжийн яам болчихсон. Асар их мөнгө гаргаж байдаг. Үр дүн байхгүй. Төр, хувийн хэвшил, иргэд энэ гурвын огтлолцоон дээр бодлого хэрэгжиж байх ёстой. Тэгээд тэр бодлогынх нь үр дүн байхгүй. Инфляц нь өсөөд байдаг. Төгрөгийн ханш нь сулраад байдаг. Тэгээд энэ дээрээ тодорхой үр дүн хэлээд өгчихвөл их зүгээр байгаад байна.

Хамгийн сүүлийнх нь. Ер нь хойшдоо хэдүүлээ Үндэсний аудитын газраа хүчирхэг болгохгүй бол болохгүй байна. Их Хурлын нүд чих бол Үндэсний аудитын газар. Эндээс бид.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье. Г.Очирбат гишүүнд.

Г.Очирбат: Үндэсний Аудитын газрын тайлангаа хэрэгжүүлдэг, зөвлөмжийг нь хэрэгжүүлдэг болохгүй бол болохгүй байна.

Тэгээд энэ сүүлийн асуултыг Н.Учрал сайдаас асууя. Үндэсний аудитын газрын Их Хуралд өгч байгаа зөвлөмж дээр энэ ажлаа хийж чадахгүй байгаа хүмүүс дээр арга хэмжээ аваач гэсэн байгаа юм. Өнөөдөр ихэнх нь дарга нар, сайд нар болчихсон. Бүр томилогдоод дээгүүр албан тушаалд оччихсон ийм байдалтай байна.

Тэгэхээр яг ямар албан тушаалтнууд дээр арга хэмжээ авсан бэ? Сүүлийн 4 жил шүү. 2021-2024 оны хугацаанд. Тэгээд энэ дээр нэг тодорхой хариулчих. Тэгээд дараа нь тодруулъя. Тэгэх үү?

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын Байнгын хороод уг асуудлыг заавал хэлэлцэх Байнгын хороо нь Эдийн засгийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо. Бусад Байнгын хороод шаардлагатай бол хэлэлцэж болно гэсэн хуулийн заалттай.

Бусад Байнгын хороодоос хэлэлцье гэсэн санал өнөөдөр ирээгүй. Тэгээд үндсэн хоёр Байнгын хороо хамтарч хуралдсан. Хамтарсан хуралдаан дээр бас энэ асуудлаар гишүүд тайлбар мэдээллүүд, асуултад хариулт авах байдлаар ажилласан.

Гэхдээ гишүүд Байнгын хорооны ажилласны дараа бас хангалттай байсангүй гэдэг дүгнэлтийг аль аль талдаа гаргасан. Хариулт тодорхойгүй байна. Тайлагнаж байгаа байдал ойлгомжгүй байна. Давхардал үүссэн байна гэдэг асуудал хөндөгдсөн.

Тэгээд энэ өөрөө энэ жил анх удаа хэлэлцүүлэгдэж байгаа хэлэлцүүлгийн хэлбэр болж байгаа. Өмнөх Баасан гарагт хэлэлцэж байхад Ерөнхий сайд ч тэр, манай С.Бямбацогт сайд ч Үндсэн хуульд орсон өөрчлөлттэй холбоотой Улсын Их Хурлын тухай хууль болон бусад хуулиудад холбогдох өөрчлөлтүүд орсон. Урт хугацаанд төлөвлөдөг болох нөхцөл бүрдсэн. Тэгээд анх удаагаа урт хугацааныхаа төлөвлөгөөг хэлэлцэж байгаа байдал гарч ирж байна. Гүйцэтгэлийг хэлэлцэж байгаа байдал гарч ирж байна гэж.

Тэгэхээр энэ дээр харин одоо бид ярилцаад, хэрвээ Байнгын хороод дээр энд санал гарч ирээгүй бол Улсын Их Хурлын гишүүдийн оролцоотойгоор, Г.Лувсанжамц гишүүн бас саналаа хэлж байсан. Санаачилга гаргаад тайлагнадаг, төлөвлөдөг, төсөвлөдөг энэ байдлыг нэгдсэн нэг ойлголтод аваачихын тулд Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж ажиллая гэж байгаа.

Тэгэхээр энэ ажлын хэсгийг эсвэл байгуулаад богино хугацаанд ажиллуулж, тогтоолын төсөл санаачлуулж Улсын Их Хурлаар батлах

боломжтой. Бас холбогдох хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулах шаардлага байвал бас оруулах боломжтой гэж үзэж байгаа.

Улсын Их Хурал хяналтын чиг үүргийг гүйцэтгэх чиг үүргийнхээ хүрээнд Их Хурлын Тамгын газарт хяналт хариуцсан газар, хэлтсүүд албан ёсоор хуулиар байгуулагдаж ажиллаж эхэлж байгаа юм. Энэ жилээс.

Тийм учраас Улсын Их Хурлын Тамгын газар батлагдсан хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ гүйцэтгэж энэ үнэлэлт, дүгнэлтүүд гарч ирж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Ням-Осорын Учрал сайд. Дараа нь Болдын Жавхлан сайд хариулт өгье.

Н.Учрал: 2020 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын хуулийг Их Хурал баталсан. 2020 онд.

Энэ хуулийн дагуу бид өнөөдөр яг энэ аудитын тайланг хэлэлцэж байгаа. Тэгээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нэг жилийн төлөвлөгөө. Нэг жилийн төлөвлөгөөнд түшиглэсэн Засгийн газрын үйл ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөөг баталдаг болсон.

Тэгээд энэ шинэ хууль эрх зүйн орчны дагуу энэ таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилтуудыг хэлэлцдэг болсон.

2022 онд хяналт хэрэгжүүлэх хуулийг бас Их Хурлаас баталсан. Тэгээд хяналт хэрэгжүүлэх хуулиар төрийн захиргааны төв байгууллагууд, төрийн захиргааны байгууллагууд, тэгээд үнэлгээ хийх механизм, тогтолцоо шинэчлэгдсэн. Ингээд Засгийн газар үнэлгээ хийх тэр аргачлалыг гаргаад, тэр аргачлалын дагуу төрийн байгууллагууд үнэлгээгээ хийдэг ийм шинэ эрх зүйн орчинтой болсон.

Их Хурал яг ямар ажлыг хийж байгаа вэ гэхээр дүн шинжилгээ хийдэг. Дүн шинжилгээ. Одоо хуулиараа бол.

Тэгэхээр яг хяналт хэрэгжүүлэх механизмыг Засгийн газар хэрэгжүүлээд, түүн дээр нь дүн шинжилгээ хийдэг ийм л тогтолцоо явж байгаа.

Сая хамтарсан Засгийн газар байгуулагдсаны дараа Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр дээрээ бид “төсөвлөлт”, “төлөвлөлт”, “гүйцэтгэл” гэдэг зүйлийг нэг тогтолцоонд шилжүүлнэ буюу DESIGN_[төлөвлөлт] MONITORING_[хяналт] EVOLUTION_[үнэлгээ] хийнэ гэдгийг зорилтоо болгосон.

Тэгээд сая Л.Гантөмөр сайдын хэлж байгаагийн дагуу бид үүнийг нэг тогтолцоонд шилжүүлэхээр ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ хүрээнд хуулийн өөрчлөлтүүдийг заавал хийж тогтолцооны нэг механизм руу шилжүүлэхэд анхаарах ёстой.

Түүнээс биш хөгжлийн бодлогын хууль өөрөө бас дэвшил байсан. Үүний дагуу Эдийн засаг, хөгжлийн яам нь өөрөө энэ 4 жилийн хөтөлбөрөө, энэ жилийнхээ төлөвлөгөөг Их Хуралдаа тайлагнадаг, хэлэлцдэг, гол бодлогоо авч явдаг ийм төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоо руу шилжсэн. Тэгэхээр шинэ механизм үйлчлээд байна гэсэн үг.

Сая хамтарсан Засгийн газар байгуулагдахад Засгийн газрын Хэрэг эрхлэх дээр байсан хяналт хэрэгжүүлэх чиг үүргийг салгаад бие даасан сайдтай болоод агентлаг тусдаа ажиллаад эхлэхээр тогтолцооны хувьд маш бэрхшээлүүд бас байгаа. Бид нарт яг үнэнээ хэлэхэд. Яагаад гэвэл нэгтгэгдээд ирэхдээ Засгийн газар орох асуудал дээр нь Хэрэг эрхлэх хариуцаад байдаг. Яг хянах чиг үүрэг нь байдаггүй.

Тэгэхээр үүнийг хуулийн хүрээнд оновчлох зайлшгүй шаардлагатай.

Тэгээд Г.Очирбат гишүүний асуултад хариулахад аудитын зөвлөмжөөр арга хэмжээ авсан тохиолдол өнгөрсөн жил байгаагүй юм байна лээ шүү. Би худлаа яриад яах вэ. Тийм. Байгаагүй юм байна. 2023 оноос хяналт хэрэгжүүлэх газар үнэлгээ анх хийж эхэлсэн. Яамдаас зөвлөмжүүдийг хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд 2 аймгийн Засаг даргад арга хэмжээ авч байсан практик байдаг.

Түүнээс биш бусдаар огт авагдсан зүйл байхгүй.

Энэ жилийн хувьд аудитын зөвлөмжийг хүлээж аваад хариуцлага тооцвол Та бүхэн мэдээлье.

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан сайд хариулт өгье. Нэмж.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя.

Төв банк бодлогын шийдвэрээ өөрсдөө тайлбарлана биз.

Ер нь энэ шийдвэрийг нь Засгийн газар яаж харж байна вэ гэж асуух шиг боллоо. Маш зөв гэж харж байгаа. Маш зөв гэж харж байгаа.

Төв банкны бодлогын нэгдүгээр асуудал нь энэ төгрөгийн худалдан авах чадварын асуудал. Өөрөөр хэлбэл энэ сувгаараа ард иргэдийн өрхийн орлогын эдийн засгийн байдлыг нь хамгаалж байна гэсэн үг. Зээлийн хүү гурав, дөрөв дэх асуудал гэж үзжээ. Энэ удаа.

Ер нь макро бүх үзүүлэлтүүдийг нэг доор бүгдийг нь эерэг барих онолын болоод практикийн ямар ч боломж байдаггүй. Байдаггүй.

Бид өрхийн орлогыг дэмжиж байна гээд цалин пүнлүү бүх юмыг нь нэмлээ. Төсөв дээрээс. Үүнийг дагаад хэрэглээ нэмэгддэг. Хэрэглээ нь хаана очиж суух вэ. Манайх дотоодын үйлдвэрлэл бага учраас импорт дээр очиж суудаг. Энэ нь ханшид нөлөөлдөг. Эргээд инфляцад нөлөөлдөг. Дээрээс нь олон улсын энэ гадаад худалдааны байдлууд гээд биднээс шалтгаалахгүй.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Б.Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Импортолж авдаг.

Тийм учраас энэ олон хөтөлбөрүүдийг Ерөнхийлөгчийн түвшинд ч тэр, Засгийн газрын түвшинд ч тэр санаачлаад бид бүрэн дэмжээд ажиллаад явж байгаа. Ийм зүйлүүд байгаа. Хөтөлбөрүүдийн талаар Ж.Энхбаяр сайд тоон үзүүлэлтүүдээр нь илүү тодорхой ярих байх.

Тийм учраас Төв банкны мөнгөний бодлого хатуу төлөвтэй байгаад зөв гэж харж байгаа шүү. Тийм. Харин тодорхой ямар хугацаанд хэрэгжих вэ гэдэг маань энэ олон хөтөлбөрүүд, дотоодын үйлдвэрлэлээ бид яаж хамгаалах вэ, яаж сэргээх вэ, энэ олон том мега төслүүд маань хэр хэмжээнд хурдан эргэлтэд орж өгөөжөө өгөх вэ. Энэ бүхнээс л шалтгаална.

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Хөдөө аж ахуй халамжийн яам гэж шүүмжлэлтэй хандаж байна.

Хөдөөгийн хөгжил нь өөрөө Монгол Улсын гол бодлого байх ёстой. Хөдөөд хүн ажиллах, амьдрах, бизнес эрхлэх тэр таатай нөхцөлийг бүрдүүлж байж улс орны гол сорилт болоод байгаа төвлөрлийг сааруулна, хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ, нүүдлийн соёл иргэншлээ хадгална.

Иймд Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны гол бодлого хөдөөгийн хөгжил рүү чиглэж байгаа.

“Хүнсний хувьсгал” бодлогын хүрээнд 1.2 их наяд төгрөгийн зээл гарсан. 3146 аж ахуйн нэгжид зээл очсон. 39 шинэ үйлдвэр ашиглалтад орж, 350 шинэ төрлийн хүнсний бүтээгдэхүүн бий болоод худалдаанд нийлүүлэгдээд байна.

Та бүхэн худалдан авч байгаа хүнснийхээ бүтцийг хараарай. Хэдэн хувь нь Монгол Улсад тарьж, ургуулж бий болсон байна вэ гэж.

Хүнсний 8 нэрийн барааны.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайд гүйцээж хариулъя. 1 минут.

Ж.Энхбаяр: Хүнсний 8 голлох нэрийн 16 хүнсний бүтээгдэхүүн хангамж 2021 онд 54 хувьтай байсан. 23 жилийн эцсийн байдлаар 74.5 хувьд хүрсэн. Энэ бол маш том амжилт.

Монголчууд тарьдаг, ургуулдаг, үйлдвэрлэдэг, бүтээдэг, улмаар хүнс экспортолдог болсон.

Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспорт 1 тэрбум доллар дөхөж явна.

30 жилийн Монгол Улсын үе үеийн Засгийн газрын мөрөөдөл байсан махны экспорт амжилттай явж байна. Жилдээ 80, 90 мянган тонн. 300-аас дээш сая долларын мах экспортолдог болсон. Хамгийн үнэтэй махны зах зээл Арабын орнууд, Ойрх Дорнодын орнууд, Төв Азийн орнууд, хоёр хөршдөө, Зүүн Өмнөд Азийн орнуудад Монгол мах амжилттай борлож эхэлж байна.

Үүний цаад үр дагавар нь яам, салбар ажлаа хийсэн гэсэн үг шүү дээ. Гадаад худалдаа, зах зээл нь тэлж, мал эмнэлгийн бодлого, вакцинжуулалтын ажил амжилттай хэрэгжиж, газар тариаланд чиглэсэн тариаланч, ногоочид руу чиглэсэн бодлого амжилттай.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайдад дахин 1 минут нэмж өгье. Та товчхон хариулахгүй бол. Дэгээрээ л явахгүй бол болохгүй дээ.

Ж.Энхбаяр: 2021-2025 онд Монгол Улсын хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн салбарын үр ажлын үр дүнг 75.6 хувиар үнэлсэн. Сайн гэж үнэлсэн. Үр дүнтэй гэж үнэлж байгаа шүү. Г.Очирбат гишүүн ээ.

Ноолуурын асуудлыг хэлэхгүй бол болохгүй. Цаг уурын сая хүндхэн айхтар үеийг даваад тууллаа. Одоо ноолуур бэлтгэл, самналт ид үргэлжилнэ.

“Цагаан алт” хөтөлбөр бодлого зарлагдаад нэг сар болж байна. Үйлдвэрүүд бэлтгэлээ хангаж байна. Монгол Улс түүхий ноолуураа гаргадаг байсан бол 100 хувь угаадаг болсон. Одоо 100 хувь самнадаг болно. Ингэснээр дотоодын үйлдвэрлэл, ажлын байр бий болгоно. Монгол Улсын өрсөлдөх чадвар сайжирна.

Бид ноолуураас нэг жилдээ 404 сая доллар олдог байсан бол бид тэрбум доллар олдог ийм эдийн засгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэхийн төлөө ажиллаж байгаа.

Махны талаар хэллээ. Мах 100 хувь экспортод чөлөөтэй гарч байгаа. Бэлтгэж, нийлүүлж, гэрээ хийж чадсан аж ахуйн нэгж болгонд ямар нэг хязгаарлалт, квотгүй махны экспортыг чөлөөтэй явуулж байгаа.

Сая сар шинийн өмнө зохион байгуулалттай үнийг хөөргөдөх зарим нэг илрэл гарсан тул техникийн зохицуулалтыг Засгийн газар богино хугацаанд хийгээд 9 мянган тонн махыг нийслэл, хүн ам төвлөрсөн газарт зориулж бэлтгээд, экспорт одоо жигд яваа.

Нэг том өөрчлөлт гарсан. Малчдын мал маллах арга ухаанд, аж ахуйн нэгжүүдэд. Өвөл өнтэй сайхан боллоо. Нөгөө талаар энэ газар тариалангийн эрчимжүүлэлтийн үр дүнд 270, 280 мянган тонн тэжээлийн баазыг бид бэлдлээ. Тасралтгүй мал тэжээж байна.

Өнөөдөр 4 сар болж байхад мах бэлтгэл явагдаж байна. Хэзээ бид ийм байсан юм. Тийм биз. Одоо үүнийгээ улам үргэлжлүүлж жилийн турш тасралтгүй мах, мал бэлддэг, экспортод гаргах чадварыг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн тодруулж асууя.

Г.Очирбат: Инфляц өссөнтэй холбоотой дотоодын нэр төрлийн 12 бүтээгдэхүүн хамгийн үнэтэйгээр нөлөөлсөн. Эрчтэйгээр.

Түүний гол 12 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний 4.8 хувь нь хонины мах, ястай мах, мах, махан бүтээгдэхүүн. 2.3 хувь нь гурил, тариа, гурилан бүтээгдэхүүн.

Ингэхээр бид сүүлийн 3, 4 жилийн хугацаанд үүнийг бодлогоор дэмжиж инфляцыг л бууруулах гэж байсан. Ингээд байгаа оноогүй.

Би танаас асууж байгаа асуулт бол яам мэргэжлийнх байх ёстой. Дандаа ингээд дотаци өгөөд яваад байх юм уу? Нэг бол бодлогоор хөгжүүлж байгаа салбараа бусад улс орны жишээтэй адилхан гаалийн татвар дээр нь, татвар дээр нь хөнгөлдөг ийм бодлогын шийдвэрүүдийг гаргаж дэмжих юм уу? Зах зээлийг нь хамгаалдаг. Тэгэхгүй мөнгө өгөөд л байвал энэ чинь үр дүнд хүрэхгүй байна гэдэг нь харагдаж байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр бодлогын шийдвэр гаргах хэрэгтэй байна гэдгийг нэгд хэлээд байгаа юм.

Хоёрт гэх юм бол Н.Учрал сайдын хэлж байгаа бол зөв өө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Дэлхий нийтийн хамгийн тулгамдсан асуудал хүнсний хангамж болж хувирч байгаа. Хангамж, хүртээмжтэй байдал. Дараа нь чанарын асуудал яригдаж байна.

Бүх улс орон дотоод үйлдвэрлэл, чадавхаа нэмэгдүүлж байна. Монгол Улс энэ бодлогыг хэрэгжүүлж байгаа.

Бид хүнсний нөөц, хүнсний чадавх тийм сайн биш байгаа. Ковидын сургамж. Ахиад нэг сар ковидын хугацаа үргэлжлэхэд бид ард түмнээ картын бараанд оруулахаас аргагүй байдалтай байсан.

Иймд яаралтай хүнсний нөөцийг бүрдүүлэхийн тулд мал аж ахуйн салбарыг, газар тариалангийн салбарыг, хөнгөн хүнсний салбарыг шийдэмгий дэмжих хэрэгтэй.

Нэг том зүйл байгаа. Хувийн хэвшилдээ мөнгө өгч байгаа. Сайд 5-хан тэрбумын хөрөнгө оруулалттай. 99.5 хувь нь хувийн хэвшилд бодлогын дэмжлэг болж очиж байгаа. Хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт хийх, үйлдвэрээ тэлэх, бизнесээ өргөжүүлэхэд зориулж байгаа. Үр дүн сайн гарч байна.

Тэгэхээр энэ бодлогыг цаашдаа тогтвортой авч явах ёстой. Тэгж байж бид ирж болзошгүй аюул заналыг сөрж гарна.

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн тодруулж асууя.

Г.Очирбат: Ойлголоо. Мэдээж бодлого хэрэгжээд, инфляцад нөлөөлөөд монгол төгрөгийн ханш үнэ цэнтэй байх болтугай гэж ерөөе дөө. Нэг.

Хоёр гэх юм бол ингээд нэг хумсаа нуусан муур шиг баймааргүй байна шүү. Ингээд Байнгын хороод дээр харахаар дандаа Ардчилсан намын сайд нар луу дайрдаг. Асуулт асууя гэдэг. Энэ чинь сүүлийн 4 жилийн Ардын нам засаг барьж байсан үеийн л ажлыг бид яриад байгаа шүү дээ.

Ингээд 2024-2028 онд хамтдаа зүтгээд улс эх орноо хөгжүүлэе л гэж байгаа. Нэг хүнд ногдож байгаа дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ үнэ цэнийг өсгөө, 10 мянган долларт хүргэе л гэж байгаа, эдийн засгаа тэлье л гэж байгаа. Тэгж байтал дандаа улс төржсөн байдлаар явах юм бол бид бас энд улс төржиж чадна шүү. Өнөөдрийг хүртэл улс төржөөгүй байгаа.

Тэгэхээр Ардын намын сайд нар Их Хурлын гишүүддээ бас хэлэх ёстой шүү. Бодлогын бүлэг дээр шийдвэрээ гаргаад хамтраад цаашаа явахгүй бол байнгын нэг дайруулсан. Тэгээд л нэг юм хэлэхээр өөдөөс нь юм асуусан. Энэ чинь сүүлийн 4 жилийн Ардын нам дангаараа засаг барьж байсан үеийн юмыг л ярьж байгаа шүү дээ. Бид нар. Тэгээд түүн дээрээ анхаараарай гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Гишүүд ээ. Нэг ийм зүйл байна.

Хүн амын маань 70 хувь хот суурин газар суучихлаа. Амьдралын хэвшил өөр. 30 хувь нь хөдөө орон нутагт ажиллаж байна.

Мах, гурил хямдхан байлгах хотын хүсэл санаа. Нөгөө талаар нутаг орны эзэнтэй байлгах, тэнд мал маллах, тариа эрхлэх, орлоготой байлгах гол бодлого. Энэ тэнцвэрийг л бид зөв олж авах хэрэгтэй.

Хөдөөгийн хөгжил байхгүй бол хотод төвлөрөл үүсэж байна. Ямар асуудал үүсэж байгааг бид харж байгаа шүү дээ. Иймд хөдөөг хөгжүүлэх бодлого маань өөрөө цаанаа их нарийн учир шалтгаантай гэдгийг сайн ойлгомоор байна.

Инфляц. Хамгийн гол нь махны хүрэлцээ хангалттай байна, гурилын хүрэлцээ хангалттай байна, өргөн нэрийн бараа, хүнс нэмэгдэж байна. Нэмэлт үүсэж байна. Эрчим хүч, тог цахилгаан, цалин хөлс, олон зардал өсөж байгаа. Өндөр өсөж байгаатай харьцуулахад хөдөө аж ахуйн суурь бүтээгдэхүүний үнэ 1 хувийн, 2 хувийн өсөлт бол маш бага өсөлт байгаа шүү. Маш тогтвортой байгаа гэдгийг ойлгох хэрэгтэй.

Энэ хөдөө аж ахуй.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хөдөө рүү чиглэсэн бодлогыг ч бас халамж ч гэж шууд хэлж болохгүй байх. Г.Очирбат гишүүн ээ. Ер нь.

Өмнөговь, Орхон, Дорнод, Дорноговийг тооцохгүйгээр ер нь 20-хон хувь нь л хөдөөд байгаад байгаа шүү дээ. Хөдөөд ард иргэдэд илүү амьжиргаагаа дээшлүүлэх боломж бололцоо маш хомс байна. Уул уурхай хөгжөөгүй аймгууд зөвхөн мал аж ахуйн хөгжлөөр л хөгжлөө тодорхойлох нөхцөлтэй. Тийм ээ.

Гэтэл арилжааны банкнаас олгогдож байгаа зээлийн 20-хон хувь нь хөдөөд байж байна. Олгогдож байгаа зээлийн хүү хөдөөд хамаагүй өндөр байна шүү дээ. Хотод олгогдож байгаа зээлийн хүү 17, 18 хувьтай байж болж байхад хөдөөд олгогдож байгаа нь 22-оос 24 хувийн хүүтэй зээл олгож байна.

Тэгэхээр нөгөө орлого багатай, өндөр хүүтэй зээлээр амьжиргаагаа тэтгэх боломж гэдэг зүйл орон нутагт огт байхгүй болчихсон зүйл байгаа юм.

Тэгэхээр цаашдаа Засгийн газраас, Улсын Их Хурлаас баримтлах бодлого илүү хөнгөлөлттэй нөхцөлийг л орон нутаг руу чиглүүлж өгч байж хотын хүн амын төвлөрлийг багасгах, хөдөөгийн хүн ам, айл өрхийн хөгжлийг дэмжих, хүн амын төвлөрөл нь бий болох. Тийм ээ. Бизнес, арилжааг хийх тэр боломжийг нь бүрдүүлж өгөхөд маш олон талын өндөр ач холбогдол байгаа юм.

Тэгэхээр энэ дээр Ж.Энхбаяр сайдын ярьж байгаа энэ олон талын ач холбогдлыг бодитой болгох чиглэл дээр Улсын Их Хурал бас бодитой дэмжлэг үзүүлж ажиллах нь зөв юм гэж бодож байгаа.

Болдын Уянга гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Уянга: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл гэх бичиг баримтуудтай холбоотой. Энэ дээр төвлөр асуулт асууя.

2021-2025 онд Монгол Улсын хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл шаардлагатай 98 төсөл, арга хэмжээ тусгагдсан байгаа юм.

Тэгээд гүйцэтгэлийг нь Үндэсний аудитын газрын тайлан дээр, дүгнэлт дээр хараад дүгнэхэд 98 төсөл, арга хэмжээний 43 нь техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл байхгүй тул хэрэгжээгүй.

Тэгээд шалтгааныг нь задлаад харахаар нотлох баримтгүй 18.

Тэгэхээр Үндэсний аудитын газрынх нь нотлох баримтгүй гэдэг дотор яг юу юуг оруулаад байгааг тайлбарлаад өгвөл хэрэгтэй байна. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл боловсруулах шатдаа байгаа нь 9 юм байна. Тэгээд санхүүжилт байхгүй. Энэ нь шийдвэрлэгдээгүй 9 гээд 43. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл шаардлагатай хэрэгжээгүй төсөл, арга хэмжээнүүд маань ингээд задарч байгаа байхгүй юу.

Тэгэхээр 2021-2025 ондоо хэрэгжиж амжаагүй, ТЭЗҮ нь одоо хийгдэж байгаа энэ 9 төсөл ч юм уу. Тийм ээ. Эдгээр төсөл, арга хэмжээ 2025 оноос үргэлжлээд явах уу? Дараагийн үндсэн чиглэлдээ тусгагдаад явах уу?

Ингээд хуулиа судлаад үзэхээр ер нь техник, эдийн засгийн үндэслэл гэдэг зүйлийг Төсвийн тухай хууль дээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль дээр ингээд оруулсан байдаг юм байна л даа. Нэг жилээс дээш хэрэгжих төслүүд дээр. Тэгээд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа тохиолдолд техник, эдийн засгийн үндэслэлийг нь мэдээж хийх төсвийг нь улсын төсөвт суулгаад явах ёстой байх.

Тэгээд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.2-т болохоор аливаа энэ хөтөлбөрт тусгагдаж байгаа төслүүд нь санхүүжилтийнх нь эх үүсвэр нь тодорхой байх ёстой юм байна. Хөрөнгө оруулалтынх нь хэмжээг урьдчилсан тооцсон, хариуцах эзэнтэй, үндэслэл зураг, төсөв нь батлагдсан ийм төслүүдийг болохоороо хөтөлбөрт тусгах ёстой байтал Үндэсний аудитын газрын тайланг харахаар тусгаагүй төслүүд байсан юм байна. 43 нь хэрэгжээгүй 98 төслөөс байна.

Тэгэхээр ер нь энэ улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдэд ТЭЗҮ хийнэ гээд байгаа нь яг ямар журмын дагуу явж байгаа юм бол? Зүгээр

хөндлөнгөөс харахад нэг л тийм ТЭЗҮ хийнэ гэдэг нэг бизнесийн шинж чанартай болчихсон юм шиг. Аягүй өндөр өртгөөр хийдэг юм шиг. Нэг иймэрхүү ажиглалт бол байгаад байгаа.

Тэгэхээр үүн дээр хариулт бас аль сайд маань хариулах ёстой юм. Холбогдох хариултаа хэлээд өгөөрэй. Ер нь ямар асуудлууд техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах дээр гарч байгаа вэ?

Д.Амарбаясгалан: Эхлээд Үндэсний аудитын газраас хариулт өгье. Д.Загджав дарга. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Б.Уянга гишүүний асуултад хариулъя.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.2-т шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл нь батлагдсан байх гэж заасан байна. 1.10-д улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд туссан 205 шалгуур үзүүлэлт бүхий 194 төсөл, арга хэмжээнээс техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл шаардлагатай 122 төсөл, арга хэмжээ байна.

Төсөвтэй нь 96 байна. Техник, эдийн засгийн үндэслэл тооцоогүй нь 26 байгаа юм.

Д.Амарбаясгалан: Энэ ч тоо ч асуугаагүй байх. Л.Гантөмөр сайд энэ ТЭЗҮ-тэй холбоотой асуудал дээр ер нь Эдийн засаг, хөгжлийн яам цаашдаа хэрхэн анхаарч, яаж ажиллах шаардлагатай юм. Ер нь энэ бас жоохон тодорхой байх шаардлага байна л гээд л яриад байна. Л.Гантөмөр сайд хариулъя.

Л.Гантөмөр: Б.Уянга гишүүний асуултад хариулъя.

Ер нь таван жилийн хөгжлийн бодлого өнөөдрөөр дараагийн хөгжлийн үндсэн чиглэл батлагдсанаар ингээд дуусчхаж байгаа хэрэг биш шүү дээ. Мэдээж хамгийн сайн хэрэгжиж байгааг нь цаашаага бид үргэлжлүүлэх хэрэгтэй. Ингэж байж бодитой эдийн засгийн өсөлт бий болно.

Ер нь улс орны хөгжлийг харахдаа

- ▶ эдийн засаг,
- ▶ нийгмийн байдал,
- ▶ байгаль орчин гэдэг 3 үндсэн ойлголт дээр яваад байгаа юм.

Боловсрол гэхэд л боловсрол дээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүд үргэлжилнэ. Шинжлэх ухаан дээр хэрэгжүүлж байгаа ажлууд үргэлжилнэ. Сая хөдөө аж ахуйн салбарын бодлогоо ярьж байна шүү дээ. Энэ

чинь их урт хугацаанд явж байж үр дүн гардаг болохоос биш таван жил явлаа. Одоо хаалаа. Дараагийнх гэдэг юм байхгүй.

Тийм учраас таны хэлж байгаа өнгөрсөн таван жилд хийгдэж амжаагүй зарим ажлууд техник, эдийн засгийн үндэслэлгүйгээс болоод хийгдээгүй байх юм бол энэ техник, эдийн засгийн үндэслэлүүдийг бид хийгээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Л.Гантөмөр: Уучлаарай. Аягүй хурдан дуусдаг юм.

Ингээд тусгаад явна. Нэг.

Хоёрдугаарт, ер нь өнгөрсөн жилээс эхлээд сүүлийн 3 жил Эдийн засаг, хөгжлийн яаман дээр техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажил хийгдэж байгаа. Энэ юу вэ гэхээр зэрэг өөрийнхөө төсвийн орлого, төсвийн зардалтайгаа уялдуулаад ер нь техник, эдийн засгийн үндэслэлтэй ажлуудаа төсөвт тусгая гэж байгаа юм.

Тэгээд харамсалтай нь жишээлбэл 2025 оны төсөвт техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зардал хоёр дахин буурчихсан. Үүнийг Их Хурал сайн дураараа шийдчихсэн. Одоо тэгээд бид жишээлбэл 2026 оны төсөв ярихад техник, эдийн засгийн үндэслэлтэй ажил чинь их цөөрөх нь байна шүү гэдэг ийм зүйлтэй тулгарах жишээтэй. Тийм ээ.

Тийм учраас 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг гаргахдаа бид дандаа төсөвтэй нь уячихсан байгаа юм. Төсөвтэй уяна гэдэг бол техник, эдийн засгийн үндэслэлтэй төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ гэсэн үг. Тийм ээ.

Тийм учраас 2026 он ч ялгаа байхгүй. Бид удахгүй 2026 оны.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Л.Гантөмөр сайдад баярлалаа.

Тэр чиглэлийн асуулт бүрэн авлаа гэж бодъё. Үндэсний аудитын газрын яг энэ тайланг нь бичсэн газрынх нь дарга нь ч юм уу хариулбал яадаг юм бол. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл гээд танайхаас тарагдсан аудитын тайлангийн 29 дүгээр хуудсын 2.35-д бичсэн зүйлийг би асуугаад байгаа юм.

Энэ бичсэн тоог буруу хэлнэ гэж бол байхгүй шүү дээ. Ямар ч хүн гэсэн. Одоо яг тэр газрын дарга нь хариулаад. Д.Загджав дарга биш. Яг үүнийхээ дүрслэл 11 гэдгийг нотлох баримтгүй гээд 18 төсөл, арга хэмжээг тавьчихсан

байх юм. Энд яг юу хэлээд байгаа юм? Ядаж энэ дээрээ яг нэг тийм бодит хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Аудитын газар. Хэн хариулт өгөх вэ? Ажлын хэсгийн 10 дугаар микрофон. Д.Загджав дарга хариулт өгье.

Д.Загджав: Б.Уянга гишүүний асуултад тодорхой хариулаад байгаа л даа.

Манайд материал өгөөгүй байгаа. Нотлох баримтгүй зүйл дээр бид юу гэж дүгнэлт хийх вэ. Энэ тоо бол гаргасан аудитын ажлын үр дүн байгаа. Материал байхгүй болохоор боломжгүй байдаг.

Д.Амарбаясгалан: Материал байхгүй. Дүгнээгүй гэж байна. Тодруулах юм уу? Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Би нэг санал, хоёр асуулт асууя.

Бид одоогоос 2 жилийн өмнө хувийн хэвшил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олон шат дамжлагатай байгаа хяналт шалгалтыг цөөрүүлэх зорилгоор мэргэжлийн хяналтын тогтолцоог өөрчилж, бүтцийн өөрчлөлт хийсэн. 2 жил боллоо. Энэ хугацаанд ямар ахиц өөрчлөлт гарав? Энэ дээр энэ хяналт шалгалт хариуцсан, энэ асуудал эрхэлсэн яам, Засгийн газар ер нь үнэлгээ, дүгнэлт хийсэн зүйл байна уу? Үнэхээр жижиг, дунд бизнес эрхлэгчдэд нэмэртэй, давхар шат дамжлага байхгүй, дарамт байхгүй болж чадсан уу, үгүй юу? Энд тэнд хоолны асуудал, хүнсний асуудал, тэгээд л барилгын кран уналаа гээд асуудлууд гараад байгаа.

Ер нь салбаруудад мэргэжлийн хяналтын стандартыг хэн мөрдүүлж байна аа? Энэ чиглэл дээр Засгийн газар ямар бодол, байр суурьтай байгаа вэ? Цаашдаа ер нь энэ мэргэжлийн хяналтын тогтолцоогоо эргэж харахгүй юм уу?

Асуудлууд гарахгүй байгаа учраас л бид ингээд яваад байгаа. Цаашдаа гарвал энэ асуудлуудад ямар хариуцлагын асуудлууд яригдах юм бэ? Энэ дээр Засгийн газар хариулт өгөөч гэж.

Хоёр дахь асуудал. С.Одонтуяа сайд, С.Бямбацогт сайд нар хариулж өгөөч.

Бага хангай дүүрэгт байрладаг зэвсэгт хүчний 337 дугаар ангийн мэдлийн нисэх онгоцны ангарт сүүлийн 10 гаруй жил нийтдээ 120 тонн аюултай хог хаягдал өнөөдөр хадгалагдсаар байна.

Дүүргийн хүн амын суурьшлын бүсээс 1 километр хүрэхгүй зайтай, хүн амын ундны усны эх үүсвэр дээр. Тэгээд өнөөдрийг хүртэл сүүлийн 12, 13 жил дүүрэг, орон нутгийн төр, захиргааны байгууллага, иргэдийн санал, гомдлын

дагуу бүх шатын төрийн байгууллагуудад асуудалд хандаад өнөөдрийг хүртэл 12, 13 жил шийдэгдэхгүй явж ирж байна. 120 тонн химийн аюултай хог хаягдлын бодис.

Энэ дээр цаашдаа Засгийн газар, Байгаль орчны яам хүний амьдрах эрх, аюулгүй орчинд амьдрах Үндсэн хуулийн заалтыг яривал олон асуудлууд зөрчигдөж байгаа. Энэ дээр салбарын сайд нарт мэдээлэл байна уу, үгүй юу гэдэг дээр нэг хариулт өгөөч.

Гурав дахь нь, би Сангийн сайд Б.Жавхлан сайдаас асуух гэж байгаа юм.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль өнгөрсөн жил батлагдсан. Ингээд 6 сарын 01-нээс хуулийн зарим өөрчлөлтүүд мөрдөгдөж эхэлж байгаа. Ирэх жилийн 01 сарын 01-нээс хууль хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлнэ.

Яг одоо Сангийн яаман дээр 2026 оны төсвийн төлөвлөлт боловсруулалтын шат хийгдэж байгаа байх. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуультай холбогдуулаад ирэх жилээс бид зөвхөн Улаанбаатар нийслэл хот ганцхан хоттой байсан бол ирэх жилээс 5 хоттой болох, улсын зэрэглэлтэй болох, 14 дагуул хоттой байх энэ асуудлууд энэ хуулийн хүрээнд хэрэгжиж эхэлнэ.

Ингэхээр төсвийн хуваарилалт, төлөвлөлт дээр өөрчлөлт гарах ёстой. Танай яам энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуультай холбогдуулж энэ улсын зэрэглэлтэй бие даасан хотууд дээр төсвийн ямар өөрчлөлт гарах юм? Ямар татвар хураамж аль шатдаа хураагдах юм?

Тэр Дархан, Эрдэнэт хотууд бас газрын асуудлаас болоод нэлээн асуудал маргаантай байгаа гэж сонсогдож байсан. Багануур, Налайх дүүргүүд бие даасан улсын зэрэглэлтэй хот болох ёстой. Газар, орон нутгийн хувьд ямар ч маргаангүй байгаа. Энэ дээр Сангийн яам төсвийн төлөвлөлтийнхөө боловсруулалтын шатад ямар ойлгоц, хандлагатай явж байна вэ? Энэ хуулийг хэрэгжүүлэх тал дээр ямар бэлтгэл хангаж байгаа вэ гэдгийг нэг тодруулж хариулж өгөөч. Ийм гурван асуулт байна.

Д.Амарбаясгалан: С.Одонтуяа сайд эхлээд хариулт өгье.

С.Одонтуяа: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Тухайн үед 2011 онд Зэвсэгт хүчний жанжин штаб энэ “Тамбов цэргийн химичид” гээд төрийн бус байгууллагатай хамтраад гэрээ байгуулаад тэндхийн ангарт энэ зүйлийг хадгалж байгаа.

Тэгэхээр тус бодисууд нь ер нь шинжилгээнд ашиглаж байгаад үлдсэн химийн бодисуудын үлдэгдэл байгаа юм.

Тэгэхээр үүнийг Ц.Сандаг-Очир гишүүн ээ, хоёулаа хамтраад 2026 оны төсвөөр шийдье гэж бодож байна.

Яагаад гэхээр энэ бүүр С.Оюун сайд байхад тэр үеэс л иргэд нь бичиг бичээд л байдаг, бичээд л байдаг. Тэгээд энэ төсөв нь жил болгон л хасагддаг юм билээ.

Тэгэхээр би энэ жил төсвийн саналдаа энэ зардлыг нь тусгаад оруулаад ирье. Та харин Улсын Их Хурал дээр үүнийг дэмжүүлэх хэрэгтэй байна.

Яагаад гэхээр одоо Сэргэлэн сумд 20 га газарт энэ аюултай хог хаягдлын ийм том байгууламж байгуулахаар Засгийн газар шийдвэрлэсэн. Энэ ажил хийгддэгээрээ хийгдэнэ.

Ер нь 2019 оноос эхлээд энэ аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахуудыг 16 аймагт байгуулаад ажиллаж байгаа. Тэгээд энэ төрийн бус байгууллагынх нь тэргүүн нь нас барчихсан юм билээ. Тэгээд энэ асуудал ингээд замхраад, иргэд нь байнга гомдол мэдүүлдэг.

Тэгэхээр 2026 онд үүнийг хамтраад шийдье гэсэн саналтай байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Хот, тосгоны хууль хэрэгжиж эхлэхтэй холбогдуулж төсвийн ерөнхий хууль дээр ямар ч өөрчлөлт ороогүй. Орох шаардлагагүй болов уу гэж харж байгаа.

Хуулийн шинэ зохицуулалтаар улсын зэрэглэлтэй хот гээд нэгжийн хувьд статус өөр орж ирж байгаа хэдий ч төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд ямар ч ялгаа байхгүй. Түвшний хувьд.

Тийм учраас шинээр зохицуулалт хийх шаардлага үүсэхгүй байгаа учраас энэ дээр тусгайлан өөр зохицуулалт хийх юм уу, эсвэл журмаар зохицуулалт хийдэг ч юм уу, эсвэл төсөвтэй холбоотой өөрчлөлтүүд оруулах ийм шаардлагагүй гэж үзэж байгаа. Тийм.

Д.Амарбаясгалан: Мэргэжлийн хяналт. Засгийн газрын Н.Учрал сайд байна уу? Э.Одбаяр сайд хариулт өгөх үү? Эрдэнэбилэгийн Одбаяр сайдад хариулт өгье.

Э.Одбаяр: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Салбарын хяналттай холбоотой асуудлыг асууж байх шиг байна. Тэгээд үүний өмнө бас нэг тайлбар хэлэх нь зөв байх.

Монгол төрийн бодлого тасралтгүйгээр үргэлжлэх ёстой. Энэ шийдвэрийг гаргаад 3 жил орчим болж байгаа. Тэгээд мэргэжлийн хяналтыг татан буулгаад оронд нь зөрүүлээд юу вэ гэхээр логикийн хувьд ард иргэд рүүгээ, бизнес рүүгээ чиглэж байгаа дарамтаа багасгаад, засаг дотроо, төр дотроо дотоод хяналтаа нэмэгдүүлбэ гэдэг энэ бодлого, концепцын хувьд энэ ажил хийгдсэн гэж харж байгаа.

Тэгэхээр энэ ажлаа бас нэг бүтэн явуулаад, бүтэн дүгнэлт хийх хугацаа гарсны дараа ахиад ярих нь зөв байх гэж харж байгаа.

Өнөөдрийн байдлаар салбарын яамдууд дээр ажиллаж байгаа салбарын хяналтын улсын байцаагч нарыг хооронд нь бодлого, уялдааг нь хангах, иргэд, аж ахуйн нэгж дээр очиж байгаа давхардсан хяналт шалгалтыг цэгцэлж, цөөлөхийн тулд салбарын сайд нарыг оруулсан Хяналт үнэлгээний Үндэсний хороог ажиллуулаад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье. Гүйцээж хариулъя.

Э.Одбаяр: Тэгээд иргэд, аж ахуйн нэгж дээр очиж байгаа тэр хяналт шалгалтын давхардлыг арилгах чиглэлээр механикаар ажиллагаануудыг бас хийж байгаа.

Ер нь цаашдаа яах вэ гэдгийг бас салбар салбар дээрээ ярьж байгаад нэгдсэн дүгнэлтэд хүрэх байх. Гэхдээ одоо саяын хэлдэг үндэслэлээр цаашаа энэ ажлаа явуулах нь зөв байх.

Түрүүн бас ганц нэг гишүүдийн асуултад бас дурдагдаж байх шиг байна. Г.Лувсанжамц гишүүн Байнгын хорооны хурал дээр асууж байсан. Ер нь энэ төлөвлөлт, тайлагналт, хяналттай холбоотой асуудлыг хэдүүлээ нухацтай ярьж байгаа нь би зөв гэж харж байгаа.

Гурван газраас гурван тоо ороод ирдэг. Тэгээд ажил хийсэн хүмүүс тоогоо хамгаалдаг. Тэгээд энэ Их Хурал дээр орж ирээд мэтгэлцээд байдаг ийм юмнууд байгаад байгаа.

Тэгэхдээ үүнийг Ерөнхий сайдын хувьд бас манлайлал үзүүлээд хараад Тэргүүн шадар сайд, Хэрэг эрхлэхийн дарга, миний бие, Сангийн сайд орсон ажлын хэсэг гараад ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Энэ мэргэжлийн хяналтын холбоотой асуудлыг Засгийн газар цаашдаа эргэж харж, ямар ахиц өөрчлөлт гарсан гэдгийг нэг эргэж дүгнэмээр байгаа юм.

Тэгэхгүй бол манайх шиг ийм стандартад дургүй, стандартыг мөрдөж ажиллаж чаддаггүй энэ хэмжээнд мэргэжлийн хяналт үргэлж хэрэгцээтэй байгаа. Нийгэмд шаардлага байгаа.

Тэгээд цаашдаа асуудал гарвал Улсын Их Хурал өөрөө хуулийг нь байхгүй болгочихсон, бүтцийг нь өөрчилчихсөн, татан буулгачихсан гэдгээр Улсын Их Хурал өөрөө буруутах асуудал руу орох гэж байгаа юм.

Тэгэхээр энэ дотоодын хяналт шалгалт чинь яг тэгж тэр хэмжээндээ ажиллаж чадаж байна уу, үгүй юу, сайжирч чадсан уу, үгүй юу. Үүнийг нэг эргэн харж, үнэлгээ дүгнэлт өгч, цаашдаа энэ бүтцийг байлгах юм уу, байлгахгүй юм уу гэдэг асуудлаа бас нэг эргэж харах шаардлагатай юм болов уу гэж би хувьдаа үзэж байгаа юм.

Тийм учраас энэ асуултыг асуусан юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ер нь Ц.Сандаг-Очир гишүүн ээ, мэргэжлийн хяналт нэгдсэн байдал нь татан буугдсан болохоос хяналт бол бүр байхгүй болоогүй шүү дээ.

Хуулиараа салбарын хяналт. Стандартад суурилсан салбарын хяналт гэдэг зүйл одоо хэрэгжиж байгаа юм. Манай мэргэжлийн хяналтын байгууллага ерөнхийдөө олон нийтийн дунд нэр хүндээ алдчихсан, олон талын давхардсан хяналтыг аж ахуйн нэгж, иргэнд үзүүлдэг дарамталдаг. Нөгөө хүн нь байвал хэрэг нь олдоно гэдэг шиг байгууллага дээр очиж ямар нэгэн байдлаар хяналт хийхэд заавал асуудал үүсгэж дарамталж байдаг. Тэрийгээ дагасан хууль бус шаардлагуудыг тавьж байдаг гээд их олон зүйлүүд үүссэн учраас энэ мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдах нөхцөл бүрдсэн.

Цаашдаа төр иргэнээ хянаж цагдана гэхээсээ илүүтэйгээр мөрдөх ёстой стандартыг тодорхой болгож, иргэн, аж ахуйн нэгж тэр стандартын дагуу үйл ажиллагаа явуулдаг л тийм XXI зууны арга барилтай хяналт шалгалтын тогтолцоо бий болох ёстой байгаа юм.

Харин энэ Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар чинь Засгийн газар дотоод хяналтаа сайжруулъя. Нэг ёсондоо өрсөлдөх чадвараа илүү дээшлүүлье, бүтээмжээ сайжруулъя гэдэг зорилго дээр дотоод хяналтын тогтолцоо бодитой бий болж ажиллаад эхэлчихсэн байгаа.

Э.Одбаяр сайдын хэлдэгчлэн одоо энэ хяналт хэрэгжүүлэх газар хуулийнхаа дагуу эрх, үүргээ хэрэгжүүлэх ёстой. Засгийн газрынхаа дотоод хяналтыг хуулийн дагуу өндөр түвшинд тавьдаг байх ёстой. Хариуцлагын асуудал ер нь хяналт хэрэгжүүлэх газар дээр өргөн хүрээгээр яригддаг болох учиртай байгаа юм.

Ерөнхий байдлаар ажиглаж байхад зарим сайд нар үүнийг бас их ойлгочихсон, агуулгын хүрээнд, хууль хэрэгжүүлэх хүрээнд хэрэгжүүлээд явж байдаг. Зарим яамд бас үүнийг хойрго хандаад байдаг тийм тал бас ажиглагддаг.

Тийм учраас хяналтын тогтолцоо гээч зүйлийг төр иргэнээ хянах гэхээсээ илүүтэйгээр төр өөрөө өөртөө хяналтаа тавиад, үр ашгаа нэмэгдүүлэх, шаардлагагүй бүтэц, орон тоог байхгүй болгох, хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага тооцдог болох гэдэг энэ зүйл дээрээ илүү анхаарлаа төвлөрүүлж ажиллах нь зүйтэй.

Харин мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа гэдэг бол салбарын хяналт дээр стандартад суурилсан хэлбэрээр явагддаг байх л ёстой.

Нэг л жишээ байдаг шүү дээ. Одоо төр иргэндээ зөвшөөрөл олгочоод араас нь хяналт тавиад яваад байдаг. Гэтэл төр өөрөө иргэндээ ямар стандартыг дагаж мөрдөх дээр нь илүү анхаарлаа хандуулаад стандартаа дагаж мөрдөөгүйтэй холбоотой асуудал үүсэх юм бол хариуцлага ярьдаг тийм тогтолцоогоо л бодитой бий болгохгүй арга барилын хувьд зохимжгүй байдаг юм.

Ингээд Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

Ж.Алдаржавхлан: Баярлалаа.

Эртээдийн чуулган Засгийн газрын гишүүд байхгүй болсноос хойш хойшлогдсон. Өнөөдөр асуулт асуух гэж байгаа ганц хоёр сайд нар байхгүй байна. Тэгэхдээ орж ирэх байх гэж бодоод асууя.

П.Наранбаяр сайд орж ирэх байх гэж бодож байна. Тэгээд орж ирэхээр нь хариултаа авъя гэж бодож байгаа.

Энэ гүйцэтгэл үзсэн чинь 2024 онд сургуулийн орчмын гэмт хэрэг 1675-аар нэмэгдсэн гэсэн тийм сэтгэл зовниулсан асуудал харагдлаа. Зөвхөн 2004 онд 1675-аар нэмэгджээ. Гэмт хэрэг. Сургуулийн орчны.

Үүнийг ер нь судалж үзсэн юм болов уу? Хүүхдүүд ер нь ямар гэмт хэрэг хийгээд байна? Энэ дээр Боловсролын сайд судалгаа, шинжилгээ хийж үзэв үү гэж. Үүнийг нэгд хариулж өгөөч.

Хоёрт нь, Монгол Улс байгаль орчны индексээр дэлхийн 180 орноос 177 дугаар байрт жагсаж, сүүлээсээ 3-т орлоо гэж ийм мэдээлэл гарсан байна.

Тэгээд мэдээж С.Одонтуяа сайдтай хамаагүй л байх. Энэ ер нь юунаас болоод, манайх ямар дүгнэлтэд ороод, ямар критер тавиад Монгол Улс хамгийн

адгийн байранд явж байдаг юм бэ? Үүнийг та салбарын сайдын хувьд бас судалж шинжилсэн юм байна уу? Хариулж өгөөч ээ гэж.

Гуравдугаарт, Эрчим хүчний сайдаас асуух гэсэн юм. Бас байхгүй байна. Зүгээр энэ бол ард түмэнд таалагдах гэж байгаа ч юм уу, оноо авах гэж байгаа асуулт биш.

Сая манай ард түмэн маань эрчим хүчний үнийн өсөлтийг бол ёстой нэг шүдээ зуугаад тэсээд гарсан. Одоо 5 сарын 01-нээс дулааны үнэ нэмэгдэх гэж байгаа. Тэгээд Эрчим хүчний яам ер нь энэ өмнөх үнийн өсөлт дээрээ нөлөөллийн судалгаа энэ тэр хийж үзсэн үү? Иргэд ер нь ямархуу байдалд орсон байна?

Одоо дулааны үнийг зайлшгүй нэмэх гарцаагүй шаардлага байна уу, үгүй юу? Эрчим хүчнийхээ үнийг, цахилгааныхаа үнийг арайхийж тэсэж гарсан хүмүүс дулааны үнийн өсөлтийг тэсэж чадах болов уу? Юу гэж бодож байгаа юм бол? Энэ дээр нэг их тийм хүн амьтанд таалагдах гэсэн зүйл биш шүү. Одоо иргэдтэй уулзаад явж байхад л хамгийн түрүүнд асууж байгаа юм нь эрчим хүч асууж байгаа юм. Энэ цахилгааны үнийг чинь бид дийлэхгүй байна л гэж байгаа юм. Одоо дулааны үнэ нэмэгдэж байгаа. Усны үнэ нэмэгдэж байгаа.

Энэ дээр ямар судалгаа, шинжилгээ хийж үзсэн юм болоо гэж.

Дөрөвдүгээрт, Сангийн сайдаас асууя. Эртээд бид хоёр нэг ярилцсан. Валютын нөөц, энэ ханшийн асуудал чинь ер нь хүндэрчихсэн байна. Төсвийн тодотголынхоо бэлтгэлийг хийж байгаа юу? Б.Жавхлан сайд аа. Төсвийн тодотголынхоо бэлтгэлийг хийж байгаа юу? Төсвийн зарлагаа бууруулах чиглэлээр та хэд маань ер нь судалгаа, шинжилгээ хийж үзэж байгаа юм уу? Энэ валютын ханшийн нөөцийн асуудал чинь ер нь нэлээн хүндэрчихсэн байгаа гэсэн мэдээллүүд хаа сайгүй явж байгаа. Своп дээр байж байгаа 2.8 тэрбум долларын асуудлаар л амьдрахаар явж байгаа гэж сонсогдсон.

Тэгэхээр энэ дээрээ төсвийн тодотгол дээр бэлтгэл хийж байна уу? Ер нь тодотголыг зарлагаа л бууруулбал яасан юм бэ л гэсэн асуудал би таньтай хоёр дахь удаагаа. Оройтоогүй байгаа дээр төсвийн тодотгол хийх чиглэл рүүгээ явбал яасан юм бэ гэсэн саналыг тавьж байна. Ийм асуултад хариулт авья.

Дараа нь нэмж асууна шүү, дарга аа. Эртээд та намайг гар өргөсөн чинь хариулуулаагүй шүү.

Д.Амарбаясгалан: П.Наранбаяр сайд асуултад хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа.

Тэгэхээр сүүлийн жилүүдэд сургуулийн орчинд гэмт хэрэг нэмэгдэж байгаа. Энэ дээр бид Хууль зүй, дотоод хэргийн яамтайгаа хамтраад сургалтуудыг бүсчилж зохион байгуулж байна.

Сургуулийн орчны гэмт хэргээс ер нь урьдчилан сэргийлэхэд хороотойгоо хамтран ажиллах, тэнд байгаа нийгмийн ажилтантайгаа хамтран ажиллах нь туйлын чухал байдаг. Сургууль доторх нийгмийн ажилтны үйл ажиллагаа туйлын чухал.

Түүний зэрэгцээд сүүлийн үед ялангуяа цахим орчинд үйлдэгдэж байгаа, бие биеэ дээрэлхэж байгаа, бөөрөлхөж байгаа, алагчилж байгаа, ганцаардуулж байгаа ийм үзэгдлүүд газар авсан. Ийм учраас цахим орчинд нь бид хүүхдийг 16 нас хүртэл нь SNS^[social networking service] буюу нийгмийн сүлжээнд нэвтрэх эрхийг хязгаарлах Австрали Улсын туршлагыг судалж байна. Үүгээр дамжуулж цахим орчин дахь эрүүл үзэгдлийг бий болгох нь туйлын чухал гэж харж байна.

Сүүлийн жилүүдэд хүүхдүүд өөрсдөө их өөр орчинтой болсон байна. Та бүхэн анзаарсан бол одоо Z-т үеийнхний хоорондын яриаг бичилцэж байгаа, бичсэн зүйлийг нь харах юм бол бараг 50 хувийг нь ойлгохгүй ийм өөр болж байгаа шүү дээ.

Тэгэхээр ийм хүүхдүүдийн сэтгэхүйд таарсан ийм үйл ажиллагааг явуулж, тэдэнд хүрэх нь их чухал байна гэж харж байгаа.

Мөн сургуулийн орчинд ингэж гэмт хэрэгтэй тэмцэхэд эцэг, эхийн оролцоо их туйлын чухал байдаг. Эцэг, эхийг татан оролцуулах, SCHOOL POLICE гээд явж байгаа шүү дээ. SCHOOL POLICE гээд зөвхөн замын хөдөлгөөнд аюулгүй оролцохыг хамгаалахдаа биш бас хүүхдийн сургуульдаа ирэх зам, гэртээ харих замыг л аюулгүй болгоход чиглэж байгаа ийм зүйл байгаа гэдгийг танд хариулъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: С.Одонтуяа сайд хариулт өгье.

С.Одонтуяа: Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга одоо Улсын Их Хурлаар орно. Энд иргэд болон аж ахуйн нэгжүүдээс хамгийн их гомдол ирдэг. Нийтдээ ерөнхийдөө 153 хоног болдог. Том ч аж ахуйн нэг ч бай, жижиг ч бай.

Тийм учраас бид үүнийг багасгаад 43 хон хоногт үүнийг багтааж хийхээр байсан. Тийм үү.

Д.Амарбаясгалан: Энэ нөгөө олон улсын үнэлгээгээр 180 орноос сүүлээсээ 3 дугаар байранд орсон байна гэдэг асуудлыг хөндөж Ж.Алдаржавхлан гишүүн асууж байна лээ. Энэ дээр яах вэ, Ж.Алдаржавхлан гишүүн тодруулж асуухдаа асуучихъя.

Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Ж.Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя.

Тэр зардлын асуудал дээр бид бүгдээрээ л одоо нэг шугам дээр байгаа гэж ойлгож байгаа.

Тийм ч учраас бид бүтээн байгуулалтуудаа ер нь нэг эрэмбэлээд дийлэнхийг нь. Төсөв дээрээс хийж дийлдгийгээ ер нь хойш нь тавьчихсан шүү дээ. Эрэмбэлээд нэлээн хойш нь тавьчихсан.

Тийм учраас одоо яг орлогынхоо хэмжээнд зарлагаа төсөвлөнө гээд бид хуульчилчихсан учраас бид энэ хэмжээндээ л явна.

Гагцхүү төсвийг гарцаагүй нэмэх шаардлага оруулчихаад байдаг. Энэ хууль, эрх зүйн орчинтой холбоотой асуудлууд байгаа. Өмнөх жил төсөв батлахад бид үүнийг танилцуулгаа оруулж ир ээ. Төсвөөс шууд зардал нэмэгдээд байгаа асуудлуудыг Их Хурал дээр эргэж харъя гээд ажлын хэсэг байгуулагдаад энэ дээр маш сайн ажиллаж байгаа. Тун удахгүй Их Хурлаар энэ асуудал орж ирээд хэлэлцэгдээд явна. Энэ дээрээ харин Та бүхэн маань их сайн хамтарч ажиллаж энэ зардлуудаа харин хэмнээд их тодорхой болгочих юм бол ер нь багагүй хэмжээгээр зардал хасагдана.

Д.Амарбаясгалан: Б.Жавхлан сайдад минут нэмж өгье. Гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Шууд хуулийн заалтаар энэ жил жишээ нь 4.5 их наядын зардал орж ирсэн байгаа шүү дээ. Нэмэгдэж. Багтаагүй цаана нь 2 их наяд байгаа.

Эд нарыгаа зохицуулалт хийгээд зоригтой шийдвэрүүд гаргачих юм бол энэ хэмжээгээр багасна гэсэн үг.

Нөөцийн хувьд бас амаргүй үеэ бид давж байна. Энэ үнэхээр тулж байгаа ийм эрсдэл. Гол түүхий эдүүдийн үнээс нүүрсний үнэ нэлээн уначихлаа. Үүнийг дагасан мэдээж орлого дээр цохилт ирнэ. Тэгэхдээ дөнгөж нэгдүгээр улирал дуусаж байна. Хоёрдугаар улирал, гуравдугаар улирал гээд цаана нь ер нь манай экспортын улирлын шинжтэй нэмэгддэг улирлууд маань урд байна.

Бусад түүхий эдүүдийн үнэ боломжийн байна гээд бүх нөөц боломжоо шавхаж байна.

Свопын хувьд бас л нэг хэрэгсэл. Бид нөөцөө нэмдэг. Тэгэхдээ мэдээж энэ хэрэгслүүдээ эрэмбэлж байгаад аль болох өртөг байхтайгаар дараа нь сөрөг үр дагаврыг нь бас эрэмбэлж байгаад ингээд шийдвэрлээд явна. Хараахан түүндээ хүрчхээгүй байна. Тийм. Тэгэхээр сандрах хэрэггүй.

Тодотголын хувьд мөн л өглөө гэнэт босож ирээд хүсэлтээрээ хийчихдэг зүйл биш. Одоо хуулиараа энэ чинь нөхцөл байдал маш тодорхой заачихсан байгаа. Ийм нөхцөл үүссэн үед Засгийн газар тодотгол өргөн барина гээд. Түүндээ хараахан бас хүрээгүй байна. Орлогоо нэмэх, орлогоо хамгаалах, зардлаа бууруулах, хөрөнгө оруулалтуудаа бас тодорхой хэмжээнд эрэмбэлэх гээд Засгийн газар өөрийнхөө эрх мэдлийн хүрээнд хийчихдэг ажлууд байна. Үүнийхээ ардаас явж байна. Энэ дээр өндөр ач холбогдол өгөөд ажлын хэсэг байгуулагдаад бас эхний үр дүнгүүд гарч байна. Одоо юу юугүй бүр хүнд байдалд орчихоогүй байна. Бас энд ийм зүйлүүд байна.

Тэгээд Засгийн газар болгон дээр бид асуудлаа яриад, Засгийн газар болгоны дараа олон нийтэд энэ экспорттой холбоотой, манай нөөцтэй холбоотой мэдээллүүдийг танилцуулаад явж байгаа. Тийм.

Ямар ч байсан нөөц Төв банкнаас мэдээлж байгаагаар олон улсад барьдаг стандарт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Ж.Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя.

Дулааны үнэ 5 сарын 16-ны өдрөөс нэмэгдэх ёстой байсан. Ийм шийдвэрийг Эрчим хүчний зохицуулах хороон дээр гаргачихсан байсан. Гэтэл сая одоогоос хоёр долоо, хоног гурван долоо хоногийн өмнө Засгийн газар дээр шийдвэр гараад энэ дулааны үнэ болон бусад хураамжуудыг нэмэх асуудлыг он дуустал хойшлуул гэдэг ийм шийдвэр гарсан байгаа.

Гол шалтгаан Монголбанк, Статистикийн ерөнхий газраас инфляцын түвшин хоёр оронтой тоонд орох гээд байгаа учраас энэ шийдвэрүүдийг он дуустал ямар ч байсан хойшлуулах ийм шийдвэр гарсан байгаа.

Д.Амарбаясгалан: Болсон уу? Жуковын Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан: П.Наранбаяр сайд та миний асуултыг ерөөсөө ойлгоогүй байна.

Энэ сургууль орчмын гэмт хэрэг 1675-аар нэмэгдсэн гэнэ. Өнгөрсөн жилийнхээс. Өмнөх жилийнхээсээ шүү. Тэгээд ямар төрлийн гэмт хэрэг нэмэгдсэн юм бол оо? Үүнийг танай яам энэ тэр судалж үзсэн юм уу? Үзээгүй бол үзээч ээ.

1675-аар нэмэгдэнэ гэдэг чинь эсвэл нөгөө тэр мансууруулах бодисын гэмт хэрэг яваад байна уу, юу яваад байна? Үүнийг та боловсролын сайдын

хувьд, өөрөө боловсролын салбарт олон жил ажиллаж байсан хүн нэг судалж үзээч ээ. Ойлгоогүй бол.

Байгаль орчны сайд бол олон улсын хуралтай байгаа юм байна. Тэрийг ойлголоо. Дараа нь тусад нь тодруулж асууя.

Д.Амарбаясгалан: П.Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Энэ нарийн тоо нь одоогоор надад алга байна.

Гэхдээ дээрэлхэлттэй холбоотой, мөн бусдын зүйлийг зөвшөөрөлгүй авах ч гэдэг юм уу, иймэрхүү хэргүүд бол ихсэж байгаа гэдгийг мэдэж байгаа.

Сүүлийн жилүүдэд энэ болохгүй зүйл үнэрлэх, мөн мансууруулах төрлийн бодис хэрэглэхэд гэх мэтийн ийм асуудлууд залуужаад байгаа нь туйлын харамсалтай. Энэ чиглэлээр бид соён гэгээрүүлэх ажлыг хамтран хэрэгжүүлж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе.

Эрүүл мэндийн сайдаас уг асуух байсан юм. Энэ хөдөө орон нутгаас энэ гурав дахь шатын эмнэлэгт ирж үзүүлэхэд эмчээс цаг авах, тэгээд онош хийлгэх, оношоо уншуулах гээд л. Тэгээд бүх үе шатууд дээр их цаг зарцуулж байна. Ер нь хөдөөгөөс ирсэн хүн дунджаар бараг 2 сар зарцуулж байна гэдэг ийм гомдол тавьж байгаа.

Тэгэхээр Эрүүл мэндийн яамны ажлыг харахаар 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл дээр бүх шатын эмнэлэг, эмийн сангуудад ашиглагдах нэгдсэн өгөгдлийн систем үүсгэх гэсэн ажил 100 хувь хэрэгжсэн гээд биччихсэн байгаа.

Тэгэхээр яг саяын миний ярьсан энэ мэдээллийг Эрүүл мэндийн яам нэгтгэж статистик гаргадаг юм болов уу? Энэ дээр одоо судалгаа хийдэг юм байна уу гэж нэг асуулт байгаад байна.

Хоёр дахь асуулт болохоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас асуумаар байгаа юм. Зүүн бүсэд малын хулгай их гарч байгаа. Тэгээд хулгайч нь олддоггүй. Нэлээн зохион байгуулалттай хэлбэрт орчихсон ийм байдалтай байх шиг байгаа юм.

Тэгэхээр энэ тал дээр Хууль зүй, дотоод хэргийн яам маань ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ гэж.

Дараагийн асуулт. Манай зүүн бүсийн Сүхбаатар аймагт нэг ийм асуудал байгаа юм. Суманд баг руу шилжилт хөдөлгөөн хийлгэхээр заавал сумын төвийн хаяг дээр шилжиж байж шилжилт хийгддэг ийм хүндрэлтэй асуудал байна гээд маш олон иргэд энэ дээр гомдол тавьж байгаа.

Тэгэхээр энэ асуудал дээр Хууль зүй, дотоод хэргийн яам судлаад юунаасаа болоод ингээд байдаг юм бэ? Дорнод аймаг дээр ийм асуудал ерөөсөө яригддаггүй юм.

Тэгэхээр Сүхбаатар аймаг дээр ийм асуудал яригдаад, энэ дээр нэг хариулт авмаар байна.

Ц.Баатархүү сайдаас нь асуумаар байна. Сумдаар явахаар багт гар утасны сүлжээ оруулж өгөөч ээ гэдэг хүсэлт их тавьдаг. Ер нь Монгол Улс маань төлөвлөгөөгөөрөө ер нь хэзээ бүрэн бүх багаа гар утасны сүлжээнд нэвтрүүлэх бодлого барьж ажиллаж байгаа юм бэ? Энэ талаар мэдээлэл өгөөч.

Мөн П.Наранбаяр сайдтай холбоотой нэг асуулт байгаа юм. Энэ хөдөөгийн сургуулийн хүүхдийн амралтыг мал төллөх цагаар амраахаар байж болдоггүй юм уу гэдэг ийм хүсэлтийг малчид их тавьж байгаа.

Тэгэхээр энэ дээр манай боловсролын яам судалсан судалгаа байдаг юм уу гэж асуумаар байна.

Ер нь Монгол Улсын ихэнх сумд маань үе шаттайгаар төвлөрсөн халаалт, цэвэр, бохирын систем рүү шилжиж байна. Шилжиж байгаатай холбоотой маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж байгаа. Гэтэл зарим сумдын ажлыг харахаар жил болгон тогоо нь цоорч байдаг. Тийм ээ. Мэргэжлийн ажилтан байхгүйгээс болдог юм уу, эсвэл буруу технологи авчихсан байдаг юм уу. Ийм байдаг шиг байгаа юм.

Тэгэхээр энэ тал дээр Ж.Батсуурь сайд маань ямар ажил төлөвлөж байна вэ? Энэ дээр тодорхой чиглэл байхгүй бол одоо бүх л сумд тус тусдаа өөрсдөө тендер зарлаад л, өөрсдөө хөрөнгө оруулалт хийгээд л. Тэгээд дараа нь үр дүн, үр ашигтай байдал харилцан адилгүй нэг ийм байдалтай харагдаад байгаа. Тэгээд энэ дээр асуумаар байгаа юм.

Энэ 2021-2025 оны ажлын төлөвлөгөөн дээр Дорнод аймгийн Чойбалсангийн нисэх буудлийг “4 Си” ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлнэ. Аэродром, зорчигч үйлчилгээний цогцолборыг байгуулна гэдэг ажил хийгдээгүй байна. 2025 оны төсөв дээр бас байхгүй байгаа.

Тэгэхээр яах вэ, өмнөх 4 жилийн төлөвлөгөөнд орчихсон байсан ажил цаашдаа хийгдээгүй бол ирэх 4 жилийн ажлын төлөвлөгөөнд орж байгаа юу гэдэг асуултыг тавимаар байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Т.Мөнхсайхан сайдыг дуудаарай. Ц.Баатархүү сайдаас эхлээд хариулчихъя. Сүлжээтэй холбоотой асуудал.

Ц.Баатархүү: Л.Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Өчигдөр бид бас зүүн бүсэд томилолттой ажиллаад ирлээ.

Ер нь орон нутгийн иргэд сүлжээний чанар, нягтрал нэмэгдэж байгаатай холбогдуулаад хамрах хүрээ багасаж байгаа.

Тийм учраас Улсын Их Хурлын гишүүдийг хөдөө орон нутагт томилолтоор ажиллахад хөдөлгөөнт холбооныхоо сүлжээг нэмэгдүүлээч ээ гэдэг саналыг маш ихээр тавьж байгаа.

2025 онд бид 139 цэг дээр, Дорнод аймагт 6 цэг дээр сүлжээ сайжруулалт хийхээр төлөвлөж байгаа. Бидний төсвийн мөнгө, бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсвийн хязгаар байгаа учраас хамгийн түрүүнд тухайн баг дээр оршин сууж байгаа хүн амын тоо, өрхийн тоо, нэмээд байгалийн эрсдэлт хүчин зүйлийн зэрэглэл, аялал жуулчлалын бүс нутаг эсэх гээд 6, 7 шалгуур үзүүлэлтээр 139 цэгийг энэ жил ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Цаашдаа хоёр зүйлийг тодорхой болгох хэрэгтэй байгаа. Бүх нийтийн үйлчилгээний сан дээр тодорхой хэмжээний төсөв бүрдсэн. Үүнийг бид хязгаарлалтгүй болгож, 2026, 2027 ондоо Улсын Их Хурлын гишүүдийн өгч байгаа санал, баг, сумын Засаг дарга, аймгийн Засаг даргаас ирж байгаа энэ олон саналыг үндэслээд үүргийн сангийн хөрөнгийг бүгдийг нь одоо энэ хөдөлгөөнт холбоо чиглэлд нь зарцуулах ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Монгол Улс нийтдээ 53 мянган километр шилэн кабельтай. Шилэн кабельд огт холбогдоогүй 5 сум байна. Нийт өргөн уудам нутаг дэвсгэрийн 23 орчим хувь нь интернэтийн үйлчилгээтэй байна.

Тийм учраас бид цаашдаа энэ өндрийн болон нам орбитын хиймэл дагуулаар дамжуулан Монгол Улсын өнцөг булан бүрт харилцаа холбооны дэд бүтцийг хүргэх бүхий л сувгуудаар дэд бүтцийг энэ 3 жилдээ хүргэх ийм бодлого барьж ажиллаж байгаа гэдгээ хэлье. Л.Соронзонболд гишүүнд баярлалаа.

Д.Амарбаясгалан: П.Наранбаяр сайд хариулт өгье.

П.Наранбаяр: Тэгэхээр ерөнхий боловсролын сургуулиудын амралтыг нийслэл болоод орон нутгаар тус тусад нь зохицуулж байгаа.

Яг бие даалтын долоо хоног өнгөрсөн долоо хоногт өнгөрөөд өнөөдрөөс эхлээд, нэг дэх өдрөөс эхлээд орон нутаг бол хоёр долоо хоногийн туршид хаврын амралт авахаар байгаа.

Яг энэ хугацаа нь мал төллөлт ид явж байдаг энэ үетэй нь зориуд давхцуулж оруулсан.

2025-2026 оны хичээлийн жилд ч гэсэн яг энэ зохицуулалтаа хийгээд явна. Ер нь сургуулийн хүүхдийн амралтын зохицуулалтуудыг нийслэл болоод орон нутагт нь тус тусад нь арай өөрөөр зохицуулж байгаа. Энэ нь илүү тухайн тухайн микро нийгмийнхээ орчинд илүү зохицож байгаа гэдгийг хэлье.

Яг энэ бодлогыг Боловсролын яам цаашдаа тууштай хэрэгжүүлнэ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эрүүл мэндийн цаг авах асуудалтай холбоотойгоор Ц.Баатархүү сайд хариулт өгье гэж байна. Ц.Баатархүү сайдад микрофон өгье.

Ц.Баатархүү: Эрүүл мэндийн цаг авах үйл ажиллагааг бид дижитал болгосон, цахимжуулсан. Олон сайдуудын үед эхлүүлсэн ажил ингээд амжилттай болсон.

Бид нэг зүйлийг бас тооцоогүй байгаа. Өвчлөлийн асуудал улирлын чанартай байдаг учраас цагаа и-монголоор дамжуулаад хөдөө орон нутагт байгаа хүмүүс, Улаанбаатарт байгаа хүмүүс цагаа авчихдаг. Тэгээд нийт хүмүүсийн 50 орчим хувь нь авсан цагтаа л очдог. Тэгээд авсан цагтаа очоогүй хүмүүс нь биеэрээ яваад оччихдог. Тэгээд гурав дахь шатлал, хоёр дахь шатлалын эмнэлэг дээр ачаалал үүсэж байгаа.

Хоёрдугаарт, эрүүл мэндийн байгууллага и-монгол юм уу, дижитал цахим системээр цаг авсны дараа дахин бүртгэх асуудлыг хийгээд байдаг. Эмнэлэг дээрээ. Иргэн хүн хөдөө орон нутгаас, сумаасаа цагаа аваад хүрээд ирэхээр дахиад та цагаа бүртгүүл гэдэг ийм дугаарлалтын үйл ажиллагаа байгаа.

Тийм учраас “Цахим эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд Т.Мөнхсайхан сайд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Давхардсан л ажил болоод байгаа юм байна. Тийм ээ. О.Алтангэрэл сайд малын хулгайтай холбоотой асуудлаар хариулт өгье.

О.Алтангэрэл: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 буюу малын хулгайтай холбоотой асуудал зүүн бүс дээр яригдаж байгаа.

Зүүн бүсийн нэг онцлог байгаа. Бусад бүстэй харьцуулахад. Яг энэ мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа цогцоороо явагддаг. Яг хаалтуудаа хаана тавих вэ, шалгалтуудаа хаана хийх вэ гээд цогцоороо тавигддаг.

Тэгэхээр зүүн бүсийнхээ онцлогт тааруулаад мал хулгайлах гэмт хэрэгтэй холбоотой статистикийг эрс сайжруулах, мал хулгайлах гэмт хэргийг таслан зогсоох энэ үйл ажиллагаа, үүрэг чиглэл нь өгөгдөөд явж байгаа гэдгийг хэлье.

Мөн манай Ц.Сандаг-Очир гишүүн санаачлаад зүүн талд бид энэ 4 дүгээр сард гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн хурал хийх гэж байгаа. Энэ дээр яг энэ зүүн бүсэд үйлдэгдэж байгаа малын хулгайтай гэмт хэргийн талаар тусгайлан ярихаар бид бас төлөвлөж байгаа гэдгийг хэлье.

Тэр бүртгэлийн хувьд баг дээр бүртгэгч гэж ойлголт байхгүй. Суман дээр нэг бүртгэгч байгаа. Тэгээд одоо энэ 4 сарын 20-ноос нөхөн сонгуультай холбоотойгоор шилжилт хөдөлгөөнүүд зогссон.

Д.Амарбаясгалан: Ж.Батсуурь сайд хариулт өгье.

Ж.Батсуурь: Л.Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр саяхан л бид хөдөөгийн аймгууд, сумд цахилгааны эх үүсвэргүй, холбоо хэлхээгээгүй гэж ярьдаг байсан бол эдгээр зүйл хангагдаад, одоо төвлөрсөн халаалтын систем, дэд бүтэцтэй болох, орон сууцтай болох, амины орон сууцыг дэд бүтэц холбох, төсвийн байгууллагуудыг нэгдсэн галлагаатай болох гээд энэ асуудлуудыг бол үе шаттайгаар шийдэж явж байна.

Гэхдээ яг галлагаа тал нь ер нь Эрчим хүчний яаманд байдаг. Дэд бүтэц, цэвэрлэх байгууламж, ус дулаан, ариутгах татуурга нь манай яамтай холбоотой байдаг. Гэхдээ үндсэндээ суман дээр очихоор энэ асуудлууд нь нэгдэж явдаг гэж ингэж үзэж байгаа юм.

Тэгэхээр үүнийг чанартай сайн болгохын тулд бүх сумдыг ерөнхий төлөвлөгөөтэй болгож, ерөнхий төлөвлөгөөний дагуу тэр хэдэн хүн амтай байна вэ, ямар хүчин чадалтай байна вэ, үүнд нь тохирсон хөрөнгө оруулалтуудыг хийх ажлыг манай яам үе шаттай хийж байна.

Одоогийн хөдөөгийн сум.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Ж.Батсуурь сайд.

Ж.Батсуурь: Одоогийн хөдөөд байгаа сумдаас 167 сум ерөнхий төлөвлөгөөгөө хийгээд байна. Бусад сумдыг үе шаттай хийж ойрын хугацаанд дуусгах асуудлуудыг бид анхаарч байна.

Хуучин ерөнхий төлөвлөгөөгөө хийгдээгүй байхад дураараа соёлын төв нь нэг галлагаатай, цэвэрлэх байгууламж байхгүй, сургууль, Тамгын газар нь гэж байсан бол одоо энэ ерөнхий төлөвлөгөө хийгдсэнээр нөхцөл байдлыг нэг гарт хяналтад оруулах боломжийг бий болгож байна. Жишээлэх юм бол 2024-

2028 онд 213 тэрбум төгрөгийг сумдын дэд бүтцэд зориулсан хөрөнгө оруулалт хийгээд эхний тендерүүд зарлагдаад явж байна.

Харамсалтай нь манай гишүүд болон анхан шатад ажлын даалгавраа буруу гаргадаг, зураг төсвөө жин тан хийдэггүй. Энэ нөхцөл байдал нь яг хийгээд дуусангуут одоо юу гэдэг юм хүчин чадлаа хангаагүй бага оврын техник, тоног төхөөрөмжид суурилсан.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Л.Соронзонболд гишүүн тодруулж асууя.

Л.Соронзонболд: О.Алтангэрэл сайд аа, тэр Сүхбаатар аймгийн асуудал нь юу байгаа юм.

Ер нь баг руугаа шилжиж чадахгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр баг дээр бүртгэгч байхгүйдээ биш байгаа юм. Заавал сумын төвийн хаяг руу тухайн иргэнийг шилжүүлээд байгаа байхгүй юу. Тэр чинь аймгийн төв рүү нүүчихсэн байж байгаад дахиад буцаад сумдаа ирээд баг руугаа шилжих гэхээр заавал сумын төвийн хаяг дээр тухайн хүнийг бүртгэж авч ингэж шилжилт хөдөлгөөн хийгдээд байгаа юм. Тэгээд энэ асуудал байгаа. Үүнийг та нэг судлаад тэгээд бүр нэг хариу өгөөдхөөч гэж.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Саранчулуун: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах зорилт 67.9 буюу хамгийн бага харагдаж байгаа юм. Үүнтэй холбоотой 4 асуулт асууя.

Монгол улс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаар олон улсын бас нэлээн олон конвенц, гэрээ, тунхагт нэгдэж гарын үсэг зурсан байгаа.

- ▶ 1969 онд Бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхахыг устгах тухай конвенц. Хэрэгжилт, тайлагналт харагдахгүй. Хэн нь хариуцдаг юм?
- ▶ 1974 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай факт.
- ▶ 1990 онд Хүүхдийн эрхийн конвенц гээд энэ бүх бичиг баримт дотор ухаад тайлангууд нь зарим нь 5 жил тутам, 4 жил тутам НҮБ-ын Хүний эрхийн хороо руу явдаг, тайлагнадаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал нь дандаа хэрэгжилт дутуу, эсвэл мэдээлэл нь бүрхэг ч юм уу ийм байгаад байгаа. Энэ асуудал энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 5.22.2-т заасан дагуу зарчмаараа “дэлхий нийтийн болон хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх”

зарчим гэж тусгаад энэ дээр “олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн дагуу уялдуулна” гэж байгаа юм.

Тэгээд тайлангаас нь харахаар олон улсын гэрээ, конвенцтой холбоотой юмаа хаана нь ч оруулдаг юм. Ерөөсөө байхгүй.

Тэгэхээр үүнийг хэн хариуцах юм бэ? Энэ дээр ямар нэгэн хариулт, тодорхой юм авмаар байна.

Тэгээд бүр ухаад үзэхээр зарим байгууллагынхан яг энэ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал ч юм уу, хүний эрхийн асуудлыг үзэхээр холбогдох тайлан ирээгүй гэж харагдаж байгаа байхгүй юу. Та нар өөрсдөө харах юм бол нэлээн л юм дутуу байх шиг байна.

Одоо бүр лавшруулъя. Хоёрдугаар асуулт нь.

Хүний хамгийн анхны хэрэгцээ бол орон байр, хоол хүнс гээд явдаг. Тийм ээ. Манайд жишээлбэл өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй 110 гаруй хүний чинь 13-хан хувь нь л орон сууц, байранд хамрагдсан байна шүү дээ. Үлдсэн хүмүүс нь зарим нь түрээсийн байранд, зарим нь айлд, зарим нь айлын хашаанд, зарим нь орон гэр байхгүй.

Тэгэхээр энэ хүмүүсийн асуудлыг ер нь яах юм? Анхаарах юм уу, анхаарахгүй юм уу? Тийм ээ. Уг нь 2023 онд Барилга, хот байгуулалтын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх” гээд хөтөлбөр гарсан байна. Энэ хөтөлбөрийн хэрэгжилтийг асуумаар байна. Хоёрдугаар асуулт нь. Бүр тодруулаад.

Зөндөө л олон улсын сайн жишээ байгаад байдаг. Би бүр аргаа бараад лавшруулаад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тандалт судалгаа авлаа шүү дээ. Ямар зээл авах хүсэлтэй байгаа юм, ямар боломжтой байгаа юм гээд асуухаар боломжтой ажил хийж байгаа хүмүүс зөндөө л байна.

Гэтэл бас холбогдох гурван байгууллага нь тэр датаг ерөөсөө тандалт судалгаа, хэрэгцээ авсан уу гэхээр аваагүй. Судалгаа хийгээд датаг нь явуулахаар боловсруулаад та нар нэгтгээд харж байна уу гэхээр бид судлаач хайж байна, боловсруулах хүн хайж байна гээд. Тийм хайхрамжгүй хандаж ингэж болдог юм уу? Энэ чинь хүмүүс биз дээ. Хүний амьдрал биз дээ.

Гуравдугаар асуулт нь, Хүртээмжтэй, аюулгүй нийтийн тээврийг хөгжүүлсэн нь 70 хувь гэжээ. Би Зам, тээврийн яам л одоо хариулах ёстой байх.

Манай нийтийн тээвэр хэзээ хүртээмжтэй болох вэ? Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг автобусаар зорчуулна гээд үнэмлэх өгдөг. Орох тоолонд хөнгөлөлттэй зорчигчид чангаар дуугардаг нэг үйлчилгээ байгаа.

Гэхдээ та нар судалж үзсэн үү гэхээр бас байхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэр автобусанд суудаггүй шүү дээ. Гэсэн мөртлөө нийтийн тээвэр мөнгө төлбөр шилжүүлээд авч байгаа. Үүнээс өөр шийдэл байж болдоггүй юм уу? Жинхэнэ үйлчилгээ гаргадаг газар луу нь үйлчилгээгээ өгөх үү, яах вэ?

Дахиад нэг асуудал. Харааны бэрхшээлтэй хүн автобусны буудал дээр зогсохоор хэдэн номерын автобус ирж байгаа нь харагдахгүй. Ерөөсөө мэдэгдэхгүй. Тийм ээ. Тэрийг нэг дуугарардаг болгодог байж хүртээмжээ 70 хувь гэж ярьж болох уу гэдэг дээр би бүр онцгойлон асуумаар байна. Маш олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүсэлт байгаа.

Дөрөвдүгээр асуулт нь, нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ гэж байгаа юм. Үйлчилгээний хүртээмж шүү. Тэгэхдээ энэ нь 78 хувьтай гэнгүүтээ зарцуулалт нь “тамирчдын зардалд” гэж байгаа. Зөвхөн тамирчид. Мэргэжлийн тамирчдын зардал чинь нийтийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье. О.Саранчулуун гишүүнд.

О.Саранчулуун: Тэгэхээр нийтийн биеийн тамирын үйлчилгээний хүртээмж гэдэг бол бүх хүн биеийн тамираар хичээллэх орчныг хэлж байгаа юм. Ажлын байрны дэмжлэг байна, нийтийн явган алхах зам байна, эсвэл фитнес даатгалаараа явдаг ч юм уу, ямар олон улсын хувилбар байна. Тийм ээ. Энэ тал руу ямар ажлууд байгаа юм бэ? Яагаад зөвхөн тамирчдын, эсвэл нэг заалны асуудал дээр ч юм уу. Яаж бодоод энэ 78 хувь болсныг нь би бас сайн ойлгохгүй байна.

Тэгэхээр эдгээр энэ зүйлүүдийг сайжруулах дээр одоо ярих ёстой л гэж би бодож байна.

Тэгэхээр энэ дээр нэг бүрчлэн юу хийх гэж байгаа юм, юу хийсэн юм, яагаад болохгүй байгаа юм гэдэг дээр хариулж өгнө үү?

Д.Амарбаясгалан: Л.Энх-Амгалан сайд эхлээд хариулт өгье.

Л.Энх-Амгалан: О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Шинэ Засгийн газар байгуулагдаж хуучин Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэж шинээр эмхлэн зохион байгуулсан.

Үүний хамгийн гол зорилт, бодлого бол хуучин бид дандаа нийгмийн хамгааллын, нийгмийн халамжийн бодлогуудыг явуулахад, ахмадуудад чиглэсэн бодлогууд, хүүхдэд чиглэсэн бодлого, хүүхэдтэй ээжид чиглэсэн бодлого гээд дандаа гэр бүлээс нь салгаж бодлого явуулсан нь бас нэг тийм сайн үр дүнд хүрч чадаагүй байна гэсэн ийм дүгнэлтүүдийг хийсэн.

Тэгээд ямар ч байсан өнгөрсөн 6 сарын хугацаанд, өнгөрсөн 15-аас 18 жилийн хугацаанд нийгмийн хамгааллын тогтолцоонд, нийгэм халамжийн тогтолцоонд зарсан мөнгө ер нь яг эзэндээ хүрсэн юм уу, үр дүн гаргасан юм уу гэдэг асуудлаар нэлээн сайн шинжилгээ, судалгаануудыг хийж, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкнаас бодлогын зөвлөмжүүд авч ажиллаж байгаа.

Энэ хүрээндээ бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ асуудлуудыг их ерөнхий ярьж явдаг байсан юм билээ. Маш их ерөнхий.

Үндсэндээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ тоог одоо л дөнгөж бид чинь нэг болгож байна шүү дээ. Эрүүл мэндийн яам нэг өөр тоо зарладаг. Боловсролын яам нэг өөр тоо зарладаг. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нэг өөр тоо зарладаг байсан. Үүнийг ямар ч байсан 11 мянга 280 хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй байна гэдгээ одоо бид 3 яам нэг тоотой болж байгаа нь маш том дэвшил гарч байгаа.

Тэгэхээр мэдээж Улсын Их Хуралд төлөөлөл болж 2 Улсын Их Хурлын гишүүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ дуу хоолой болж Улсын Их Хуралд орж ирснээр нэлээн тийм эрх зүйн шинэчлэл хийх хувьсгалын тохироо бүрдсэн байна гэж харж байгаа.

Өнгөрсөн хугацаанд бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухай хууль. Үүнийг дагасан хуулиуд дандаа лоозонгийн шинж чанартай хуулиуд байсан. Яг үнэнийг хэлэхэд. Ерөөсөө хэрэгжээгүй. Ихэнх нь.

Тэгэхээр яагаад хэрэгжээгүй юм гэдэг асуудлууд. Мэдээж эргээд л нөгөө төсөв, мөнгөний асуудлууд, санхүүгийн асуудлууд, хүний нөөцийн асуудлууд, бодлого, зохицуулалтын асуудлууд гээд олон яамдын уялдааны асуудлаас болж тодорхой бодлогын өөрчлөлтүүд гарч чадаагүй. Энэ хугацаанд бид олон улсад нэгдсэн конвенцоос авхуулаад, конвенцоор хүлээсэн үүргээсээ авхуулаад.

Удахгүй бид Улсын Их Хуралд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ эрхийн тухай хуулийг дагуулж нэлээн тийм багц 5, 6 хуулиудыг өргөн барихаар ажиллаж байна.

Тэгээд ирэх 3 жил бас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэл рүү төрийн бодлого яг зорилтот бүлэгтээ хүрсэн бодлого байх болов уу гэж бодож байна. Давхар бид энэ хуулиа дагуулж яг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Монгол Улсын төрөөс үзүүлж байгаа нийгмийн хамгааллын тогтолцооны зураглалуудаа хийж байгаа. Энэ талаар та мэдээлэлтэй байгаа. Би Байнгын хороон дээр энэ тогтолцооны зураглалын эхний загваруудыг танилцуулсан. Тэгээд их тодорхой ахиц дэвшил гарах болов уу гэсэн ийм зорилт тавьж л одоо бид ажиллаж байна.

Д.Амарбаясгалан: Зам, тээврийн яамнаас Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд 2 дугаар индрээс хариулт өгье.

С.Батболд: О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд.

Тэгэхээр манайд нийтийн тээврийн үйлчилгээнд 50/12 гэдэг стандарт байдаг. Үүгээр нийтийн тээврийн энэ тавигдах шаардлагуудыг заагаад өгчихсөн. Зогсоол, гишүүр, бариулаас авхуулаад бүгдийг нь заагаад өгчихсөн ийм стандарттай. Энд зогсоолыг зарлах, бичгэн болон аудио хэлбэрээр зарлах ийм дүрэм журамтай.

2022 онд Нийслэлийн иргэдийн хурлаас баталсан нийтийн тээврийн зогсоолын ерөнхий шаардлага гэсэн шаардлагыг бас зааж өгсөн байгаа. Энэ дээр нийтийн тээврийн зогсоол дээр байх зогсоолуудын байршлын мэдээлэл, цагийн хуваарийг тавих асуудлыг бас энэ дүрэм, журмаар зохицуулаад өгчихсөн байж байгаа.

Нийслэлээс өнгөрсөн жилүүдэд хэрэгжүүлсэн шинэ автобусуудад зогсоолыг зарладаг системийг үйлдвэрт нь захиалж хийлгэсэн байгаа.

Зүгээр нөхөн олговрын асуудлыг орон нутгийн Засаг дарга, иргэдийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: О.Саранчулуун гишүүн тодруулж асууя.

О.Саранчулуун: Тэгээд яагаад автобусууд нь зарлахгүй байгаа юм бэ? Яагаад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс автобусанд одоо болтол суудаг болохгүй байгаа юм? Дүрэмтэй, стандарттай гээд байгаа мөртлөө тэр нь яагаад тэгээд хэрэгжихгүй байгааг нь л би асуугаад байна шүү дээ.

Тэгээд орон сууцын талаарх мэдээллийг авмаар байна.

Д.Амарбаясгалан: С.Батболд Төрийн нарийн нэмж хариулт өгье. 2 дугаар индэр. Дараа нь Ж.Батсуурь сайд хариулт өгнө.

Ж.Батсуурь: Стандартын хэрэгжилтийн асуудал дээр бид анхаарч хяналт тавьж ажиллая.

Уг нь нийслэлийн нийтийн тээвэрт явж байгаа автобусны жолооч нараа бас давхар хянадаг ийм системтэй болсон байгаа. Үүгээр нь бид илүү хянаж зарладаг болох асуудлыг тавья.

Зүгээр бид нар дээр ирсэн санал, гомдлоор ялангуяа тэргэнцэртэй иргэд нийтийн тээврээр үйлчлүүлэх боломжгүй байна. Тэр болгон хүртээмж муутай. Бид автобусанд сууж чаддаггүй. Өөрсдөө таксигаар болон хувийн унаагаараа явдаг гэдэг ийм асуудал байгаа. Үүнтэй холбоотой ч гэсэн нийслэл дээр зогсоол, гарцууд дээр бас өөрчлөлтүүд хийж байгааг Та бүхэн харж байгаа

байх. Лазер болон бусад гэрлүүдээр, чанга яригчаар бас үе шаттайгаар, замаар зорчих нөхцөлийг ч гэсэн үе шаттайгаар бүрдүүлээд явж байгаа. Хэрэгжилтийн асуудал дээр хяналт тавьж ажиллая.

Д.Амарбаясгалан: Ж.Батсуурь сайд хариулт өгье.

Ж.Батсуурь: Орон сууцын хүртээмжийн асуудлын талаар Та асууж байх шиг байна.

Тэгэхээр өнөөдөр Монгол Улсын хэмжээнд 5 мянга гаруй айлын орон сууц түрээс маягаар явж байгаа юм. Үүний тодорхой хувь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд оногдож байгаа гэдгийг та мэдэж байгаа.

Цаашид бид хэд яах ёстой вэ гэхээр аймгуудад дэд бүтэц, сумдад дэд бүтэц нь хийгдээд баригдах гэж байгаа орон сууцаас тодорхой хувийг ерөөсөө орон сууцын сан бий болгоод тэр сангаа залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, орлого багатай иргэдэд хуваарилах ийм боломжийг бий болгоно гэж үзэж байгаа юм.

Мөн алслагдсан суурингуудад, 90 хүртэлх сумдад 8-аас 15 айлын орон сууцуудыг бид барьж эхлүүлэхээр тендерүүд нь зарлагдаад байна. Үүний бас тодорхой хувь тухайн аймаг, сумынхаа удирдлагуудтай ярьж байгаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хуваарилагдах болно гэж ийм хариултыг өгч байна.

Д.Амарбаясгалан: О.Саранчулуун гишүүн дахин тодруулж асууя.

О.Саранчулуун: Тодорхой хувь гэдэг нь яг жишиг тэдээс тэдэн хувь гэсэн ийм RANGE байна уу?

Тэгээд журам нь хэзээ батлагдах юм бэ?

Д.Амарбаясгалан: Ж.Батсуурь сайд хариулт өгье.

Ж.Батсуурь: Ер нь хүмүүсийн хүсэл эрмэлзлэлийг хангах боломж байхгүй. Орон сууцын хувьд ч тэр, нөхцөл байдлын хувьд ч тэр.

Гэхдээ бид 150 мянган айлын орон сууцыг ашиглалтад оруулна гэж байгаа. Энд бол амины орон сууц хүртэл орж байгаа. Гэхдээ инженерийн дэд бүтцийг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, цахилгааны дэд бүтэц, халаалтын системийг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн энэ газрууд дээр хувийн хэвшлийн барьж байгаа орон сууцаас сан үүсгэж байгаа.

Тэгэхээр тодорхой хувь гэдэг нь олон талын оролцооны нөхцөл байдлаасаа л шалтгаална. Жишээлэх юм бол зарим аймагт, зарим сумд тийм ээ, зарим дүүрэгт нөхцөл байдлууд нь өөр байгаа. Тэгэхдээ бид 5 хүртэлх

хувийг үндсэндээ сан үүсгээд, түүн дотроо дарааллын дагуу, хүсэлтийн дагуу олгоно л гэсэн ийм баримжаатай явж байна.

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууж, үг хэлье. Ч.Номин сайд. Уучлаарай. Б.Түвшин гишүүн. Ч.Номин сайд хариулт өгье. О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Ч.Номин: Гишүүний асуултад хариулъя.

Манай биеийн тамир, спортын чиглэлийн хувьд сүүлийн 4 жилийн хугацаанд улсаас маш өндөр түвшний анхаарал хандуулж явж байгаа салбаруудын нэг.

Бид бүхэн өнгөрсөн хугацаанд Биеийн тамир спортын тухай хуулиа батлуулсантай холбогдуулан олон зүйлүүд дээр анхаарал тавих боломж үүссэн. Тэр дундаа тэгш, хүртээмжтэй байдлыг хангахад илүү давуу талууд үүссэн. Энэ ч утгаараа оюуны бэрхшээлтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олон улсын болон дотоодын чанартай яг спорт чиглэлээр хамрах боломжийг бий болгосон.

Нөгөө талдаа спортын байгууламжуудыг бид өнгөрсөн 4 жилийн хугацаанд 44 ширхгийг бий болгосон. Тэгэхээр энэ спортын байгууламжууд маань бүгд тэгш, хүртээмжтэй байх дээр нөхцөл шаардлагаа хангасан гэж харж байгаа.

Нөгөө талаасаа таны хэлж байгаа нийтийн биеийн тамир дээр яаж иргэдийг хүртээмжтэй байлгаж байгаа вэ гэдэг дээр асууж байна. Энэ бол бид нарын дараагийн жилүүдэд анхаарах шаардлагатай ажлуудын нэг. Таны хэлсэн 70.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Түвшин: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Өнөөдөр бид Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөний үндсэн чиглэлийн гүйцэтгэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны гүйцэтгэлийн тайлан зэрэг маш олон чухал бичиг баримтуудыг нэлээн олон хяналтын байгууллагууд хянасан тайланг хэлэлцээд байгаа.

Нэг ёсондоо 2024 онд Монгол Улсын нийгэм, эдийн засаг яаж хөгжив гэдэг дүгнэлтийг бид өнөөдөр тавих гээд байгаа.

Тэгэхээр энд хамгийн түрүүнд төлөвлөлтийн асуудал байгаа. Нийгэм, эдийн засагт ямар импакт өгөв, нийгэм эдийн засагт ямар зүйл болов гэдгийг иргэдийн оролцоо, санал асуулгаар асууж тодруулаагүй. Хэдүүлээ энд ингээд

126 иргэдийн төлөөлөл гэж байгаа боловч өөрсдийн бодож байгаагаараа асуугаад яваад байдаг.

Ер нь 2024 онд зөвхөн улсын төсвийн хувьд 30.5 их наяд төгрөгийг зарцуулсан. Үүний 22.5 их наядыг урсгал зардалдаа зарцуулсан. Тэгээд энэ мөнгөөр одоо бид яг импакттай ямар зүйл хийчхэв ээ, манай улс маань яаж хөгжихөв өө гэдэг логик гаргалгаатай, тогтолцоотой,

- ▶ төлөвлөлт,
- ▶ гүйцэтгэл,
- ▶ хяналт,
- ▶ тайлагналын

систем байхгүй учраас өнөөдөр одоо хэдүүлээ ингэж яриад л. Тэгээд нөгөө гурван газрын гаргаж өгсөн гурван зөрүүтэй тайланг нь ярьж байгаад, тэгээд асуултаа асууж байгаад л тэгээд л нэг дүн тавиад л явах байна.

Гэтэл үүний чинь нөгөө талд нь ерөөсөө энэ улсын нийгэм, эдийн засаг дээр юу болоод байна вэ гэдэг асуулт байгаа юм. Иргэдийн харж байгаагаар Эрчим хүчний зохицуулах хороо цахилгааны үнэ тарифыг нэмчихсэн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татварыг өсгөчихсэн. Зам ашиглалтын төлбөрийг нэмчихсэн. Яг орлого ерөөсөө огт нэмэгдээгүй. Ийм стресстэй орчинд бид 22.5 их наядын урсгал зардлыг зарцуулаад, нөгөө талд нь энэ тайланг хэлэлцэж байгаа.

Энэ тайлан дээр юу тодорхой байна вэ гэхээрээ энэ тайлан дээр хамгийн тодорхой байгаа зүйлүүд бол хөрөнгийн зардлууд буюу 16 их наядын 8-ыг нь зээлээр 8-ыг нь улсын төсвөөр ийм ийм ажлуудыг ингэж ингэж хийсэн гэдэг маш тодорхой, гүйцэтгэлийн хувь нь ч тодорхой байна.

Бусад тэр 22.5 дандаа “үг”. Тэрийг нь дүгнэж байгаа газрууд нь ерөөсөө олон нийтийн санал асуулга, нийгэмд үзүүлж байгаа нөлөөлөл талаасаа биш, цаасан дээр материал бүрдүүлсэн талаасаа явж байгаа учраас “бүтээмжийн асуудал” байхгүй. Тайлагналын асуудал ч гэсэн 126 дотор ийм чухал бичиг баримтуудыг нэг доор оруулж ирээд л, ийм асуулт хариултаар өрнүүлээд л, тэгээд л одоо бид ингээд л хаагаад л дуусгах гэж байна.

Тэгэхээр цаашдаа “бүтээмжийн асуудал”, “төлөвлөлт”, “гүйцэтгэл”, “хяналт”, “тайлагнал”-ын системийг олон улсад нийцэх боловсронгуй болгох шаардлагатай байна. Тэр тусмаа иргэдийн нийгэм, эдийн засгийн амьдралд нөлөөлөх томоохон тогтолцоонуудын бодлогыг авч явуулах хэрэгтэй байгаа юм.

Уул уурхайгаас гадна манай Монгол Улсад хамгийн том салбар бол “нүүдлийн мал аж ахуй”. Нүүдлийн мал аж ахуй дээр 105 мянга гаруй малчин

өрх, 400 гаруй мянган иргэд ажиллаж амьдарч байгаа. Ийм олон хүн ажиллаж амьдарч байгаа салбар байхгүй. Үүнийг зөвхөн соёлын хэмжээнд авч болохгүй.

- Мэдээж энэ бол Монгол Улсын соёлын дангааршлын асуудал.
- Мэдээж энэ бол Монгол Улсын эдийн засгийн асуудал.

400 гаруй мянган хүн өөрөө өөрийгөө тэжээдэг. Гэтэл өнөөдөр бид үүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах одоо тэр ложистикийн системийг төлөвлөөгүй.

Яаж нүүдлийн мал аж ахуй эрхэлж байгаа хүмүүсийг нүүдлийн чигээр нь соёлын өвийг нь алдуулахгүй, амьдралын хэв маягийг нь өөрчлөхгүйгээр үүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах вэ гэдэг ерөөсөө л тогтолцооны асуудал.

Үүнийг хийхгүйгээр бид өнөөдөр тавхан хүн, аравхан хүн, тавьхан хүн, зуун хүний маш том том төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээд яриад байдаг. Гадаад, дотоод, улсын геополитикийн.../минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Түвшин гишүүн 1 минут.

Б.Түвшин: Гадаад, дотоодын геополитикийн нөлөөлөл, эдийн засгийн нөлөөлөл их байна гээд байдаг. Гэтэл энэ 5 малыг 10 болгож байгаа, 10 малыг 20 болгож байгаа үйлдвэрлэл эрхэлж байгаа энэ малчдыг зах зээлтэй нь шууд холбох ложистикийн тогтолцоо байхгүй байна.

Энэ тал дээр 400 мянган өрх, иргэн амьдарч байгаа энэ салбарыг, дээрээс нь манай Монгол Улсын гаднаас үл хамаарах энэ том өөрөө үйлдвэрлэл эрхэлж байгаа энэ салбарын талаар ямар бодлого явуулах гэж байна вэ?

Цаашдаа бид яг энэ нүүдлийн мал аж ахуйг нүүдлийн чигээр нь соёлын өвтэй нь хадгалж байж л Монгол Улсын эдийн засгийн бат бэх байр суурь болно. Улаанбаатар хотын иргэдийн хувьд ч гэсэн шинэ махыг өдөр тутамдаа зах зээл дээрээс нь авч чадахгүй байгаа шүү дээ. Энэ бол дахиад л ложистикийн гаргалгаа.

Тийм учраас хамгийн том өөрсдийнхөө үйлдвэрлэж байгаа салбар дээрээ ямар бодлого явуулж байгаа вэ гэдгийг хамгийн түрүүнд асууя.

Хоёрдугаарт, бүтээмжийн асуудлын тухай тодруулъя.

Гуравдугаарт, “төлөвлөлт”, “гүйцэтгэл”, “хяналт”, “тайлагнал”-ын систем яаж үр ашигтай болох вэ? Яаж нийгэм, эдийн засагтаа шууд нөлөө үзүүлдэг болгох вэ?

Энэ талаар ямар ажил бодож, төлөвлөж байна вэ гэдэг ийм 3 асуултыг асууя.

Х.Булгантуяа: Л.Гантөмөр сайд эхлэх үү.

Л.Гантөмөр: Тэгэхээр нүүдлийн мал аж ахуй дээр бид мэдээж хагас эрчимжсэн бодлогыг их олон жил хэрэгжүүлсэн. Эндээсээ ухармааргүй байгаа юм. Жишээлбэл, түрүүн Ж.Энхбаяр сайд хэлж байна шүү дээ.

Бид зөвхөн намар мал нядалдаг, мах нийлүүлдэг биш 12 сарын аль ч сард нь бид махыг нийлүүлэх чадвар, чадамжийг. Ер нь хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадвар гэдэг зүйл байгаа юм. Хөдөө аж ахуйн салбар зүгээр нэг хүмүүс амиа тээдэг салбар биш л дээ. Олон янзаар хэлдэг.

- Хил хамгаалдаг;
- Нутаг хамгаалдаг;
- Уламжлалаа хадгалдаг гэж.

Тэгэхээр хил хамгаалах, нутаг хамгаалах уламжлалаа хадгалахын зэрэгцээгээр эдийн засгийн хувьд өрсөлддөг, одоо банк бус санхүүгийн байгууллага шиг өөрөө өөрийгөө аваад явж чаддаг, банкны салбар шиг хөгжиж чаддаг тийм салбар болгох бодлого нь хамгийн чухал байгаа.

Тэгээд энэ бодлого дээр хөдөө аж ахуйн салбарын манай олон жилийн тууштай баримталж байгаа бодлого бол энэ мал аж ахуйг ер нь эрчимжүүлье. Тэгэхдээ нүүдлийн аж ахуйг бүрэн устгах гэдэг бодлого энд ерөөсөө байхгүй.

Тийм учраас төлөвлөгдөж байгаа, төсөвлөгдөж байгаа зүйл юу вэ гэхээр тэр мал аж ахуй эрхэлж байгаа хүмүүсийн

- ▶ “амьжиргаа” гэж нэг зүйл байгаа.
- ▶ “Амьдралын чанар” гэж нэг зүйл байгаа.

Нөгөө талд нь

- ▶ “өрсөлдөх чадвар”,
- ▶ “үйлдвэрлэлийн чадлыг нэмэгдүүлэх”.

Энэ дээр маш тодорхой бодлогуудыг явуулж байгаа гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа. Үр дүнд хэзээ хүрэх вэ л гэдэг асуудал байгаа юм. Үр дүнд хүрэхийн тулд үйлдвэрлэлийг нь давхар хийж өгөх хэрэгтэй. Одоо бид нэг санаачилга гаргаад байгаа шүү дээ. Малын эзэн үйлдвэрлэлийн эзэн гэж. Энэ хамгийн оновчтой бодлого болж гарна гэдэгт эргэлзэхгүй байна.

Тэгэхээр тодорхой тариалан эрхэлдэг. Тариалан гэдэг нь малынхаа иддэг хоолыг бэлддэг. Тэгээд мал нь хоолтой. Тэр хэмжээгээр тарга тэвээртэй байж

байдаг. Тэр хэмжээгээр олон улсын зах зээл дээр гаргадаг. Үйлдвэрлэл байгаад дараа нь үйлдвэрлэлээ дагасан зах зээлийн асуудал яригдаж байгаа.

Зах зээлээ бид хамгийн түрүүн онилж байгаа нь энэ Евразийн зах зээл. Казакстан, Киргиз, Орос, Армен, Беларусь гээд. Энэ улсууд руу бид бүтээгдэхүүнээ гаргадаг хаалгаа одоо нээж байгаа. Хаалга нээнэ ээ гэдэг нь зөвхөн татвараар хэмжигдэхгүй.

- Хил, гаалийн асуудал байна,
- Гарал үүслийн асуудал байна,
- Бүртгэлийн асуудал байна,
- Зөвшөөрлийн асуудал байна

гээд их олон асуудлуудыг бид яаралтай шийдэхийн төлөө одоо ажиллаж байна.

Тийм учраас яг Б.Түвшин гишүүнтэй санал нэг байна. Хөдөө аж ахуйн салбар босож байж Монголын эдийн засаг бүтэн болох юм билээ. Босож байж өөрөө ядуурлаас Монгол Улс гарлаа гэдэг дохио их тодорхой болох юм билээ.

Тэгэхгүй бол одоо бид макро Б.Түвшинд мөнгөний бодлого ч бай, төсвийн бодлого ч бай, аль ч бодлого явуулсан хоёр үзүүртэй болчихоод болохгүй байна. Нэг нь.../минут дуусав/

Х.Булгантуяа: Шадар сайд Л.Гантөмөр даргын микрофоныг нэмж өгье.

Л.Гантөмөр: Хоёр үзүүртэй болчихоод байна.

Импорт асар их нэмэгдэж байгаа. Мөнгөний нийлүүлэлт ихэссэн учраас тодорхой бодлогын шинэчлэлүүд хийгдэж байгаа юм. Нэг үгээр хэлбэл импортыг бид хэрхэн тогтвортой байлгах вэ гэдэг бодлого явж байгаа.

Гэтэл яг импортын үзүүрт нирвэгдэх аюул нь юу вэ гэхээр импортын сул тавьчихъя, зөнд нь орхичихъя гэхээр барааныхаа үнийг дийлэхээ больчихож байгаа юм. Барааны үнээ дийлэхгүй төгрөгийн ханшаа алдаад эхлэх юм бол яг нөгөө 40 гаруй хувийн орлого багатай иргэд дээрээ цохилт болоод оччихож байгаа юм.

Тийм учраас бид ингээд хос жолоодлоготой яваад байна шүү дээ. Нэг суллаад, нэг чангалаад. Мөнгөний бодлого. Энэ юу хэлж байна вэ гэхээр яаралтай тэр 40 гаруй хувьд багтаж байгаа хүмүүсийн нэгдүгээрт “амьдралын чанар”. Нөгөө талдаа “орлогын өсөлт”, “бодит аж ахуйн түвшинд очих” гэдэг энэ тойргийн бодлогыг бүрнээр нь хийх шаардлага бидэнд байгаа гэж хэлмээр байна.

Х.Булгантуяа: Б.Түвшин гишүүн нэмж тодруулъя.

Б.Түвшин: Энэ “бүтээмж” болон “төлөвлөлт”, “гүйцэтгэл”, “хяналтын тайлагнал”-ын талаар хариу авсангүй.

Яах вэ, ерөнхийдөө энэ нүүдлийн мал аж ахуй, фермерийн аж ахуй хоёрын хооронд нэг тодорхой харьцаа байгаа.

“Фермерийн аж ахуй”-г цөөхөн хүмүүс бүтээмжтэйгээр ажиллаж үйл үйлдвэрлэнэ.

“Нүүдлийн мал аж ахуй” манай Монголын, одоо бид нарыг байхаас өмнө ер нь монголчуудын уламжилж амьдарч ирж байсан арга.

Үүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах арга нь гол нь тогтолцоо. Малчид хамгийн анхан шатын үйлдвэрлэлээ бүрэн явуулж байгаа. Үүнийг зах зээлтэй нь шууд холбох тэр байнгын тогтолцоог хийж байж л энэ бүрэн эргэлтэд орох юм. Энэ тогтолцоог бид зайлшгүй хийх ёстой.

Хоёрдугаарт, тэр нийгэмд нөлөөлж байгаа хамгийн том импакттай зүйл бол эрчим хүчний асуудал шүү. Өнөөдөр Монгол Улс эрчим хүчний нүүрсээр баян байж байж юуг төр хийх вэ, хийхгүй юу гэдгээ ярьж байгаа энэ цаг үед эрчим хүчний нүүрсээр баялаг улс өөрөө үйлдвэрлэл.../минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Түвшин гишүүн сая нэмж үг хэллээ. Э.Одбаяр сайд.

Э.Одбаяр: Б.Түвшин гишүүний асуултад нэмж хариулъя.

Энэ “төлөвлөлт”, “төсөвлөлт”, “хяналт”-тай холбоотой асуудлыг энэ тайлан хэлэлцэж байгаа хугацаанд нэлээн олон удаа хөндөгдлөө. Тэгээд үүнийг сайжруулах нь зүйтэй юм байна гэдэг дээр ажил хийгдээд явж байгаа.

Тэргүүн Шадар сайд, Хэрэг эрхлэх газрын дарга, миний бие, Сангийн сайд гээд дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг энэ DESIGN_[төлөвлөлт] MONITORING_[хяналт] EVOLUTION_[үнэлгээ] гээд олон улсын цогц системийг нэвтрүүлъя.

Ер нь төлөвлөж байж төсөвлөе, төсөвлөж байж гүйцэтгэе. Тэгээд түүнийгээ үр дүнтэй хянае гэдэг энэ концепц явж байгаа.

Тэгээд энэ ажил дээр бас таныг хамтраад, зөвлөгөө өгөөд, ажлын хэсэгтэй хамтарч ажиллаарай гэж хүсэж байна.

Мэдээж энэ проблем бол байгаа. Тэгээд шалтгаанаа олоод харчихсан байгаа учраас тодорхой алхмууд хийгдэж байгаа гэж ойлгож байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Хүний хөгжлөөр л улс орны хөгжлийг тодорхойлж хардаг л гэж би ойлгож байгаа.

Тэгэхээр хүний хөгжлийн суурь асуудлуудыг хэрхэн шийдсэн бэ гэдгээс л асуудлууд тодорхойлогдоно. Өнөөдөр бид нарт нэг проблем бол хот хөдөөгийн ялгаа. Яагаад хөдөөд хүмүүс бага байна, яагаад хот руу чиглэсэн хөдөлгөөн их байгаа юм.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас төвлөрлийг сааруулна гээд л ярьж байгаа. Яагаад гэвэл хөдөөд хүний анхан шатын хэрэгцээг хангах тийм орчин нөхцөл байхгүй байгаатай л холбоотой юм шүү дээ.

Тэгэхээр энэ чиглэл рүү ямар ажлууд төлөвлөөд, ямар үр дүнд хүрсэн юм гэдэг талаар талаар мэдээлэл өгөөч ээ. Энэ их чухал зүйл байгаа.

Ер нь бид бүхэн хүний хөгжлийг хангахын тулд том том төслүүдийг хэрэгжүүлж байна. 14 том мега төсөл гээд л байгаа. Тэгэхдээ хүний хөгжлийг хангахдаа жижиг зорилтуудаа ерөөсөө орхигдуулж болохгүй. Ингэх юм бол бид том зорилго, тэр зүйл чинь алсраад л явчих ийм нөхцөл байдал үүснэ.

Энэ хөгжлийн төлөвлөгөөний биелэлтэд үнэлэлт, дүгнэлт өгснийг харж байна л даа. Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна гэххээд төрийн албаны хүний нөөцийн тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ. Түүнийг хэрхэн дүгнэх вэ гэсэн чинь төрийн албанд зарласан сул орон тоо байна гээд л дүгнэчихсэн байна.

Тэгэхээр эндээс юу харагдаж байгаа вэ гэхээр бид эхлээд төлөвлөхгүй байна. Яг нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн төлөвлөлтөө хийж, түүнд хүрэх арга зам, дүгнэлтээ тодорхой болгож чадахгүй байна л гэсэн үг.

Тэгэхээр энэ дээр ямар ахиц гаргах юм бэ? Эдийн засгийн хөгжлийн яам цаашлаад. Яаж төлөвлөх юм? Яаж дүгнэх юм? Энэ зүйлээ бид хийж чадахгүй бол тэр том том хөгжлийн тухай яриад үлгэр болно шүү. Жижиг зүйлээ л хийж чадахгүй бол бид тэгээд том зүйл алсраад одчих ийм нөхцөл байдал үүснэ гэж харж байна.

Тэгэхээр энэ дээр надад нэг хариулт өгөхийг хүсэж байна.

Зүгээр өнөөдөр ингээд хүний хөгжил гээд ярина. Тэр төвлөрөл гээд л ярьж байгаа. Хөдөө орон нутагт чинь эмч, багш байхгүй байна шүү дээ. Математикийн багш, физикийн багш, биологи, химийн багш нар байхгүй. Бидний ирээдүйн хүүхдүүд тийм хичээл үзэж чадахгүй, суралцаж чадахгүй төгсөх гэж байна.

Гэтэл салбарын сайд нь энд Улаанбаатар хотод их дээд сургуулиудын удирдлага томилоод байж байдаг. Харин тэрэнд орвол хөдөө алслагдсан сумд руу тэр химийн багш, физикийн багш, математикийн багш томил. Энэ илүү шударга ёсонд илүү иргэн хүнээ бодсон нөхцөл байдалд үр дүн өгнө гэж би харж байгаа.

Тэгэхээр сайд энэ тал дээр анхаарч ажилламаар байна.

Хоёрдугаарт нь, манайд нэг хариуцлагын зуд л нүүрлэхээд байна л даа. Олон олон асуудлууд яригдаж байгаа хэдий ч гэсэн түүний үр дүнгүүд нь базаахгүй байгаа. Тухайлах юм бол ганцхан жишээ ярья.

Энэ төрийн гүйцэтгэлийн аудит дээр төсвийн ерөнхийлөн захирагч болон хөтөлбөрийн үр дүнг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан 34.3 тэрбум төгрөгийн зарцуулалт ерөөсөө тайлагнаагүй. Түүний 18.3 нь агаарын бохирдлыг бууруулах дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ гэсэн байгаа.

Нөгөөдөх нь түгжрэлийг бууруулна гээд 16.0 тэрбум зарцуулсан байдаг. Тайлан байхгүй. Юу гэж ойлгох вэ? Юунд зарцуулчихсан юм бол?

Хэрвээ үүнийг бид хариуцлагатайгаар зарцуулчихсан бол энэ утааны асуудал чинь ядахдаа бас гайгүй болох байсан болов уу гэж бодож байгаа шүү дээ. Өнгөрсөн өвөлжингөө бид утаа ярьсан. Улаанбаатар өнөөдөр утаатай байсан уу гэвэл байсан.

Утаагүй болсон нөхцөл байдал, цаг хугацаа байсан шүү. Монгол Улсын Ерөнхийлөгч Ерөнхий сайдаар ажиллаж байх үед, Ерөнхий сайд Хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байх үед Улаанбаатар хот утаагүй болсон шүү дээ.

Тэр бол төрийн бүх шатны байгууллагууд, хүмүүс хариуцлагатайгаар ажилласны үр дүн байсан. Түүхий нүүрс оруулдаггүйгээс авхуулаад маш олон хяналтуудыг сайн тавьж ажилласны үр дүн байхгүй юу. Харин одоо тэр зүйл нь байхгүй болчихсон. Хариуцлагагүйн зуд нүүрлэхихсэн. Ингээд утаатай болж байгаа.

Х.Булгантуяа: Эхлээд Л.Гантөмөр сайд хүний хөгжилтэй холбоотой.

Л.Гантөмөр: Тийм. Д.Батлут гишүүнтэй санал нэг байна.

Хүний хөгжил нь явахгүй бол тухайн улсын эдийн засгийн хөгжил явахгүй л дээ. Хүнээ хөгжүүлэхийн тулд боловсролын бодлого их ойлгомжтой тодорхой байх хэрэгтэй юм билээ. Боловсролын бодлогоо бид их ойр ойрхон солих гэж оролддог. Энэ их буруу.

Ялангуяа боловсролын бодлого дээр ямар хүн хүсээд байгаа юм бэ гэдгээ их тодорхой хэлчихмээр юм билээ. Тэр нь ямар ур чадвартай хүнийг бид

хөгжсөн хүн гэж байгаа юм бэ гэдгээ хэлээд тэр лүүгээ боловсролын байгууллага өөрөө анхаарлаа хандуулдаг байх нь хамгийн чухал байгаа юм.

Тийм учраас хүний хөгжлийн бодлого дээр маш тогтвортой, 10 жилийн төлөвлөгөө гаргаад, хүний хөгжлийн хөтөлбөрөө зарлаад. Ингээд ярихаар зэрэг тал талын нөгөө хүний мэддэг зүйлийн тухай юм руу аягүй их нэвтэрдэг. Одоо дэлхий даяараа боловсролын тухай ойлголт их өөр болж байна шүү дээ. Хүн зарим зүйлийг мэдэхгүй байж болно. Цээжлээгүй байж болно. Тогтоогоогүй байж болно. Тэгэхдээ тухайн хүний чаддаг юм байх ёстой. Тэр чаддаг зүйлийг хэр зэрэг хөгжүүлсэн бэ гэдгээсээ хамаараад тухайн улс орон хүнийхээ хөгжлийн индексээр өрсөлдөөд явж байна.

Ялангуяа бид баримжаа авах улс Финлянд байгаа юм л даа. Үнэхээр бие даасан хүнийг бүтээж чаддаг. Бие даасан хүнийг бүтээж чадахын тулд тэр хүнийг маш их сорилт руу өөрөөр нь алхуулдаг.

Бид бол хэн нэгний удирдлагаар хүн болдог гэдэг ийм үндсэн хуучин философиосоо салахгүй өнөөдөр хүртэл ингээд орж гараад л байгаа юм. Эндээ л алдаад байгаа юм.

Түүнээс бие дааж суралцах чадвар гэдэг хамгийн агуу чадвар. Замаа өөрөө олдог, малаа өөрөө таньдаг, мэргэжлээ өөрөө сонгодог, амьдралаа өөрөө мэддэг, өөрийн замаа зурдаг гэдгээр одоо жишээлбэл Финлянд үүгээрээ дэлхийд нэг номер болоод гараад ирсэн. Энэ боловсролынх нь агуулга, философи, бодлого дээр зөндөө улс маргасан. Хэн ч дийлээгүй.

Тийм учраас энэ хүний хөгжлийн бодлого буюу боловсролын бодлого их тогтвортой, ойлгомжтой, яг ямар хүнийг хүсээд байгаагаа шууд утгаараа нэг өгүүлбэрээр илэрхийлж чаддаг байх нь их чухал байна. Тэгээд тэрийг тойрсон таны хэлдгээр бичил хөтөлбөрүүд заавал явах хэрэгтэй. Тэрийг дэмжсэн хөтөлбөрүүдээ заавал хэрэгжүүлэх ёстой. Ийм байна.

Тийм учраас бид гол бодлогын нэг хэсэг нь нийгэм. Нийгэм дотроо хүн. Хүн дотроо хүний хөгжил гэдэг зүйлээ барьсан. Хөгжлийн загвар луу бид шилжилтээ хийж байгаа гэдгийг хэлмээр байна. Угаасаа ч ийм чиг баримжаатай явж ирсэн.

Тэгэхдээ манай гишүүдийн анзаараад байгаа зүйл бол энэ төлөвлөлт дээр яг аль загвар нь юм бэ гэдэг дээр их тийм хүчтэй асуултууд гараад байна. Яг үнэндээ сүүлийн он жилүүдийн төлөвлөлт бол NORDIC загвар дээр явсан. Нийгмийн баталгаа. Нийгмийн баталгаа байвал бусад нь болно гэдэг бодлогоор явсан. Зөвхөн нийгмийн.../минут дуусав/

Х.Булгантуяа: Хоёр дахь асуултад П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Д.Батлут гишүүний асуултад хариулъя.

Орон нутагт багш дутагдаад байгаа нь үнэн. Төрийн зүгээс сумын хэмжээнд багшилж байгаа багш нарт 40 хувийн цалингийн нэмэгдлийг олгодог болсноос хойш байдал бага зэргээр дээшилж байгаа. Гэхдээ маш их дутагдалтай байгаа.

Та таны хэлсэнчлэн математик, физик, хими, ялангуяа байгалийн ухааны чиглэлийн багшийн дутагдал өндөр хэвээр байна.

Бид 2024 оны 8 сард нэг тоо авдаг. Ингээд дараа нь 11 сард авахад багшийн дутагдлыг зохих хэмжээнд бууруулж чадсан байдаг. Гэхдээ өнөөдөр 1500 орчим багш дутсан хэвээрээ л байгаа.

Багшийн дутал яагаад үүсээд байна вэ гэхээр өмнөх жилтэй харьцуулахад хүүхдийн тоо ч нэмэгддэг. Багшийн тоог нэмэх болоход жишээлбэл ноднин жил гэхэд л 11 хувиар ерөнхий боловсролын сургуульд шинээр багш хэрэгтэй болж байгаа.

Мөн багш нарын хөдөлгөөн их байна. 5 дахь жил дээрээ больж байгаа багшийн тоо бол бараг.../минут дуусав/

Х.Булгантуяа: П.Наранбаяр сайдын микрофоныг нэмж өгье.

П.Наранбаяр: Тэгэхээр яг багшлах чиглэлээр хэдийгээр төгсөөд, ажиллаад 5 дахь жил дээрээ больж байгаа багшийн тоо бараг 50 хувь руу орж байх жишээтэй ийм өндөр байна.

Тийм учраас багшийн дутагдлыг арилгахын тулд яамнаас онцгой анхаарч ажиллаж байна. Та бүхэн анзаарсан бол нэгдүгээрт бид

- ▶ багш мэргэжлээр төгссөн боловч багшийн ажил эрхлээгүй хүний нөөцийг эргүүлж ашиглах,
- ▶ тэтгэвэрт гарсан багш нарыг бага цагаар багшлуулах,
- ▶ шинжлэх ухааны чиглэлээр их, дээд сургууль амжилттай төгссөн, эсвэл 3, 4 дүгээр ангид суралцаж байгаа оюутныг багшийн ажилд татан оролцуулах,
- ▶ сургалтын цагийн норм 19 цагт хүрдэггүй зарим багш нарыг хөрвүүлж ижил төстэй хичээл заалгах,
- ▶ багш бэлтгэх их дээд сургуулийн 4 дүгээр ангийн оюутнуудыг дадлагажигч багшаар урих,
- ▶ цахим сургалтыг багшийн дутагдал өндөр байдаг хичээл сургалтад илүү эрчимтэй хэрэгжүүлэх гэх мэтийн ийм ажлуудыг хийж байна.

Ялангуяа баруун бүсэд багшийн дутагдал их байгаа. Ийшээгээ оруулах багшийг цаашид нь нэмэгдүүлэх.../минут дуусав/

Х.Булгантуяа: Л.Гантөмөр сайд байгаль орчинтой холбоотой. С.Одонтуяа сайд.

Л.Гантөмөр сайдын микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Бид нэгэнт хамтраад ажиллаж байгаа хүмүүс муур болгон болоод хэрэггүй л байгаа юм.

Ер нь боловсролыг өөд нь татъя гэвэл багшийнхаа цалинг л нэмэх хэрэгтэй. Өөр арга байхгүй. Багш нар байна. Багш нар төгсөж байгаа. Математик, физик чадахаа больсон хүмүүс гэдэг худлаа. Чаддагууд нь чадаж байгаа. Өөр ажил хийгээд байна.

Хэрвээ энэ Их Хурал үнэхээр хүний нөөц дээрээ анхааръя, хүний хөгжил дээрээ анхааръя гэвэл шинээр очиж байгаа багшийнхаа цалинг 1 сая 500 мянган төгрөг болгочих хэрэгтэй. Тэгэхгүй бол энэ чинь үнэхээр юм чаддаг залуу, физик мэддэг, тоо мэддэг залуу хүн ажилд орохдоо очоод 800 мянгаар ажилд орохоор чинь орохгүй байгаа байхгүй юу. Юу үнэн энэ үнэн. Үүнийг тойроод 800 мянгын цалин өгчхөөд олон юм амлаад хүн очихгүй юм билээ.

Тийм учраас хэдүүлээ зүгээр шударгаар одоо шийдье ээ. Нам нам дээрээ хуралдаад боловсролоо үнэхээр аваръя гэж байгаа бол шууд анх очсон.../минут дуусав/

Х.Булгантуяа: П.Наранбаяр сайд нэмэх үү? Цалингийнхаа асуудал дээр.

П.Наранбаяр: Өнөөдөр багшийн яг үндсэн цалин бол яг эхлэхдээ 1 сая 500-аас эхэлж байгаа.

Харин цаашдаа бид энэ салбар дээр чадварлаг сайн багшийг улам нэмэгдүүлье, бий болгоё л гэвэл 2 саяас, доор хаяж 2 саяас эхлүүлэх хэрэгтэй байгаа юм. Бүр 2 саяас. Ингэж байж л багшлах зах зээл дээр, энэ салбар дээр олон хүн орж ирнэ.

Зарим нэгэн тоог хэлэх юм бол хэдхэн жилийн өмнө яг ингээд багшаар төгсөж байгаа оюутнуудын бараг тал нь энэ салбар дээр үлдэж байсан. Гэтэл сүүлийн жилүүдэд буураад байгаа нь яахын аргагүй анх авч байгаа цалин нь 1 сая 500-аас эхэлчхээр ийм л нөхцөл байдалд байгаа. Ноднин гэхэд 1 сая 400 байсан. Энэ жил 1 сая 500 дээр байгаа юм.

Тэгэхээр хэдийгээр сүүлийн жилүүдэд хамгийн эрчимтэй нэмж чадсан салбарын нэг нь боловсролын салбар мөн боловчиг цаашдаа бид чадварлаг

багшийг авч ажиллуулах, түүний зэрэгцээ хамгийн сайн чадвартай багшаас чинь сайн боловсрол явдаг учраас цалинг нэмэгдүүлэх бодлогыг л зоригтой.../минут дуусав/

Х.Булгантуяа: Д.Батлут гишүүн асуултаа. С.Одонтуяа сайд.

13.00 цаг болж байна. Чуулганы хуралдааныг цайны завсарлагаар үргэлжлүүлье. С.Одонтуяа сайд агаарын бохирдолтой холбоотой.

С.Одонтуяа: Тэгэхээр агаарын бохирдлын талаар энэ жил маш тийм эрсдэлтэй нөхцөл байдал үүссэнийг бүгдээрээ харсан. Энэ дээр утааны сонсгол хийгдсэн. Энэ дээр иргэд, төрийн бус байгууллага, бүх л хүмүүстэй маш идэвхтэй оролцсон. Олон удаагийн уулзалт сонсгол хийсэн. Их Хурлын гишүүд ч гэсэн бодит байдалтай танилцсан.

Энэ юунаас болж байна вэ гэхээр ерөөсөө л... Үгүй ээ үгүй агаарын бохирдлын талаар асуусан юм биш үү.

Тэгэхээр агаарын бохирдол дээр бол. Мэдэхгүй ээ. Агаарын бохирдлын асуудал олон яам дамжаад явчихсан. Манай яамны хувьд хамгийн гол асуудал юу вэ гэхээр бид энэ.../минут дуусав/

Х.Булгантуяа: С.Одонтуяа сайдын микрофоныг нэмж өгье.

С.Одонтуяа: Тэгэхээр агаарын бохирдлоос салах дээр манай яамны гол барьж байгаа бодлого юу вэ гэхээр утаанаасаа салдаг, шууд байгальд ээлтэй технологиудыг хувийн хэвшил өөрсдөө хийе гэхэд нь хөнгөлөлттэй зээлийг нь олгох гол ажил байгаа. Энд ердөө 1.2-хон тэрбум төгрөг зарцуулсан. 2025 оны төсөвт ердөө 10 тэрбум төгрөг тавигдсан байж байгаа.

Х.Мөнхзул дарга яг тэр аудитын 18.3-ыг нь хариулчих.

Х.Булгантуяа: Х.Мөнхзул даргын микрофон нь хэдэн номер байна? 1 номерын индэр дээрээс хариулъя.

Сайд нар гишүүдэд маш тодорхой асуулт асуугаад байх юм. Тодорхой хариулаад өгөөч. 1 номерын индрийн микрофон.

Х.Мөнхзул: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам. Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Х.Мөнхзул.

Агаарын бохирдолтой холбоотой асуудал ганц яг манай салбар дээр тавигдаагүй. Энэ бол төсөл, хөтөлбөрүүд дээр тавигдсан мөнгө байгаа. Ихэнх нь нийслэл дээр тавигдсан хөрөнгийн зарцуулалт байгаа. Манай дээр 3 тэрбум төгрөг зарцуулагдсан гэсэн тооцоотой.

Х.Булгантуяа: Д.Батлут гишүүн тодруулъя.

Д.Батлут: Төрийн залгамж халаа гэж байхгүй болчихсон юм болов уу. Сайд нар жаахан асуудалд анхааралтай хандмаар байна. Одоо ингээд хариулж байгаа нь хар даа ингээд бөөрөнхийлөөд. Манайх бол тэд. Нөгөөдөх нь бүү мэд.

Яам чинь нэгдсэн кабинетын бодлогоор үйл ажиллагаа явуулдаггүй юм уу? Засгийн газар чинь. 18.3 тэрбум. Бид том тоо л ярьсаар байгаад жижиг тоог анзаардаггүй болчихсон байж болно. 18.3 тэрбум гэдэг чинь их мөнгө шүү. Зарцуулчихаад тайлан тавьдаггүй. Юунд зарцуулсан гэж үзэх юм? Үүнийг. Энэ дээр холбогдох тайлбарыг надад ирүүлээрэй гэж хүсмээр байна.

Хоёрдугаарт нь, төлөвлөх, дүгнэх аргачлалаа бид өөрчилъе. Сайд нараа. Бүр бодитой болгоё. Хөгжлийнхөө зорилтод нийцүүлсэн хэлбэрээр. Тэгэхгүй нэг жижүүрийн үгээр. Тийм ээ. Дунд шатын албан тушаалтнууд хийхдээ хийдэг. Нөгөөхийг нь хянахгүй бид ингээд оруулаад явчихдаг асуудлууд зөндөө байгаа. Энэ бүхэн дээрээ нягт хяналттай баймаар байна.

Гуравдугаарт нь, П.Наранбаяр сайдад би зөндөө санал хэлж байсан. Цалиндаа гол биш шүү. Тэнд амьдрах орчныг нь сайжруулж өгөх хэрэгтэй байгаа. Тэнд орон байраар хангах хэрэгтэй байгаа.

Х.Булгантуяа: Д.Батлут гишүүнд бичгээр нэмэлт мэдээллийг заавал хүргүүлээрэй.

Уг нь асуулт асууж байгаа. Дээрээс нь нэмээд ялангуяа аудитаас тавьсан мэдээлэлтэй холбоотой бүх мэдээллүүд бэлэн байх ёстой.

Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг.

О.Номинчимэг: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Байнгын хороо сая ярилцсан юмнуудаас давхцахгүйгээр тодорхой гурван асуулт байгаа юм. Ер нь энэ гурван асуулт.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой.

3.20.2.2-т бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлнэ гэсэн энэ зорилтыг дэвшүүлсэн. Харамсалтай нь тал орчим үзүүлэлт дээр нь хэрэгжих хугацаа болоогүй гэдэг тайлагнал гарч ирж байгаа.

Тэгээд эхний асуулт Т.Доржханд сайдаас. 3.2.2.1, 2.3 дээр ерөнхийдөө Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинэчилнэ. Зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих

монополын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гээд ийм зорилтыг Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөртөө дэвшүүлсэн.

Тайлан дээрээ хэрэгжүүлэх хугацаа болоогүй гээд ороод иржээ. Гэтэл Та бүхэн энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их Хурлаар батлуулчихаад Засгийн газар 2028 он хүртэлх хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгох чиглэлээ Засгийн газар өөрөө баталдаг болсон. Улсын Их Хуралд танилцуулалгүй баталдаг болсон.

Энэ баталсан 2028 он хүртэлх хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийн чинь 17, 18 дээр нь таны хариуцаж байгаа Хөрөнгө оруулалтын тухай хууль, Өрсөлдөөний тухай хуулийг 2024 онд боловсруулж өргөн барина гээд орчихсон байна. Ийм хугацаатай юман дээр яагаад хэрэгжүүлэх хугацаа болоогүй гэдэг тайлагналтай орж ирж байна. Энэ дээр тайлагнал, хэрэгжилт, үр дүнгийн уялдаа холбоо гэдэг юм чинь ийм жижигхэн юмнаасаа л уялдаа холбоогүй байгаа гэдэг нь харагдаж байна. Энэ дээр нэг тайлбар өгөөч ээ.

Хоёрдугаар асуулт. Хууль зүйн сайдад.

Хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах чиглэлд 3.2.2.7 дээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх, иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, компани шударга өрсөлдөөнийг сайжруулна гээд, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг сайжруулна гэсэн ийм зорилт орж ирсэн.

Та бүхэн тантай хамтраад Хууль зүйн байнгын хороон дээр тодорхой WORKSHOP_[семинар] хэлэлцүүлгүүдийг хийсэн.

Тэгээд иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг аваад үзэхээр манайх сүүлийн жилүүдэд харахаар маш хангалтгүй. Ер нь хэргийнхээ, шүүхийн шийдвэрийнхээ 50 хувьд хүрэхгүй гүйцэтгэлтэй байгаа.

Тэр дотроо энэ дээр хүүхдийн тэтгэмжийн асуудал байгаа. Үр хүүхэд төрүүлчхээд эцэг, эх нь хаяад салаад явдаг. Энэ хүүхдээ эрүүл саруул бойжиход тус дэм тэй байх хүүхдийн тэтгэмжийн асуудал маш хэцүү. 2021 оноос хойш хүүхдийн тэтгэмжтэй холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тоо баримтыг харахаар ердөө л 7.5-аас 8 хувийн л хэрэг маргаан шүүхийн шийдвэр гүйцэтгэл биелж байна гэсэн тоо тооцоо байгаа.

Тэгэхээр эцэг, эхчүүд хүүхэдтэй болоод, үүнийхээ төлөө тэтгэмжээ өгөх ёстой хүмүүс маань үүргээ гүйцэтгэхгүй байна. Ер нь бодит хэрэг, асуудал дээр ч гарч байгаа шүү дээ. Мөнгөгүйдээ биш. Яг үнэнийг хэлэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэл хүрээд ирэхээр унаж байгаа 570 том машин нь ч, амьдарч байгаа байр, орон сууц нь ч гэсэн ээжийнх нь, аавынх нь, хамаатан садных нь болчихдог. Хүүхдүүддээ мөнгө өгдөггүй энэ асуудал болж байгаа. Үүнээс болж л

ээжүүд ихэвчлэн хүүхдээ эрүүл саруул өсөн торниулах энэ асуудал дээр анхаараад өгөөч ээ гээд Улсын Их Хуралд ч гэсэн хандаж байгаа.

Тэгэхээр үүнийг сайжруулах хамгийн том хөшүүрэг, гол асуудал маань энэ хууль эрх зүйн орчин дээр энэ иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг сайжруулах асуудал байгаа.

Ер нь бизнесийн харилцаан дээр ч гэсэн аваад үзэх юм бол энэ өөрөө хувь хүн рүү, жижиг аж ахуйн нэгжид нэлээн халтай. Томоохон аж ахуйн нэгжүүдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэл маш их тодорхойгүй шалтгаанаар удааширдаг ийм дүр зураг харагдаж байгаа.

Үндсэндээ манай иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээдэст ээлтэй, доодостоо энэрэлгүй ийм л тогтолцоо болчихоод байгааг бид бүгдээрээ ойлгож байгаа. Үүнийгээ хурдан засаж сайжруулмаар байна.

Хуулийн төсөл явж байгаа. Энэ маань хэзээ орж ирэх вэ? 2025 онд гэж төлөвлөгдсөн. Аль чуулган дээр орж ирэхээр Та ажиллаж байна вэ? Мэдээлэл өгөөч.

Гурав дахь асуулт байна. Нэмэлт 1 минутаа авчихъя. Дарга аа.

Х.Булгантуяа: О.Номинчимэг гишүүний нэмэлт 1 минут.

О.Номинчимэг: Дахиад л 3.2.2. Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин гэдэг дээр л яваад байгаа. Тэгэхэд л ийм олон асуулт гарч байгаа гэдгийг Та бүхэн анхаараарай.

3.2.2.1 дээр 2028 он хүртэлх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр “иргэн, хуулийн этгээдийн хувийн өмчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулна” гэдэг зорилт тавьсан. Хэрэгжилт дээр нь хуулийн төсөл боловсруулж 2025 онд өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн бөгөөд бэлтгэл ажил хангах чиглэлээр ажиллаж байна гэж байна. Энэ ямар хууль юм бол оо? Та бүхний Засгийн газар баталсан 2028 он хүртэлх хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл дээр яг энэ 3.2.2.1-ийг хангах хүрээнд ямар нэгэн хууль тогтоомж боловсруулна гэсэн юм юу ч байхгүй байна. Яг үүгээр нь харахаар. Яг энэ хүрээнд ямар хууль тогтоомж гэдэг нь Засгийн газрын тогтоол дээрээ байхгүй байна.

Тэгэхээр энэ яг ямар хуулийн төслийг хэн боловсруулж 2025 онд хүний болон хуулийн этгээдийн өмчийг хамгаалах хуулийг оруулж ирэх гэж байна гэдэг дээр хариулт авъя.

Х.Булгантуяа: Эхний асуулт Т.Доржханд сайд хариулъя. Тэгээд О.Алтангэрэл сайд.

Т.Доржханд: Баярлалаа. О.Номинчимэг гишүүний асуултад хариулъя.

Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Монополын тухай хууль өргөн баригдах ёстой. Тэгээд энэ ажил маань хаана явж байна вэ гээд.

Тэгэхээр энэ хуулиуд маань яг оны өмнө бүгдээрээ төслийн хэлбэрээр бэлэн болчихсон, хэлэлцүүлэг нь хийгдчихсэн. Тэгээд өргөн барихад бэлэн болчихсон байсан.

Тэгээд хамтарсан Засгийн газрын хүрээнд бид ярьж тохироод, тухайлбал хөрөнгө оруулалтын хуулийг татварын асуудалгүйгээр өргөн барих юм бол энэ маань өөрөө цогц асуудал биш болж байна. Тийм болохоор нэгэнт хувийн сектороо бид дэмжих ёстой. Татварын орчноо бид багц хуулийн түвшинд анх удаа 10 жилийн дараа өөрчилье гэдэг шийдлээ гаргаад. Мөн нийгмийн даатгалын шимтгэл, нийгмийн даатгалтай холбоотой асуудлаа мөн цогцоор нь реформын хэмжээнд шийдэх нь зүйтэй байна. Тийм болохоор эд нарыгаа уялдуулаад хамтад нь өргөн барья гээд хүлээгдэж байгаа.

Тэгэхээр бэлэн болчихсон байгаа. Одоо хүлээгдэж байгаа. Тэгээд тэр нь ч зөв байгаа.

Бид нэг хуулийг нөгөө холбогдох хуулиудтай нь уялдуулж явахгүйгээр дан дангаар нь явахаар хуулийн хийдлүүд гарах гээд байдаг. Нөгөө талдаа үр дүн гаргах талаасаа энэ өөрөө хангалтгүй юм байна. Хамтад нь өргөн барья гээд өнөөдөр 10 жилийн дараа бид Татварын багц хуулийн төслийг боловсруулаад санал авах түвшиндээ явж байгаа. Энэ хаврын чуулганаар өргөн барна. Өргөн барихдаа Хөрөнгө оруулалтын тухай хуультай хамт өргөн баригдана.

Монополын эсрэг хууль мөн адил бэлэн болчихсон байгаа. Тэгэхдээ бид концепцын түвшиндээ яг ямар байдлаар үүнийг өргөн барих юм бэ. Шинэчилсэн найруулга юм уу, нэмэлт, өөрчлөлтийн түвшинд юм уу, агуулга нь ямар байх юм бэ гэдгээ бас тохирох шаардлагатай. Төсөл бол бэлэн байгаа. Тэгээд надад ирсэн мэдээллээр Улсын Их Хурал дахь ажлын хэсгийг таныг ахлах юм байна гэдэг мэдээлэл би энэ долоо хоногт авсан.

Тэгэхээр энэ түвшиндээ мэдээллээ солилцоод явахад бэлэн байгаа.

Тэгээд хамтарсан Засгийн газрын хувьд бидний барьж байгаа бодлого юу вэ гэхээр одоо бол ингээд хувийн сектортоо бид маш сайн дэмжлэг үзүүлэх ёстой. Дэмжлэг нь юу вэ гэхээр хууль эрх зүйн орчны хувьд, дээрээс нь үйл ажиллагааны хувьд цогц байдлаар үзүүлэх бодлого хийгдэнэ.

Хийгдэх гэж байгаа болохоор энэ хаврын чуулган маш их чухал ач холбогдолтой чуулган байгаа. Дахин дахин хуулийг өөрчилж болохгүй. Хийх юм бол нэг сайн хийх хэрэгтэй. Тэгээд цоожлох хэрэгтэй. Тогтвортой байдлыг бий болгох хэрэгтэй. Ингэж байж бид урт хугацааныхаа хөрөнгө оруулалтыг

дотоодын буюу гаднаас авчрахгүй бол байнга өөрчлөөд байдаг энэ эрх зүйн орчинд хөрөнгө оруулалт орж ирэхгүй байна гэдэг ийм агуулгаараа ажиллаж байна.

Тэгээд манай Засгийн газрын хувьд дахиад хэлье. Одоо ингээд Засгийн газар том байна.../минут дуусав/

Х.Булгантуяа: Т.Доржханд сайд нэмэлт минут өгье.

Т.Доржханд: Баярлалаа. Засгийн газар том байна. Хувийн сектор агшаад байна гэдэг шүүмжлэл явдаг.

Бид зах зээлийн эдийн засагт шилжчихсэн. Хувийн сектороо дэмждэг бодлогыг бид хамтарсан Засгийн газрын үед нэлээн углуургаар нь асуудлуудаа гаргаж ирж үүнийгээ цогцоор нь шийдье гэсэн байдлаар явж байгаа.

Тэгээд үр дүнд нь ер нь экспорт, тэгээд хөрөнгө оруулалт, тэгээд хөрөнгө санхүү босгох, тэгээд зөвхөн том хэмжээний бизнес биш, жижиг, дунд хэмжээний бизнес дээр хүртэл бид нэлээд томоохон хэмжээний нөлөө үзүүлэхээр ийм өөрчлөлтийг нэгмөсөн шийдээд явъя. Хамтарсан дээрээ гэсэн байдлаар бодлогоо уялдуулаад явж байгаа шүү гэдгээ бас хэлмээр байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: О.Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Тэр хүний болон хуулийн этгээдийн өмчийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомж. Энэ дээр ямар хууль тогтоомж тусаж ямар байгаа вэ гэдгийг би танд яг тодруулж эргэж хэлье.

Яг энэ Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн иргэний хэрэгтэй холбоотой хэсэг нь бичигдээд дуусчихсан. Одоо бид энэ долоо хоногт эрүүгийн хэргийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой хэсгийг нь эргэж нягтлаад энэ долоо хоногтоо багтаагаад яамны вебсайт дээр тавиад саналд гаргах гэж байна.

Тэгээд зорилго бол бид энэ 5 дугаар сардаа багтаагаад өргөн барьчих юмсан гэдэг ийм зорилго байна.

Энэ хуулийн төсөл боловсруулагдаж байгаатай холбоотойгоор та манлайлаад энэ хэлэлцүүлэг Их Хурал дээр хийсэн. Энэ хэлэлцүүлгийн үеэр яригдсан асуудлуудын бараг 90 шахам хувьтай тусгагдаж байгаа. Банкууд эхнээсээ байр сууриа илэрхийлж байгаа.

Хэрвээ үнэхээр иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэл ийм болоод ирэх юм бол хүү буурах нөхцөл бүрдэнэ шүү гэж байгаа.

Хүүхдийн тэтгэлэг дээр бид бас хариуцлагын арга хэмжээ.../минут дуусав/

Х.Булгантуяа: О.Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Т.Доржханд сайдын хариултаас ер нь бэлэн болж байгаа гэж ойлголоо.

Энэ дээр тэгвэл анхаараач ээ. Таны доор ажлын алба чинь байдаг юм уу. Тайлагналаа зөв хийж сураач ээ. Үйл ажиллагааны хөтөлбөр дээр хэрэгжих хугацаа болоогүй ээ гээд ороод ирж байгаа чинь үнэн зөв тайлагнал болж чадахгүй байна.

Хоёрдугаарт, үнэхээр бид бизнесийн орчноо сайжруулъя гэж байгаа бол одоо Төрийн өмчийн хууль, Төрийн өмчит компанийн тухай хууль. Тийм ээ. Төрийн оролцоог яаж багасгах вэ гэдэг энэ асуудлууд яригдаад эхнээсээ ажлын хэсэг Улсын Их Хуралд хуулиуд нь орж ирээд ажиллаж байгаа.

Ингээд бид төрийн өмчит компанийн төрийн оролцоо, зах зээл дэх оролцоог багасгаад ирэхээр яалт ч үгүй зах зээл дэх хувийн, бизнесийн орон зай гарахад энд тэгш шударга өрсөлдөх боломжтой хууль дүрэм, хэм хэмжээ нь бий болчихсон байж бидний хэлээд байгаа нөгөө жижиг, дунд үйлдвэрлэл, цаашдаа өсөн бойжих, аж ахуйн нэгжүүдийг дэмжих нөхцөл бүрдэх юм.

Тэгэхээр үүнийгээ яаравчлаач ээ гэдгийг хэлмээр байна.

Х.Булгантуяа: Санал хэллээ. Буланы Бейсен гишүүн.

Б.Бейсен: Аялал жуулчлал, соёлын сайдаас асуулт асууя.

Алтай таванбогд Хотон, Хорго нуурыг аялал жуулчлалын бүс болгон Засгийн газрын мөрийн хөтөлбөрт байгаа. Өнгөрсөн 4 жил юу ч хийгдээгүй. Тэр явж байгаа жуулчдын бие засах газар, отоглох газар. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон юм дээр яагаад ийм юм хийгээгүй вэ? Энэ талаар асууя. Нэгдүгээрт.

Алтай таванбогдын чиглэлд 30, 40 мянган жуулчид явж байна. Гэтэл хураамжийн асуудал дээр анхааралтай хандаад тэр отоглох газар энэ тэрийг нь шийдэхгүй бол бас хураамж төлөхгүй ийм нөхцөл байдалд ард иргэд хүсэлт ирж байгаа юм. Үүнийг яаж шийдэх юм.

Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Сангийн сайдаас асуух асуулт байна. Дотоодын одоо 17 гурилын үйлдвэр байсан байна. Одоо ингээд 10 хэд нь хаалгаа барьчихаад 6, 7 нь байгаа юм байна. Ноднин бид гурилын импортын татварыг тэглэсэн. Зудтай холбоотой. Нийтдээ 86 компани гурил оруулж ирсэн байна. Баяжуулсан гурил гэхэд 20-иод тонн, баяжуулаагүй гурил гэхэд бараг 100 гаруй тонн оруулж ирсэн байна л даа.

Үүнтэй холбоотой дотоодын үйлдвэр, тариаланчид маань будаагаа борлуулж чадахгүй. Тэгээд тариалалт 57 хувиар буурчихсан ийм нөхцөл байдалтай байна. Үүнийг яаж шийдэх вэ? Энэ энэ талаар асууя.

Дараа нь Сангийн сайдаас асуух асуудал байна. Баян-Өлгий аймгийн Оношилгоо, эмчилгээний төвийн барилгыг 2019 онд эхэлсэн. Одоог хүртэл ашиглалтад өгөөгүй. “Морин Сувд констракшн” гээд компани. Гэтэл эдний барилга яамны дүгнэлт нь гарчихсан. Эрүүл мэндийн яамнаас бас юу гарчихсан мөртлөө 3 тэрбум 758 сая төгрөгийн санхүүжилтийг тавихгүйгээс болоод энэ эмнэлэг ашиглалтад өгч чадахгүй ийм байдалд хүрчхээд байна.

Цалингийн зөрүү бас бус юм байдаг юм байна. Тэгэхдээ энэ юуг нь аваад харж байна. Одоо бүх дүгнэлт энэ тэр нь гарчихсан мөртлөө 10 сарын 07-нд дүгнэлт гарчхаад өгөхөд одоо энэ жилийн төсөвт яагаад суулгаагүй юм бол.

Дараа нь Хөдөө аж ахуйн сайд, Боловсролын сайдаас. Ер нь хөдөө аж ахуйн мэргэжилтэн бэлдэх асуудал сүүлийн үед ер нь. Одоо Хөдөө аж ахуйн дээдэд 1500-хан оюутан байна гэж ярьж байна шүү дээ. Бараг. Гэтэл малын эмч, зоо техник, агрономи энд чухал. Атрын аяны хэрэгжээд байдаг. Малын мэргэжилтнүүд бараг хөгширчихсөн, мэргэжилтэнгүй болчихсон ийм нөхцөл байдалтай. Үүнийг энэ жил элсэлт дээр яах вэ. Элсэлтийг нь шинээр нэмэх юм уу. Хөдөө аж ахуйн дээдэд зөвхөн аялал жуулчлалын анги, ямар ямар анги гэнэ үү. Шаардлагагүй тийм анги л ажиллуулаад л мэргэжилтэн бэлдээд байгаа л даа. Үүнийг яаж шийдэх юм?

Эрүүл мэндийн сайд байна уу. Эрүүл мэндийн сайдад бид. 1 минутаа нэмээд авчихъя.

Би жилийн эцсээр Эрүүл мэндийн сангийн эрсдэлийн сангийн тэр 50 хэдэн тэрбум, Эрүүл мэндийн даатгалын чөлөөт үлдэгдлийн 60 хэдэн тэрбум, дээр нь 350 хэдэн тэрбум нэмж өгсөн.

Гэтэл одоо ингээд улсын эмнэлгүүдийг бараг 10 хувиар санхүүжилтийг нь хассан. Хувийн эмнэлгүүд түрүүн бид уулзалт хийхэд бараг 40-өөс 50 хувь хасагдлаа гээд ярьж байсан. Энэ чинь ард иргэдэд бас хүндээр тусаж байна. Хувийн эмнэлгүүд төлбөр авч эхэлж байна. Жилийн жилд бид Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг нэмэхдээ бас нэмэгдэнэ гээд бодсон чинь одоо өр зээл тавиад тэгээд сүүлдээ эрүүл мэнд даатгалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ цалгардах юу руу хүрч байна л даа. Жилийн жилд ингээд байх уу, яах вэ? Үүнийг яаж шийдэх гэж байна? Энэ талаар асууя. Дараа тодруулъя.

Х.Булгантуяа: Эхлээд Ч.Номин сайд. Эрүүл мэндийн сайд хаачив? Эдийн засаг, хөгжлийн сайд аа, Эрүүл мэндийн сайдаа дуудахгүй бол.

Ч.Номин: Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт маш тодорхой асуулт асуусан учраас хариулчихъя. 2021-2025 оны хооронд тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн хүрээнд Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан зэрэг газрууд дээр ТЭЗҮ Азийн хөгжлийн банктай хамтран төсөл хэрэгжүүлэхээр байсан.

Хэдий тийм боловч өнгөрсөн жилийн хугацаанд Улсын Их Хурал дээрээс буюу Байнгын хороон дээрээс энэхүү хоёр дахь төсөл буюу Баян-Өлгийтэй холбогдолтой төслийг цуцалсан. Дэмжээгүй учраас Азийн хөгжлийн банктай хамтарч хэрэгжүүлж байсан төсөл цуцлагдсан байгаа.

Энэ хоёр төсөл хэрэгжсэн. Нэгдүгээр хэсэг нь Хэнтий аймагт хэрэгжүүлж байгаа Эзэн Чингис хаантай холбогдолтой түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл. Энэ төсөл яг цаг хугацаандаа хийгдээд явж байгаа.

Үндсэн чиглэлээр нь аялал жуулчлалын салбарыг хэлэхэд аялал жуулчлалын салбар сүүлийн 4 жилийн хугацаанд хамгийн өндөр өсөлттэй, эдийн засгийн өсөлт гаргасан салбар буюу ковидын дараах дэлхий дахинаа хамгийн өндөр. Манай Монгол Улс эргэн энэ салбарын үйл ажиллагааг явуулж эхэлсэн салбар гэж үзэж байгаа.

Манай аялал жуулчлалын тоо ковидын өмнө 577 мянган жуулчин байсан бол өнөөдөр 808 мянган жуулчныг бид яг 2024 онд хүлээж аваад байна.

Бид бүхэн өнгөрсөн хугацаанд Монгол Улсыг олон улсад илүү сурталчлах ажил дээрээ анхаарсан. Яагаад вэ гэхээр бид дэлхий дахинаас жуулчин авчирч байж энэхүү салбар нь хувийн хэвшил суурьтай хөгжиж явах салбар гэж үзэж байгаа учраас бид хэрэглэгчийг бэлдэх ажил дээр буюу дэлхийд Монгол Улсыг сурталчилж, үүгээрээ дамжуулан аялал жуулчлал татах, жуулчлал татах ажлыг илүү түлхүү хийсэн.

Бид үүнээс цаашаа илүү дотооддоо таны хэлж байгаа энэ зам дагасан ариун цэврийн байгууламжуудыг нэмэгдүүлэх. Түүнээс гадна 4 улирлын аялал жуулчлалыг хөгжүүлж, хөдөө орон нутагт өвлийн улиралд үйл ажиллагаатай байдаг жуулчны кампуудыг нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг одоо яг стратегитэйгээр хийж байна.

Үүнийгээ хийж хэрэгжүүлэхийн тулд бид одоо бүсчилсэн хөгжлийнхөө үйл ажиллагаатай уялдуулан 7 бүстэй, 66 аялал жуулчлалын орон зайг бий болгож, энэ орон зайндаа уялдуулсан дэд бүтцүүдийг хэрхэн хөгжүүлэх вэ гэдгээ одоо яг Зам, тээвэр аялал жуулчлалынхаа яамтай уялдуулан ажиллаж байгаа.

Манай сан салбар дээр хамгийн чухал бас нэг зүйл юу байдаг вэ гэхээр бид олон улсаас ирж байгаа жуулчдыг Монголд ирүүлэх агаарын тээврийг нэмэгдүүлэх.

Хоёрдугаарт, орон нутаг руу явж байгаа дотоодын агаарын тээврийг тогтвортой болгох ажлууд байдаг.

Тэгэхээр эдгээр ажлууд дээр анхаарч ажиллаж байгаа. Тэгээд энэ хүрээндээ таны түрүүний асуусан зам дагасан ариун цэврийн байгууламжуудын хувьд бид хувийн хэвшилтэйгээ хамтран Байгаль орчны яамны гаргасан стандартын дагуу 100 гаруй газар ариун цэврийн байгууламжуудыг бий болгохоор ирэх онуудад төлөвлөн ажиллаж байгаа.

Тэгэхээр аялал жуулчлалын салбарын хувьд өнгөрсөн 4 жилийн хугацаанд хамгийн өндөр өсөлттэй буюу.../минут дуусав/

Х.Булгантуяа: Хоёр дахь асуултад Ж.Энхбаяр сайд хариулах уу. Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийн асуудал.

Ж.Энхбаяр: П.Наранбаяр сайд хариулах ёстой. Салбарын хүний нөөц бэлтгэх бодлого Боловсролын яамд харьяалагдаж байгаа.

Салбартай холбоотойгоор үндсэндээ салбар хүний нөөцийн гүн гүнзгий дутагдалд орж байна. Яаралтай Улсын Их Хурлаас онцгой арга хэмжээ авч хэрэгжүүлж хөдөө аж ахуйн салбарт ажиллах мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх энэ бодлогыг авч хэрэгжүүлэхгүй бол салбар хүний нөөцийн гүн дутагдалд орж байна гэдгийг би дахин хэлэхийг хүсэж байна.

Тэгээд ямар бодлого хэрэгжүүлж байгааг Боловсролын яам хариуцаж байгаа.

Х.Булгантуяа: П.Наранбаяр сайд боловсон хүчний бодлогын асуудлаар.

П.Наранбаяр: Хөдөө аж ахуй, ялангуяа хүнс үйлдвэрлэлийн чиглэлээрээ үнэхээрийн боловсон хүчин дутаж байгаа нь үнэн. Бэлдэж байгаа нь ч гэсэн цөөрч байна. Агрономи гэхэд л 230 орчим л хүн сурч байх жишээтэй. Ийм л нөхцөл байдалтай. Гэтэл гол үйлдвэрлэдэг хөдөө аж ахуйн салбар чинь эндээ явж байх жишээтэй.

Ер нь салбараар нь харах юм бол 2127 хүн сурч байгаагаас газар тариалан, мал аж ахуй нийлээд л 423 хүн сурч байх жишээтэй.

Тэгэхээр ийм нөхцөл байдалд бид юу гэж бодож байна гэхээр нэгдүгээрт эрэлттэй тэргүүлэх мэргэжлийн жагсаалтад 20 орчим хөдөө аж ахуйн чиглэлийн мэргэжил байгаа. Үүнийг нэмэгдүүлье гэж.

Хоёрдугаарт нь, хөдөө орон нутагт их дээд сургуульд суралцаж байгаа суралцагчийн 50 хувийн хөнгөлөлтийн асуудал гээд Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа хөндөөд байгаа. Нөхцөлийг нь зөөлрүүлэхгүй бол бас болохгүй байгаа юм.

Амьжиргааны түвшинг шаардчихсан байгаа. 50 хувийн хөнгөлөлттэй зээл олгоод 50 хувиар нь хөнгөлүүлээд тэгээд явчих юм бол бас энэ чиглэлд.../минут дуусав/

Х.Булгантуяа: П.Наранбаяр сайдын микрофоныг нэмж өгье.

П.Наранбаяр: Орон нутагт ажиллах боловсон хүчин тэндээ бэлтгэгдэж эхэлнэ гэж харж байгаа.

Түүний зэрэгцээ хөдөө аж ахуйн салбарт мянган мэргэжилтэн бэлтгэх бодлогыг нь дэмжих, Атрын-IV аян зохион байгуулж байгаатай холбоотойгоор хөдөө аж ахуйн мега төслийн хүн хүний нөөцийг бэлтгэх, сурах төлөвлөгөөг бусад салбаруудтай хамтраад бид Засгийн газраар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Мөн хөдөө аж ахуйн чиглэлийн мэргэжлийн индексүүдийг багцлаад зоотехникч, малын эмчийн хөтөлбөрүүдийг нь түлхүү дэмжих шаардлага гарсан. Төрөлжсөн ахлах сургуулиудаар дамжуулаад малчин фермер болох хүүхдүүдийг тасралтгүй бэлтгэх хосмог сургалтаар дэмжих ажлууд явж байна.

Бид бас малчин өрхийн гишүүний мал аж ахуй эрхлэхтэй холбоотой ур чадварыг хөгжүүлэх сургалтыг эхлүүлсэн. Энэ жил сайдын багц дээр 150 сая суусан байгааг хэрэгжүүлэхээр өнөөдөр төлөвлөгөө нь гараад холбогдох яамд руу явуулаад хамтран ажиллаж байна. Ийм нөхцөл байдалд байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Хүний нөөцийн асуудал ганцхан хөдөө аж ахуйн салбарт гэлтгүй бараг бүх салбарт байгаа. Одоо эрүүл мэндийн салбарт ч байгаа, боловсролын салбарт, П.Наранбаяр сайдын салбарт ч байгаа. Тийм ээ.

Тэгээд 2023 оны хүний нөөцийн том судалгаагаар манай төгсөж гарч байгаа хүүхдүүдийн 4 хүүхэд тутмын 1 нь ямар нэг юмны менежментээр төгсөж байгаа. Бизнесийн удирдлага, аялал жуулчлалын удирдлага гэх мэтчилэн. Яг хөгжилд хөтөлдөг SCIENCE TECHNOLOGY, инженер, математик чиглэлээр 4 хүүхэд. 10 хүүхэд тутмын 1 нь төгсөж байна гэж гарсан байна лээ.

Тэгэхээр угаасаа хүний нөөцийн асуудал ялангуяа манай Боловсролын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, дээрээс нь нэмээд Эдийн засаг, хөгжлийн сайд оролцоод үүн дээрээ маш том бодлогын баримт бичиг гарахгүй бол энэ дээр ер нь амжихаа байсан.

Тэгээд үүнийгээ Та бүхэн маань ганцхан салбарын хүрээнд гэхгүй бас авч үзэх ёстой шүү.

Эрүүл мэндийн сайдаас түрүүн Б.Бейсен гишүүн асуулт асуусан.

Т.Мөнхсайхан: 2024 онд Эрүүл мэндийн сайдаар томилогдоход Эрүүл мэндийн даатгалын сан маш их хүнд нөхцөл байдалтай байсан. Маш их өр зээлтэй. 2024 оныг эмнэлгийн тусламж, үйлчилгээг тасалдуулахгүйгээр давж чадахгүй хэмжээнд оччихсон байсан.

Энэ дээр харин нэлээн зохицуулалтуудыг хийгээд, сайдын багцаас хэмнэлтүүдийг хийгээд, Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлээд, Эрүүл мэндийн даатгалын сан дээр эрсдэлийн санг бий болгоод, эндээсээ бид төлбөр тооцоогоо хийж байж 2024 оноо амжилттай давсан.

Ингээд давахдаа бид Эрүүл мэндийн даатгалын санг 15 хувийн өсөлттэй 2025 оны төсвөө батлуулсан. Энэ нь 300 гаруй тэрбум байсан боловч үүгээр өнгөрсөн 3 жилийн хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудад өгөх ёстой байсан төлбөрийг төлж барагдуулсан.

Ингээд үндсэндээ 1.9 их наяд орчим төгрөгийг бид эрүүл мэндийн байгууллагууддаа энэ жил хуваарилалт хийж байгаа гэсэн үг. Тэгээд үүнийг.../минут дуусав/

Х.Булгантуяа: Т.Мөнхсайхан сайдын микрофоныг нэмж өгье.

Т.Мөнхсайхан: Тэгэхээр энэ дээр бид нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнүүдээ бүгдийг нь санхүүжүүлэхээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад байгаа мөнгөө л бүгдийг нь хуваарилж байгаа юм.

Тэгэхээр цаашдаа бид энэ дээрээ ямар нэгэн асуудал байхгүй шийдье гэх юм бол эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг нь олон улсынх нь түвшинд хүргэж дотоодын нийт бүтээгдэхүүнийх нь доор хаяж 6 хувьд хүргэхгүй бол энэ асуудал хэзээ ч дуусахгүй.

Одоо 2025 онд нэмэгдээд тавигдсан төсөв нь нийтдээ дотоодын нийт бүтээгдэхүүний дөнгөж 3 хувьд хүрч байгаа. Үүнийг бид ямар ч зохицуулалт хийгээд энэ их өсөн нэмэгдэж байгаа тусламж, үйлчилгээнд бүгдийг нь хүргэх боломжгүй. Үүнийг бид жил болгон үе шаттайгаар нэмэгдүүлж, 2026 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувьд, 2027 онд 5 хувьд хүрч ингэж явахгүй бол Эрүүл мэндийн даатгалын сангийн өнөөдрийн байж байгаа энэ санхүүжилтээр хүссэн хэмжээний санхүүжилт юмыг өгөөд явах ямар ч боломж байхгүй. Бид байгааг нь боломжоор нь зөв хуваарилалт.../минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Бейсен гишүүн нэмж тодруулъя.

Б.Бейсен: Эрүүл мэндийн сайд аа, ийм асуудал байна л даа.

Жилийн жилд өрийг нь төлөөд өгөөд байдаг. Жилийн жилд өр нь нэмэгдээд байдаг. Ер нь орон тооны илүүдэл бас байгаа байхгүй юу.

Жишээлбэл, аймгийн нэгдсэн эмнэлгийн 386 орон тоогоор баталж өгсөн мөртлөө. Төсвийг нь нөгөө талын санхүүжилтээр. Гэтэл одоо ингээд 505 орон тоогоор ажиллаад байгаа байхгүй юу. Энэ дээр хяналт хийхэд жаахан төсөвтөө хэмнэлт хийх тал дээр хяналт шалгалт сайжруулахгүй бол болохгүй байх гэж үзэж байна л даа.

Төсвийн гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой нэмээд өгсөн мөртлөө тэр нь тэгээд өр, зээл өсгөөд байдаг асуудал байж байгаа. Хариуцлагын асуудал бас байгаа. Энд одоо хяналт хийж үзсэн үү гээд.

Хоёрдугаарт, Сангийн сайд Баян-Өлгийн нэгдсэн эмнэлэг, оношилгооны төвийн барилгын дутуу санхүүжилтийн 10 сард яасан байна шүү дээ. Үүнийг шийдээгүй юм болов уу? Энэ эмнэлэг нь ашиглалтад ороогүй хэвээрээ л байна.

Х.Булгантуяа: Б.Бейсен гишүүний асуултад нэмж. Ажлын хэсгийн 6 номерын микрофоныг өгье.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя. Сангийн яам. Ж.Дэлгэржаргал.

Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн барилга анх 2019 онд төсөв дээр 8.7 тэрбумын өртөгтэй батлагдсан. 2020 онд ашиглалтад орохоор. Түүнээс хойш хэрэгжилтийн явцад материалын үнийн өсөлт, төсөвт өртгийн нэмэлт санхүүжилт гээд одоогоор 6 дахь жил рүүгээ орчихсон. Дуусаагүй. 28 тэрбум болчихсон явж байгаа.

Барилга, хот байгуулалтын сайдаас энэ төсөл дээр цалингийн зөрүү буюу цалингийн нэмэгдэлтэй холбогдуулаад 3.7 тэрбумын нэмэгдлийн хүсэлт ирсэн.

Тэгээд 2025 оны төсөв батлагдахад гарсан Их Хурлын 52, 54 дүгээр тогтоолоор эдгээр нэмэгдлүүдэд үндэсний аудитын дүгнэлт гаргуулах ийм ажлыг Засгийн газарт чиглэл болгож өгсөн байгаа.

Энэ дагуу бид Барилгын сайдаас ирсэн тооцооллын нэлээн эрсдэлтэй гэж үзээд Барилгын яаманд буцаасан байгаа. Дахиж нягтлах шаардлагатай. Эдгээр нягталж дахиж хүсэлт ирсний дагуу Үндэсний аудитын газарт хүргүүлж.../минут дуусав/

Х.Булгантуяа: Үндэсний аудитын газар луу хүргүүлээд. Тэгж байж төсөв дээр суулгах ёстой. Тийм ээ. Улсын Их Хурлын тогтоолоор өгсөн үүрэг чиглэлийн дагуу.

Т.Мөнхсайхан сайд нэмж хариулах уу? Орон тоо нэмэгдэлтэй холбоотой асуудлаар.

Т.Мөнхсайхан: Өөрсдөө өрөнд орчхоод байгаа эмнэлгүүдийн өрийг нь ерөөсөө төлөхгүй байгаа. Бид. Эмнэлгүүдэд Эрүүл мэндийн даатгалаас өгөх ёстой мөнгийг нь л төлж өгч байгаа.

Харин эмнэлгүүд өөрсдөө менежмент муутай, орон тоогоо нэмэгдүүлээд өр төлбөрт орсон тохиолдолд удирдлагын багтай нь тооцоололыг нь хийгээд хариуцлагыг нь тооцох асуудал яригдаж байгаа. Түүнээс биш хуучин шиг ямар нэгэн байдлаар орон тоогоо хэтрүүлээд, буруу менежмент хийгээд, өр төлбөрт орсон бол тэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас даадаг тийм зүйл огтоосоо байхгүй болчихсон байгаа.

Тэгэхээр цаашдаа менежментээ зөв авч явж чадахгүй бол удирдлагын багт нь хариуцлага тооцох ийм л арга барилаар явж байгаа гэсэн үг.

Х.Булгантуяа: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр.

Ж.Энхбаяр: Монгол Улс стратегийн бүтээгдэхүүн болсон улаан буудайгаа дотоодоосоо 100 хувь хангах нөхцөл бүрэн бүрдсэн.

Өнгөрсөн онд гэхэд 386 мянган тонн үр тариа хураан авч хүнсний чиглэл 210 мянган тонныг нийлүүлсэн.

Нөгөө талаар өнгөрсөн өвөл хаваржилтын хүндрэлтэй холбоотойгоор эрсдэлийг бууруулах үүднээс гурилын болон улаан буудайн албан татварыг тэглэсэн. Улсын Их Хурал шийдвэр гаргаж.

Үүнтэй холбоотойгоор хөрш Оросын Холбооны Улсаас 64 мянган тонн бэлэн гурил, 76 мянган тонн улаан буудай татваргүй орж ирсэн. Энэ нь “Хүнсний хувьсгал” зорилтын хүрээнд дотоодоосоо 100 хувь хангаж байсан манай улаан буудай, гурил үйлдвэрлэлийн салбарт нэлээн том цохилт болсон. Үндсэндээ 100 хувиас буцаад 60 хувь руу үйлдвэрлэлийн байдал.../минут дуусав/

Х.Булгантуяа: Гүйцээж хариулъя. Ж.Энхбаяр сайдын микрофоныг нэмж өгье.

Ж.Энхбаяр: 100 хувийн дотоод хангалтаасаа бид 60 хувь руу унаж, 40 хувь импортын хамаарал эрс нэмэгдсэн ийм үзүүлэлт байгаа.

Үүнийг Засгийн газар дээр асуудал ярилцаж зудын гол эрсдэл өнгөрсөн тул Засгийн газар үүнийг Их Хуралд өргөн барьж хуулийг дахин эргэж харах ёстой гэдэг хуулийн төсөл өргөн барьсан.

Одоо хаврын тариалалт эхлэх гэж байна. Яаралтайгаар 4 сарын эхний хоёр долоо хоногт багтаж асуудлыг шийдэхгүй бол 5 сарын 01-нд тариалалт эхэлнэ. Үүнээс өмнө үр хангалт, бодлого тодорхой байх ёстой. Үүнийг эрхэм гишүүд минь анхаараарай. Энэ асуудал шийдэгдэхгүйгээр бид цаашдаа газар

тариалангийн салбарын хөгжлийн асуудал ярихад туйлын хүндрэлтэй, эрсдэлтэй байдал үүснэ.

Дэлхийн бүх улс орон тарифын бодлогоор дотоод зах зээлээ хамгаалж байгаа гэдгийг бүгд сайн мэдэж байгаа. Ийм хариулт өгье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзориг.

П.Ганзориг: Улс орны таван жилийн үндсэн чиглэл буюу 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт ярьж байна.

Энэ уг нь төсөв төлөвлөгөө батлахаас чухал асуудал байгаа юм. Бусад улс орнуудын жишиг тийм байдаг. Төсөв, төлөвлөгөө батлахаасаа илүүтэйгээр төсвийнхөө гүйцэтгэл, бодлогынхоо төлөвлөлтийн гүйцэтгэлийг ярихад илүү цаг гаргаж ач холбогдол өгч суудаг. Харамсалтай нь өнөөдөр Засгийн газрын ач холбогдол өгч байгаа байдал их сул харагдаж байна. Сайд нарын оролцоо, хариулж байгаа байдал гээд. Энэ дээр цаашид Их Хурал анхаарч ажиллах ёстой гэсэн ийм саналтай байна.

Тэгээд бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн гүйцэтгэл ярьж байхад гурван асуудал байна. Нэгд биелэлтийн хувь хангалтгүй. 50 гаруйхан хувьтай.

Ялангуяа яг энэ бодлогын тэргүүлэх чиглэлүүд, тэгээд үндсэн зорилтууд болох агаарын бохирдол, түгжрэл гээд ард иргэдийн амьдралын чанартай холбоотой, амьдрах орчинтой холбоотой, ажил орлоготой холбоотой асуудлууд 50-иас доош хувьтай байж байна.

Тэгэхээр энэ асуудлыг бас төлөвлөлтөө хийхдээ хүн хүч, хөрөнгө санхүү, цаг хугацаагаа бодитоор төлөвлөхгүйгээр ингэж тооцож хийснээс болоод төлөвлөгөөний биелэлт нэг талдаа бага гараад байгаа асуудал байна.

Тэгэхээр энэ төлөвлөлтийнхөө аргачлал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Хоёрт, гол үндсэн чиглэл, асуудлууд үр дүнд хүрэхгүй байгаа асуудал. Төсвийн бүтцэд нэг шинэчлэл хийхгүй бол болохгүй гэдгийг харуулж байна. Өөрөөр хэлбэл сүүлийн 5 жилд 2021-2024 он, 2025 оны төлөлтийг оруулаад Монгол Улсын нийт төсөв 115 их наяд төгрөг зарж байгаа. 115 их наяд шүү. Үүний жил бүр 65-аас 74 хувь нь урсгал зардалд явж байгаа.

Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалт хийх зардал маш бага. Тэгээд эдийн засаг дахь төрийн оролцоо ихэссэн, хувийн хэвшил хумигдсан ийм үед яг энэ хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтууд бага байгаагаас болоод үндсэн асуудлууд шийдэгдэхгүй байна.

Тэгэхээр хоёр дахь төсвийн шинэчлэлээ яаж хийх юм бэ? Хэзээ хийх юм бэ гэдэг дээр тодорхой хариулт Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайдаас асууя.

Гуравт нь, хяналт, хариуцлагын асуудал маш сул байна. Бид маш олон сонсголууд хийсэн. Жишээлбэл, агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой сүүлийн 15 жил ярилаа. Хэдэн их наядаар нь зарцуулсан байна. Үр дүн гардаггүй ээ. Улам л доройтоод байдаг.

Одоо удахгүй нийслэлийн 2040 төлөвлөгөөг бид ярих гэж байгаа. 2020 он хүртэлх биелэлт нь 20 хэдхэн хувьтай. Тэгээд 20 хэдэн хувьдаа биелэлтээ дүгнэж асуудлаа шийдээгүй байж дахиад 2040-ийг нь батлах гээд сууж байгаа. Нэг их гоё гоё агуулгатай, уриатай.

Тэгэхээр төлөвлөлтийнхөө гүйцэтгэлийн хяналтын асуудлуудыг хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож шийдэхгүйгээр бид дараагийн мянга гоё үгтэй төлөлт хийгээд нэмэргүй.

Тэгээд төсөв дээр ялангуяа сонгуулийн зорилготой “Шинэ хоршоо” гээд 1 их наяд төгрөг шахуу зарцуулчихаад байгаа шүү дээ. Үр дүн байхгүй. Төсөвтөө ач холбогдолгүй зардлуудыг оруулж ирж шийддэг. Энэ асуудлуудыг яаж шийдэх вэ? Засгийн газраас ямархуу бодлого чиглэл энэ дээр барьж ажиллах вэ гэдэг ийм гурван асуултыг асууя.

Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас бас асуумаар байна. Дэлхийн эдийн засгийн өнгөрсөн 2 сард болсон форум дээр Монгол Улсад ирээдүйн 10 жилд тулгарах топ 5 эрсдэлийн нэгээр хамгийн эхэнд нь “ажиллах хүчний хомсдол”-ын асуудал дурдагдсан. Энэ дээр бас яг ямархуу бодлого чиглэл цаашид барьж ажиллах гэж байна?

Өнгөрсөн 4 жилийн яг энэ дээр чиглүүлж барьсан бодлогын баримт бичгүүд яг төлөвлөсөн ажлуудын биелэлт бас хангалтгүй харагдаж байна.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд түрүүлж хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя.

Төсвийн шинэчлэл хэзээ хийгдэх вэ гэж байна.

Тэгэхээр энэ нэр томьёог яаж ойлгож байгаагаасаа л болно доо. Энэ бол цоо шинэ сэдэв биш. Өмнө нь төсвийн шинэчлэл байнга хийгдэж ирсэн. Одоо ч хийгдэж байгаа. Цаашдаа ч хийгдэнэ.

Тодорхой асуудлууд яригдаж байгаа бол тэрийг ардаас нь бүгдээрээ тал талаас нь ярья. Яг ямар асуудал байна. Маш олон эдийн засгийн ангиллууд байна. Гадаад нөхцөл байдал байна.

Ер нь явж явж энэ төсвийг тэлж байгаа хамгийн том шалтгаан нь хууль, эрх зүйн орчин байдаг. Ер нь хуулиар заачихсан зардал, төсвүүд чинь л хамгийн их энэ төсвийг бид буцалтгүйгээр өсгөх, нэмэх ийм л асуудал болж орж ирээд байгаа.

Тийм учраас тун удахгүй Их Хурал дээр, өмнө нь Их Хурлын тогтоолоор өгсөн үүргийн дагуу Засгийн газраас энэ жилийн төсөв болон цаашдаа ойрын ирээдүйд 4.5 их наядаар жил бүр шүү. Доор хаяж нэмэгдээд байгаа хууль, эрх зүйн энэ орчныг танилцуулна.

Энэ дээр та маш сайн суугаад энэ энэ хуулиудыг нь бүр ажиллуулахаа больё, хүчингүй болгоё, энэ зардлуудыг нь таная, ийм хууль эрх зүйн орчин шаардлагатай, шаардлагагүй гээд үүнийг нэг тосыг нь тосоор нь, усыг нь усаар ялгах дээр идэвхтэй сайн ажиллах юм байна гэж ингэж ойлголоо шүү.

Хоршооны хувьд чиглэлийн сайд нь дэлгэрэнгүй хэлэх байх. Тэр дүнгийн хувьд 1 их наяд гэж энэ худлаа. Буруу зөрүү ийм дүн ярьж ингэж төөрөгдүүлж болохгүй шүү.

Төсөв дээр тийм хэмжээний дүн ачаалал ерөөсөө огт ирээгүй байгаа. Тийм.

Х.Булгантуяа: Л.Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: П.Ганзориг гишүүний асуултад хариулъя.

Өнгөрсөн 2 сард Дэлхийн эдийн засгийн форум дээр гурван том шилжилт хүн төрөлхтний өмнө том сорилт болох юм байна гэдгийг зарласан.

- ▷ Хүний нөөцийн шилжилт,
- ▷ Технологийн шилжилт,
- ▷ Ногоон шилжилт.

Ийм том шилжилтүүд улс орон бүхэнд сорилт болох нь ээ гэж.

Тэгэхээр манай улсад ч гэсэн үндсэндээ энэ гурван сорилт гурвуулаа том сорилт болж ирж байгаа. Бид энэ сорилтыг даван туулах бодлого хэрэгтэй байгаа. Тэр тусмаа манайх шиг хөдөлмөрлөх, ажиллах хүчний хомсдолд орчихсон улсуудын хувьд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт буюу хөдөлмөрийн зах зээл дэх ур чадварын эрэлт, нийлүүлэлтийг хангах зөв бодлого хийх ёстой гэж харж байгаа.

Энэ хүрээнд П.Наранбаяр сайд бид хоёрт Ерөнхий сайдын зүгээс яг энэ хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтэд суурилсан их өгөгдлийн платформыг боловсруулах чиглэлүүдийг өгсөн байгаа.

Энэ хүрээнд хоёр яамны хамтарсан ажлын хэсгүүд гарч.../минут дуусав/

Х.Булгантуяа: Л.Энх-Амгалан сайдын микрофоныг нь нэмж өгье.

Л.Энх-Амгалан: Тэгэхдээ бид ер нь өнөөдөр үүсчхээд байгаа нөхцөл байдлыг их сайн ойлгомоор байгаа юм.

Хэзээнээс Монгол Улс хөдөлмөрийн зах зээлийн хомсдолд орчхов, ажиллах хүчний хомсдолд орчхов. 200-аад мянган залуучууд гадагшаа гараад, 130 мянган залуучууд гадаадад ажиллаад, 60, 70-аад мянган залуучууд гадаад оронд суралцахаар бид хөдөлмөрлөх, ажиллах хүчний хомсдолд орчихлоо гэж бас тийм гэнэн ойлгож болохгүй юм билээ. П.Ганзориг гишүүн ээ.

Энэ бол 1990-2005 оны хооронд буюу нийт 15 жилийн хугацаанд Монгол Улсад “бага төрөлтийн үе” гэж ийм үе байсан. Энэ бага төрөлтийн үеэс шалтгаалж бид жил бүхэн 20-иос 30 мянган хүн өнөөдөр хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах ёстой залуучуудынхаа алдагдсан боломж гэж хэлдэг энэ боломжийг алдсан учраас өнөөдөр Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дээр 500-аад мянган хүний ажиллах ёстой байсан залуучуудын сох дутаж байгаа нэг ийм асуудлуудаас болж манай хөдөлмөрийн зах зээл дээр бодитой хомсдол үүсэж байна.

Манай хөдөлмөрийн зах зээл чинь өөрөө их бага шүү дээ. 1.2 сая хүний багтаамж одоо байгаа зах зээл. Тийм ээ.

Тийм учраас бид бодлогоо их зөв.../минут дуусав/

Х.Булгантуяа: П.Ганзориг гишүүн нэмж тодруулъя.

П.Ганзориг: “Шинэ хоршоо” дээр яг өнгөрсөн хугацаанд хэдий хэмжээний мөнгө гарчхаад байгаа вэ?

Хоёрт, 2025 онд хэд гарахаар байгаа вэ? Нийтдээ ямар хэмжээний төсөв зарцуулж байгаа гэдгийг тодорхой асуучихъя. Сангийн сайдаас.

Тэгээд ер нь гол нь бид мянга гоё төлөвлөгөө батлаад хяналт хариуцлагын тогтолцоогоо шийдэхгүйгээр явахгүй л дээ. Өнгөрсөн хугацаанд ч гэсэн улсын төсвөөр хийгдэж байгаа олон төсөл, арга хэмжээнүүдийн төсөв нь нэмэгддэг. Цагтаа ордоггүй. Үр дүн гардаггүй ийм асуудлууд байж байгаа.

Тэгэхээр гүйцэтгэл ярьж байгаа дээр цаашдаа гүйцэтгэлтэй холбоотой, үр дүн муу байгаатай холбоотой хаана ямар алдаа гараад байгаа юм, ямар учир

шалтгаан байгаа юм бэ гэдгийг нь бодитоор дүгнэж байгаад цаашдаа энэ асуудлуудыг тодорхой хуульд оруулж явахгүй бол болохгүй байх. Одоо бас хяналтын асуудал хариуцсан сайд бас байна. Тэгээд холбогдох хүмүүс нь энэ дээр бас санаачилгууд гаргаж ажиллаарай гэж хүсье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн Баясгалан.

Ж.Баясгалан: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе.

Өнөөдөр бид чинь яг юуны төлөө хуралдаад байгаа юм бэ? Гүйцэтгэлийн тайланг харахаар 52 хувь, 64 хувь биелсэн гэж үзээд байгаа. Гэтэл нөгөө талаасаа бид биелээгүй байна гэж хараад байгаа. Биелсэн ч бай, биелээгүй ч бай үүний дараах үр дүн нь юу юм бэ? Хариуцлагаа тооцохгүй бол бид ингэж хуралдаад ямар ч хэрэг байхгүй байна шүү дээ. Үүний дараа Их Хурлаас ажлын хэсэг гардаг ч юм уу, яадаг юм ямар ч байсан гүйцэтгэлээ дүгнэж дүгнэлт гаргах хэрэгтэй байна. Тийм ээ. Дарга аа. Тэгээд түүнийхээ араас явах хэрэгтэй байна.

Тэгэхгүй бол ингэж хуралдаад байх хэрэг алга байна шүү дээ. Тав дахь өдөр бид хуралдсан. Тав дахь өдөр хуралдаад яасан. Сайд нар байхгүй гээд л больцгоосон шүү дээ. Хойшлуулсан шүү дээ. Нэг дэх өдөр болтол.

Одоо тэгээд байгаа сайд нараа хар л даа. Бас л байхгүй байна шүү дээ. Яг үнэндээ. Төсөв ярихаар бүх сайд ороод ирдэг шүү дээ. Авах болохоороо. Ирээдүй ярих болохоор. Яагаад өнгөрснийг ярих болохоор ингээд байхгүй байгаад байгаа юм бэ?

Мэдээж ажил ихтэйг нь ойлгож байна. Бүгдээрээ л ажил ихтэй байгаа. Давхар дээлтэй учраас. Гэхдээ энд суугаад байдаг сайдууд байна шүү дээ. Байнга хариултаа өгч байдаг. Огт суудаггүй сайдууд байна шүү дээ.

Үгүй ээ, тэгээд үнэхээр сууж чадахгүй, хоёр ажил хийж чадахгүй бол тэр давхар дээлээ болих хэрэгтэй байна шүү дээ. Сайд нарын зүгээс тийм асуудал дээр яриад байсан шүү дээ. Бид яаман дээрээ ажиллаж чадахгүй байна гээд. Тэгвэл яаман дээрээ ажиллах боломжийг нь олгоё л доо.

Ингээд л Их Хурал яам гэсэн хоёр юм давхцуулчихаад л, тэгээд л асуудал үүсээд байна шүү дээ. Эндээс чинь болоод.

Тэгээд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тодорхойлсон зорилго, зорилт, арга хэмжээний хүрээнд 21.7 их наяд төгрөг зарцуулсан ч нийгэм, эдийн засагт эерэг өөрчлөлт бий болсон нь тодорхойлогдохгүй байна гээд Үндэсний аудитын газар дүгнэчихсэн байна.

Тэгээд ийм дүгнэлт байхад бид үүнийг дахиад л задлаад яриад байх хэрэг байна уу? Энэ дээр сайдууд минь яг суух үедээ энэ танхимдаа суугаад, хариулах үедээ яг хариулчих л даа.

Тэгэхгүй бол ирсэн мэргэжилтнүүд нь бөөрөнхийлсөөр байгаад ямар асуулт асууснаа бүр мартахаар байна шүү дээ энэ танхимд.

Тэгээд би нэг л юм асууя. Одоо бүгдээрээ л тал талаас нь асууж байгаа. Энд хоёр юм асуух юм байна. Уучлаарай.

Нэгдүгээрт, эмийн чанар. Эмийн чанартай холбоотой ажлын хэсэг нэгийг байгуулж, тэгээд төсөл, арга хэмжээ нэгийг хэрэгжүүлээд эмийн чанар дэлхийн жишигт байна гэдгийг 90 хувиар баталсан байна.

Тэгвэл үүнийгээ яаж баталсан юм бэ? Яг үүнийг хариуцаж байгаа яам, үүнийг хариуцаж байгаа хүн нь яг энэ дээрээ тайлбар хэлээд өгөөч. Эмийн чанар яг үнэхээр дэлхийн жишигт байгаа гэдгээ 90 хувь баталж байгаа юу? Энэ дээр нэгдүгээрт яг тодорхой хариулт авъя.

Хоёрдугаарт, энэ танхимд байгаа хүмүүс, энэ танхимд байгаа сайд нар өөрсдөө хуулиа хамгийн сайн биелүүлдэг байх ёстой.

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлд заасан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэх тухай. 25-аас дээш ажиллагсадтай албан газар 25 хүн тутмын 1 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах ёстой. Ажиллуулахгүй бол тэр хэмжээгээрээ төлбөрөө төлөх ёстой. Тэгвэл энэ манлайлал манай Их Хуралд байхгүй байна шүү дээ, энэ Засагт байхгүй байна.

Би Засгаас үүнийг нэхмээр байна. Хамгийн түрүүнд. Хаана байна? Ерөөсөө 48 хувийн биелэлттэй л байна шүү дээ. 2023 онд ийм байсан. 2024 оны дүнг харлаа. Ялгаа байхгүй.

Яагаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэхэд нь саад болоод байгаа юм бэ? Яагаад чирээд явахгүй. Энэ аж ахуйн нэгжүүд чинь 52 хувь хэрэгжүүлж байгаа шүү. Тэгэхэд одоо энэ танхимд байгаа.

1 минутдаа нэмээд авчихъя.

Х.Булгантуяа: Ж.Баясгалан гишүүний микрофон дээр 1 минут нэмье.

Ж.Баясгалан: Энэ танхимд байгаа сайд нараас одоо яг босож ирээд манайх 100 хувь биелүүлж байгаа гээд хэлчих сайд байна уу? Надад 2024 оны 10 сарын 01-ний байдлаар ирсэн мэдээлэл байгаа.

Тэгэхээр Та бүхэн яг 100 хувь биелүүлж байгаа гэсэн тийм сайд байна уу? Ер нь хэдэн хувьтай байгаагаа Та нар нэг өөрсдөө хэлээд явчхаач ээ. Энэ асуултыг би энэ танхимд байгаа сайд нараасаа асуух гэсэн юм. Ийм хоёр асуултад яг тодорхой хариулаад өгөөрэй.

Х.Булгантуяа: Ж.Баясгалан гишүүн маш тодорхой асуулт асуулаа. Түрүүн П.Ганзориг гишүүний асуултад би санал гээд өнгөрөөчих шиг боллоо.

Эхлээд Б.Жавхлан сайд хариулъя. Тэгэх үү?

Б.Жавхлан: П.Ганзориг гишүүний асуултад хариулъя.

Өнгөрсөн онд “Шинэ хоршоо” төсөл дээр 25.1 тэрбум, энэ жил 105.3 тэрбум гээд төсөвлөгдсөн байгаа. Нийтдээ 130 тэрбум гэсэн үг.

Тэгэхээр 1 их наяд бол биш шүү.

Ж.Баясгалан гишүүний асуултад хариулъя. Манайх 100 хувийн гүйцэтгэлтэй байгаа.

Х.Булгантуяа: Эмийн чанарын асуудалд Т.Мөнхсайхан сайд хариулъя.

Т.Мөнхсайхан: Энэ эмийн чанарт өөрчлөлт гарах түвшин нь 90 хувийн биелэлттэй л байна гэж дүгнэлт гарсан байх л даа.

Түүнээс одоо яг эмийн чанар, үнийн асуудал өнөөдөр 90 хувьтай байна гэдэг тийм дүгнэлт биш байх л даа. Гэхдээ энэ дээр маш том өөрчлөлтийг хийж байгаа шүү дээ. Энэ ажил авсан цагаасаа хойш ер нь томоохон бодлогын өөрчлөлтүүд хийгдэж байна.

Одоо энэ нэг эх үүсвэрийн худалдан авалт, эмийн чанартай, гаднын хатуу зохицуулалттай эмийн улсуудаас эхний ээлжийн эмүүд орж ирээд ард иргэд хүрээд үр дүнгээ өгөөд эхэлж байна.

Түрүүн бас Ж.Чинбүрэн гишүүн асууж байсан. Эмийн олон улсын стандартыг шаардлагыг хангасан лабораторийн төсөл маань 9 сараас хойш эхлээд одоо зураг төсөл нь бий болчихсон. Энэ тендерийн шалгаруулалт нь явагдаж байгаа. Энэ намар 11 сар гэхэд ер нь лаборатори маань ашиглалтад орохоор явж байгаа. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтраад энэ төслийг хийж хэрэгжүүлж байгаа.

Манай улс ер нь эмийнхээ чанар, аюулгүй байдлын үнэлгээг сайжруулах түвшний, суурь түвшний олон ажлуудыг хийхгүй бол бид зүгээр ганц нэг эмийн асуудлуудыг шийдээд энэ маань үр дүнд хүрэхгүй нь тодорхой байгаа юм.

Тэгэхээр суурь шинэчлэлийн ажлуудыг бид маш сайн хийж байгаа. Ирэх 2026 оны төгсгөл гэхэд манай улсад нийлүүлэгдэж байгаа бүх эм тарианууд чанартай, боломжийн хэмжээний, хямд үнэтэй байх энэ бодлогын ажлуудыг бүгдийг нь бид эхнээс нь цэгцлээд, хийгдээд үр дүнд хүрч байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан.

Л.Энх-Амгалан: Ж.Баясгалан гишүүн ээ, цөмөөрөө одоо бас нэг зүйлийг ойлгох ёстой. Бас гээндээ ч бий, гомдоо ч бий гэдэг шиг.

Яг энэ төрийн байгууллагууд энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэд авч ажиллуулах тийм огт хүсэлгүй байгаа асуудал биш юм билээ. Хамгийн гол нь бид Төрийн албаныхаа тухай хуульд өөрчлөлт оруулж, төрийн байгууллагад орж байгаа, яам, Тамгын газарт ажиллаж байгаа ажиллах улсууд дээрээ тавьж байгаа шаардлагуудыг яг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байдлаар жаахан хөнгөвчилсөн шалгууруудыг тавьж өгөхгүй бол бид одоогийн байгаа энэ төрийн албан хаагч нарын сонгон шалгаруулдаг энэ журмаар яам, Тамгын газруудад яг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бүгдийг нь энэ хуулийнхаа хүрээнд ажлын байртай болгочихно гэдэг энэ жаахан гэнэн төсөөлөл юм байна лээ шүү.

Үүнийг бид нэг тохируулга хийх зайлшгүй шаардлага бас үүссэн байгаа.

Манай Засгийн газрын мөрийн хөтөлбөрт яг энэ хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. Энэ хэрэгжилтийг хангаж ажиллана гэдэг том зорилт тусчихсан байгаа шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ хүрээндээ одоо цөмөөрөө хяналтаа тавиад явах бүрэн ийм боломжууд нь байгаа болов уу.

Х.Булгантуяа: Ж.Баясгалан гишүүн тодруулах уу? Нэмж. Ж.Баясгалан гишүүний микрофоныг өгье.

Ж.Баясгалан: Тэгэхээр Эрүүл мэндийн сайд ээ, энэ дээр төсөл, арга хэмжээ гэж би асуусан. Ямар төсөл, арга хэмжээ явсан юм бэ гэдгийг л асуусан. Эмийн чанар дээр.

Яг тэрийг танай яамнаас мэдээлчих хүн байна уу? Яг ямар төсөл явчихсан юм? Бид одоо ингээд хийгээд байна, хийгээд байна гэдэг. Гэтэл яг сонгогчид, ард иргэд тэрийг мэдрэхгүй байгаа шүү дээ.

Тэгэхээр юу хийчихсэн юм бэ гэдгээ яг тодорхой л хэлчихмээр байна. Би тодорхой хариулт авахыг хүссэн.

Л.Энх-Амгалан сайдтай санал нэг.

Тэгэхээр та тэр хууль зүйн зохицуулалт дээрээ манлайлаад. Одоо би ч гэсэн цуг явъя. Хоёулаа энэ дээр энэ ажилд орох боломжийг нь хангаж өгье. Тийм ээ. Төрийн албаны зүгээс ирсэн энэ дүнгээр бол ерөөсөө хоёрхон яам л шаардлага хангаад байна шүү дээ. Байгаль орчин.../минут дуусав/

Х.Булгантуяа: 1 минутаар хоёр удаа авах ёстой байгаа. Хугацааны хувьд болчихсон байх. Хоёр яам. Байгаль орчин, аялал жуучлалын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хоёр гайгүй байгаа байх. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын бариар хангаж байгаа асуудлаар. Тийм ээ. Тийм.

Ж.Баясгалан гишүүн энэ мэдээллүүдийг өгөх ёстой шүү. Энэ бол хуулийн хэрэгжилт юм гэдгийг хэлж байна.

Т.Мөнхсайхан сайд эмийн чанарын асуудал их сайн болсон гэж дүгнэж байгаа юм байна шүү дээ. Хэрэгжилт дээр. Т.Мөнхсайхан сайд. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан.

Т.Мөнхсайхан: Яах вэ, төсөл, арга хэмжээний биелэлт нь сайн явж байгаа л гэж дүгнэж байгаа.

Нэгдүгээрт, ер нь чанаргүй эм үнэтэй байгаагийн гол шалтгаан нь манай улс хүн ам цөөтэй, эмийн бизнест ер нь тоо ширхгээсээ их шалтгаалдаг. Ийм л дээ.

Тийм учраас бид нэг эх үүсвэрийн худалдан авалт буюу гаднын хатуу зохицуулалттай улсуудаас үйлдвэрүүдтэй шууд хэлцэл хийгээд чанартай эмийг хямд үнээр хангах энэ бодлого маань хийгдээд эхний 30 төрлийн эм, тариа нь орж ирээд ард, иргэдэд хүрчхээд байна.

Нэгдүгээрт, энэ төсөл маань сайн явж байна. Энэ үргэлжилж байна.

Хоёрдугаарт, бид эмийн чанарыг нь баталгаажуулдаг лабораторийн ажил маань зураг төсөл нь хийгдээд, барилгын ажил нь хийгдэх түвшинд явж байна. Энэ төсөл маань амжилттай үргэлжилж байна.

Гуравдугаарт, эмнэлгийн цахим, бүртгэл мэдээллийн систем маань амжилттай хийгдэж байна.

Монгол Улсад хил, гаалиар орж ирж байгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Т.Мөнхсайхан: Монгол Улсын гаалиар орж ирж байгаа бүх эм, тариа үнийн дүнтэйгээ, тоо ширхэгтэйгээ, бар кодтойгоо бүгдээрээ бүртгэгддэг болж байна.

Ингээд аль бөөний худалдааны төвөөр, аль эмийн сангаар дамжаад, хаана хэрэглэгчид очив оо. Монгол Улсын зах зээл дээр ямар эм, тариа ямар нөөцтэй байна гэдэг энэ бүх бүртгэл, мэдээлэл бий болж байна.

Мөн цахим эмийн жор маань нэг үеэ бодох юм бол нэлээн төлөвшиж байна.

Ингэснээрээ эргээд бид эмийн зохисгүй, замбараагүй хэрэглээг цэгцлэх ажил маань амжилттай үргэлжлээд явж байна. Гэх мэтчилэн эмийн зохицуулалт хийх, чанартай эмийг хямд үнээр аюулгүй хангах бодлого манай улсын түвшинд өнгөрсөн хугацаанд хийж төлөвлөсөн түвшиндээ хүрэхүйц хэмжээнд явж байна.

Гэхдээ энэ маань болчихлоо гэсэн үг биш. Цаашдаа үргэлжлүүлээд маш их хийх ажил бид нарт байна.

Д.Амарбаясгалан: Э.Одбаяр сайд хариулт өгье.

Э.Одбаяр: Ж.Баясгалан гишүүний асуултад нэмж хариулъя.

Эмийн чанарын тухай асуудлыг асуусан. Тэгээд эмийн чанар, орц найрлагын тухайд дэлхийн стандарт нь байх ёстой, эмийн нөгөө бүрдүүлэгч орцууд нь ямар байгаа билээ гэдэг дээр дүгнэлт хийгээд энэ дээр Эрүүл мэндийн яам тодорхой хэмжээнд би ажиллаж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгээд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын зүгээс ч гэсэн энэ асуудал руу нэлээн ороод.

Гол асуудал нь бид тэр стандарттай байгаа юм билээ. Ямар эмийн орц найрлага нь хэд байх ёстой вэ гэдэг. Тэгээд түүн дээрээ нөгөө нийлүүлэгч гэдэг системийн хувьд засаж сайжруулах ёстой зүйл байвал анхаараад явчихъя гэдэг дээр ажиллаад явж байгаа гэдгээ хэлэх нь зөв байх.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байраар хангах тухай асуудал дээр. 25 орон тоо тутамд 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах ёстой. Үгүй бол яах вэ гэхээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийг дэмжих тухай санд тэр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр хураамж төлөх ёстой. Төлбөр төлөх ёстой. Тэгээд энэ ажил маань.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Салдангийн Одонтуяа сайд нэмж хариулъя.

С.Одонтуяа: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах асуудал дээр манай яам 100 хувийн биелэлттэй байгаа.

Салбарын хэмжээнд нийт 81 хүн байдаг. Хөдөө орон нутагт боловсон хүчний хомсдолоос болоод зарим газар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажлын байраар хангах жоохон бага байдаг. Яагаад гэхээр нарийн мэргэжил заачихдаг.

Нийт байгууллагын хувьд гэвэл түрүүн гишүүн асууж байсан. Манайх нийт салбарынхаа гүйцэтгэлийг олон улсын индексээрээ ерөнхийдөө үнэлээд явдаг.

Тэгэхээр нийтдээ манайх 180 орноос одоогоор 143 дугаарт эрэмбэлэгдчихсэн. 48 хувь буюу эрчимжүүлэх шаардлагатай гэсэн дээр байдаг.

Энэ дээр хамгийн гол зөрчил нь юу байна гэхээр агаарын бохирдол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье. Гүйцээж хариулъя.

С.Одонтуяа: Болчихсон.

Д.Амарбаясгалан: Болчхож. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууж, үг хэлье.

М.Нарантуяа-Нара: Сайн байцгаана уу?

Монгол Улсыг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэлд 9 зорилтын гуравдугаарт байгаа “дундаж давхаргыг дэмжих” гэсэн асуудал байгаа.

Гэхдээ дундаж давхаргыг ямар бодлогоор, хэрхэн яаж, ямар төсөл хөтөлбөрөөр, нийт хэдэн төгрөгийн зардлаар, ямар түвшинд хүртэл нь дэмжсэн юм бэ гэдэг асуултыг асуумаар байгаа юм.

Тэгэхээр дундаж давхаргыг дэмжихдээ татварын. Одоо яг энэ бизнес эрхлэгч, хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд бизнес болон үйлдвэрлэл эрхлэгч энэ хүмүүсийг татварын хөнгөлөлт эдлэх, татварын ямар нэгэн ээлтэй, таатай орчинд ажиллах нөхцөлөөр хангаж чадсан юм уу?

Энд хэрэгжилт нь 9 хувь, хэрэгжээгүй 18 хувь гэчихсэн байгаа нь үүнийг яаж үнэлээд ингэж гаргасан байгаа юм бэ?

Тэгээд миний бодлоор “дундаж давхаргыг дэмжих” бодлого яг үнэндээ огт явагдаагүй юм шиг санагдаж байгаа. Явагдсан байдлаасаа жижиг, дунд бизнес эрхлэгчид захаасаа уйлаад. Тийм ээ. Цаашид энэ ажил, бизнесийг эрхлэх боломж алга. Нэг, хоёр хүнд ч болов цалин орлого залгуулаад ажил олгогч байгаад явах ийм боломж алга байна гээд энэ татварын дарамтад сөхөрсөн иргэд захаасаа энэ улс орноо хаяад гадаад улсад хар ажил ч болох нь ээ хийгээд явъя гэдэг ийм нөхцөл байдалтай байгаа.

Ийм нөхцөл байдалтай байж байхад дээрээс нь манай Монгол Ардын намын зарим нэгэн гишүүд нөгөө халамжийн бодлого, хамгааллын бодлого энэ тэрийг илүү түлхүү бариад явж байгаа нь хэр үндэслэлтэй байгаа юм болоо.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдаас сайдаас би анхдугаар чуулганаас авхуулаад “Цалинтай ээж” хөтөлбөрийг доор хаяж

цалингийн доод түвшинд хүртэл нэмэгдүүлэх боломжийг нь тухай маш олон удаа дараалан асуулга, асуулт, хариултын байдалтай байж боломжгүй гэдэг ийм хариултыг авсан.

Гэтэл одоо танай намын гишүүн 500 мянга болгох боломжтой гээд яриад явж байна л даа.

500 мянган төгрөг болгох боломжтой бол сайн л биз. Гэхдээ нэгхэн жилийн дотор 10 дахин нэмэгдүүлсэн энэ зүйлээс болж нөгөө бага орлоготой иргэд болон бусад цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж нь 10 дахин нэмэгдээгүй энэ хүмүүсийн амьдрах амьдрал, орлого, эдийн засагт ямар нэгэн таагүй үр дагавар үүсэх эрсдэл байгаа юу? Тэрийг Сангийн сайд хариулаад өгөөрэй.

Бүхэл бүтэн одоо нэг хэсгийнх нь орлого, тэтгэмж, халамж, хамгаалал ч байдаг юм уу. Энэ нь 10 дахин нэмэгдлээ гэхэд нөгөө талд ялангуяа тэтгэвэр нь нэмэгдээгүй ахмадууд, цалин хөлс нь нэмэгдээгүй багш, эмч бид нар, тэгээд бусад бага орлоготой өрх, бусад хөдөлмөр эрхлэгчид чинь энэ 10 дахин нэмэгдсэн үнийн өсөлтөөс болж хөөрөгдөх, үнийн инфляц, эдийн засгийн таагүй байдалд өртөх магадлал байгаа юу гэдгийг би асууя асуумаар байна.

Тэгээд дээрээс нь халамжаас хөдөлмөр лүү гээд бодлого яригдаад байгаа. Тэгээд энэ бодлого яг хэзээнээс эхлэх юм бэ? Одоо ингээд өмнөх өмнөх парламент шиг сонгуулиас сонгуулийн хооронд ингээд л нэг гоё мөнгөн дүн яриад л, энэ бол боломжтой гээд л иргэдийг хий дэмий төөрөгдүүлээд л. Ийм байдал чинь зөв ч юм уу, үгүй ч юм уу.

Тэгээд хамгийн гол нь яг одоо энэ дундаж давхаргыг дэмжих ямар бодлого байгаад энэ хүмүүсийг ямар таатай нөхцөлөөр дэмжсэн юм бэ? Энд хэчнээн төгрөг зарцуулаад ямар үр дүнд хүрчихсэн байгаа юм бэ гэдгийг нь хэлээд өгнө үү гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Л.Энх-Амгалан сайд хариулт өгье.

Л.Энх-Амгалан: М.Нарантуяа-Нара гишүүн ээ,

Одоо бид өнгөрсөн хугацаанд нийгмийн халамжийн тогтолцоонд ер нь яг юу болоод өнгөрөв. Хэдэн төгрөг зарчхав. Одоо яг нийгмийн халамжид өнөөдөр улсын төсвөөс зарж байгаа мөнгө маань даруй 2.4 их наядад хүрч байна. Энэ бол улсын төсвийн нийт зарлагын бараг үндсэндээ 10 хувь билүү дөхөж байгаа маш том дүн шүү дээ. Тийм ээ. 10 хувиас ч илүү болж байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа хувь маань бараг 4, 5 хувь руу хүрчхэж байна.

Тэгэхээр бид энэ тоог их зөв үнэлэлт дүгнэлт, анализ хийж байж халамжаас хөдөлмөр лүү шилжих бодлогыг ямар бодлого байх вэ гэдгийг их зөв тооцоолох ёстой. Бодлого их зөв байх ёстой гэж харж байгаа.

Тэр хүрээндээ өнгөрсөн хугацаанд одоо энэ халамжид зарсан бүх төсөл, хөтөлбөрүүд дээр бид анализ хийсэн. Тэгээд яах вэ, бусад энэ дэлхийн улс орнуудтай харьцуулахад бид орлогын түвшнээс нь уялдуулаагүй дандаа хавтгайруулж халамжийн бодлого зарласан нэг ийм зовлон бас байгаа.

Хоёр дахь асуудал бол энэ 2.4 их наядыг бид халамжид зарж байна гэж яриад байгаа мөртлөө энэ 2.4 их наядыг чинь бараг үндсэндээ 1.6 их наяд нь хүүхдийн мөнгө байхгүй юу. Хүүхдийн мөнгө.

Тэгэхээр цаанаа ер нь яг энэ халамж буюу халамж хүртэх ёстой зорилтот бүлэгт зарж байгаа мөнгө 600-аас 700 орчим тэрбум төгрөг юм билээ. Гэхдээ бид үүнийг ч гэсэн бас тодорхой яг тэр зорилтот бүлэгтээ энэ мөнгө маань зарцуулагдаж чадаж байна уу, үгүй юу гэдгийг бид анализ хийх цаг нь болсон.

Одоо бид энэ хаврын чуулганд бид Халамжийн тухай хуулиа өргөн барих гэж байна. Халамжийн тухай хуультайгаа уялдуулж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Гэр бүлийг дэмжих тухай хууль, нийгмийн даатгалынхаа багц хуулиудыг ингэж цогцоор нь өргөн барихаар орж ирж байгаа.

Энэ хүрээндээ цөмөөрөө цаашдаа Монгол Улсад халамж байвал ямархуу хэмжээний халамж байх ёстой юм. Юуг бид ер нь халамж гэж үзэх юм. Хэнийг халамжлах юм.

Ер нь бусад улс орнуудад зарладаг халамжийн хөтөлбөр бол дандаа хугацаатай байдаг юм билээ. Хэзээ эхлээд, хэдэн хүнийг хамруулаад, ямар үр дүн гарах вэ гээд. Тэрийгээ дүгнэж байж дараагийнх нь хоёр дахь, гурав дахь шатынх нь төслүүд явдаг. Манайх шиг нэг эхэлчхээд л хэзээ ч дуусдаггүй халамжийн хөтөлбөртэй улс орон их ховор юм билээ гэдгийг би онцолж хэлье гэж бодож байна.

Нөгөө талаас би тантай санал нэг байна. Энэ “дундаж давхарга” гэдэг асуудал Монгол Улсад хамгийн чухал.

Тэгэхээр “дундаж давхарга”.

➤ Өнөөдөр Монгол Улсад нийт хүн амын хэдэн хувьд нь байна вэ. Яг тэд нар өнөөдөр дундаж давхаргад орж чадсан уу.

➤ Өнөөдөр авч байгаа цалин хөлсөөрөө ипотекийнхоо зээлийн эргэн төлөлтийг хийж чадаж байна уу.

- Авч байгаа машиныхаа лизинг төлж чадаж байна уу.
- Үр хүүхдүүд нь төлбөртэй сургууль, цэцэрлэгт сурч байгаа тэрийг төлж чадаж байна уу.
- Цаана нь жижигхэн хуримтлал болж чадаж байна уу гэдэг зүйлүүдийг бид их сайн хэмжиж байж Монгол Улсын.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье.

Л.Энх-Амгалан: Ийм учраас бид Үндэсний статистикийн газартай хамтарч ер нь Монгол Улс цаашдаа ядуурлын түвшинг зарлах, ядуурлын доод түвшин, мөн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн асуудлууд, тэгээд цаашдаа бид нийгмийн дундаж давхаргуудын үзүүлэлтүүдийг зарлах тооцоо судалгаануудыг үндэсний эх өгөгдлийн платформд суурилж энэ бодлогуудыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна гэдгийг хэлье.

Тэгээд тусдаа “Цалинтай ээж” дээр тайлбар хэлэхэд нэлээн урт хугацаа хэрэгтэй.

Тэгэхээр хэн нэгэн одоо юу гэдэг юм, Их Хурлын 126 гишүүд маань уралдаад халамжийн хөтөлбөрүүдтэй уялдсан хуулиудыг санаачлаад байж болохгүй. Үнэхээр бид тогтолцооны шинэчлэл хийх гэж байгаа бол энэ шинэчлэлээ хийсэн шиг хийж, тооцоотой, судалгаатай өмнө гарсан алдаагаа давтахгүй байх ийм л бодлогын шинэчлэл хийх ёстой.

Та бүхэн ч гэсэн Байнгын хороон дээр олон хувилбар танилцуулсан. Бид нартай санал нэг байгаа байх гэж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: М.Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя.

Юуны өмнө огт тэтгэвэр нь нэмэгдээгүй ахмад гэж байхгүй байгаа гэж би хэлье. Огт цалин нэмэгдээгүй эмч, огт цалин нэмэгдээгүй багш гэж байхгүй шүү. Тодорхой хэмжээнд их бага хэмжээгээр бүгд нэмэгдсэн байгаа.

Инфляц нэлээн хөдөллөө. Дотоодоос шалтгаалж байгаа зүйл ч байна, гаднаас шалтгаалж байгаа зүйлүүд ч байна. Үүнийг гүйцэх гэж байна гээд нөгөө цалин мөнгө, тэтгэврээ нэмчхээр хоёр зүйл байна. Төсөв нь ч дийлэхгүй. Нөгөө талаар инфляцаа ч бид бүр дийлэхгүй болно. Тийм.

Тэгэхээр энэ дээр маш судалгаатай, тогтвортой хэмжээнд эдийн засгийнхаа орцуудыг нь тааруулж явах нь их чухал. Ийм учраас ирэх оны төсөв

оруулж ирэх үед мөнгөний бодлоготойгоо уялдуулаад эдгээр асуудлууд дээр маш тодорхой өсөлт, бууралт ямар байх нь вэ яригдана гэж үзэж байна.

Хоёрдугаарт, өнөөдөр олон гишүүд энэ дундаж давхаргын асуудлаар ярилаа.

Л.Энх-Амгалан сайдын хариулж байгаа дээр нэмэлт мэдээлэл өгөхөд.

Улс орон болгон л өөрсдийнхөө эдийн засгийн онцлог бүтцээс шалтгаалж дундаж давхаргаа томьёолдог.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье.

Б.Жавхлан: Тэгээд ерөнхий суурь ойлголт өрхийн түвшинд ипотекеэ төлчихдөг, машиныхаа лизинг төлчихдөг, хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлчихдөг, тэгээд тодорхой хэмжээний хуримтлалтай. Их бага хэмжээгээр.

Үүнийг манай хувьд “дундаж давхарга” гэж үздэг. Ингээд OECD-ийн орнуудын тэр томьёоллоор бид судалгаа хийгээд үзэхэд одоо манай байгаа өрхийн түвшинд 1 сая 600-аас эхэлж байгаа. 1 сая 600 мянган төгрөгөөс эхэлж байгаа.

Тэгэхээр ямар ч байсан манай дундаж сэхээтнүүдийн түвшинд, дундаж давхаргад орох тооцоо судалгаанууд байдаг. Гэхдээ бүрэн хамрагдаж чадаж байна уу, үгүй юу гэдгийг их сайн судалж, яг тодорхой чиглэсэн бодлогуудаа оновчтой болгох нь зүйтэй.

Зүгээр эцэст нь хэлэхэд төсөв болон бусад эх үүсвэрүүдээс санхүүжигдэж байгаа хөтөлбөрүүд, ялангуяа үндэсний хэмжээний, хоршооны хөтөлбөр, “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал”.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: М.Нарантуяа-Нара гишүүн тодруулж асууя.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр баярлалаа сайд нарт.

Ер нь нийгэмд үүсээд байгаа асуудал ялангуяа “Цалинтай ээж”-ийн нэг гишүүний боломжтой гэж хэлсэн зүйлээс болоод маш олон иргэдийн дунд талцал, төөрөгдөл, маш олон асуудлуудад хөвөрч байгаа л даа.

Тэгэхээр би өнгөрсөн хугацаанд төр засаг, парламент тийм ээ, ялангуяа Улсын Их Хурлын гишүүд сонгуулиас сонгуулийн хооронд иргэдийн асуудал бэрхшээл дээр дөрөөлж сайхан үг ярьж тийм ээ, ингээд нэг бага багаар дусаасан, эсвэл худлаа мөнгөн дүн амлаж, худлаа хайрлаж, өрөвдөж, хүмүүсийн амьдрах чадварыг алдаж ирсэн зүйлтэй энэ парламент илүү сайн тэмцээсэй.

Яг үнэнийг хэлэхэд Монголд хөдөлмөрийн чадамжтай хүмүүс ажилгүйчүүдийн эгнээг нэмээд байгаа нь үнэхээр эмгэнэлтэй байхгүй юу.

Тийм учраас яг энэ боломжтой, үгүй юм уу гэдэг энэ зүйлийг би сонсьё гэж асуулт асуусан юм. Түүнээс биш цалин хөлс их бага хэмжээгээр нэмэгдээд байгааг бол би бас мэднэ.

Д.Амарбаясгалан: Л.Энх-Амгалан сайд нэмж хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр “Цалинтай ээж” гэдэг угаасаа хөтөлбөрийн нэр нь жаахан зохицоогүй, энэ тэтгэмжтэйгээ зохицоогүй нэр учраас л өнөөдөр ийм асуудал үүсээд байгаа юм л даа. Үл ойлголцол.

Тэгээд цалин гэдэг бол тийм ойлголт байгаа бол мэдээж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ яригдах нь зөв.

Гэхдээ өнөөдөр “Цалинтай ээж” гэдэг хөтөлбөр чинь ерөнхийдөө нэг эргэж харахгүй бол яг энэ 3 жилийн хугацаанд 36 сарын хугацаанд сар бүхэн 50 мянган төгрөг өгөөд, тэрийг бид “Цалинтай ээж” гэдэг хөтөлбөр хэрэгжүүлж байгаа юм гээд суугаад байж байсан болохгүй.

Тэгэхээр бид халамжийн бодлогын шинэчлэлийн хүрээнд бид ерөөсөө яг энэ хүн амаа өсгөх бодлого. Тийм ээ. Гэр бүлийг дэмжих бодлого одоо яг юу байх вэ. Тэр бодлогын хүрээнд бид ямар хөтөлбөрүүд хэрэгжүүлэх вэ. Энэ “Цалинтай ээж” гэдэг хөтөлбөрийг бид яаж өрхийн орлогод нь нийцсэн хэлбэрээр яаж зөв зохицуулалтууд хийх юм. Тийм ээ. “Алдарт эх”-ийн одонгийн асуудлууд, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн асуудлууд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Загджавын Мэндсайхан гишүүн асуулт асууж, үг хэлье.

З.Мэндсайхан: Гишүүдээ энэ өдрийн мэнд хүргэе.

2021-2025 онд Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэл дээр “Ногоон хөгжил” бодлогын хүрээнд “нийт хүн амын 85-аас доошгүй хувийг шаардлага хангасан үндны эх үүсвэрээр хангана.” гэж тусгасан байгаа.

Тэгээд ирсэн тайлангаар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын үнэлгээгээр энэ ажил 50 хувийн хэрэгжилттэй байна. Тамгын газрын үнэлгээгээр 30 хувь гэсэн байна л даа. Тэгэхээр ерөөсөө тайлагналт хангалтгүй байна гэж байгаа юм.

Тэгэхээр С.Одонтуяа сайдаас асуух гээд байгаа нь, ер нь энэ тайлан ирүүлэхгүй байгаа нь ямар учиртай юм бэ?

Хүн амын шаардлага хангасан ундны эх үүсвэрээр хангах асуудал хамгийн нэн тэргүүний асуудал. Ялангуяа манай Говь-Алтай аймгийн урд талын сумд, манай Ховд аймгийн Дөргөн сум гэхэд Хар ус нуурын усыг цэвэршүүлж ууж байна. Энэ ундны усны шаардлага хангахгүй байгаа бол иргэдийн эрүүл мэнд, цаашлаад насжилттай шууд холбоотой. Өвчлөлтэй.

Тэгэхээр энэ ажил яагаад хангалттай хэрэгжихгүй байна аа? Энэ дээр ямар бодлого баримталж байна аа?

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.32-т “хөдөө аж ахуйн салбарын хүний нөөц, залуу малчид, тариаланчдыг бэлтгэх, зохистой бодлого хэрэгжүүлнэ.” гэж заасан байгаа.

Тэгэхээр Хөдөө аж ахуйн яам энэ чиглэлд ямар бодлого гаргаж хэрэгжүүлж байна аа? Тойрогт ажиллаж байхад малчдын маань хамгийн том асуудал малчдын залуу халаа асуудал. Тариаланчдын маань. Энд орон нутаг руу чиглэсэн тэр залуучуудыг бүс нутагтаа мал маллаж, эдийн засгийн өгөөжөө хүртэж амьдрах тэр боломжийг бүрдүүлэх бодлого дутагдалтай байгаагаас хамаараад залуучууд маань төв суурин руу орж байна.

- Мал маллах хүнгүй болж байна.
- Гэр бүл төлөвлөлт, орон нутаг эзгүйрч байна.

Ховд аймгийн Дөргөн сум дээр ажиллаж байхад Аргалант баг дээр 47 залуу эхнэр аваагүй гээд багийн дарга нь яриад сууж байна лээ л дээ. Тэр нэг талаасаа инээдэм шиг боловч энэ бас том асуудал болж байна шүү. Бүс нутагт. Энэ дээр хөдөө аж ахуйн салбар малчдыг бэлтгэх тал дээр, энэ орон нутагт ажил хөдөлмөрөө эрхлэх тал дээр нь ямар бодлого баримталж байна аа?

Одоо малчдын ганц орлого олдог үе буюу ноолуурын үе. Зүүн талын аймгуудаас эхлээд ноолуур үнэтэй гараад, баруун аймгууд руу маш бага үнэтэй болчихдог.

Тэгэхээр “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд энэ жил хөнгөн үйлдвэрүүдийг дэмжих ноолуурын бодлого гээд нэлээн асуудлууд Их Хурлаар батлагдсан. Боломжит хөтөлбөрүүдийн төсөв. Энэ ажлууд ямархуу явж байна?

Одоо ингээд хаврын тариалалт эхлэх гэж байна. Өнгөрсөн жил бид гурилын татвараа буулгаснаас болоод газар тариалангийн буюу улаан буудайн тариалалт 20 хувиар буурсан. Энэ жил энэ асуудлаа ямархуу байдлаар шийдэх гэж байна. Бас тодорхойгүй байж байгаад тариалалтад ордог. Бид энэ эрсдэлтэй цаг үед улаан буудайн үйлдвэрлэлээ нураах асуудал руу орох вий дээ. Энэ дээр салбарын яам ямар бодлого баримталж байна гэдгийг асуучихъя гэж бодож байна.

Ц.Туваан сайд байхгүй байна. Сая хоёр долоо хоногийн өмнө Ховд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Улаанбаатар хотод ирсэн.

Миний бие уулзсан. Нийтдээ 30 гаруй хүнтэй уулзсан. Иргэдийн ярьж байгаа асуудал өнгөрсөн намрын тэр Ховд аймагт үүссэн “Халзанбүргэдэй” ордын талаарх иргэд, аж ахуйн нэгжийн хоорондын тэмцлийн асуудлаас болоод ойлгомжгүй байдлыг цэгцлэх тал дээр аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан юм билээ. Энэ ажлын хэсэгтэй уулзсан.

Тэгээд тэр ажлын хэсэг төр засгийн байгууллагаас ер нь газрын ховрын талаар баримталж байгаа төрийн бодлогыг тодруулах чиглэлээр ирж уулзсан. Харамсалтай нь яамдаас хүлээж авч уулзаагүй байна лээ. Энэ ажлын хэсэгтэй.

Тэгээд тавьж байгаа хүсэлт бол Ц.Туваан сайд аа. Төр нэгэнт тэр тусгай зөвшөөрлийг нь олгосон учраас Та Ховд аймагт очиж ажиллаач ээ. Иргэдэд газрын ховор элементийн талаар нэгдсэн төрөөс барьж байгаа бодлогын талаар та мэдээлэл хийгээч ээ гэж хүсэх байна. Иргэдтэй газар дээр нь очиж танилцаач ээ.

Тэгэхгүй бол зөвшөөрөл өгсөн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 3.Мэндсайхан гишүүнд нэг минут нэмж өгье.

3.Мэндсайхан: Зөвшөөрөл өгсөн төрийн байгууллага нь хойш сууж үлдээд иргэд, аж ахуйн нэгжийн хооронд асуудал үүсээд, тэнд бүс нутгийнхаа экологийн асуудалд санаа зовсон иргэд гаднын гар хөл гээд нийгэмд адлагдаад явж байна.

Үүний ойлголтыг Та цэгцлэх талд нь анхаарч өгөөч ээ гэдэг хүсэлт байна.

П.Наранбаяр сайдад хандаж хэлэхэд П.Наранбаяр сайд аа, 2024 оны 9 сарын 09-нд гарсан таны тушаал байна.

Би энэ хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийнх нь талаар маргалдах зүйл алга. Таны тайлбарыг би харсан. Би хууль зөрчөөгүй гээд сууж байна лээ. Засгийн газрын гишүүн гэдэг бол хууль хэлбэрэлтгүй сахих ёстой.

Та сонгон шалгаруулалтгүйгээр 1.2 тэрбум төгрөгийг өөрийн ашиг сонирхол бүхий нөхдөд өгсөн байна. Энэ бол хоёрдугаар асуудал.

Гол нь та Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдсан байна. Төсөв батлагдаагүй байж байх төсвийн захиран зарцуулах эрхийг тушаал гаргаад шийдэж байдаг ийм байдал байж болохгүй.

Таныг энэ тушаалаа цуцалж, хуульд нийцүүл гэдгийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайд хариулах уу? “Цагаан алт” хөтөлбөрийн талаар. Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Салбарын боловсон хүчний талаар П.Наранбаяр сайд бэлдэж байгаарай. Би ноолуур дээр мэдээлэл өгье.

Малчид маань хоёр гол “ноолуур” болон “мах” гэдэг дээр гол орлого нь, амьжиргаа нь явагдаж байна. Ноолуурын дэлхийн зах зээлийн байдал өнөөдөр хамгийн гол худалдан авалт хийгддэг, самнасан ноолуур авдаг Европын зах зээл дээр 1 килограмм самнасан ноолуур 97 доллар буюу Монгол төгрөгөөр шилжүүлэхэд 340 орчим мянган төгрөг дээр яг байна.

Ер нь ноолуурын салбарын хөгжлийн хандлага өөдрөг байгаа. Нийт ноолуур, ноос өөрөө нийт энэ TEXTILE буюу энэ салбарын нийт орцын 1.3-аас 1.6 хувь орчим байгаа болов уу буюу энэ өөрөө маш хязгаарлагдмал нөөц байгаа.

Тэгэхээр Монгол Улс ноолуур, ноосон дээрээ нэлээн том зорилго тавьж ажиллах бололцоотой байгаа.

Ингээд 97 доллар буюу 340 мянган төгрөгөөр тооцоо хийгээд үзэхээр 1 килограмм түүхий ноолуур 150-аас 155 мянган төгрөгийн ханшны төсөөлөл бий болж байна.

Сая хаврын түймэр, саяын шамарга, цаг уурын өөрчлөлтийн дараа үндсэндээ тогтвортой сайхан дулаан ийм өдрүүд эхлэх нь. Ноолуур бэлтгэл ид өрнөнө. Бэлтгэл ажлаа хангах хүрээнд “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд бид ноолуурын салбарт 230 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, эргэлтийн эх үүсвэрийг шийдэж өгсөн. Ингээд үйлдвэрүүд энэ долоо хоногоос зүүн бүсээс эхэлсэн ноолуур худалдан авалт, зохион байгуулалт явах нь гэж ойлгоорой.

Нөгөө талаас дэлхийн дайн, эдийн засаг, геополитикийн асуудлаас болоод олон улс хоорондох худалдааны зохицуулалт нэлээн хүндрээд байгаа шүү. Харьцангуй ноолуурын зах зээл боломжийн тогтвортой байгаа.

Та бүхэн нүүрсэн дээр гэхэд ямар хүчтэй савлагаа үүсэж байгааг харж байгаа бол ноолуур 150 мянгаас доошоо буухгүйгээр түүхий ноолуурын борлуулалт улсын хэмжээнд явагдах бололцоотой байна.

Бид өмнө нь түүхий ноолуур гаргадаг байсан. Дараа нь 100 хувь угаадаг болсон. Одоо 100 хувь самнадаг болно. Ингэснээр Монгол Улсад дотоодын үйлдвэрлэлд ажлын байр бий болох, 250-аас доошгүй сая долларын нэмүү өртөг Монгол Улсад үлддэг болох түвшинд гарна. Аль болгон бусдаас хамааралтай байх вэ. Дотоодынхоо үйлдвэрлэлийг сэргээх бодлогын хүрээнд “Цагаан алт” хөтөлбөр хэрэгжиж байгаа.

Улаан буудайн тухайд. 776 мянган тонн улаан буудай импортоор орж ирсэн. 64 мянган тонн гурил орж ирсэн. 100 хувь дотоодоосоо хангалт хийж байсан энэ салбарт одоо 60 хувь руу уналт хийсэн. Энэ нь бол тухайн үеийн өвөлжилтийн байдал, цаг уурын бэрхшээлийг даван туулах үүднээс Их Хурал зохицуулалт хийж гурил, улаан буудайн албан дотор тэглэсэн.

Энэ бодлого үр дүнд хүрсэн тул одоо энэ хэлэлцэх асуудлыг Их Хуралд өргөн барьсан байгаа. Тэгээд яаралтай хэлэлцэж энэ асуудлыг шийдвэр гаргаж өгөхийг бид хүлээж байгаа.

Д.Амарбаясгалан: П.Наранбаяр сайд хариулт өгье.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ асуудал дээр би ярья.

Нэгдүгээрт, таны хэлсэнчлэн малаа маллаж яваа, ялангуяа залуу гэр бүлийн асуудал дээр сургуулийн асуудал, хүүхдийн сургуулийн асуудлаас болж малчин айл 6 насанд нь сургуульд ороход хоёр талдаа амьдрах гээд хүндрэлтэй талууд байгаа.

Боловсролын яамнаас багийн бага сургуулийг сэргээж ажиллуулах, багийн бага сургуулийг малчинд нь ойр сургуулиудыг дэмжиж ажиллуулах ийм чиглэлээр ажил хийж байгаа.

Хүний нөөцийн асуулт. Түрүүн би хариулсан учраас зарим нэг юмных нь үнэхээрийн бэлчээр хамгаалал, нөхөн сэргээлт гэхэд л ердөө энэ жил гэхэд 7 хүүхэд сурч байх жишээтэй. Ийм л байгаа.

Тэгэхээр малчныг дэмжих тухай хуулиараа малчин нэг хүүхдийг 10-аас дээш жил тасралтгүй мал малласан хүүхдүүдийг төрийн өмчийн дээд сургуульд суралцуулах тухай хууль байгаа. Үнэ төлбөргүй.

Энэ хуулийн хэрэгжилтээр бид яг энэ бэлчээр хамгаалал нөхөн сэргээх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье. Гүйцээж хариулъя.

П.Наранбаяр: Уучлаарай. Нөхөн сэргээлтийн чиглэлээр суралцуулахаар 2025 оны 9 сараас эхлээд энэ ажлыг хэрэгжүүлж эхэлнэ. Хууль өөрөө 2025 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн хууль байгаа.

Тэр 120 сургууль дээр хэрэгжүүлж байгаа төслийн тухайд боловсролын салбарт өмнөх сайдуудын үед ч гэсэн сургуулиудын менежментийг сайжруулах чиглэлээр тодорхой төслүүд хэрэгжүүлж ирсэн байдаг. Үүний үргэлжлэл болоод явж байгаа төсөл. Тэр нь сургуулиудынхаа хөгжилд зориулж, сургуулиудад нь

мөнгө нь хуваарилагдаад тэндээсээ явж байгаа. Ямар нэгэн төсвийг шилжүүлж хууль зөрчсөн зүйл байхгүй.

Зүгээр ирэх жилийн төсөвт тусгах чиглэл өгч хамтран ажиллах, арга хэмжээ авах, төсөвт суулгах арга хэмжээ авч ажиллах чиглэлийг Төрийн нарийн бичиг тушаалаар буюу бүрэн эрхийнхээ хүрээнд өгсөн юм бий. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ц.Туваан сайд.

Ц.Туваа: Асуултад хариулъя.

Сүүлийн үед дэлхийд ерөөсөө энэ CRITICAL MINERAL буюу чухал ашигт малтмал, газрын ховор элементийн асуудал уул уурхайн салбарын хамгийн чухал асуудал болчихоод байна.

10 асуудал байна гэж бодоход бараг 6, 7 нь энэ газрын ховрын CRITICAL MINERAL-ын асуудлыг л ярьж байгаа. Үзэсгэлэн, яармагууд дээр ч тийм байна.

Дэлхий дээр явж байгаа дайн тулааны асуудал ч гэсэн энэ дээр л явагдаж байна. Бид хараад эхэлсэн. Тийм ээ. Украйнд ямар юм болж байна.

Тэгэхээр бид бүхэн энэ талынхаа асуудлыг нэлээн тодорхой болгохоор хуульдаа оруулж, жагсаалтаа батлах, бодлогоо гаргах гээд асуудлуудаа бол ярьж байгаа. Яам дээр зөвлөхтэй, хэлтэстэй, агентлаг дээр хэлтэстэй, төрийн өмчит компани дээр “ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛ” гээд компани байгуулаад ажиллаж байгаа.

Тэгэхээр бид бүхэн дэлхийн чиг хандлага болж байгаа энэ асуудал руу ойрын 3 жилийн хугацаанд бодлого гаргаж орохгүй бол эндээс хоцорно. Дараа нь яаж ч нэмэр хийгээд нэмэргүй болно.

Тэгэхээр энэ их чухал асуудал байгаа юм. Тэгээд энэ дээр сая.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж минут өгье.

Ц.Туваан: Сая “Халзан бүргэдэй” төсөлтэй холбоотой асуудлаар Ховд аймгийн байгуулсан ажлын хэсгийнхэн, тэндэх нутгийн иргэдтэй цуг хүрч ирж ажилласан.

Энэ үед манай яамны төлөөлөл Ашигт малтмал, газрын тосны агентлаг дээрээ хүлээж авч уулзаж бүх асуултад нь хариулт өгч, тавьж байгаа саналуудыг нь сонссон.

Мөн үргэлжлүүлэн манай яамны салбарын хяналтын газар дээр дутуу тавьж үлдээсэн асуудлуудад нь хариу өгөх ажил явагдаж байгаа. Тэгэхээр

тойргоос сонгогдсон гишүүдэд нь давхар энэ хариултуудыг нь бид хэд хүргүүлъя.

Тэгээд ер нь бид бүхэн энэ газрын ховор элементийн төд болон критиклийн дайн явж байгаа энэ цаг үед гарын арван хуруунд багтахар төсөл байгаа. Түүний хамгийн урд талд нь хууль номынхоо дагуу явж байгаа “Халзан бүргэдэй” төсөл гэсэн төслүүд рүүгээ ингэж хандаад байвал бид бүхэн гацсан төслүүдийнхээ араас оруулчих эрсдэл байгаа.

Д.Амарбаясгалан: С.Одонтуяа сайд.

С.Одонтуяа: 1 минут уу? Тийм ээ. З.Мэндсайхан гишүүний асуултад хариулъя.

2024 онд сайдын тушаалаар бид нийт 8 сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байгаа. Одоо бид Ховд, Завхан, Дорнод аймгийн хамарсан Хар нуур, Ховд, Үенч, Бодон, Хяргас нуур, Завхан сав газрын усны менежментийн нэгдсэн төлөвлөгөөг батлуулахаар одоо яг ажиллаж байгаа.

Энэ жил гол төсөв бол говийн бүсийн 44 суманд бид иргэдийн ундны усны чанарыг тодорхойлох ажил энэ жил хийгдэнэ.

Гол нь усны хайгуул дээр улсын төсөв сайн тавигддаггүй болохоор манай нийт хэмжээ өсдөггүй. Тэгэхдээ бид ямар ч байсан гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдсэн газар нутгийн хэмжээг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: С.Одонтуяа сайд гүйцээж хариулъя.

С.Одонтуяа: Тэгээд нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн төв, 71 сумын төвийн нийт 101 хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлууд хийгдэж байгаа.

Тийм учраас саяын миний хэлсэн зүйлүүд хийгдээд явж байна гэсэн үг.

Ер нь хүн амыг ундны эх үүсвэрээр хангах нь чиг үүргийнхээ хувьд Барилга, хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны чиг үүрэгт бас орж байгаа.

Д.Амарбаясгалан: З.Мэндсайхан гишүүн тодруулж асууя.

З.Мэндсайхан: П.Наранбаяр сайд та төсөл, хөтөлбөр нь их хэрэгтэй төсөл, хөтөлбөр гэж яриад байна. Тэгээд сайн хөтөлбөр хэрэгжүүлэхийн тулд хууль зөрчиж болохгүй шүү дээ.

Тэгэхээр та хууль зөрчөөгүй гэж байна. Улсын Их Хурлын төсөв батлах эрхэд та халдсан байна. Энэ тушаалаа цуцал. Үгүй бол би таныг Үндсэн хуулийн цэцэд өгнө. Үүнийгээ танд хэлчихье.

Ж.Энхбаяр сайд аа, манайх баруун бүсэд хөдөө аж ахуйн үйлдвэр технологийн парк байгуулж байгаа.

Тэгэхээр энэ “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд хөнгөн үйлдвэрлэгчдийг баруун бүс нутаг руу үйлдвэрлэлийн салбараа нээх, шинээр үйлдвэр байгуулахад нь зориулж энэ үйлдвэр технологийн парк дээр хөнгөн үйлдвэрүүдийн нэг зөвлөгөөнийг баруун бүсэд зохион байгуулж өгөөч ээ. “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд. Монгол Улсад баригдаж байгаа ганц паркаа дэмжиж өгөөч ээ гэдэг хүсэлт байна.

С.Одонтуяа сайд ээ, гол асуудал бол ундны усны чанарын асуудал байгаа шүү. Говь-Алтай, Ховд аймгийн сумдын. Энэ дээр та надад бас нэг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: З.Мэндсайхан гишүүнтэй бид хамтран ажиллах болно.

Ховдод үйлдвэр технологийн паркийн хөрөнгө оруулалт энэ жил 18 тэрбумтай. Үндсэн үнэндээ энэ жил дэд бүтцийн ажил нь хийгдээд дуусна.

Одоо бид хувийн хэвшлийг тэр парк байгуулах орчныг бүрдүүлэх, урих, хөрөнгө оруулалт, таатай орчныг бүрдүүлэх ажлыг хийх ёстой. Бидний давуу тал бол “Цагаан алт” хөтөлбөртэй болоод авсан. Хөтөлбөр маань 2028 он хүртэл үргэлжилнэ. Энэ жил гараанаасаа гарлаа.

Тэгэхээр ирэх жил баруун бүсийн 5 аймгийн арьс шир, ноос, ноолуурын боловсруулалтыг Ховдод төвлөрүүлж хийнэ гэсэн бодлогыг яам барьж байгаа.

Тэгээд энэ хаврын тариалалтын хүрээнд хамтдаа очоод Ховдын ногоочидтойгоо, тариаланчидтайгаа уулзах ажил байгаа. Энэ ажлыг хамтатгаад нэг зохион байгуулъя бүгдээрээ.

Д.Амарбаясгалан: С.Одонтуяа сайд. Усны чанарын асуудал.

С.Одонтуяа: Би хэлсэн. Энэ жил говийн бүсийн 44 сумд гэсэн.

Говь-Алтай аймгийн хувьд нэлээд ажлууд хийгдэнэ. Жишээлэхэд 2024 онд Говь-Алтай аймгийн Төгрөг сумын усны эх үүсвэрийн судалгааны ажил эхэлсэн байгаа. Мөн Говь-Алтай аймгийн Цогт сум бас усны нөөцийн эх үүсвэрийн судалгааны ажлыг хийх нөөцийг батлахад орсон байна.

Тийм учраас Говь-Алтай аймгийн Цогт сум мөн орсон байна.

Тэгээд бид зөвхөн ундны эх үүсвэрээс гадна зэрэг гадаргын усаа бас нэмэгдүүлэх энэ ажлуудыг хийж байгаа. Тэгэхээр гадаргын усан дээр энэ жил Говь-Алтай аймагт одоо маш олон хөв цөөрмүүдийг хийх ажлууд эхэлж байгаа.

Тэгээд ер нь нийт улсын хэмжээгээр 333 сум, 333 хөв.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тийм. Сая чуулганы завсарлагаанаар хөдөө явж ажиллахад хөдөө сумдын усны чанарын асуудал нэлэнхүйдээ маш муу байна гэдэг зүйл сумын иргэд бүгд ярьсан.

Сумын түвшинд хатуулгыг нь арилгасан шүүлтүүртэй ус ууж байгаа сум гэж үндсэндээ байхгүй байна. Зарим сумд бүр өвлийн цагт худгаасаа ус авч уух боломжгүй байна гээд. Тухайлбал, Увс аймгийн Зүүнхангай, Тэлмэн гээд зэрэг сумд өвлийн цагт худаг нь ажиллахаа больчихдог. Тэгээд иргэд байгалиас мөс цас авч хайлуулж уух нөхцөл дээр байна гэдэг асуудал хөндөгдөж байна.

Тэгэхээр сумдын усны худаг дээр шүүлтүүр тавих, усны судалгааг нэгдсэн зохион байгуулалтаар хийх, цаашлаад өвөл зуны аль ч улиралд усны дутагдалд ордоггүй байх чиглэл дээр дорвитой арга хэмжээ авах нь зүйтэй байх гэж бодож байгаа. Тэгээд тань руу бас албан бичиг явуулсан байгаа. Энэ дээр тэгээд анхаарч ажиллаарай.

Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу?

Хамтарсан Засгийн газар байгуулагдаад хэд хэдэн мега төслүүд хөтлөөд авлаа. Гол зорилго нь мэдээж эдийн засгаа тэлэх, тэгээд дотоодын нийт бүтээгдэхүүнээ ихэсгэх. Тэгснээрээ олон гишүүдийн ярьж байгаачлан монгол хүн, монгол иргэн өөрөө амьдралын чанар нь сайжирсан, ололт нь айл болгоны өрхөөр орсон, тэр нь бид нарт мэдрэгдэхүйц байх ёстой.

Тэрийг гол үздэг шалтгаан нь ерөөсөө хүний хөгжил буюу энд 3 юм байгаа. Тийм ээ.

- ▷ Эрүүл мэнд,
- ▷ Боловсрол,
- ▷ Орлого.

Орлогыг Баялгийн сантай, ажил олголттой холбож ярьж байгаа.

Ингээд харахаар зэрэг эрүүл мэндийн салбарт жишээлбэл урт удаан хугацааны бодлого, дунд хөгжлийн бодлого нь одоо сая хэрэгжүүлсэн үйл

ажиллагаатайгаа уялдаж байна уу, үгүй юу, адилхан хэмжүүс хэмжүүрийг хэрэглэж байна уу, үгүй юу гээд харж үзэж байна.

Жишээлбэл, “Эрүүл Монгол хүн” чиглэлийн ийм 4 зорилго, 18 зорилтыг тусгасан байна.

Нийгмийн эрүүл мэнд дотроо үүнийг нь хараад үзэхээр өмнө ч гэсэн ярьж байсан. Нийгмийн асуудал дээр. Байнгын хороон дээр ч ярьж байсан, намрын чуулган дээр ч олон дахин ярьж байсан.

Энэ шалгуур үзүүлэлтүүд нь ямар байна аа? Их тунхгийн шинжтэй байна, бодлогын ул суурьгүй байна, үргэлжилсэн үгийн зохиол шиг орж ирж байна. Зарим тохиолдолд бүр нэг хүний хувийн тэмдэглэл шиг. Тийм газар очиж ийм уулзалт хийлээ гэсэн юмнууд орж ирээд байх юм.

- ▶ Шалгуур үзүүлэлтээр чинь бид яаж дүгнэх юм бэ?
- ▶ Суурийг нь яаж тодорхойлох юм бэ?
- ▶ Суурь нь тодорхой биш болохоор яаж гүйцэтгэлийг нь үнэлэх юм бэ?

Хаана явж байгаа, яаж бусад улс орныхоо BENCHMARK-тай харьцуулж үзэх юм бэ гэдэг асуудал санааг минь зовниулж байна.

Дахин дахин үүнийг ярьж байгаа учраас 3 жил хагасын дараа бас яг үүнийгээ яриад сууж байх вий дээ гэж санаа минь зовоод байна.

Одоо жишээлбэл, Эрүүл мэндийн сайдын тэр тушаал, Боловсролын яамны сайдын тушаал хамтарсан байдлаар 1 дүгээр ангийн хүүхдэд нүд, шүд, зүрх урьдчилан сэргийлэх үзлэг, 2.3.1.1, 2.3.1.3 дээр яг адилхан хөтөлбөрүүд мөртлөө өөр газар тавигдаад явчихсан байх юм.

Тэгэхээр энэ бас хөрөнгө нь давхардаад зарцуулагдчихсан байх вий дээ гэсэн нэг асуудал байгаад байна.

Нийгмийн эрүүл мэндээс гадна эрүүл мэндийн тусламж үйлчилгээ яг HEALTHCARE талаас нь асууя гэвэл маш тодорхой хэдэн асуулт надад байх юм. Асуучихъя.

Одоо энэ эрүүл мэндийн тусламж “чанар”, “үйлчилгээ”, “хүртээмж”, “аюулгүй байдал” гэсэн эдгээр гол үзүүлэлтүүд байгаа шүү дээ. Тийм ээ. Эрүүл мэндийн. Эдгээрийгээ тус бүрд нь ямар шалгуур үзүүлэлтээр үзээд байгаа вэ? Одоо энэ шалгуур үзүүлэлт байтугай тэр тодорхойлолтыг нь ч би олж харсангүй. Энэ өгч явуулсан бид нарт үзүүлэх гэж байгаа материал дээр. Үүнийгээ хэлээд өгөөч.

Хоёрдугаарт, яг салбар яам маань энэ тал дээр одоо яг ямар бодлого барьж үзэж ажиллаж байгаа юм бэ? Одоо энэ HEALTH, эрүүл мэндийн тогтолцоо чинь 4 л систем байгаа шүү дээ. Тийм ээ.

- Semashko,
- Beveridge,
- Bismarck,
- Out-of-Pocket

гэж ярьдаг юм. Одоо тэгээд өөрийн зардлын.

Энэ тогтолцооныхоо яг альныг нь манайх хэрэгжүүлж явж байгаа юм? Урт хугацааныхаа бодлогодоо. Энэ дээр нэг тодорхой хариулт авчихъя. Тэгэх үү?

Д.Амарбаясгалан: Т.Мөнхсайхан сайд хариулт өгөх үү. Салбарын асуудал.

Т.Мөнхсайхан: Яах вэ, эрүүл мэндийн салбарын ерөнхийдөө барьж байгаа бодлого, чиглэл бол ер нь цаашдаа ялангуяа эмнэлгийн таны асууж байгаа тусламж үйлчилгээ, чанар, аюулгүй байдал, хүртээмжийн чиглэл дээр ерөнхийдөө бодитой, хэмжигдэхүйц, хүрэхүйц тоо баримт, үзүүлэлттэй төлөвлөгөөгөө гаргая гээд ажиллаж байгаа.

Өнгөрсөн хугацаанд бид бодитой тоо баримттай төлөвлөгөөнүүдийг гаргаж ажиллаагүй өнөөдрийг хүртэл ирсэн юм билээ шүү дээ.

Тэгэхээр эд нарыг бид гаргахын тулд бас тийм богино хугацаанд гаргачихааргүй юм билээ.

Тэгэхээр энэ дээр бид маш сайн нухацтай ажиллаж байгаа. Жишээ нь, иргэдэд хүрэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна гэвэл төвлөрлийг сааруулах, Улаанбаатарт ирээд төвлөрөөд байгаа тусламж үйлчилгээг хэдэн хувиар бууруулах юм бэ. 2028 он гэхэд Улаанбаатарт ирж байгаа 80 хувийн тусламж, үйлчилгээний хэдэн хувийг нь орон нутагт нь үзүүлчихдэг болгох юм бэ гэх мэтчилэн бид яг ингэж тоон үзүүлэлтүүдээр тусламж, үйлчилгээгээ гаргая гэж байгаа юм.

Монгол Улсад эмчлэгдэхгүй байгаа өвчлөлийг яг 2028 он гэхэд хэдэн хувийг нь эмчилдэг болоод, хэдэн хувийг нь гадагшаа явдаг, хэдэн он гэхэд 100 хувь бүгдийг нь эх орондоо эмчилдэг болгох юм бэ гэдэг тоон үзүүлэлтүүдээ бид ер нь бүгдийг нь сайн гаргах ёстой юм билээ.

Цаашдаа бид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ерөнхийдөө үзүүлэх гол зарчим маань аль болох ард иргэдэд санхүүгийн эрсдэл багатай, карманаас гарах зардлыг бага байлгах, Эрүүл мэндийн даатгалаас нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг түлхүү хийх, санхүүжүүлэх.

Иргэний өөрийнх нь хариуцлагагүйгээс үүдэлтэй юм уу, тийм тусламж, үйлчилгээнүүдийг илүү иргэн төвтэй санхүүжилтээ гаргадаг ийм нөхцөл байдал руугаа бид шилжихгүй бол өнөөдрийн байж байгаа энэ санхүүжилтээр бүх тусламж үйлчилгээг санхүүжүүлээд явна гэх юм бол энэ маань ямар ч боломжгүй. Өнөөдрийн байгаа санхүүжилтээр.

Түрүүн хэлсэн. Олон улсын түвшнээс бид хамгийн доод хэмжээнээс хоёр дахин бага санхүүжилтээр бид хурц, архаг, бүх тусламж, үйлчилгээг бүгдийг нь санхүүжүүлээд явах боломжгүй.

Тэгэхээр цаашдаа бид ер нь аль тусламж, үйлчилгээгээ даатгалаасаа илүү их санхүүжүүлэх юм, альныг нь илүү их иргэдээсээ хамтын төлбөрөөр нь шийдэх юм, аль тусламж, үйлчилгээгээ төлбөртэй тусламж үйлчилгээгээр байх юм бэ гэдэг энэ зүйлээ бид маш сайн тодорхой болгож байж манай салбарын тулгамдсан асуудал шийдэгдэх юм билээ.

Явж явж ер нь манай салбарын хамгийн гол асуудал санхүүжилт дээр очоод л хамаг юм гацдаг. Өнөөдөр чанартай тусламж, үйлчилгээг нэхэж байгаа боловч өнөөдөр яг эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилчдын авч байгаа цалин мөнгө амьдрал ахуйн хаана нь ч хүрэхгүй.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваасамбуугийн Ганмаа гишүүн тодруулж асууя.

Д.Ганмаа: Асуулт. Нийгмийн эрүүл мэнд тал дээрээ тэр давхардсан хөрөнгө зарцуулчихсан байна уу, үгүй юу гээд яг зүйл заалттай нэгдүгээрт асуусан.

Хоёрдугаарт, салбарын сайдын хариултыг ойлгож байна. Санхүүжилт хэцүү байгаа. Тэгэхдээ санхүүжилтээс гадна эрүүл мэндийн тогтолцоо чинь өөрөө шинжлэх ухаанд суурилсан, мэдлэгт суурилсан, биеэ даасан салбар юм байгаа юм уг нь.

Гэтэл энэ салбарыг бодлогыг хариуцаж авах ёстой энэ байгууллага маань өөрөө нэг том эмнэлгийг менеж хийж байгаа юм шиг үйл ажиллагаа явуулаад байгаа нь олон жилийн давтагдалтай гарч ирж байгаа юм байна.

Д.Амарбаясгалан дарга өөрөө ч гэсэн мэдэж байгаа байх. Дахин инженерчлэл. Төрийн байгууллагуудыг үр ашигтай болгох. Энэ судалгааг харахаар манай салбарын яам хамгийн муу буюу Эрүүл мэндийн яам бодлогын хувьд 28-хан хувь. Тэгээд хэрэгжилт. Гол нь хэрэгжилт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Д.Ганмаа: Тэгэхээр нэгэнт биеэ даасан салбар учраас, мэдлэгт суурилсан, шинжлэх ухаанд суурилсан салбар учраас энэ бодлогоо маш

тодорхой болгож өгөөд саяын миний асуусан тэр эрүүл мэндийн системүүдийн тогтолцооны яг аль хэлбэрээр нь явах гэж байгаагаа маш тодорхой бодлогоо боловсруулж энэ дээрээ хариултаа өгөх үгүй бол салбар өөрөө буюу дотор нь ажиллаж байгаа хүмүүс ч яг сая ярьж байсан цалин мөнгөний асуудал, цалин бага асуудал, ажлын ачааллын асуудал, хүний нөөцийн асуудал, тэр байтугай эрх зүйн асуудал дээр айдас хүйдэстэй байна.

Хамгийн сүүлд болсон П.Батчулуун эмчийн асуудал дээр ч гэсэн бид бэлээхэн харж байгаа. Энэ дээр их тодорхой байр суурьтай баймаар байна.

Эргээд иргэд бас эндээсээ маш их хохирч байгаа гэдгийг минь анхаарч үзнэ үү.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууж, үг хэлье. П.Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Тэгэхээр Д.Ганмаа гишүүний нэг асуултад.

Боловсролын яам, Эрүүл мэндийн яам хамтарсан 6 настны үзлэгийн асуудал хөндсөн учраас зарим нэгэн тоо баримтыг хэлье.

Ямар нэгэн тийм төсвийн давхцал байхгүй. Ялангуяа нүдний үзлэгийг 6 наснаас авахад тоног төхөөрөмжүүдийг нэмж авах шаардлагатай болсон учраас 300 сая төгрөгийг шийдээд, одоо ингээд орон даяар нүдний үзлэг явж байна.

6 настай хүүхдүүдээс зүрх, шүд, нүдний үзлэгийг нийтдээ ингээд надад ирсэн мэдээллээр 3 сарын 19-ний байдлаар 40 мянга 749 хүүхдээс авчхаад байна л даа. Тэгээд эндээс харахад шүдний өвчлөл нэлээн айхтар байна. Нийтдээ 80.7 хувь буюу 32 мянга 868 хүүхдээс авсан байхад 94 хувь нь өвчлөлтэй л гэж гарч ирж байгаа юм.

Эмчлүүлсэн хувь хэмжээг нь харахаар 18 хувь буюу 5 мянга 406 хүүхдийг эцэг, эх, багш нар нь нийлээд эмчлүүлсэн байна. Энэ их сайн үзэгдэл.

Эрүүл шүдтэй л байвал монголчууд бид ирээдүйд эрүүл сайхан амьдарна гэсэн үг.

Нүдний.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Нүдний өвч өвчлөлийн тухайд нийтдээ 68 хувь нь хамрагдсан. 27 мянга 534 хүүхэд. Үүнээс бас хараа муудсан гэж илэрсэн 5 мянга 650 хүүхэд, 20 хувьтай байна.

Ингээд дараагийн шатанд 739 хүүхэд шилжсэн.

Зүрхний үзлэгийн тухайд нийтдээ 33 мянга 898 хүүхдийн зүрхний бичлэг хийж илрүүлснээс 7 мянга 230 хүүхдэд өвчин илэрсэн нь 21 хувьтай байна.

Дараагийн шатанд үзүүлээд явж байгаа 4 мянга 418 буюу 61 хувь нь байна гэж ингэж гарч ирж байна.

Тэгэхээр энэ завшааныг ашиглаад хэлэхэд ингэж эрт илрүүлж байгаа нь маш маш хэрэгтэй зүйл болж байгаа. Хоёр яам хамтраад үүнийг хэрэгжүүлж байгаа. Хамгийн гол нь үүнийг анги удирдсан багш нар болоод эцэг, эхчүүд нь цааш нь хүүхдээ эрүүлжүүлэхэд онцгой анхаараач ээ гэж хэлэх гэсэн юм.

Цаашдаа Эрүүл мэндийн яамтай ярьж байгаа. Өсвөр насанд нь, төгсөхөөс нь өмнө гээд нийтдээ 3 удаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайд асуултад хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ маш чухал маш санаа зовмоор тоо баримтууд гараад ирж байгаа юм.

Гэхдээ үүнийг бид цэгцлэх бололцоо байна. 94 хувь нь шүдний өвчлөл гэдэг бол сүү дутагдаж байгаа асуудал. Нүдний хараа муудаж байна гэдэг “А” амин дэм дутаж байна.

Тэгэхээр бид лууван, сүү хоёроо шийднэ шүү дээ. Бусад орны жишээ байна. Сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг бид цоо шинээр эргэж хараад яг энэ бодлогын хувьд хөгжүүлж байгаа “Атрын IV аян”, “Хүнсний хувьсгал”-тайгаа нэг уяад өгвөл их олон асуудал шийдэгдэнэ.

Мөн “Цагаан алт” хөтөлбөр буюу хүүхдийн цүнхний ачааллыг тааруулах, нурууны хөгжилд нь тааруулах, сургуулийн хүүхэд насны хүүхдийн гутлын стандарт гээд арьс ширний салбараа бас холбоод өгвөл үр дүн гарахаар юмнууд байна.

Бодлогуудаа хооронд нь уях нь ийм зайлшгүй шаардлага бидний хувьд их байгаа шүү. Энэ дээр хамт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваасамбуугийн Ганмаа гишүүн тодруулж 1 минут өгье.

Д.Ганмаа: Их сонирхолтой сэдэв хөндөж байгаа болохоор яах аргагүй дахиад авчихъя.

Энэ салбар хоорондын уялдааг зайлшгүй хангах ёстой байгаа юм. Энэ хүүхдийн нүд, шүд, зүрх. Зөвхөн нүд, шүд, зүрх ч биш шүү. Өсөлтийн асуудал байгаа. Бичил шим тэжээлийн асуудал байгаа.

Хүнсний баяжуулалтын хуулийг 2018 онд баталчихсан юм шүү дээ. Түүнийхээ хэрэгжилтийг хийгээд өгчхөөч.

Тэгэх юм бол энэ асуудлуудын чинь ихэнх нь нэгдүгээрт шийдэгдэх гээд байгаа юм. Хэрэгжүүлж чадахгүй байгаа бол яагаад хэрэгжихгүй байгаа юм бэ? Хууль тогтоомжийн хуулиар хэрэгжилтийг шалгах боломжтой. Салбар хоорондын асуудлаа шийдэх тэр “Алсын хараа” гэдэг үйл ажиллагаа, Үндэсний хороогоо бас идэвхтэй ажиллуулбал энэ дээр нэлээн олон юм хийх боломжтой байгаа шүү. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Ингээд л зарим нэг чухал асуудлууд ярих гэхээр ерөөсөө сайд нар ер нь байхгүй болохоор одоо үнэхээр хэцүү юм.

Өнөөдөр өдөржингөө ч суулаа. Манай 22 Засгийн газрын сайд нараас хамгийн олондоо 12.

Тэгээд л ер нь 7 сайд л сууж байна. 7 сайд бол үнэхээр тууштай сайн сууж байна. Тэгээд Засгийн газрын сайд нар томилогдохдоо Улсын Их Хурлын гишүүдийг 28 цаг хуралдуулж байгаад, шөнөжин өдөржин хуралдаж байгаад томилогдож байсан. Тэгээд ажлаа тайлагнах болохоор Ерөнхий сайдыг суувал нэг арай гайгүй ирцтэй. Бусад үед 7 хүн л сууж байна.

Тэгэхээр ийм байх юм бол. Бид өөр өөрсдийнхөө жижиг асуудлыг ярих гээгүй юм л даа. Энэ бол сайд нарын хувьд нэгдүгээрт хийсэн ажлаа олон нийтэд хүргэх, мэдээлэл хүргэх. Бид ч гэсэн зарим асуудлыг мэдэж байгаа.

Тэгэхдээ үүнийг яг сайд нь өөрөө хэвлэл мэдээлэл олон нийтэд хэлээсэй гэж бодож бид уг нь асуулт асуугаад байгаа юм.

Тэгээд одоо энэ таван жилийн үндсэн чиглэлийг Үндэсний аудитын газрын тайлангаас ингэж байна. Судалгаа тооцоогүй боловсруулсан. Төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх төсвөө тавьдаггүй. Хамгийн чухал нь гүйцэтгэл муу байлаа гээд ямар хариуцлага тооцох вэ гэдэг нь тодорхойгүй.

Гурван Шадар сайдаас нэг ч шадар сайд байхгүй байна. Тэгэхээр би одоо хэнээс асуухаа мэдэхгүй байна.

Гүйцэтгэл муу байгаа тохиолдолд хэнтэй яаж ямар хариуцлага тооцох вэ? Нэгдүгээрт. Э.Одбаяр сайдаас асууя. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, та битгий ингэж нэг ийм жижигхэн юман дээр улс төржөөч. Нэгэнт энэ байна шүү дээ, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн дагуу Та бүгдийн хамтдаа кноподсон Засгийн газрын тухай хуулийн дагуу чиг

үүрэг нь. Эсвэл Эдийн засаг, хөгжлийн сайдаар, нөгөөдөх нь Э.Одбаяр сайд дээр хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан сайд дээр байгаа юм.

Тэгэхээр хариуцсан сайдаас нь л асуух ёстой гэж би бодож байна. Улс төржиж байгаа юм биш.

Дээрээс нь нэмээд энэ хяналт үнэлгээг уг нь хуучин Засгийн газрын Хэрэг эрхлэх, аудит хоёр хийгээд аль аль нь яах вэ болдог байсан чинь одоо шат дамжлага нэмэгдээд шал дордов гэдэг л яг энэ боллоо.

Одоо тэгсэн чинь дээрээс нь нэмээд Хяналт үнэлгээний Үндэсний хороо, агентлаг. Дээрээс нь нэмээд ахиад Улсын Их Хурлын Тамгын газар. Дөрвөн газраас бараг хяналт шинжилгээ хийгээд хоорондоо тоонууд нь зөрөөд. Хамгийн сүүлд хэнийг нь альныг нь ярьж барих вэ гэхээр яг салбарын мэргэжилтнүүдийг хооронд нь мэтгэлцүүлэхгүй юу Та нар гээд ингээд ийм юм яриад байх юм.

Уг нь нэг дээр нэгийг нэмээд хоёр. Сайн, муу гэдэг асуудал чинь субъектив биш байдлаар шийдэгдэж болмоор юм. Тэгээд энэ дээр Улсын Их Хурлын гишүүд бид альныг нь барих юм бэ?

Дараагийн асуудлууд нь хэрэгжих болоогүй байгаа гэсэн 2989 зүйл, заалт байна. Тэгээд хамгийн инээдтэй нь зарим нэг жоохон тааруухан байгаагаа тэгээд биччихсэн юм шиг байгаа юм. Жишээлбэл, 3.1.1 дээр эдийн засгийн өсөлтийг жил бүр 6 ба түүнээс дээш хувьд тогтвортой байлгана. Инфляцыг 5 хувиас бага түвшинд хадгалах бодлогыг баримтална гэхээд. Үүнийгээ хэрэгжих болоогүй гэж үнэлсэн байгаа. Яагаад вэ гэвэл инфляц үүнээсээ давчихсан учраас тэгж хэлээд байх шиг байгаа юм.

Тэгэхээр үүнийг хэрэгжүүлэхэд хэдэн жил хүлээх ёстой байсан юм бэ? Энэ чинь 4 жилийн төлөвлөгөө шүү дээ. Тийм ээ. Эхний жил нь дуусаж байна гэсэн үг.

Дээрээс нь энэ удаагийн Засгийн газрын мөрийн хөтөлбөр 3 намаас:

- ▶ Нийгмийн бодлогыг Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрөөс,
- ▶ Ардчилсан намаас эдийн засаг, бизнесийн хөрөнгө оруулалтын орчин, эрх чөлөө, хүний өмчийн эрх чөлөөг хангах,
- ▶ ХҮН намаас эрчим хүч, боловсролын салбарын шинэчлэл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт гэсэн.

Эндээс 2024 онд та бүхэн маань нам, нам дээрээ өөрөө өөрийнхөө мөрийн хөтөлбөрийн үнэлэлт, дүгнэлтийг хийж үзсэн үү? Нам дотроо өөрөө үүнийгээ ярьж байгаа юу?

Дараагийнх нь асуудал нь, өнөөдрийн нэг ийм статик тоо ярихаасаа илүүтэйгээр санаа зовмоор эдийн засгийн том үзүүлэлтүүд, асуудлууд гараад байх юм. Та бүхэн энэ дээр дүгнэлт хийж байгаа юу?

Эдийн засгийн өсөлт сайн байгаа ч гэсэн иргэдийн амьдрал дээр буухгүй байна. Үүнийг Хятад Улс ярьж байна. Дундаж давхар хумигдаж байна гэж.

Солонгос Улс эдийн засгийн өсөлт гайгүй байгаа ч гэсэн иргэд өрөнд орж байна. Үүн дээр ямар дүгнэлт хийсэн бэ? Хэнээс асуух вэ? Их Хурлын дарга аа.

Д.Амарбаясгалан: Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт хариулт өгье.

С.Бямбацогт: Тийм. Х.Булгантуяа гишүүн чухал асуудал хөндөөд байгаа юм.

Бид 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийж Монгол төрийн бодлого тодорхой байх, тогтвортой байх энэ асуудлыг Үндсэн хуульд оруулсан. Үүнтэй холбоотойгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль баталсан.

Үүний дагуу үндсэндээ урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримт “Алсын хараа-2050”. Дунд хугацааных нь батлагдаагүй байгаа. Хөгжлийн 8 зорилт. 10 жилийн хугацаатай.

- 5 жилийн төлөвлөгөө батлагдсан.
- 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан.
- Жилийн төлөвлөгөө батлагдсан байгаа.

Анх удаагаа хэлэлцэж байгаа. Анх удаагаа. Анх удаагаа хэлэлцэж байгаа болохоор үндсэндээ ойлгомжгүй. Цаашид засаж залруулах, сайжруулах асуудал гараад байгаа.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг нэмэгдүүлсэн. Улсын Их Хурлын гишүүдийн хянан шалгах эрхээ хэрэгжүүлэх бололцоог.

Үүнтэй холбоотойгоор 2020 онд бид Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль баталсан.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйл, 18, 19, 20 дугаар зүйлээр үндсэндээ улсын хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн мөрийн хөтөлбөрийн биелэлт, жилийн төлөвлөгөөний биелэлт, дээрээс нь

- төлөвлөлт,
- төсөвлөлт,

► тайлагналыг

хэрхэн хангаж байна вэ гэдэг асуудлыг хянах эрхийг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар Улсын Их Хуралд өгсөн байгаа.

Үүний дагуу Улсын Их Хурлаас Улсын Их Хурлын Тамгын газар анх удаагаа маш олон хуудастай 3 бодлогын бичиг баримтыг.

Бодлогын бичиг баримт нь 5 жилийн үндсэн чиглэл байж байгаа. Богино хугацааных нь төлөвлөлтийн бичиг баримтууд.

Эдгээрийн биелэлтийг хянаад, шалгаад, үзээд анх удаагаа том дүгнэлт оруулж ирсэн. Үүнийг манай Их Хурлын гишүүд харж уншсан уу, үгүй юу. Мэдэхгүй байна.

Ингээд хоёр өдрийн туршид, үндсэндээ 3 хоногийн туршид хэлэлцүүлэг явж байна. Хэлэлцүүлгийг харж байхад анхаарах, засах, сайжруулах асуудлууд байна.

Аудитын байгууллага санхүүгийн аудит, гүйцэтгэлийн аудит, нийцлийн аудит хийдэг.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бичиг баримтууд дээр голцуу нийцлийн аудит хийгдэж байгаа. Нийцлийн аудит.

Үүний хажуугаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, дээрээс нь Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газар, тэгээд Улсын Их Хурлын Тамгын газар, аудит гээд олон байгууллагууд Засгийн газрын үйл ажиллагааны бодлогын бичиг баримтууд дээр 5 жилийн үндсэн чиглэл, 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, нэг жилийн төлөвлөгөө, төлөвлөлт, төсөвлөлт, тайлагналт дээр бүгд дээр нь хяналтууд хийсэн. Энд нэг талаасаа давхардаж байгаа зүйлүүд байгаад байх шиг байна. Нөгөө талаасаа бас дутагдалтай. Юу гэдэг юм. Орхигдоод байгаа зүйлүүд байх шиг байна. Х.Булгантуяа гишүүн яг үүнийг хөндөж байна.

Тийм болохоор Улсын Их Хурлын дарга өглөө хэлж байна лээ. Ажлын хэсэг байгуулбал яасан юм бэ. Бодлогын бичиг баримтуудын хоорондын уялдаа холбоо, бодлогын бичиг баримтад зайлшгүй засвар хийх байна уу, үгүй юу.

Одоо бид 10 жилийн хугацаатай 8 зорилт, хөтөлбөрөө батлаагүй байгаа. Дунд хугацааны.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: С.Бямбацогт сайдад 1 минут нэмж өгье.

С.Бямбацогт: Тийм болохоор бид яах аргагүй хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бичиг баримтуудаа сайжруулах, уялдаа холбоог нь хангах, алдаа, асуудал байна уу үгүй юу гэдгээ дүгнэж цэгнэх шаардлага байгаа юм.

Тийм болохоор Улсын Их Хурлын дарга тэр ажлын хэсэг байгуулаад, энэ дээр нэлээн том дүгнэлт өгвөл яасан юм бэ.

Заримдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуульд байхгүй бодлогын бичиг баримт бид Их Хураас батлаад байгаа. Эдгээрийг нэг эргээд харчихвал яасан юм бэ. Х.Булгантуяа даргын хэлж байгаа саналыг бас анхаарах ёстой юм байна л гэж хэлэх гэж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Харин тийм. Одоо яг энэ асуудлаар өргөн хүрээгээр ярилцаж байгаа юм чинь олон гишүүдийн санал гарч байна. Тэгээд санал дээр нь үндэслээд ажлын хэсэг байгуулаад, энэ төлөвлөлт, төсөвлөлт, тайлагналт, гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг цэгцтэй болгох чиглэл дээр анхаарахгүй бол.

Манай төлөвлөгөө үндсэндээ олон мянган ажил төлөвлөж байна гэдэг дээрээ төвлөрөөд яваад байдаг.

Өнөөдөр гишүүдийн голчлон нэхэж байгаа зүйл үр дүнгийн асуудлыг хөндөж яриад байдаг. Тэгэхээр бид төлөвлөж байгаа, төсөвлөж байгаа гүйцэтгэл, тайлангаа хийж байгаа байдал бүр илүү үр дүнтэй байх, үр дүн өгөөж нь зохих ёстой хэмжээнд байсан эсэхтэй холбоотой асуудлыг хөндөж ярьдаг байх нь зүйтэй гэж.

Тэгээд бид бас нэг ажлын арга барилыг бүх түвшиндээ авмаар байгаа зүйл нь буруу гэж үзэж байгаа, хэрэгжих боломжгүй гэж үзэж байгаа зүйлийг ер нь тухайн цаг үед нь зогсоогоод, шинэ төлөвлөлт, шинэ төсөвлөлт хийдэг тэр арга хэлбэр лүү шилжихгүй бол.

Нэгэнт бид төлөвлөчихсөн учраас гээд хэрэгжихгүй, бүтэхгүй зүйлийг араас нь он удаан жил үргэлжлүүлж яваад байгаа байдал нь үр дүнгээ үзүүлэхгүй байгаа нэг л хэлбэр байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бүгдээрээ төвлөрч ажиллая.

Тэгээд нэгэнт Байнгын хорооноос дагасан тогтоол гаргахаар санал орж ирээгүй учраас. Харин Улсын Их Хурлын даргын захирамжаар гишүүдийн оролцоотой ажлын хэсэг байгуулаад, энэ яригдсан асуудлыг цэгцлэх, шаардлагатай бол хуулиудад өөрчлөлт оруулах чиглэл дээр ажлын хэсэг байгуулаад ажиллая гэж бодож байгаа юм.

Э.Одбаяр сайд хариулт өгье.

Э.Одбаяр: Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяагийн асуултад хариулъя.

Тэгээд өөрийнх нь асуултад нам гэдэг үг хоёр, гурван удаа гарч ирж байх шиг байна.

Тэгээд салбарын сайд нартай холбоотой асуудал дээр хариуцлагын асуудлыг яаж ярих вэ гэж байх шиг байна.

Ер нь кабинетын зарчмаар салбарын сайд нар, аль нэгэн сайд нар хариуцлагын асуудал яригдвал мэдээж томилсон субъект буюу Ерөнхий сайд хариуцлагын тухай асуудал ярих байх.

Дээрээс нь олон тайлан мэдээ орж ирж байна. Тэр нь бараг Э.Одбаяр энэ салбарыг нь авсантай холбоотой ойлгомжгүй байдал үүсчхэж байгаа юм биш үү гэдэг агуулгаар ярьж байх шиг байна.

Хэрвээ тийм асуудал байгаа гэж үзэж байгаа бол та хэд маань дотооддоо ярих нь зөв байх.

Энэ тайлан мэдээгээ ярьдаг, дүн шинжилгээгээ нийлүүлдэг хэлэлцүүлэг Улсын Их Хурал дээр анх удаагаа хэлэлцэгдэж байгаа.

Хуучин 2024 оныг хүртэл ажиллаж байсан Засгийн газрын бүтцээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар зохион байгуулаад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье.

Э.Одбаяр: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар салбарын яамдынхаа ажлын уялдааг хангаад, дээрээс нь дэргэд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа үйл ажиллагаа явуулдаг хяналт хэрэгжүүлэх газрыг тусад нь бие даалгасан.

Өөрөөр хэлбэл төлөвлөөд өөрийгөө хянаад байдаг тогтолцоогоо эрүүл болгоё. Хамтарч засаг бүрдүүлж байгаа нөгөө намдаа энэ хяналтын чиг үүргээ хариуцуулъя гэдэг шийдвэр гарсан байх гэж би ойлгож байна.

Тэгээд хоёр өдөр үргэлжилж байгаа хэлэлцүүлэг дунд ерөөсөө нийтлэг нэг юм дээр санал нэгдэж байгаад их баяртай байна.

Энэ төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл хяналтын цогц системийг нэвтрүүлъя гэдэг хэрэгцээ үүсчихсэн байгааг Их Хурлын гишүүд маань зөвөөр харж байгаад их талархалтай байна.

Тэгээд энэ дээр Ерөнхий сайдын захирамжаар нэг ажлын хэсэг гараад байгуулагдаад ажиллаж байгаа. DMEDESIGN[төлөвлөлт] MONITORING[хяналт] EVOLUTION[үнэлгээ] гээд цогц системийг оруулна. Тэгээд явцынхаа мэдээллийг солилцоод хамтарч ажиллана.

Д.Амарбаясгалан: Х.Булгантуяа гишүүн тодруулъя.

Х.Булгантуяа: Манай сайд нар битгий ийм эмзэг дэлбээ шиг бай л даа.

Зүгээр хариуцсан асуудлын чинь хүрээнд л ярьж байгаа шүү дээ. Түүнээс биш хэн ч намчирхаагүй.

Тэртээ тэргүй Засгийн газрын тухай хууль дээр энэ бол эдийн засгийн хөгжлийн хариуцах асуудлын, дээрээс нь нэмээд Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайдын эрхлэх асуудал гээд.

Энэ хүрээнд нь асуухаар манай сайд нараас асуугаад байна гээд байх юм. Одоо бид асуудал асуудлаа л хариуцаж байна.

Зүгээр бид ингэж л хэлэх гээд байна л даа. Хариуцлага тооцох асуудал бол ийм байдаг юм байжээ. Та бүхэн Засгийн газар дотроо энэ асуудлыг нэлээн сайн ярив уу? Бид нарыг яриулж, яриулж, бухимдуулж, бухимдуулж, хоёр хоног чуулган хуралдчихаад л дуусах юм биш биз дээ.

Яагаад гэвэл ард түмэн бид нараас хариуцлага нэхээд байна. Бид энэ дээр гарын үсэг зурдаг албан тушаалтнууд биш учраас Та бүгдээс иргэдээс ирээд байгаа асуултуудыг л асууж энд хариуцлагатай ажиллаач ээ л гэж хүсээд байгаа юм.

Эдийн засаг, хөгжлийн сайд байхгүй болохоор одоо хэнээс асуух вэ? Энэ эдийн засагт тулгамдаад байгаа, иргэдийн амьдралд тулгамдаад байгаа асуудлууд дээр та нар ямар гол асуудлууд байна?

Д.Амарбаясгалан: Э.Одбаяр нэмж хариулт өгье.

Э.Одбаяр: Одоо тэгээд субъектив юм яримааргүй байна.

Энэ 8 сарын 27-ны өдөр Улсын Их Хурлаар бид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөө батлуулаад ажилдаа ороод явж байгаа.

Хуулийн хувьд 2024 оны сүүлийн улирлын үйл ажиллагааг 2 сарын 01-нээр тайлан болгоод нэгтгээд орж ирж байгаа.

Тэгэхээр энд ямар нэгэн байдлаар амьдрал сайхан байна, гоё байна, ирээдүй гэрэлтэй байна гэдэг тайлан байхгүй байгаа гэж ойлгож байгаа. Бодит байдлаа яриад, болж байгаа болохгүйгээ яриад, засаад, хамтраад цаашаа явъя.

Шалгуур үзүүлэлтүүд чинь болохгүй байна. Метр барьчхаад хүний жинг хэмжинэ гээд байна. Үүнийгээ больё. Журмаа өөрчилъё. Цогц байдлаар нь гээд бүх юмаа төвлөрүүлсэн. Тэгээд тэр нь төлөвлөлт, гүйцэтгэлээ гаргахдаа учир

дутагдалтай байна. Түүнийгээ салгаад 3 журам болгоод батлуулсан. 5 сарын 01-нээс хэрэгжээд явна.

Ингээд алдаа бол байна. Засаад явъя л гэж байгаа юм. Тэгээд энэ дээр яг тийм сайхан байна, ийм байна гэж байгаа тайлбар, тайлан ерөөсөө байхгүй байгаа шүү.

Д.Амарбаясгалан: Дахиж тодруулъя гэж байна. Х.Булгантуяа гишүүнд микрофон өгье.

Х.Булгантуяа: Би хэдэн зүйл дээр Та бүгдийг анхаараасай гэж бодож байгаа юм.

Сая манай эмэгтэй гишүүд хүүхдийн “Цалинтай ээж”-ийн мөнгөний асуудал яриад байгаа нь Монгол Улсын төрөлт буураад байна. Өнөөдөр залуучуудын улс гэж байгаа ч гэсэн энэ бол 18, 20, 30 жилийн дараа маш том асуудал болно.

Бид Монголын төрийг барьж байгаа хүмүүсийн хувьд үүнд анхаараач ээ л гэж байгаа юм.

Дээрээс нь нэмээд эдийн засаг өсөөд байгаа мөртлөө иргэдийн амьдрал дээр буухгүй байна. Цалингийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа хувь хэмжээг Та бүхэн маань хараарай. Энэ бол яг иргэдийн амьдралд эдийн засгийн өсөлт буухгүй байгаа нэг том илэрхийлэл шүү. Үүнийг Та бүхэн анхаараарай гэсэн юм.

Нөгөөдөх нь, өрийн дарамт иргэдэд маш их байна. Үүнд Та бүхэн маань анхаараарай. Хэдүүлээ хэдэн хуурай тоо тойроод яриад байх биш, яг бид нарыг ард түмэн юу гэж үнэлэх вэ гэхээр ажлын хэсэг гарсан. 50 хувь гэж бид өөрсдийгөө үнэлдэг. Ард түмэн бол энэ хууль хэрэгжээд бид нарт таалагдахгүй байна. 50 хувь гэж үнэлдэг.

Тэгэхээр энэ хоёрын хоорондох асар том ялгаа байгааг Та бүхэн маань анхаараач ээ л гээд байгаа юм. Түүнээс биш бие биенийхээ муу.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууж, үг хэлье.

Х.Тэмүүжин: Өнөөдөр Улсын Их Хурал дээр анх удаа гэж хэлээд байх шиг байна.

2021-2025 оны хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, түүний 2024 оны гүйцэтгэлийн тайлан гээд.

Өнгөрсөн таван жил юу болоод өнгөрсөн юм бэ гэдэг л үнэлгээ яваад байх шиг байна.

Засгийн газар дотооддоо, аудитын байгууллага хөндлөнгөөс үнэлэхээс гадна олон улсын байгууллага хэрхэн яаж үнэлж байгаа тухай бас яг энэ хэлэлцүүлэг эхлэхэд Д.Бум-Очир гишүүн бас хэлнэ лээ.

Энэ Монгол Улс чинь ер нь дарангуйллынхаа тогтолцоо руу шилжчихсэн юм биш үү гэж.

Тэгээд магадгүй Засгийн газраас тайланд дурдагдаад гараад ирэхээр том төслүүд8 эдийн эдийн засгийн тоо баримтуудаа илүү хэлээд байгаа болохоос биш яг иргэний эрх, ардчилал, хуулийн засаглал тал руугаа юу хийсэн юм бэ гэдэг үзүүлэлтүүд маш сул байна.

Энэ тайланг хэлэлцэхийн өмнөхөн бид төмөр замын холболттой холбоотой бас нэг асуудал хэлэлцсэн. Түүн дээр Ерөнхий сайд маш ноцтой нэг үг хэлнэ лээ.

Монгол Улсад төр байхгүй болчихсоны, хариуцлага алдагдсаны хамгийн том жишээ байх. Монгол Улсын Засгийн газар өөрийнхөө хийсэн гэрээг өөрөөсөө олохгүй байна. Айл улсаасаа энэ гэрээг олж ирлээ гэдэг үг хэлсэн.

Үндэсний аюулгүй байдлын “олс” чинь бараг “хялгас” дээрээ тогтож байгаа юм биш үү гэдэг тийм хардалт, тийм санаа зовнилыг бараг хэлмээр тийм үг хэлсэн.

Яахаараа Засгийн газрын архив дотор байгуулсан гэрээ нь байхгүй болчихдог юм. Хариуцаж байсан албан тушаалтнууд нь юу хийж байдаг юм. Засгийн газар өөрөө өөрийнхөө дотор байгаа алдаа завхралыг, төр өөрөө өөрийнхөө дотор байгаа энэ авлига гэж хэлэх юм уу, ашиг сонирхол гэж хэлэх юм уу, юу гэж хэлэх юм. Энэ зүйлээ олж тогтоож чадахгүй байж алдаагаа яахаараа иргэний хувийн амьдрал, бизнес эрхлэгчдийн бизнесийн дундаас босгож ирээд байгаа юм бэ.

Энэ бол манай ардчиллын хамгийн хойшоо татсан тэр сул үзүүлэлтийн нэг шүү.

Монгол Улсын хэн нэгэн албан тушаалтан архивыг бүтнээр нь айлын тал руу гаргахад бид эрүүгийн хэрэг үүсгээд хариуцлага тооцоод явахад тэрийг нь таслан зогсоогоод төрийн том шагнал өгчхөж байсан юм.

Энэ мэт галзуурал чинь төр дотор байгаа энэ хариуцлагагүй байдлыг өөгшүүлээд байгаа юм. Сүүлд Засгийн газар их аюултай үйлдэл хийж байна лээ. Түүхийг өөрчлөх гэж оролдсон шүү.

Эцсийн дүндээ ер нь юмыг гацаадаг, хулгай хийдэг, гаднын гар хөл болдог хэсэг нь эх орончид болж хувираад, бизнесээ босгох гэж явдаг, хууль дагаж амьдрах гэж оролдсон эсэх нь бараг дайсан болон хувирчихсан уу, яасан. Ийм ийм мэдээллийг ингэж бохирдуулж болохгүй.

Монгол Улсын ардчилал яагаад ингэж дампуураад байгаагийн шалтгаан энэ танхим дотор ч гэсэн байгаа. Парламентын чуулганы толгой дээр гүйцэтгэх эрх мэдлийн толгой гараад суучихдаг гэдэг улс байхгүй шүү.

Та бүхэн одоо хар. Энэ улс орны чинь 3 даргын улс болчихлоо. Авторитар дэглэм бий болчихлоо гэдгийг чинь илэрхийлэл энэ санал суудлын хуваарь чинь шүү дээ.

Ерөнхий сайд нь парламентынхаа толгой дээр гараад суудаг улс хаана байна. Та бүхэн бусад ардчилсан улсын парламентын дотоод зохион байгуулалтыг олоод хараарай. Ерөнхий сайд нь гишүүнийхээ суудал дээр сууж байгаа. Энд гишүүдийн хариултад Засгийн газрынхаа байр суурийг тэндээс хэлж байгаа.

Улсын Их Хурлын гишүүдийн толгой дээр гарч суучхаад даргалж байгаа юм шиг ярьж болохгүй. Засгийн газрын хуралдааны хажууд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут өгье.

Х.Тэмүүжин: Засгийн газрын хуралдааны танхимд Улсын Их Хурлын дарга хажууд нь санал тавиад суувал энэ Үндсэн хуулийн зөрчил болно.

Улсын Их Хурлын чуулганы дэргэд спикерийн хажууд Ерөнхий сайд ирээд сандал тавиад сууж байгаа бол энэ бас Үндсэн хуулийн зөрчил болно. Ядаж ийм асуудлаа шийдэж байж энэ улс орон парламентын ардчилалтай урагшаа явж байгаа юм байна гэдэг тийм хэлэх үгтэй болох ёстой.

Парламентад мэтгэлцээн яагаад байхгүй байгаагийн чинь гол шалтгаан энэ. Мэтгэлцэх байр суурин дээр байхгүй байна шүү дээ. Ерөнхий сайд нь тэр Засгийн газрынхаа тэр жигүүр дээрээ суугаад, сөрөг хүчин нь энэ талд суугаад ярих ёстой.

Өнөөдөр ч гэсэн Засгийн газрын гишүүд хоорондоо маргаад сууж байгаа байхгүй юу. Кабинет дотроо тэр асуудлаа ярь л даа.

Чуулганы танхимд ирээд Засгийн газрын гишүүд маргаж болохгүй шүү дээ. Бараг Шадар сайдууд нь Ерөнхий сайдынхаа харалдаа тэнд очоод суух ёстой шүү дээ. Тэгж ярь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал хариулт өгье.

Н.Учрал: Энэ ардчиллын индекстэй холбогдуулаад бид холбогдох хэд хэдэн арга хэмжээ хийх ёстой, авах ёстой.

Энэ төсөвлөлт, төлөвлөлт, гүйцэтгэл чинь нэг тогтолцоо руу шилжиж чадахгүй байгаагийн шалтгаан нь бид олон улсын индексүүдийн тавьдаг индикатортай харьцуулж энэ хэмжүүрээ тэгээд тавьж чадахгүй байна.

Тийм учраас тэр олон улсын индексүүд дээр байр урагшлахгүй байна. Энэ чинь өөрөө репорт өгдөг. Тэр индикаторуудаа тавьсан зорилтод нь нийцүүлж ажлаа явуулдаг.

Өнгөрсөн 2 жил цахим засаглалын индекс 28 байраар урагшилсан. Энэ бол гайхамшигтайдаа бас биш. Энэ бол олон улсаас тавьдаг индикаторуудад нь зориулж тэр зорилтуудыг нь хэрэгжүүлж явсны үр дүнд цахим засаглал 28 байр E-PARTICIPATION цахим оролцоо 17 байр, кибер аюулгүй байдлын индекс 16 байраар урагшилсан.

Энэ бол индикаторуудад нь тавьж ажиллаж байгаа юм.

Бид Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орон.

Тийм учраас бид энэ олон улсын индексүүдэд тохируулж тэр репортуудыг нь илгээдэг байх ёстой. Олон улс ардчиллынхаа индекс дээрээ яагаад ухралт хийгээд байна вэ гэдэг дээр тодорхой хоёр шалгуур хэлсэн юм. Тэр нь юу вэ гэхээр төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалаа сайжруулаа л гэсэн. Энэ хуулиа гаргаж ир гэсэн. Яг энэ OECD-гийнх нь барьж байгаа зарчмынх нь дагуу бид энэ хуулийг барьж байгаа юм.

Үүний дараа хууль хэрэгжүүлнэ. Хууль хэрэгжүүлэхийн тулд улс төрөө давж гарна гэдэг айхтар хэцүү юм болно. Үүнд харин гишүүд хамт байх ёстой юм билээ. Тэгээд хамтарсан засаг гэдэг нэрийн доор бид чадахгүй мэдэхгүй хүмүүсээр баахан томилгоо хийчхээд, тэгээд компанийн алдагдал ийм байна гээд сууж болохгүй.

Тийм учраас бид олон улсад хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой.

Хоёрт, Олборлох салбарын ил тод байдлын хуулийг оруулж ир гэсэн. Их Хурлаараа батал гэсэн. Батлаагүй өдий хүрсэн.

Одоо олборлох салбарын ил тод байдал, байгалийн нөөцийн ил тод байдлын хуулийг оруулж ирнэ. Ингэсэн цагт ардчиллын индекс давуу тал өгнө.

Өнгөрсөн хугацаанд 820 мянган UNIT мэдээллийг бид нээлттэй болгосон. Одоо олборлох салбарыг бүтэн ил болгосны дараа шударга ёс яриад байдаг,

шударга үнэний дуу хоолой болчихсон энэ танхимд сууж байгаа зарим нөхдүүдийн үйлдэл нь ил болно.

Түрүүн ч хэлж байна. Л.Гантөмөр сайд хэлж байна лээ. Яриад яваад байгаа гэж. Үг нь бол үнэн. Үйлдэл нь худлаа гэдгийг хэлчихье. Үг, үйлдэл хоёр нэг цэгт огтлолцож байх ёстой шүү. Ярьж байгаа шигээ сайхан байвал сайхан байна. Амьдрал дээр өөр байгаа шүү.

Тийм учраас хүний өөрийнгүй хамтарсан байгаа дээрээ энэ олборлох салбараа ил болгоё. Тогтоолоо оруулж ирье. Тэгээд шийдье. Хэн нэгэн шударга болж үлдэхээ больё л гэж би хэлмээр байгаа юм.

Д.Амарбаясгалан: Х.Тэмүүжин гишүүн тодруулж асууя.

Х.Тэмүүжин: Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой дээр бас хэлэх нэг санаа байгаа юм.

Ер нь бусад улсын Засгийн газар чинь парламент шигээ хуралдаад суугаад байдаггүй юм байна лээ шүү. Засгийн газрын шийдвэр гэдэг гурван юмаар хэмжээд л тэр хэмжээс дээр багтаж байвал Ерөнхий сайд нь үүрэг хариуцлагаа хүлээж аваад, Ерөнхий сайдын өмнө хариуцуулагдаж байгаа салбарын сайд нь ажлаа хийгээд л яв юм байна лээ.

Гурван хэмждэг зүйл нь юу вэ гэхээр явуулж байгаа бодлого чинь

- ▶ хүний эрх болон хуулийн засаглалд нийцэж байгаа юм уу гэдэг дээр нь Хууль зүйн яам нь хяналт тавиад л,
- ▶ төсөв мөнгө, санхүүгийн нөөц нь хүрэх юм уу гэдэг дээр нь Сангийн яам нь хяналт тавиад л,
- ▶ захиргааны нөөц байгаа юм уу, зохион байгуулалт нь болж байгаа юм уу гэдэг дээр нь тэр хариуцсан чиг үүрэг бүхий сайд нь хяналт тавиад л явдаг юм билээ.

Яг энэ зохион байгуулалтыг араас нь дагаад парламент энэ чиглэлээр хяналт тавьдаг юм билээ.

Манайд Хүний эрхийн Үндэсний Комисс гэж байгаа. Хүний эрхийн OMBUDSMAN гэж нэрлэв үү, яана уу, ийнэ үү өнөөдөр энд тэдний дүгнэлт бас орж ирэх ёстой.

Засгийн газрын үйл ажиллагаа яагаад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын даргад баярлалаа.

Засгийн газрын үйл ажиллагаа яагаад хүний эрх рүүгээ очихгүй байгаа юм бэ, хүний эрхийн нөхцөл байдал нь яагаад дээшлэхгүй байгаа юм бэ гэдгийг хэмжиж хянахын тулд Хүний эрхийн Үндэсний Комиссын энэ үйл ажиллагаатай холбоотой дүгнэлтүүд нь бас орж ирэх ёстой юм.

Сая Н.Учрал сайдад үг хэлж байх шиг байна. Үнэхээр захиргааны нөөцөө данхайлгаад, давхардуулсан орон тоо бий болгоод, процесс нь шударга биш, эсвэл зохион байгуулалт муутай яваад байгаа бол түүн дээр нь Төрийн албаны зөвлөл хяналт тавьж сууж байх ёстой шүү дээ.

Төрийн албаны зөвлөлд зүгээр тэнд хөндлөн хэвтэж байх биш. Парламентын хяналтыг бие даасан байдлаар хэрэгжүүлж байгаа мэргэжлийн байгууллагынхаа хувьд Улсын Их Хурал руу дүгнэлтүүдээ оруулж ирээд, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд чинь болохгүй байна. Мэргэжилтнүүдийнх нь боловсон хүчнийх нь ур чадварт хүрэхгүй байна. Процесс нь болж өгөхгүй байна гэж байгаа бол энэ дүгнэлт орж ирчихсэн энд яригдаж байх ёстой байхгүй юу.

Гэтэл ганцхан аудитын дүгнэлт орж ирээд, тэрийг тойроод хэлэлцэж байна гэдэг Улсын Их Хурал харах харааныхаа хувьд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Тийм. Х.Тэмүүжин гишүүний хэлж байгаа үнэн.

Төсөвлөлт, төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт нэг тогтолцоо руу шилжих ёстой.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт суусан. Үүнийг Хяналт шинжилгээний Үндэсний хороо Э.Одбаяр сайд хариуцна.

Их Хурал хуулиараа дүн шинжилгээ л хийнэ. Дүн шинжилгээ хийнэ.

Ингээд зөв тогтолцоо руугаа шилжээд явах ёстой гэж байгаа юм.

Тэгээд түрүүн би хэлэхэд Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар Үндэсний баялгийн сангийн хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хэсгийг ахалж байгаа хүн бол би.

Тийм учраас хамтарсан үедээ ямар нэгэн ашиг сонирхолгүй хүмүүс энд ажиллаж байгаа учраас үр дүнд хүрнэ гэж бодож байгаа.

Тийм учраас үүн дээр бид хамт байх ёстой. Энэ салбарыг ил тод болгох ёстой. Ярьдаг шигээ бүгдээрээ байх хэрэгтэй гэдгийг би хэлмээр байгаа юм.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Жаргалан: Өнөөдөр бид нэгэн зэрэг хэд хэдэн баримт бичгийн гүйцэтгэлийг хэлэлцэж байна.

Эхнийх нь дийлэнх гишүүдийн яриад байгаа Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлийн тайлан.

Зарим гишүүд улс төржлөө барилаа гээд байх юм. Гэтэл Монгол Ардын нам л үнэмлэхүй олонх байх үедээ. “Алсын хараа-2050” гэдэг баримт бичгийг хүч түрэн батлаад таван жилийн үндсэн чиглэл гэдэг юм бодож олсон шүү дээ.

Тэрийг нь л асууж байгаа. Тэгээд өмнөх нийгмээ санагалзсан юм уу, урд хойд хөршөө даган дуурайсан юм уу. Ойлгомжгүй. Уг нь манай улс Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөгөө 4 жилээр батлаад явдаг. Энэ парламент ч тэр сонгогдсон даруйдаа Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан. Уг хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан бас орж ирж байна.

Тэгээд нэг зүйл дээр гишүүдтэй санал нэг байна. Ийм олон давхардсан баримт бичиг, давхардсан үнэлгээ, давхардсан цаас хийлээ гээд ажил сайжирдаг бол хамаа алга.

Таван жилийн коммунист төлөвлөгөө баталлаа гээд иргэдийн амьдрал сайжирдаг бол бас хамаа алга.

Гэтэл хангалттай сайхан хэрэгжсэн зүйл нэг ч алга. Бүгд л үр дүн муутай, тодорхой үр дүнд хүрээгүй гэсэн дүгнэлттэй байна.

Тэгээд сүүлийн хэд хоног Улсын Их Хурал гүйцэтгэлийн тайлан хэлэлцэж байгаа сургаар энэ хэдэн яамдын дарга нар, төрийн албан хаагчид ордны коридорыг хэд хоног сахиж суулаа шүү дээ. Одоо ч гэсэн сууж л байна. Тэгээд хэзээдээ үндсэн ажлаа хийх юм бүү мэд.

Тэгэхээр цаашид Улсын Их Хурал зөвхөн сайд нар ажлаа тайлагнах ёстой, асуултаа тариулах ёстой, төрийн албан хаагчид орж ирэх шаардлагагүй гэж Улсын Их Хурлын дарга удаа дараалан сануулаад байгааг дэмжиж байгаа.

Уг нь Баасан гарагийн өглөө Ерөнхий сайд илтгэлээ өөрөө танилцуулаад, сайд нар ч овоо танхимд суугаад байсан юм. Харин өнөөдөр Ерөнхий сайд алга. Тэгээд маш олон яамны сайд нар бас алга.

Тэгээд Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд л хандаж үг хэлэх гэсэн юм л даа.

Тэгээд Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ бол одоо Монгол Улсын түүхэнд хамгийн удаан Ерөнхий сайдаар ажиллаж байгаа хүн. Тав дахь жилдээ ажиллаж байна.

Ардчилсан Үндсэн хууль батлагдсанаас хойш ингэж удаан ажилласан Ерөнхий сайд байхгүй. Гэтэл энэ хугацаан дахь Засгийн газрын ажлын үнэлгээ 66 хувьтай гарсан байна шүү дээ. Тэгээд 66 хувь гэдэг чинь “F” үнэлгээ мөн биз дээ.

Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд гүйцэтгэлээ тайлагнасан илтгэлдээ КОВИД-ыг ялсан гээд ярьчих шиг болсон. Тэгээд КОВИД-ын үед юу болсныг дахиж сануулах хэрэгтэй юм шиг байна.

Эх орондоо ирж чадалгүй гэр бүлээсээ хагацсан хүмүүс, Улаанбаатар хот руу орж ирэх гээд 22-ын товчоон дээр амь насаа алдсан эмэгтэй, 8 сая төгрөгийн КОВИД-ын багц, үй түмэн хүний эрхийн зөрчлүүдээ бид мартчихсан юм уу. Эдийн засаг 5 хувиар агшсан тэр үеийн алдагдлаа өнөө хэр нөхөж чадалгүй дампуурсан үй түмэн олон аж ахуйн нэгжүүд байна шүү дээ. Боловсролын хоцрогдлоо өнөө хоёр арилгаж чадахгүй байгаа маш олон хүүхэд, багачууд байна. Тэгээд энэ хугацаанд юмны үнэ хэд дахин нэмэгдсэн. Иргэд өдөр тутам үнийн өсөлтөд дарлуулж байгаа. Тэгээд КОВИД-оос хойш нүүрсний экспорт өссөн учраас нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн нэмэгдсэн гээд гэж харагдаад байгаа боловч иргэд үнийн өсөлт, ханшийн өсөлтөд дарлуулсан хэвээр л байгаа шүү дээ.

Гэтэл төсөв данхайсан хэвээр, төр нь мөнгөөр туйлсан хэвээр.

Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдаар ажиллах хугацаандаа 100 гаруй их наяд төгрөгийн улсын төсвийг захиран зарцуулсан. Тэгтэл аудитын байгууллагаас 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан 21.7 их наяд төгрөгийн зарцуулалт нийгэмд ямар ч эерэг өөрчлөлт авчраагүй гэсэн дүгнэлт хийсэн байна.

Өөрөөр хэлбэл 21.7 их наяд төгрөгийг тодорхой үр дүнгүй зүйлд зарцуулчихсан байна гэсэн үг.

Энэ нь одоо бас нөгөө нүүрсний 40 их наяд гэдэг шиг замхраад алга болох юм уу.

Өнөөдөр Ерөнхий сайдын тайлагнаж байгаа таван жилийн үндсэн чиглэл нь үндсэн 9 бодлоготой байсны эхнийх нь “**үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх**” гэсэн зорилт байжээ.

Нэг нэмэлт 1 минутаа авчихъя. Тэгэх үү, дарга аа.

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье.

Б.Жаргалан: Тэгээд “үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх” гэсэн зорилт нь 51 хувийн үнэлгээтэй.

Үнэхээр үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэхийг хүсээд байгаа юм бол Ерөнхий сайд өөрөө улс төрийн манлайлал үзүүлэх хэрэгтэй шүү дээ. Хэн нэгэн хийсвэр дайсныг дарах тухай ярих биш, шүүмж хэлсэн хүнийг хар PR-дах биш, улс орныг талцуулсан нэвтрүүлэг хийж бүх телевизээр цацах биш.

Монгол Улсын Ерөнхий сайд урагшаа харсан эерэг манлайлал үзүүлж чадах юм бол бодит үр дүн гарна. Монголчууд бид үндэсний эв нэгдлээ хангаад явна гэдгийг танд бас сануулахыг хүсэж байна.

Тэгээд эцэст нь Улсын Их Хурлын өөрийнх нь үйл ажиллагаатай холбоотой зүйл дээр Улсын Их Хурлын Тамгын газраас асууя.

Тамгын газраас бас нэг дүгнэлт гаргасан байна лээ. Энэ нь Засгийн газраас гаргасан, аудитаас гаргасан дүгнэлттэй зөрөөд байгаа. Тэгэхээр энэ тал дээр тайлбарыг хийнэ үү.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат дүн шинжилгээний талаар хариулт өгье. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Ү.Амарбат: Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

2024 онд Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг батлахдаа бусад улс орны жишгийг харгалзаад Засгийн газрынхаа үнэлгээг хэлэлцэхдээ тухайн парламентынхаа гишүүдийг Засгийн газрын үнэлгээний бодит байдал, энэ үнэлгээ ер нь ямархуу түвшинд хийгдэв, дахин авч үзэх зөрүүтэй байдал байна уу, үгүй юу гэдгийг нягтлах зорилгоор Тамгын газар нь гишүүддээ энэ асуудлыг хэлэлцэхэд зориулж дүн шинжилгээ хийж өгдөг ийм зохицуулалтыг оруулсан байгаа.

Тэгэхээр энэ өгөөд байгаа дүн шинжилгээний эцсийн зорилго бол яг энэ хэлэлцүүлгийг явуулахад парламентын гишүүдэд нөгөө үнэлгээний талаар үнэн бодит байдал, мэдээллийг тодруулж өгөх зорилготой дүн шинжилгээ байгаа юм.

Тэгэхээр энэ бол тусдаа хийгдсэн үнэлгээ гэхээсээ Засгийн газрын үнэлгээн дээр хийгдэж байгаа дүн шинжилгээ.

Энэ дүн шинжилгээг хийхэд мэдээж тооны зөрүүнүүд гараад байгаа. Тэгээд энэ зөрүү яагаад үүсэж байгаа вэ гэдгийг тайлбарлая.

Засгийн газар өөрийнхөө гүйцэтгэлийг үнэлэхдээ 3 бодлогын бичиг баримтаа 206 дугаар журмынхаа дагуу үнэлдэг. Энэ үнэлгээний журам дотор хоёр аргачлалаар үнэлэх боломжийг зааж өгсөн байгаа. Нэг нь чанарын буюу

бодлогын бичиг баримт ямар хувьтай биелсэн юм, ажлын хэсгээ байгуулсан юм уу, үйл ажиллагаагаа яаж явуулсан юм гэдэг тал байгаа нөгөө тал нь тоон үзүүлэлт байгаа.

Тэгэхээр зарим үнэлгээ жишээлбэл Засгийн газар 50 гээд дүгнэхэд Тамгын газар дээр хийж байгаа дүн шинжилгээ 30 болж байгаа нь тоон үнэлгээнүүдийг, тоон зорилттой хэсгүүдийг яг тэр тооных нь хэсгээр харж байгаа. Жишээлбэл, хотын түгжрэлийг бууруулна гэдэг зорилтыг 45 хувь биелсэн гэж үнэлээд үйл ажиллагаануудаа илүү тоочиж байгаа бол нөгөө талд нь энэ тоон үзүүлэлт байгаа. Оргил ачааллын үед 10 километр цагийн хурдтай байгааг 22 километр цагийн хурдтай болгоно гэдэг зорилттой. Үүнийх нь биелэлт нь 22-тоо хүрээгүй, 13 километр цаг болж байгаа юм.

Ингэхээр нөгөө 45 хувь маань үр дүнгийн хувьд буураад 20 гэж үнэлэх үндэслэл нь энд гарч ирж байгаа юм.

Тэгэхээр яг Засгийн газар өөрийнхөө тавьсан зорилт тэнд байгаа энэ тоон үзүүлэлтдээ хүрсэн эсэхийгээ зөв үнэлсэн байна уу, үгүй юу гэдэг дээр хийж байгаа дүн шинжилгээ байгаа юм. Энэ маань өөрөө гишүүдийг яг энэ асуудлын хэлэлцэхэд илүү үнэн бодит мэдээллээр хангах зорилготой үнэлгээ юм гэдгийг тодотгож хэлье. Хариулж дууслаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Сайн төлөвлөлт ажлын 40 хувь байдаг юм.

Өнөөдөр гүйцэтгэл дээр маш олон янзын төлөвлөлт байна. 2021-2025 оны төлөвлөлт, 2024-2028. 9 зорилттой, 4 зорилттой. Бүх зорилтууд нь тунхгийн шинжтэй байгаа байхгүй юу.

- Эдийн засгийг өсгөнө,
- Экспортыг нэмэгдүүлнэ,
- Хүний эрхийг дээдэлнэ гэсэн.

Тэгээд энэ олон зорилтуудаас харин нэг зорилт хамгийн их боломжтой.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт шинжилгээ, үнэлгээ, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин гэсэн.

- ▶ Алсын харааны 2 дугаар заалт. Хүний хөгжлийн үзүүлэлтийг 10 байраар ахиулна.
- ▶ Алсын харааны 3 дугаар зорилт. Ядуурлын түвшнийг 2 дахин

бууруулна гээд.

Ийм хэмжих нэгжтэй зорилтыг тавимаар байна. Ийм хэмжих нэгж. Хэрвээ ийм зорилтыг тавьж ажилласан бол бид нарын өнөөдрийн гүйцэтгэл маш өөр түвшинд хүрч ирэх бололцоотой байсан.

Ер нь бид дандаа цаг хугацаанд шахагдаж ажиллах юм. 126 гишүүнтэй парламент бүрдээд, Засгийн газар бүрдэнгүүтээ 60 хоногийн дотор үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг баталсан.

Одоо энэ төлөвлөгөөг эргээд харахад бас дутуу зүйл зөндөө байна. Энэ дутуу зүйлүүдээ бид хийж гүйцэтгэхийн тулд өнөөдөр Улсын Их Хурлын даргын зүгээс ажлын алба байгуулъя гэж санал болгосон.

Төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын ажлын албыг байгуулъя. Хэрвээ энэ ажлын албыг байгуулах юм би энэ ажлын албанд орж ажиллах саналаа хүргүүлье.

Яагаад гэхээр бид 2026 оны төлөвлөгөөгөө батална. 2026 оны төсвөө батлахад бид үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг энэ хавар 5 сарын 01-нээс 6 сарын 01-ний хооронд батална.

Энэ төлөвлөгөөгөө батлахдаа бид төлөвлөлт, гүйцэтгэлээ, төлөвлөх аргачлалаа нарийвчилсан механизмыг сайжруулчихсан байх ёстой. Тэгж байж бид энэ төлөвлөлтийг сайн батална гэж үзэж байгаа.

Ер нь энэ төлөвлөлтүүдийг харж байхад бидэнд сайн хийж гүйцэтгэж байгаа зүйлүүд байна. Энэ бол 14 мега төслийн төлөвлөлт сайн байгаа, гүйцэтгэл сайн байгаа. Уул уурхайн үйл үйл ажиллагааны явц сайн байгаа.

Гэхдээ бас учир дутагдалтай салбарууд байна.

- Түгжрэл,
- агаарын бохирдол,
- ядуурал,
- эрүүл мэнд,
- хүүхэд хамгааллын салбарууд дээр бид хангалттай сайн ажиллаж чадахгүй байна. Үнэндээ чадахгүй байна.

Өнөөдөр нийгмийн хамгийн том сэдэв болох ядуурлын тухай асууя л даа.

Энэ 2024-2028 он, энэ 2024 оны төлөвлөгөө дээр ядуурлын бууруулах ямар ажлууд хийв? Хэдэн хүнийг ядуурлаас гаргачхав аа? Энэ талаар асуулт асууя.

Д.Амарбаясгалан: Л.Энх-Амгалан сайд. Б.Пунсалмаа гишүүний асуултад хариулъя.

Л.Энх-Амгалан: Одоо Л.Энх-Амгалан чи яг хэдэн хүнийг 7 сарын дотор ядуурлаас гаргачхав гэж асуувал би одоо яг тэд гэж хэлэхэд хэцүү байна.

Сая та өөрөө хэллээ шүү дээ. Хэмжих хэмжүүртэй, хүрэх үр дүнгээ тодорхойлчихсон, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 10 мянган доллар болгоё, ядууралыг хоёр дахин бууруулъя. Энэ 4 жилд гэдэг зорилт. Энэ 4 жилд.

Тэгэхээр үүнийг яаж болгох юм бэ гэдгийг та сая өөрөө хариултыг нь хэлчих шиг боллоо. 14 мега төслүүд хөтөлж байж л дотоодын нийт бүтээгдэхүүн 10 мянган долларт хүрэх, ядуурал буурч, ажилгүйдэл буурах ийм л үндсэн суурь нөхцөлүүдийг л бид хамтдаа хийхээс өөр арга байхгүй байна шүү дээ.

Бид ядуурал 30 хувь гэдэг тоог сүүлийн 30 жил ярилаа шүү дээ. Сүүлийн 3, 4 жилд 27 хувь руу буусан байгаа. Мэдээж эдийн засгийн өсөлт 6, 7 хувьтай байхад үүнийгээ дагаад буурах нь ойлгомжтой.

Нөгөө талдаа ажилгүйдэл 5-аас 6 хувьтай гээд байдаг. Байнга л 70-аас 80 мянган хүн ажилгүй байдаг гэсэн нэг ийм тоогоор тайлан гаргаад сурчихсан гэж хэлэх үү дээ. Тайлан гаргаад сурчихсан.

Тэгэхээр одоо яг таны хэлж байгаа зарчимтай би санал нэг байгаа. Юу гэхээр тоо бүхэн өөрөө үр дүн авчирч байх ёстой, хэмжихүйц байх ёстой. Нөгөө хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй үг байдагтай адил.

Тэгэхээр одоо бид цаашдаа Статистикийн ерөнхий газартай хамтарч ядуурлынхаа түвшинг, хэмждэг хэмжүүрүүдийг ч гэсэн ерөнхийдөө нэлээн өөр түвшинд гаргаж ирье.

Саяхан Дэлхийн банк энэ ядуурлын хэмждэг хэмжүүрүүдээ 2022 онд өөрчилсөн байна лээ. 10 жил тутамд өөрчилдөг юм байна.

Тэгэхээр Монгол Улс олон улсын байгууллагуудын ядууралыг хэмждэг энэ хэмжүүрүүдийг би авч яваад байгаа. Их буруу гэж ойлгож байгаа. Манай Монгол Улсын өөрийн онцлог бас байгаа. Манай албан бус секторууд, хөдөө аж ахуйн салбарын ядуурал гэдгийг хэмжих яг ямар хэмжүүр байх вэ гэдгийг ч хүртэл бид өнөөдөр эцэслэж чадаагүй сууж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хүрээндээ бид үндэсний эх өгөгдөл гэдгээ их хурдан боловсруулъя. Тийм ээ. Өнөөдөр ядуурлын түвшин, ажилгүйдлийн түвшин, энэ бүх юмнуудаа зөв хэмждэг больё. Тэгээд зөв оношилж байж зөв эмчилгээ хийхгүй бол бид эмчилгээ буруу явахын хорыг бид зөндөө их амссан.

Ер нь цаашдаа бид ядуурал гэж ярихаар ерөнхий ярихаа больж, ер нь ядуурлын олон хэмжээс, их олон ядуурал байдаг. Ядуурал янз янзаар хэмждэг нэг ийм зөв тогтолцоонууд байна. Үүнийгээ аваад явъя.

Одоо Монгол Улсад хүүхдийн ядуурлыг ярих цаг болсон байгаа байхгүй юу. Ерөнхий л хүн амын ядуурал гэж ярихаасаа илүү хүүхдийн ядуурал гэдэг маш том сэтгэл зовних ийм том асуудлууд бий болчихсон, бодитой хөрс сууриуд нь бий болчихсон.

Д.Амарбаясгалан: Наранцэцэгийн Алтаншагай гишүүн. Алга байна.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. /алх цохив/

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцлээ. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

Дараагийн асуудалд оръё.

Хоёр.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 5 цаг 25 минут үргэлжилж, 15 цаг 25 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД